

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ХЭЛ ЗОХИОЛЫН ХҮРЭЭЛЭН

О. Сүхбаатар

МОНГОЛ ХЭЛНИЙ ХАРЬ ҮГИЙН ТОЛЬ

Редактор. доктор профессор Д.Төмөртогоо
доктор. Л.Хүрэлбаатар
дэд доктор Б.Амаржаргал

Улаанбаатар 1997

Хэл зохиолын хүрээлэнгийн Эрдмийн зөвлөлийн баталснаар хэвлэв.

ӨМНӨТГӨЛ

Түүхэн хөгжлийн урт замыг түүлж аажмаар бүрэлдэн тогтсон монгол хэлний үгсийн санг судлах нь үгсийн сангийн тогтолцоог зөв тогтооход чухал ач холбогдолтой юм. Учир нь аливаа хэлний үгсийн сан нь салангид үгсийн тооны энгийн нийлбэр биш, тодорхой систем гэж хэлшинжээчид үзэг билээ. Монгол хэлний үгийг гарал үүслээр нь уугал монгол үг, зээлдсэн үг, олон улсын чанартай үг гэж үндсэнд нь гурав хуваасан байдаг. Үүнд зээлдсэн буюу харь гаралтай үгсийг тодруулан тогтоох нь монгол хэл ямар ямар хэлтэй холбоо хэлхээтэй явж ирснийг тодорхойлох боломж олгоно.

Монгол хэлэнд янз бурийн хэлний үг нэвтэрч ирсэн нь монгол хэлний үгсийн сан, бүрэлдэх үүний хувьд дутуу дулимаг байснаас шалтгаалсан хэрэг огтхон ч бус, харин хол ойрын олон улс гурэнтэй нийгэм-түүхийн янз бурийн үе шатанд түүх соёл, шашин шүтлэг, улс төр, эдийн засаг худалдааны талаар өргөн харилцаатай явж ирсний баталгаа болох юм.

Ер нь үг зээлдэх явдал нь хэлний хөгжлийн явц дахь зүй ёсны үзэгдэл байдаг бөгөөд энэ нь тухайн ард түмний оюуны болн соёлын хөгжлийн зайлшгүй хэрэглээ болоод зогсохгүй төрөл буюу төрөл бус хэлтэн ард түмэнтэй харьцах хэрэглүүр болдог. Иймд өөрийн хэлэндээ үг зээлдээгүй цэвэр хэлтэй ард түмэн гэж байхгүй. Зөв зохистой зээлдсэн үгс тухайн хэлний үгсийн санг баяжуулж илэрхийлэх бололцоог нь нэмэгдүүлдэг тухайд судлаачид нэгэн дуугаар зөвшөөрдөг билээ. Хэлний хөгжлийн энэ зүй тогтол ч монгол хэлэнд тодорхой туссан байдаг.

Монгол хэлэнд орос, хятад, манж зэрэг хөрш зэргэлдээ улс үндэстний хэлнээс гадна араб, перс, түрэг, төвд, самгарди зэрэг эртний харилцаатай байсан улс үндэстний хэлний үгээс авахуулаад орчин цагийн англи, герман, франц зэрэг хэлний үгс ч байгаа нь түүх, хэлшинжлэлийн үүднээс нягтлан судлууштай зүйлийн нэг болно.

Эрт цагт монгол хэлэнд орсон үгс нь монгол хэлний уугал үгээс ялгарахгүй шахам болсон байдаг нь монгол хэлний зүй тогтлын дагуу өөрчлөгдөн хувирсантай холбоотой юм.

Дэлхийн улс түмнүүд өөрийн хэлний үгсийн санд харь хэлнээс зээлдсэн үг хэллэгийг эртнээс судлан тогтоож тийм үгийн толь бичгийг хийсээр ирсэн байна. Тухайн хэлнээ хэрэглэгдэж байгаа болон хэрэглээнээс гарсан харь гаралтай үгсийг багтаан тайлбарласан, уг шаг нь ямар хэлний ямар утгатай уг болохыг нь

О.Сүхбаатар
Монгол хэлний
харь үгийн толь

Эх бэлтгэсэн
Ө.Тунгалаг, О.Самбуудорж
Техник редактор О.Самбуудорж

Цаасны хэмжээ 60 x 84/16 см, х.х.
ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн
Авианзүйн лабораториид эхийг 1997 оны 5 сард
бэлтгэж, 1997 оны 6 сард ном хэвлэлийн
Адмон компанид хэвлэв.

хадаад одоо ямар утгаар хэрэглэгдэж байгааг нь тайлсан толийг харь гаралтай үгийн толь гэдэг. Гэтэл монгол хэлэнд орсон үгийн ийм толь бичиг өнөө болтол гараагүй байна.

Орчин цагийн монгол хэлнээ орсон харь гаралтай үгсийг бүртгэн судалж, толь бичгийг нь зохиох, хэлзүй, зөв бичих зүйгий нь боловсруулан гаргах нь манай хэл шинжлэлийн хойшлуулшгүй чухал ач холбогдолтой зорилт болж байгаа юм. Ингэснээр хүний өөрийн угзээ ялан танъж, монгол хэлнийхээ угат язгуурын үгийг зөв тогтоож, эх хэлнийхээ үгийн бүтцийн тогтолцоог илрүүлэхэд үлээмжхэн ач тустай зүйл болж өгөх нь дамжигүй.

Энэхүү зорилтын үүднээс миний бие эрдэм шинжилгээний төслийн хүрээнд “Монгол хэлний харь гаралтай үгийн тайлбар толь” хэмээх энэхүү бүтээлийг гүйцэтгэсэн болно. Монгол хэлний харь гаралтай үгс бидний төсөөлж байгаагаар бичигт тэмдэглэгдэн уламжлагдан ирсний хамгийн эртнийх нь ХШ зууны үетэй холбогдож байгаа юм. Тийм ч учраас энэ толь бичигт тэр үеийн бичгийн дурсгалаас авахуулаад өнөөдрийг хүргэл монгол бичгийн болон аман зохиол, ярианы хэлэнд хэрэглэгдэж ирсэн хуучин шинэ үгийн зонхийг бүртгэн оруулахыг хичээсэн болно. Нэгэн зүйлийг онцлон тэмдэглэхэд энэ толь бичиг монгол хэлний хувьд анхдагч нь болох ба хоёр дэвтрээр бэлтгэсний нэгдүгээрх нь болно. Энэ нэгдүгээр дэвтэрт гол төлөв Дорнодахины хэлнээс орсон үгийг хамруулахыг оролдсоноо тэмдэглэсү. Хоёрдугаарт дэвтэрт их төлөв 1921 оноос хойш европын хэлнүүдээс шууд ба дам хэлбэрээр орж ирсэн орчин үеийн шинэ үг хэллэг, нэр томъёоны чанартай үгсийг оруулсан болохыг дурдалтай.

Монгол хэлэнд хариас орсон үг гэдгийг ямар шалгуураар тогтоов гэвэл монгол хэлний авиа зүйн онцлог шинж, цаад хэлэнд буй үгийн авиа зүйн бүрхүүл зэргийг харьцуулж улмаар тэр үгийн бүтэц язгуур үндсээрээ задарч буй эсэхэд ажиглалт хийн бас урьд өмнийн судлаачдын судалгааны эх хэрэглэгдэхүүнтэй дүйцүүлэх замаар гүйцэтгэсэн болно. Тухайлбал өлөг гэдэг үгийг түрэг гаралтай үзсэний учир нь түрэг хэлнээ ол- нь “үхэх” гэсэн утга хадгалж ирсэн, бас түрэг зүгийн олон хэлэнд энэ утгаараа байгаа зэргийг эш үндэс болгосон байх жишээтэй. Зарим үгийн гарлын тухайд осол омтгойгоор тайлбарласан зүйл байхыг угүйсгэхгүй боловч урьд өмнийн эрдэмтэн мэргэдийн судалгааны үр дүн, өөрийн ажиглалт дүгнэлт сэлтэд тулгуурлан тогтоосноо ч бас дурдууштай. Өөрийн үг үү, өрөөлөөс авсан үг үү гэдгийг судлагсдад энэ толь бичиг ямар нэг хэмжээгээр тус болох байх гэж найдаж байна. Сүүлийн үес монгол хэлний үгийн гарлын талаар эрдэмтэн

Л.Түдэв, М.Базаррагчаа нар нилээд зүйл хийснийг онцлон тэмдэглэхийг хүснэ.

Монгол хэлэнд орсон харь гаралтай нилээд үгсийн авианы бүрхүүлд үлээмжхэн өөрчлөлт гарсан нь их төлөв амаар дамжин орж ирсэн угст ажиглагдаж байна. Тэгвэл бичиг судрын хэлээр дамжин ирсэн угст тийм өөрчлөлт бага гарсан буй. Өөр нэг тэмдэглэх зүйл гэвэл хэлний өөрийнх нь олон талт дотоод хөгжлийн үр дүнгээс салгаж болшгүй өөрчлөлт гарсан нь утгын хувирал болно. Тиймээс ч харь гаралтай үг бичгийн хэлээр дамжсан бол анх хэдийд ямар утгаар хэрэглэгдэж байсан, хэрэв бичгийн дурсгалд тэмдэглэгдээгүй бол аман зохиолын зүйлд байгаа эсэх, цаад хэлэндээ ямар утгатай байсан, бусад төрөл хэл аялгуунд ямар утгатай байгаа зэргийг харьцуулж үзснээр утгын хувирлыг нь тогтоож болох юм.

Энэхүү толь бичигт орсон үгсийг утга зүйгээр нь авч үзвэл одоогийн хүмүүст огт ойлгогдохгүй болсон үгс, ерөнхий утга нь тоймлогдох авч монгол хэлний үгийн сангийн хэрэгцээнээс шахагдан гарч идэвхгүй үгийн нээцэд орсон үгс, толь бичигт тэмдэглэгдсэн авч тайлбар шаардах үгс, орчин цагийн монгол хэлний үгийн санд идэвхтэй хэрэглэгдэж байгаа үгс гэхчлэнгээр ангилан үзэж болох байна. Монгол хэлнээ орсон харь гаралтай үгс нь жинхэнэ монгол үтгэй хоршин хэрэглэгдэх, урьд өмнө нь огт холбогдож байгаагүй үтгэй хавсрان шинэ холбоо үг бүтээж бүтцийн утга үүсгэсэн нь цөөнгүй тул эдгээрийг эл тольд тусгасан болно.

Үгийн утгад өөрчлөлт орох буюу олон утгатай болох, үгсийн сангийн шинэ нэгж үүсгэх зэрэг нь үгсийн сангийн нийтлэг үзэгдэл, үгийн баялаг шинжийн илэрхийлэл болж өгдөг бөгөөд монгол хэлнээ орсон харь гаралтай үгийн утга ч ийм зүй тогтолоор хөгжиж иржээ. Түүгээр ч үл барам үгийн хэлбэр буюу авианы бүрхүүл өөрчлөгдсөнөөс агуулга буюу утгад нь ноцтой хувьсал өөрчлөл гарсан цөөнгүй баримт нийтлүүлэн бүхий толь бичигт орсон болно. Монгол хэлний яриа бичгийн хэлний үгийн санд байгаа харь гаралтай түүхэн ба хуучирсан үгийг шинэ утгаар сэргээн хэрэглэх нь монгол хэлнээ шинэ нэр томъёо тогтооход баримтлууштай нэг зарчим болно. Тийм ч учраас зарим амьтан ургамлын нэр томъёоны ард латин нэрийг нь хадаж өгөв. Ер нь уг тольд орсон бүх л үгийн ард ямар хэлнээс орсныг нь зааж тэр л хэлнийх нь галигаар тэмдэглэн монгол бичгээр хэрхэн бичиж ирснийг нь галигчлан буулгасан болно.

Харин хятад хэлнээс эд юмс, хүнс хоол, зэрэг дэв, худалдаа арилжааны холбоотой нилээд үг орж ирсэн нь одоогийн хятад бичгийн хэлнээ зарим нь бараг хэрэглэгдэхгүй, дээр үед хятад нутгийн аялгуунаас орсон учир ханз нь олдохгүйн бэрхшээл гарсныг дурдая.

Шашин шүтглэгийн холбоотой газар ус, орон хот, сүм хийд зэргийн харь гаралтай нэрийг оруулав.

Эцэст тэмдэглэхэд Монголын ард түмэн өнө эртнээс нааш дэлхийн олон улс гүрэнтэй дэлгэр харилцаатай байсны гэрч болох энэ толь бичиг монгол хэлний үгсийн сангийн баялагийг бүрэн багтаасан тайлбар толь хийгээд зохих нэмэр хандив болно.

Нэгэн үе хуучирч мартагдсан үг хэллэгийг үзэл суртлын харгайгаар хоцрогдсон “феодалын үг” гэж адалж, хэрэгцээнээс шахан гаргасан бөгөөд тийм үгс, эл тольд олон орсон нь өнөөдөр Монгол улс нийгмийн шинэ тогтолцоонд шилжснээр хуучны соёлын өв уламжлал, шашин шүтгэг сэргэж байгаатай холбогдон нийгмийн эрэлт шаардлагатай нягт уялдаж байгаа болно. Одоогоор яриа болон бичгийн хэлнээ идэвхтэй үүрэгтүй үгсийн нэлээд нь харь гаралтай хуучирсан үг хэллэг бөгөөд эдгээр нь эртний мэдлэгийн салбар ухааны янз бүрийн ойлголтыг тэмдэглэсэн байдаг учир мэргэжлийн хүний хувьд танил үг байдаг гэдгийг бас тэмдэглэх хэрэгтэй.

Энэхүү толийн талаар үнэт зөвлөгөө өгч байсан доктор Л.Хүрэлбаатар, Л.Болд, компьютерийн эх бэлтгэсэн эрдэм шинжилгээний ажилтан О.Самбуудорж, Θ.Тунгалаг нартаяа гүн талархал илэрхийлэх ялдамд уг толийн талаархи санал хүсэлтээ доорхи хаягаар ирүүлэхийг эрдэмтэн, судлаач, эрхэм уншигч нараасаа хичээнгүйлэн хүсье.

Монгол улс.
Улаанбаатар-20
шх - 70

Хэл бичгийн ухааны дэд доктор
Хатгин Осорнамжмын Сүхбаатар

ТОВЧИЛСОН НЭР ХИЙГЭЭД НОМ ЗОХИОЛЫН ЦЭС

I.

англ.	англи
апабхр.	апабрамша
ар\араб.араб	
арам.	арамей
вен.	ベンгал
герег.	герег
зөрч.	зөрчид
иран.	иран
исп.	испани
лат.	латин
манж.	манж
мо.б.	монгол бичиг
нан.	нанай
ор\орос.	орос
перс.	перс
сам.	самгарди
согд.	согд
солон.	солон
тө.	төвд
түнг.	түнгүүс
түр.	түрэг
уй.	уйгар
фр.	франц
хинд.	хинди
эвенк	эвенк
як.	якут

II.

шилж.	шилжсэн утга
цэц.	цэцэн үг
зүйр.	зүйр үг
хорш.	хоршоо үг
яриа	ярианы үг
харьц.	харьцуул
хууч.	хуучирсан үг

III

Б.Р.	Б.Ринчен
Б.Я.	Б.Явуухулан
Ц.Д.	Ц.Дамдинсүрэн
Д.Н.	Д.Нацагдорж
Д.Р.	Д.Равжаа
Л.Т.	Л.Түдэв
Ж.Л.	Ж.Лувсандорж
Д.П.	Д.Пүрэвдорж
С.Д.	С.Дашдооров
С.Даш. С.Дашдэндэв	
Ч.А.	Ч.Алтангэрэл
З.Б.	З.Баттулга
Соном.	Сономгара
Д.Май.	Д.Майдар
С.У.	С.Удвал
Гэл.	Гэлэгбалсан
Б.Лх.	Б.Лхагвасүрэн
Кали.	Калидас
Паж.	Пажай хуурч
Паг.	Пагва ламын туж
Д.Нам.	Д.Намдаг
Гам.	Гамал
Ч.Ж.	Ч.Жигмид
С.Э.	С.Эрдэнэ
Д.Цэв.	Д.Цэвэгмид
О.Д.	О.Дашбалбар
Рас.	Рассадин В.И.

IV.

Мондом -Монгол домог, эмхэтгэн боловсруулж, тайлбар, удиртгал бичсэн Х.Сампилдэндэв. УБ - 1984
 МШЯН -Монголын шилдэг яруу найраг. УБ. 1961
 МХШЗ -Монголын хошин шог зохиол. УБ.
 Суба -Сайн үгт эрдэнийн сан Субашид. УБ. 1990
 Үл.Дал/ай/ -Үлгэрийн далай, хөрвүүлж тайлбар бичсэн Д.Бүрнээ, Д.Энхтөр. УБ. 1997
 МААЗДБ -Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Ш.Гаадамба, Д.Цэрэнсодном. УБ. 1978
 MAY -Монгол ардын үлгэр. Д.Цэрэнсодном эмхэтгэж, удиртгал тайлбар бичив. УБ. 1982.

МНР -Монголын нууц товчоо.

Жан -Жангарын тууль

Түрф -Турфаны монгол бичгийн дурсгалууд

Данж -Данжурын зарим ботиос

ЗУАЗ -Монгол ардын зан үйлийн аман зохиол. УБ. 1987

ИТ -“Ил товчоо” сонин

АЭ -“Ардын эрх” сонин

МУЗД 1. -Монгол уран зохиолын дээжис. 1 боть

ЦБЛ -Цагаан лянхуан баглаа

А.Х -Алтан хүрдэн. Хэвлэлд бэлтгэсэн Л.Хүрэлбаатар. УБ. 1992

ААЗ -Ардын аман зохиолоос

Влад -Б.Я.Владимирцов. Сравнительная грамматика монгольского письменного языка и халхасского наречия. Мос. “Наука” 1989

ГМА -Ганга мөрний айзам. УБ. 1989

Гэс -Гэсэр. Сонгомол эхийг боловсруулж, удиртгал, тайлбар бичсэн акад. Ц.Дамдинсүрэн. 1987

12 зох -Arban qoyat jökiyangui üiles. De Čhos kyi 'od zer Traduction de Ses-rab Senge. Par.Louis Ligeti. Budapest, 1974

Preklasszikus Emlékek; 3. jüan és Ming-kori szövegek klasszikus Atirasban közzetészi Ligeti Lajos. Budapest, 1967.

А.то. - Altan tobči. Hans Peter Vietze, Gendeng Lubsang. Tokyo, 1992.

Алексei M. Pozdneev -Religion and ritual in Society: Lamaist Buddhism in late 19th - century Mongolia. Bloomington, 1978.

МЗАО -Mongyol-un Jang ayali-yin oyilburi. ОМАКQ - 1981

Сув.эрхих -Subud erike.

Зуун.бил -Mongyol uran jokiyal-un degeji Jayun bilig orušibai, C.Damdinšüürüng, UB-1959.

Раш.дус -Rašiyan-u dusul-un mongyol töbed tayiburi. Ce.Damdinšüürüng, “CSM”, Tom.VII. UB-1964.

Injinnasi -Yeke yuan ulus-un manduysan törü-yin köke sudur, ОМАКQ. 1991. Uyiyurjin mongyol üsüg-ün durasqaltu bičig-üd, Begejing, 1983

ОМТ -Орос монгол толь, Ц.Дамдинсүрэн, А.Лувсандэндэв. УБ, 1982

Ков -Ковалевский.О. Монгольско-Русско-Французский словарь, Том.1-Ш, Казань. 1844-1849.

ДТС -Древнетюрский словарь, ред.В.Наделяев и др. Ленинград - 1969.

ЯЦ -Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь. УБ. 1967.

A

Ю.Р -Ю.Н.Рерих. Тибетско-русско-английский словарь \с санскритскими паралелями\, Вып. 1-11, Изд-во “Наука”, М.1983-1987.

Мукад - Монгольский словарь Мукад-и-мат ал-адаб. 1, П. М-Л 1938.

С.Р -Сумадирадна. Bod hor kyi bzda yig min tshig don gsum gsal bar byed pa mun sel sgron me, Vol.1-II. CSM. UB-1969.

ЦЦ -Sečenčočtu. Mongol üges-ün ījayg-un toli bičig, ОМАКQ-1988.

Цин -Цинциус В.И. Сравнительный словарь тунгусо-маньчжурских языков. Том. 1, П. Л-град. 1975, 1977.

Mongol ei iui toli bičig U.Mandaqu emkidken tayilburilaba. Begejing, 1995.

B.Vangjal- Köke tülkigüri, Köke qota, 1987.

Saya -Mongyol ügen-ü tayiburi toli, Begejing, 1994.

Tashi Tshering -English-Tibetan-Chinese Dictionary, Beijing - 1991.

Csoma de Körös -Sanskrit-Tibetan-English Uocabulary. Budapest-1984.

Kitad-Mongol toli. Köke qota. 1983.

Chos Grags -Brida da min tshig gsal ba, Begejing, 1957.

Raghu Vira -Mongol-Sanskrit Dictionary, with a sanskrit mongol index, New Delhi, 1956.

Pentaglot dictionary of Buddhist terms in Sanskrit, Tibetan, Manchurian, Mongolian and Chinese, New Delhi, 1961.

Monier Williams -Sanskrit-English Dictionary, New Delhi, 1981.

Sarat Candra Dass -Tibetan English Dictionary, New Delhi, 1979.

Lessing -Mongolian-English Dictionary. Berkeley, 1960.

И.Захаров -Полный маньчжурско-русский словарь, СПб-1875.

Г.Ц.Цыбиков -Избранные труды, Том второй, Новосибирск-1991.

Гучин зургаат тайлбар толь. УННС-д.

Монгол-орос-латин-төвд-хягад хэлээр хавсарсан ургамлын нэр томъёо. №89-90, УБ, 1970.

Баавтай Ч, Бодсайхан Б -Монголын уламжлалт анагаах ухаан. УХГ , УБ, 1990.

Хайдав Ц, Шерхан О. -Монгол ардын эмнэлэгт хэрэглэгдэж байсан зарим эрдэс. УБ, 1975.

Словарь иностранных слов, Издание седьмое, М, 1980.

Д.Дагвадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ, 1995.

Д.Цэрэнсодном. Монгол Данжурын төгсгөлийн шүлэг, “ХЗХ”, боть УШ, УБ. 1970.

АВАДХУТИ сам. avadhuti; мо.б. avadhuti; Хүний биеийн хураагуур судас. Дандрыг (үз) судалж, өөрийн бие дэх цусны эргэлгэд ухаанаа төвлөрүүлснээр дээд хэмжээнд хүрсэн хүнийг хэлнэ.

АВАРТА a-warta(сам.) мо.б. avarta; Хорин хийн өвчний нэг, нуруу бөгтийж, амьсгаа давхцан, мэдрэл алдах зэрэг шинжтэй.

АВГА манж. abuha; мо.б. abuū-a; Иш шударга, навч дүгрэг, маш илбэрүү, хатуурахын урьд навчийг авч холимог хийж идэх ногоо.

АВИД сам. Amithābha; мо.б. abida; “цаглашгүй гэрэлт”; Сухаавадийн орноо ном номлон суудаг язгуурын таван бурхны нэг. Аминдавааг үз.

АВИДАРМА сам. abhidharma; мо.б. abidarm-a; “илт ном”; Бурхны шашны зарлиг номуудын гурван аймаг савын нэг болох сав шим ертөнцийн тогтоц, бодит үзэгдлийг танин мэдэх асуудлыг багтаасан доод хөлгөний ном.

АВИЙЗ сам. abhijit; мо.б. abiži; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг, матрын ордын таван од. Монголоор Дуулагч өнчин одон гэнэ. Бас Яруу эгшигт од ч гэнэ. Авижи ч гэж бичдэг. Эрт цагт авижи однаа төрсөн нэгэн хүмүн далайгаас эрдэнэ аваар одож бөлгөө (Раш.дус); 2. Энэтхэгийн зуны эцэс сар, цагийн хүрднээ зуны дунд сар, хятад, төвдийн намрын эхэн бичин сар, монголын долдугаар сар.

АВИРД сам. amṛta; мо.б. amrita; амрита-авирд, м~б; үүрд, ашид, насад, өнид.

АВРАЙ a'bras<сам. abhra буюу amraphala. мо.б. abrai; Torreya nucifera; Ratan Valamus Rotang; Их бие том биш, навч гишүүнийх лүгээ адил, шүхэр хэлбэрийн цэнхэр цэцэгтэй модонд ургадаг, зууван урт, бугын засаатай төсөөтэй, исгэлэн амттай жимсний гонзгой бөөрөнхийдүү, бор хүрэвтэр хальстай үр, эмнэлэгт хэрэглэнэ.

АВШИГ сам. abhiṣeka, мо.б. abiśig “эрх олох, эрх өргөхүй”, 1. эртний Энэтхэгт шинээр хаан ор суухдаа дөрвөн мөрний ус буюу рашааныг толгой дээрээ цутгаж төрийн эрх барих эрхийг олох зан үйл; ...Дөрвөн Махаракхаан бууж ирээд хүжсийн усаар дүүрсэн хумх бариад оройд нь авшиг өгвэй. (ул.далай); 2. нууц хөлгөнөө, мандалт толгой дээр ус цутгаж нууц үндсийг сонсох,

номлох, бясалгах эрх олох буюу тарнийн үүдэнд орох зан үйлсээр эрх өргөмжлөх ёс; 3. эрдэм чадалтай мэргэн багш нар хамаг амьтанд тус үйлдэх үүднээс ван тавьж номын хурим үйлдэх ёс. Авшиг хүртээгч нь найман эрх баялагийг эзэмшишэн байдаг. Биеийн эрх баялаг (бие хувилах нь цаглашгүй), Зарлигийн эрх баялаг (хэлний мэдлэг), сэтгэлийн эрх баялаг (аттаг сэтгэлгүй), рид хувилгааны эрх баялаг (хувилгаан шинжтэй), хүслийн эрх баялаг (хүссэн хүслээ хэрэгжүүлэгч), орны эрх баялаг (орон, цаг, ахуйн учрыг ухаарагч), үүсгэгчийн эрх баялаг (сав шим өртөнцийн сайн төрөл ологч), эрдмийн эрх баялаг (арван эрдэмд төгс байх) эдгээр болно.

АВЬЯАС сам. *abhyāsa*; мө.б. *abiyas*; 1. мэдрэхүйн эрхтэнд урьд өмнө тусгагдсан юм хүнд дадал болж, түүнээ бүрэн гүйцэтгэж, хийж чадах чадвар; *Уран гарын авьяасаар урлагийн шижир бүтээнэ* (*Б.Я.*); 2. терөлхийн хүсэл дурсил; авьяасжих (авьяас чадвар нь улам нэмэгдэх); авьяаслах (авьяас нь илрэн гарах).

АГ I түр.ац; мө.б. аү; Буурал, цагаан; аг буурал хорш. *Агийн* (*Буурлын. О.С.*) өндөр давааг, алтанхан шаргаараа туулна. *Аг* (*буурал.О.С.*) л буурал аваасаа арайхан хол сууна л (*МААЗДБ*).

АГ II *sngags*; мө.б. аү; "тарни"; Бурхны шашны ёсны уншлага залбирлын үйл; агийн ном (тарнийн ном); аг тарни хорш. *Санж гэцэл тэрхүү аг ёсны номыг нэг л удаа холоос харсан юм сан* (*Л.Т.*)

АГААР сам. *akara*, мө.б. аяаг; "эзэлхүүн, орон зайд, бөмбөрцөг"; 1. хийн мандлыг бүрэлдүүлдэг азот, хүчилтөрөгч зэрэг хий; 2. аливаа хэлбэрт бодсын үүдэх оршиход үл торох зайд, огторгуй; 3. аливаа орон зайд, багтаамж; 4. мөн чанар, эх үүсгэл.

АГАМ сам. *āgam*; мө.б. *agam*; 1. уран илтгах хэлбэр, урнаар өгүүлэхүй; 2. уламжлалт сургаал номлол, ариун ном; ...*агам юги номууд-тор сайтар дадсан...* (*турф.*).

АГАР сам. *agru*; мө.б. *agru*; *Aloe arborescens*; *Aquilaria agallocha Roxb*; нимгэн цаас шиг долонтой, хайрслаг шилмүүстэй, хөхөмдөг, бараан цэнхэр, шар зэрэг өнгийн цэцэгтэй, сайхан үнэртэй анхилмал тослог ургамал. мөнх ногоон мод буюу бут, олон зүйл буй.

АГАСТА сам. *agastya*, мө.б. *agasta*; Алтан гадас од (*Ков*).

АГБУУСВАА сам. *nāgapushpa*; мө.б. *a/busba*; Халуун орны жимс, боловсорсон хойноо хүрэн өнгөтэй, хадгалахад дотроос нь тахианы өндөг шиг арван жимс гардаг, ховхолж идэхэд тун

амттай, дунгуа шиг том. Угтаа самгардийн наагапүшпа гэдгийг монгол бичгээр бичихдээ н үсгийн дуслыг орхисноос ингэж дуудаж бичих болжээ.

АГЛИ тө. *ag lig*; мө.б. *agli*; Харгай модны дурснаас ургасан ур, ардын эмнэлэгт дотрын өвчнийг анагаахад хэрэглэх ба бас малын дайранд тавьж эмчилдэг.

АГНИ сам. *agni*; мө.б. *agni*; "гал"; Галын тэнгэр, галайхан, орос хэлний огоны той гарал нэг. Эртний энэтхэгчүүд гол бол дөл утаагаараа хүмүүсийн өргөлийн зүйлс болох ариун зоог гүнцэг, алийн нандин ундаа тэргүүтнийг тэнгэр бурхад хүргэж өгдөг гэж үздэг байжээ. Бас агнийг хүсэл эрмэлзэл буюу сайн сайхныг авчрагч бүрэлбаа төдийгүй хамгийн ариун зүйл, ад түйтгэр бүхнийг хөөн зайлцуулагч гэж үздэгээс Агни тэнгэр шүтдэг ажээ. *Алдар сүлд мөнх түрээмэл, агнийн өлзий хутаг орш* (*Зуун бил*); Агни хан (Галайхан); *агни хан гэгдсэн галыг ариутгал чанартай гэдэг ээ* (*МШЯН*); агни бузартах (галд ус асгаж гол унтрааваас хар бузар, цус махны шөл асгаваас улаан бузар, сүү, айраг, дарс тэргүүтэн дусааваас цагаан буртаг болохыг хэлнэ).

АГНИСДА сам. *akanışha*; мө.б. *agnista*; Бурхны шашны цадигт гардгаар дөтгөөр дияаны их бусын орон, үл зовоогчийн орон, хотол төгссөний орон, маш үзэхүйн орон, доор бусын орон нь хутагтны таван ариун орон буюу. Эдгээрээс дээр таван зуун нумны турш дававаас таван магад лугаа төгссөн төгс жаргалангийн бие суух орон болох үзэсгэлэнт агниидын орон бий гэнэ. Энэ орон нь бурхан бүхний төгс жаргалант биесийг олох газар, Түүнчлэн ирсэн бурхны суух магад орон гэнэ.

АГРАМБА тө. *sngags rams ra*; мө.б. *a/gatamba*; Бурхны шашны ёсны тарнийн аймаг номлолд мэргэжсэн хүний эрдмийн дээд зэрэг, тарнийн ухаанд суралцах жуд дацанд 10-15 жил суралцаж учир ёсыг ухаарч байж аграмбын дамжаа барьдаг.

АГТ түрэг хэлний ат гэдгээс үүссэн үг.

АГЧИМ агшин гэдэг үгийн ойрад аялгуунд хувирсан хэлбэр. *Агчмын зуурт арван гурав хувилдаг...* (*Жан.*)

АГШАЙ сам. *aksaya*; мө.б. *a/sai*, *a/say-a* (*Ков*); 1. төгсгөлгүй, мөнхийн; 2. жаран жилийн хорьдуугаар жилийн нэр, мөн билгийн тооллын дөрөв, долдуугаар өдөр.

АГШИН сам. *kṣaṭa*; мө.б. *gsan*; 1. эртний энэтхэгийн гүн ухааны ёсоор алийн юмс үзэгдлийн үүсэх, эвдрэх хугацааны хамгийн бага нэгж; Энэ хэмжээг энэтхэгт нүдний ирмэх хугацаа,

төвдөд инчдэлийн дууны тавны нэгтэй тэнцэх хугацаа, монголд инчдэлийн аравны нэг хувь гэж тус тус ойлгож иржээ. *Мянга мянган жилийн бясалгалаас сэрэх алтан агшин дөхсөөр амуй* (*О.Д.*); 2. хором, нүд ирмэх зуур; агшин зуур (нэн охор хугацаанд).

АД сам. *ata*; "хорт санаа"; түр. *ada*; мөб. *ada*; 1. муу сүг, чөттөр; ад зэтгэр хорш; ад нөхцөх (сэтгэл оюун нь гажих); гаригийн ад (гал, ус); *Үтэл аднууд түүнийг сахина гэж номлосон мэт* (*Суба.*); 2. этгээд, гажууд; ад үзэх (шоодон шоовдорлох); *Мал зуу хоновол ижил болно, хун зуу хоновол ад болно* (*Ж.Л.*).

АДАГБАА тө. *mnga' bdag ra*; мөб. *ada*; Сиккимиийн хаадын угсаагаар түшиг болгосон хэд хэдэн сүм хийдэд баримталж байсан шарын шашны нэг жижиг салбар.

АДАМБАЛ түр. *admala*; мөб. *adambala*; Шар цэцэгтэй, зургаа долоон талт цөмөтэй, гашуун боловч амттай, лис жимстэй адилаутар жимс.

АДИС сам. *ādiśa*; мөб. *adis*; Аврал өршөөл, тус соёрхол бий гэж итгэх шашны ёсны баримтлал; мутрын адис, сунтийн адис, бурхны адис гэх зэрэг буй; адис ажис (их эрдэмтэй зүйл); адис авах (а. адис гүйх санаа; б. лам багш, бурхан шүгээнээс зулай дээр адис өгөхийг гүйх; в. ямар нэг юмыг хүндэтгэн зулайд хүргэх); адис өгөх (мөргөх хүний зулайд мутар, бурхан, ном хүргэх ёс); адислах (адистидлах).

АДИСТИД I сам. *adhiṣṭhita*; тө. *byin rlabs*, мөб. *adistid*; Монголоор бас жанлав ч гэнэ. Өршөөл аврал, хишиг соёрхол гэсэн утгатай. Бурхны номд хамаг амьтныг ивээн өршөөх гэсэн утгаар хэрэглэгдэнэ. Адистид нь аливаа сүсэгтэн, шавь нар лам багшаасаа буюу өөрийн үйл бүтээлээр олж авсан сэтгэл санааны хүч чадлыг хэлнэ. Амьтны сэтгэл үнэхээр тусгайлан бүтээгүй, амьтанд байdag сэтгэл дээр хамаг эрдмийг үүсгэж болох, тэрчлэн хамаг түйтгэрийг тэвчиж чадах хүч чадал, шалтгаан нөхцөл бүрдсэнээр болон номын чанар олсноор үл доройтох ажээ. Иймд адистид бол сэтгэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхийг хэлнэ. Адистид нь: 1. үнэний адистид (*bden pa'i byin rlabs*); 2. өглөгийн адистид (*gtong ba'i byin rlabs*); 3. машид амируулахын адистид (*ne bar zi ba'i byin rlabs*); 4. билгийн адистид (*ses rab kyi byin rlabs*) хэмээх дөрвөн зүйл байна. адистидлах (а. юмыг ариусгах, сэтгэлийн хүч чадлыг нэмүүлэх гэж итгэн тарни урьж шивших зан үйл; б. адис өгөх).

АДИСТИД II: адистид тавцан сам. *adhiṣṭhita*; мөб. *adistid*; арслангийн ордын гурван одны нэр.

АДЬЯА сам. *āditya*; мөб. *adiy-a*; Ням буюу наран гариг.

АЖАГ тө. *a byag*; мөб. *a jaū*; Навчны зах ширүүн, өргөслөг, ар газар буюу зүлгэнд ургах өвслөг ургамал. Хатгалтыг дарагч ажаг (тө. *a byag gzer ſjoms*); хөх өргөст ажаг (тө. *a byag tſher sngon*) гэж хоёр зүйл бий. Бас цэцгийн өнгөөр нь улаан ажаг, шар ажаг гэж ч нэрлэдэг. Ажиг ч гэж бичдэг.

АЖИНА АДИСТИД II тө. *a dici na* < сам. *ājina*; мөб. *ājin-a*; Хар гөрөөсний сахлаг үстэй арьс. Шашны сургуулийн шавь хуврагууд ор сандлаа бүтээдэг.

АЖИНАЙ сам. *ājaneya/ ājnaneuya* мөб. *ājinai*; "лавтай мэдэгч, "лавтай мэдэгч, аюулгүй"; 1. билгийн морь, маш дээд төгс, эрдэмт билгүүн морь, хүний хэл мэддэг тэнгэрийн хүлэг гэж домогт гардаг; 2. хэв яс сайн, явдал ялгуум, алхам сайн, сүвэрэгэний хоёр талын хавирганы матаас гуянаас гадуур харагдах, дөрвөн хөлөө цүг цүг гишгэх хурдан хүлэг; 3. Монгол улсын цог хийморийн билэгдэл болгож, төрийн сүлдэнд залсан эрдэнийн хүлэг. *Ажинай моринд зэмсэг болсон, атаат дайсанд сүр болсон...* (*Зуун бил.*)

АЗ түр. *az*, мөб. *aja*; зол завшаан; хорш.аз жаргал

АЗАР I тө. *a.tsa-ra*<сам. *ācāgva*. мөб. *ajag*; 1. Энэтхэг газрын их багш; азарын хэл (энэтхэг хэл); 2. Вээдийн үеийн ном судар үншигч, номлол айлдагч; 3. их эрдэмтэн.

АЗАР II: азар үхэр; мөб. *ajag*; толгойдоо өтгөн сахлаг үстэй үхэр.

АКАШ сам. *ākāśa*; мөб. *akaš*; тэнгэр, огторгуй; *Ариун тэргэл саран нүүрт, akaš дахь одон мэт нүдээт* (12 зох.) .

АКШОБИ сам. *akṣobhya*; мөб. *aṣobhi*; "Үл хөдлөгч"; Тэгүнчлэн ирсэн бурхны нэг. Улэшгүй харшийг үүсгэх нь бяруузанын үе, даган тачаахуй нь Базарсадын үе, авшиг өгөхүй нь Акшобийн үе, рашаан амсах нь Авидын үе, тахил өргөх нь Амогасидийн үе, магтахуй нь Раднаасамбхавын үе гэдэг. Акшоби бурхан дорно зүгийн ариун орон Абиради улст ном номлон суудаг гэнэ.

АЛ I тө. *mngal*, мөб. *ala*; "сав, умай"; 1. хүний бэлэг эрхтэн; 2. хүний салтаа буюу өмдний салтаа.

АЛ II түр. *al*; мөб. *al*; ал шар; гал улаан өнгө, хурц улаан; Галын сорыг түргээр алай-алаз гэнэ. Монгол хэлний гал гэдэгтэй гарал нэг; ал харш (номын шар хувцас).

АЛАГ түр. alaq; мө.б. alaq; al- (улаан)+aq(цагаан); 1. хоёроос доошгүй өнгө холилдсоныг нь; 2. тэгш биш, өөр өөр; алаг булаг (а. алагтай ажил; б. янз бүрийн өнгө холилдсон нь).

АЛАМ түр. alma; мө.б. alam/alma; Хонины хаашаа, хот хүрээ; *Алагчuurд хонилыг адуулж, алам дүүргэсү (МНТ)*.

АЛАНГАР сам. alaŋkāra, мө.б. alangyar; (Ков.); "чимэг", чимэглэл, гоёл.

АЛАЧУХА түр. alcıqa; мө.б. alçıq-a; "майхан, овоохой" Ядуусын орогох оромж буюу шургаагаар барьсан түр сууц, бүхээг, өөвөн гэр ч гэдэг.

АЛБИН уй. albasti; гер. ahalmani; мө.б. albin; Улгэр домогт гардаагаар улаан өнгөтэй, улаац гуу жалганд орших нэг зүйл ад; ад албин; "Субашид" (Сономгара)-ын орчуулгад ablin (l~b) гэж гардаг. албины гал (шөнө үзүүгдэх хөх гэрэл, амьд бодос ялзрахад үүсч ноцсон гэрэл).

АЛГИНЧЛАХ манж. alyiŋ; мө.б. alyincilaqu; "алдар" гэсэн утгатай; тагнах турших; ...*Тийн хэмээгээд Чингис хаан өөрөө алгинчилж Хасрыг гол засуулж. (МНТ)*.

АЛИГАЛИ: али галийн үсэг; сам. ali + gali (эгшиг+гийгүүлэгч); Аюуш гүүшийн галиг үсэг. Самгарди хэлний үсгээс эх авч зохиосон арван зургаан эгшиг, гучин дөрвөн гийгүүлэгч. Али галийн үсгийн арга билгийн мөн чанар ч гэдэг.

АЛИС манж. alisun; мө.б. alisu; 1. хөх өвс; 2. үрлэж боловсроогүй үед ногооноор нь хонгорцогтой нь хадсан буурцагт тарианы өвс.

АЛИУС алистой гарал нэг. мө.б. aliasu; 1. үр тариаг хадахад газар унасан үрээс гарсан өвс; 2. үерт автуулж дахин ургасан өвс.

АЛИШАМ зарим эрдэмтэд энэ үгийг алим, алма, алмарад, алис, алиус, алирс зэрэг үйтэй гарал нэг гэж үздэг. Үгтаа самгардийн налишам (үз) гэдэг үгийг монгол бичгээр тэмдэглэхэдээ н-ийн дуслыг орхисноос болсон гэх нь зохистой.

АЛМАРАД перс. almurat; мө.б. almurad; Нэг буюу олон наст ороонго ургамал, улаан шаргал өнгөтэй, амтлаг, гонзгойдуу хэлбэртэй махлаг жимс.

АЛМАС ар. перс. almas; уй. almas, хинд. almāsa; мө.б. almas; 1. монгол ардын домогт эм шулам, айсхий, муус эмгэн гэсэн утгаар гардаг; 2. хүн дүрст нэг зүйл амьтан буюу цасны хүн; 3. өнгөгүй тунгалаг, онц хатуу чанарын нэг зүйл эрдэнийн чулуу.

АЛЦАА I тө. mingal chags; мө.б. alčay-a; Хоёр гуяны хоорондох газар буюу өмдний хоёр гуяны хоорондох газар, салтаа ч гэнэ.

АЛЦАА II алаачуха, мө.б. alčay-a.

АМАНГАЛ сам. amanγal; мө.б. amangyal; өлзий бус, ээл ивээлгүй, бэлэг дэмбэрэлгүй; ...зэмдэг амангал муу бэлгэсийг арилгаж... засуулвай (12 зох.).

АМАР I сам. amaga, мө.б. amur; (Ков.) "үхэшгүй, мөнхийн"; 1. энх түвшин, зовлонгүй, тайван; 2. дүү хүн ахмад хүнтэй мэндчилэхэд хэрэглэх үг.

АМАР II сам. āmra > хинд. ām; мө.б. amr-a; Citrus Medica; Mangifera; 1. Өмнөд Азийн халуун оронд ургах жижиг жижигхэн цэцэгтэй, гялалзсан ногоон навчит мод; 2. шар ногоон хальстай, дотроо анхилуун үнэртэй, эхүүндүү амтлаг, нялцгайдуу улаан шаргал жимс. Монголоор анхилзгана гэж нэрлэх ч бий; *Тэр цагт тэр охины гарг нь амрын нэгэн жимс барьсан ажтуу. (Үлдалай)*.

АМБАА манж. amba; мө.б. amba; "их"; 1. аавын үе тэнгийн ахмад хүнийг хүндэтгэн дуудах нэр; 2. амбан.

АМБАН манж. amban; мө.б. amban; "том, их"; 1. Манжаас монголд суулгаж байсан төлөөний сайд; Улиастайн амбан, Хүрээний амбан, Ховдын амбан гэж гурван амбан байв; амбан хот (Хятад улсын одоогийн Хайлаар хотын хуучин нэр. Амбан ноёны суудаг хот байсан учир ийн нэрлэж байжээ.); амбас (амбаны олон тоо, амбасын яам); амбасын үеийн юм (их дээр үеийн юм); 2. их, том; амбан шар (нас гүйцсэн шар); 3. нэг улсаас нөгөөд суух захирагч; амбан захирагч.

АМДОО тө. a mdo, мө.б. amdoa; Төвдийн дорно өмнийн хувьд орших Хөх нуурын газрын нэр.

АМИНДАВАА сам. Amithābha; тө. 'od dpag med; мө.б. Amindava; "цаглашгүй гэрэлт"; Язгуурын таван бурхны нэг, урт насны шид увдис соёрхогч Авид бурхан.

АМРИДА сам. amṛita; мө.б. amṛita; "үхэшгүй, мөнхийн"; 1. үхэшгүй, үүрд мөнхийн; 2. домгийн ёсоор анх бурхад, асуурь нар сүүн далайг булж гарган авсан мөнхийн ундаа, бурхдын идээ буюу рашаан. Дундад үеийн монгол бичгийн дурсгалд тааралдана.

АНАВАД сам. Anavatapta; мө.б. anabad; "үл бүлээдэгч"; Кайлас уулын өлмийд орших ариун шүтлэгт Маансаровар нуурын эртний нэр. Төвдөөр tarphat (эс бүлээдэгч), mtso (далай) гэдэг. Нарны тугаяаар бүлээсдэггүй далай гэсэн утгатай. Монгол аман, бичгийн зохиолд дайралдана. Элдэв эрдэнэсээр цогцолсон Сүмбэр уул

МИНЬ, энд тэндээс олон мөрөн цутласан *Анавад* далай минь (*A.to*).

АНА МАНА тө. ap тан; мо.б. an-a man-a; 1. хүч тэнцүү байдал; 2. бараг адил, яв цав.

АНАМАД анавад; мо.б. anamad; *Анамад мөрөн далай аль талаар урссан бэ?* (*МААЗДБ*).

АНАЛ сам. anala; мо.б. anala; тал.

АНАР I уй.тур. anag<перс.nag<сам.nātangas; мо.б. anag; Дугариг ногоон навчтай, шүхэр хэлбэрийн дэрэвгэр модны цэвэрхэн цагаан цэцгийн хулуу шиг үрийн оронд үрийн оронд хэсэг хэсгээр байрласан үр, амт исгэлэн, үр мөхлигт хүрэн бор өнгийн жимс. Сэмбэрүү ч гэдэг.

АНАР II перс. anār, мо.б. anag; Amethyst; нал эрдэнэ; Бадмаартай адил боловч арай хүрэндүү буюу үзэмний шүүс мэт өнгөтэй, олон талст бүхий. Сайтар өнгөлсөн анарыг лавай дээр тавихад дээр нь галын дөл мэт өнгөтэй, гэрэл цацаардаг гэж хэлэлцдэг ба түүгээр хөөрөгний толгой, гоёл чимэглэлийн зүйл хийнэ.

АМБАРАЙ аврай мо.б. angbarai; төвдөөр a'bras гэх ба үүний шанаган а (')-ийг хамаршуулан дуудсанаас ингэж бичих болсон бололтой.

АНВАН манж. anwan; тур. aluwan; мо.б. angvan; Хавтгай биетэй, шар цоохор, нуруундаа ганцхан сэлүүртэй нэг зүйл загас.

АНГАРАГ сам. aṅgātaka; мо.б. angyaga; Мягмар, улаан нүдэн гариг. Гал гариг ч гэнэ.

АНГИ тө. ang ge; мо.б. anggi; 1. сургуулийн хичээл хийх өрөө; 2. бүлэг хэсэг, салаа салбар; 3. шилж. тусгай, онцгой; этгээд өөр; анти дамба (тө. ang ge dan po, "тэргүүн зэрэг", суралцаж буй зиндаандаа ном хаялцаад шалгарсан хүнийг хэлнэ.

АНГИР тө. ang gir; мо.б. anggir; Задгай ус бүхий газар цагааар сэлгэн нүүж, нутаглах шувуу. Цагаан толгойтой, гал шар өнгөтэй, усанд шумбах хөвөх нь чадамгай. Лам шувуу ч гэдэг; Ангир шар уураг (эхийн хөхний сүү).

АНИА манж. aniya; мо.б. aniy-a; "он", "жил" буюу цагаан сар гэсэн утгатай. Монгол хэлэнд төрлийн доторх ахмад хүмүүсийн нэрийг цээрлэх хүндэтгэлийн үг.

АНИР түр. anir; мо.б. anir; 1. Дуунаас дам дам доргиотон гарах шутиан; чимээ анир. хорш; 2. сураг чимээ, мэдээ занги.

АНОА ор. apoa (лат. apoа); мо.б. anu-a; Нэг зүйл зэрлэг үхэр. Индонезийн Целебис арлын уулархаг газарт орших одой одос.

АНУСВАР сам. anusvara, мо.б. anusvar-a; "оройн дусал" (Ков), үсгийн дээр тавих дусал, цэг.

АНУУРААД сам. anurādhā; мо.б. anurad; Анурад ч гэдэг. Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг, хилинцийн ордын дөрвөн од. Нэгэн эм есөн эрийг дарах одон гэсэн монгол нэртэй. Бас Гар од ч гэнэ. *Хилинцийн дөрвөн од ануураад гялалзанхан харагдана биш үү?* (*Л.Т.*)

АНХИАН манж. anghiyān; мо.б. angkiyan; Хавтгай өргөн биетэй, нарийн сүүлтэй, дээрээ хоёр бяцхан далбаатай, далайн ёроолын хортой амьтан, мах тэжээллэг арсыг элдэж юм хийнэ.

АНЧАР сам. anucara; мо.б. ančīr; 1. боол, харьят албат; 2. хорт давирхай гаргадаг мод; ...харгис харуул мэт анчар хорвоод ганцаараа шиг зогсоно. (*Д.Н.*)

АПАРАВАКТРА сам. aparamavaktara; мо.б. aparamavagtar-a; Самгарди яруу найргийн дөрвөн мөр шүлгийн хэмжлийн нэг нэр.

АРАВНАЙ тө. gab gnas; мо.б. gabnai; "сайтар оршуулах", Сүм дуган, бурхдыг ариусган машид батаар оршуулах буюу амь оруулан тахих зүйл болгох зан үйл. Өөрөөр хэлбэл сүсэгтний сүсэглэдэг бурхдын зураг хөрөг, баримал цутгамлыг эзэн биед нь оруулж, дүрийг тодотгон, тахиж байх биет шүтээн болгос ёс. Аравнайлах (сүм хийд, бурхны хөрөг баримлыг ариусган амилуулах); аравнай уншилага (дэлгэрэнгүй ба хураангуй аравнайг уншин ариутгаж, сүм хийд, бурхдыг биет шүтээн болгож ариутгахын тулд унших уншилага).

АРАВНАС аравнай; төвд бичлэгийг нь дөрвөлжин бичигт үсэгчлэн буулгасан хэлбэр.

АРАМ сам. ram; мо.б. gam; Бурхны шашны ёсонд бурхан болгон нэг нэг үсгээс үссэн гэдэг. Галын бурхныг Рам үсгээс гарсан гэнэ. Монголын уламжлалт хэлзүйн бичгүүдэд ра- үсгийг гал махбодтой гэж үзэж ирсэн нь үүнтэй холбоотой; *арам үсгээс эгудсэн ... (Зуун бил.)*.

АРАНЖИН: аранжин зэс тө. rang byung zangs, "өөрөө гарсан зэс", сам. gañjana; мо.б. aranjin; "улаан, улаан шаргал"; цэвэр улаан шаргал зэс, улаан хүнцэл ч гэнэ.

АРАНШИН тө. rang bžin, сам. svabhāva; мо.б. arangśin; "өвөрчлөн"; 1. аливаа юмын мөн чанар, төрөлх шинж; 2. зан ааш, ааш авир.

АРАТА ЗАНА Дэванагарын а-га-та ја-на таван үсгийг хэлэх бөгөөд энэ нь Бурхны номлосон таван язгуурт үсэг болно. Манзшир бурхныг бас ялгутсан бүхний ганц уг гэтэлгэгч таван язгуурт бурхан гэдэг.

АРВАЙ түр. arbai, уй. агра; м.б. arbai; Амуу тарианы сүрэл түрүүт ургамал, үрээр нь гурил хийж, шар айраг иsgэн, охь нэрнэ.

АРВИС: арвис тарни; түр. arbīš < сам. ārvījā; м.б. arvíš; 1. их гэрэл гарган, олон амьтныг аюулаас хамгаалах шившилэг тарни; *Нууц тарни, арвис тарниар хүлж, оройгоос төрсөн хаан нөхөд сэлт явж эс чадвай* (*Ул.далай*); 2. мэдлэг, ухаан; арвис ухаан.

АРГАМАГ түр. arqamaγ, м.б. agamaγ; Дундад Азийн цэвэр угсааны морь, одоо бол гоёмсог цэвэр галбиртай морийг магтаж нэрлэсэн нэр.

АРДИР сам. ardra; м.б. ardir; Тэнгэрийн түвшний цагирагийн шадар бүхий хамтдахын ордын гялбалзсан гурван од. Жуулчин од ч гэдэг, бас Усанд алдсан шумнасын одон буюу Хэрцгий охин ч гэнэ.

АРИГ түр. ari- (цэвэрлэгдэх), ariγ (цэвэр, ариун, нандин), тува. ari, ariγ (цэвэр, ариун); уй. erik, бур. ariγ (цэвэр), ариун (цэвэр, цэмцгэр), м.б. ariγ ariyun; 1. цэвэр тунгалаг, цэнгэг, буртагч; ариг ус; 2. арви гам.

АРИМ тө. а-гэ-па; м.б. aitim; (сам. ari); "ад, зэтгэр, муу сүнс; чөтгөр" 1. түүхий гурилаар хийсэн эрлэгийн есөн яргачингийн сүг дурс. Хүний сүнсийг дуудах үед саванд хийж битүүмжлээд, эргэн тойронд нь есөн хувраг зогсож, тусгай уншлага үйлдсэний хойно гадагш гаргаж хаяд алх сухээр бяц цохин устгадаг. *Туламнаас сүтнүүдийг дахин асгахад таван арим уруугаа харан ойчжээ.* (*Л.Т.*); 2. хачин амьтан, хар мангас гэсэн утгатай муу хараал уг; 3. шилж.. үл бүтэх этгээд; хуумгай хүн.

АРТАСЭД сам. arthasiddha, м.б. artasidi; "тус бүгсэн", Шагжамуны эцэг эхийнхээ гэрт байх үеийн анхны нэр. Сиддхаартыг үз.

АРУР тө. а-ги-га, м.б. agur-a; Terminalia bellerica; Халуун орноо ургадаг нэг зүйл модны үр. Дотроо ястай, ясны дотор тослог идээтэй, эхүүн амт бүхий, хоёр үзүүр шөвгөр, гонзгой бөөрөнхий хэлбэртэй. Вишнү тэнгэр хүрдээр дэлдсэнд Раахын

хүзүү тасрахад рашаан үсэрснээс арур ургасан гэдэг домогтой. Энэ нэрийн утга нь анагаах увдис агуулсан гэж эмийн сударт гардаг. А- нь үсгийн тэргүүн учир өвчин бүхнийг үүсгэгч хий, шар бадгана зэргийн гэмийг, -ру нь "мянган чадал төгс" гэсэн утгатай тул гурван гэмийн өвчнийг -ра нь бодь гөрөөсний эвэр мэт, долоон тамирын өвчнийг тус тус арилгана гэсэн байдаг. Тийн ялгуугч арур, аюулгүй арур, рашаан арур, арвигтагч арур, хатангир арур, шөвгөр хушуут арур, очижхэн хар арур гэсэн долоон зүйл бий. Хамгийн дээд нь намжил арур (*тө.гнам rgyal аги-га = Тийн ялгуугч арур*) болно.

АРХАД тө. arhad < сам. arahanta < aghana, "дайныг дарсан", м.б. arqad; 1. нисванисыг тэвчигсэд. Бага хөлгөний дөрвөн бодгалийн нэг, нисванисын хорыг дарж, амирлуулан бага хөлгөний үзүүр ёс архадын үриг олжээ. Архадад шарвааг, братигбуд хоёр орно. Хүний үйл, нисванис, үл мэдэхүй зэрэг сэйтэхүйн хөгжилд саад болдог аливаа зүйлийг гэтлэн давснаар "дайныг дарагч" буюу архад болдог гэж Бурхны шашны гүн ухаанд өгүүлдэг. *Бурхан-бээр түүнд дөрвөн үнэний ямарваа ном үзүүлсэнд архадын хуттийг олвай.* (*Ул.далай*); 2. бурхан багшийн эрдэмт мэргэн шавь нар.

АРХАНД: архад; *Бас Модгалаяна тэргүүтэн арханд-тор-бээр зовлон буюу. (Турф.)*

АРХИ араб. araqi, уй. arki, м.б. araki; Дал модны шилмүүс буюу тутрагаар хийдэг согтууруулах ундаа, охыт унд.

АРШИ сам. ḥṣi, тө. drang strong, м.б. arši; "шударга залагч"; Үзэл бодол, явдал, бясалгал гурвын шударга мөрт бие, хэл, сэтгэл гурваа өгөхүйеэ залан үйлдэхийн учраас шударга залагч гэжээ. Арши нь аглагт сууж, бясалгал хийн, рид хувилгаан, эрдэм увдис сурсан хүн. Бас даянч хувилгаан ч гэнэ. Аршийн манлай, их арши, дээд арши (Бурхан багшийн цол); 2. вээдийн домгоос монгол домогт орж ирсэн бясалгалыг эрхшээгч тэнгэр; Арши тэнгэр.

АРШИМ оп. аршин; м.б. aršim; (*Ков.*); 1. хагас алд буюу ойролцоогоор 71 см-тэй тэнцүү.

АРЬСУУ: арьсуу (арьсан) бөднө; манж arsu; м.б. ārisu; Нэг зүйл бөднө шувуу буюу тогоруу шувууны нэг зүйл.

АРЬЯА сам. āgavalō<āgavalokita; тө. rgyan ras gzig, м.б. ariγ-a; "хутагт өршөөн үзэгч, мэлмийгээр үзэгч"; Хонсим бодьсадва; Арьяабал арван нэгэн нигуртай, бусдын зовлонг өөрөө үүрэхээ

илтгэн тэргүүнээ арван нэгэн хэсэгт хуваасан гэх домогтой. Бас маанийн зургаан үсгийг зохиосон гэдэг. Иймд шашны аливаа гүрэм ном уншихын өмнө Арьяабал бурханд мөргөдөг ажээ.

АСАМ ГАРБХИ сам. *asmakarbha*; мө.б. *asam-a garbhi*; (Ков.) маргад.

АСАНГИ < сам. *asamkhyeya*, мө.б. *asanggi*; "тоолшгүй"; 1. авидармаас номлосон тооны нэр, жаран оронтой тоо, ингүүмэл ч гэнэ. 2. хэмжээлшгүй; ...*Амин бие-бээр үл хайрлан асанги галавуудад зургаан бармидыг бүтээн явлаа (12 зох.)*.

АСАР = асуурь; *Осолдохгүй л тэнгэр асар хоёр хүний маягтай гэж ойлгожээ* (Л.Т.).

АСИТАКА сам. *āśitakī*; мө.б. *asitiķa*; Халуун орноо ургах нэг зүйл өвслөг ургамал; *Гар хөлийн үес атирч аситаха ногооны үе мэт... (12 зох.)*

АСЛИС сам. *āślesā*, мө.б. *aslīs*; Тэнгэрийн бүслүүрийг огтолон орших Угсаагийн хүн ордын зургаан одны нэр, хэлбэр нь могойн толгой лугаа адил. Өрнө умрын шижмийн одон буюу үнэг одон ч гэнэ. *Анурад биш аслис гэдэг угсаагийн хүн орд байлгүй дээ. (Л.Т.)*

АСУРИ сам. *asura*, мө.б. *asuri*; "тэнгэр бус" буюу "дарсгүй". Бурхан шашны ёсноо зургаан зүйл амьтны нэг, тэнгэр газрын хоорондох дайнч амьтан. Асурийн чивх (охь архи); Асурийн цус (сармисны илт нэр). Асуурь ч гэж бичдэг.

АТ түр. *ata*, мө.б. *ata*; морь; *agta~ata~ada(sun)*; агталсан морь; адуун сүрэг

АТАВА сам. *ata~adava*, мө.б. *atava*; (Ков.); "үл энэлэгч", Бурхны шашны дөтгөөр дияаны нэр.

АТГАГ түр. *atqaq*, мө.б. *adqaγ*; 1. нууж далдалсан дотуур санаа; 2. сэтгэлийн сэжгээсээ антижирч үл чадах тээнэгэлзэх санаа; 3. далдуур хорсол занал өвөрлөсөн санаа; *аттаггүй* (хар хоргүй); *аттаглах* (далдуур сэжиг хорсол агуулах).

АТУУ манж *ati*; мө.б. *ati*; эм загас.

АТУУХ манж *atiqa*, мө.б. *atiq-a*; эр загас.

АЧАЛ сам. *acala*, мө.б. *ačala*; (Ков.) "Үл хөдлөгч"; хөдөлгөөнгүй үл хөдлөх.

АШВАТА сам. *āsvatta*; мө.б. *āsvata*; "морин оршихуй мод" (Ков.), Инжрийн мод.

АШИВАНИ ашуувани.

АШОКА сам. *aśoka*; мө.б. *ašuki*; "гаслангүй"; сайхан бүсгүйн хөл хүрэхэд салаа мөчруүдээс нь цэцэг жимс гардаг гэсэн домогт мод, бас энэтхэг ардын билэг зүйд залуу насны билэгдэл гэдэг.

АШУУВАНИ сам. *āśvinī*; мө.б. *aśvani*; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг, Шийдмийн турван од буюу нэг хүмүн хязгаар дайсан дарагч одон. 2. энэтхэгийн намрын дунд сар, цагийн хүрднээ намрын эхэн сар, хятад төвдийн нохой сар, Монголын есдүгээр сар.

АЮУШ I: аюуш там; сам. *avici*; мө.б. *ayuši*; чөлөөгүй там. Найман халуун тамын нэг. Бурхны шашны номд гардгаар ширмэн тогоонд буцалгах, хурц сүхээр цавчих, төмөр алхаар дэлдэх, гар хөлд нь гадас шаах, ам хамарт нь халуун ширэм цутгах, араатан жигүүртнээр махыг идуулж, цусыг соруулах зэрэг зүйл зүйлээр тарчилгадаг там ажээ. *Аюуш тамд орохоор нутгэл алдсыг нэгэн эгшинээ нуд ирмэх зуур хийж мэднэ. (Л.Т.)*

АЮУШ II тө. *a-uy-si*< сам. *āyushaman*, мө.б. *ayuši*; Насан төгөлдөр буюу Амин гавьяат; Насны тэнгэр буюу бурхан; Аюуш хадаг (Аюуш бурхны хөрөг бүхий хадаг, эцэг эх, ахмад настан, эрхэм хүндтэй хүнд голчлон барина).

АЯГА уй. *ajaq*, мө.б. *ayaγ-a*; Идэх уухад хэрэглэх, шавар, шаазан, мод зэргээр хийсэн сав; аягалах (аяганд хийх), аягач (урьд цагт хаад ноёдод аяга барих гэрийн зарц).

АЯГА ТЭХИМЛИГ уй. *ajaqqa tekimlig*, мө.б. *ayaγ-a takimlig*; "хүндтэй шүгээн" энэхүү аяга нь бишрэл, сүслэл, хүндлэл гэсэн утгатай, аяга тавагны аягатай холбогдолгүй үг болно. Аяга тэхимлиг нь бурхны шашны ёсонд хоёр дахь удаагаа сахил хүртсэн гэлэн санваартан "аягаар гүйцэтгэгч" гэсэн үг гэж зарим судлаачид тайлбарласан ч бий. *Аялгуу холбон магтагч аяга тэхимлиг Чойжи-Одсэр... (Зуун бил)*.

АЯД, сам. *ayuda*, мө.б. *ayud* (Ков.); тооны нэр, түм. Наяд, аяд гэсэн хоёр үгийг монгол бичигт цэгтэй, цэгтүй хоёр янзаар бичсэнээс нэг л тооны нэр гэж будилж ирсэн нь үзэгдэнэ.

АЯН сам. *ayana*, мө.б. *ayap* (Ков.), "зам, жуучлал"; Алслан явах явдал; аян жин *хорш*. аян шалтаг (ямар нэг зүйлээр шалтаг хийж өөр үйл хэргээс зайлсхийх завшаан олох); аянчин (аян замд яваа хүмүүс); аянших (алс замын явдалд алжаах).

Б

БАА I хя. *ba*; мөб. *ba*; торгууль, шийтгэл; ял; *Албын хар баагаар миний ганц алтан бөлжтийг ... булаан авсан* (*Цэц.*); баалах (торгох).

БАА II хя. *bā*; мөб. *ba*; 1. хулс, тэнз; баа ташуур; 2. хулс бургас зэргээр сүлжин гөрсөн хашаа.

БАА III бааш.

БААЗ орос. база (<фр. *base* < гер. *basis*), мөб. *baayača*; "үндэс, суурь, ул"; 1. нөөц, бэлтгэл; тэжээлийн баазтай болох; 2. түр байрлалын цэг буюу түшиц газар; цэргийн бааз; 3. юм агуулах газар; бараа бааз; 4. нийгмийн эдийн засгийн байгуулал.

БААСАН тө. *pa sangs*; сам. *sukra*; мөб. *basang*; сугар; 1. долоон хоногийн тав дахь өдөр; 2. нарны аймгийн нэгэн өртөнц.

БААШ хя. *bāxī*; мөб. *baayaši*; 1. арга бач; бааштай хүн; 2. илбэ, ховс, жилбэ.

БААЮУ хя. *wa yao*; мөб. *baushi*; "тоосго, туйпуу"; Тоосго шатаах зуух; бааюуны газар.

БАВААСАН тө. *pa-va-sangs*; мөб. *bavasang*; баасан; монгол хэлнээ зөвхөн оноосон нэрийн үүргээр хэрэглэгдэнэ.

БАВУУСЭРВЭ тө. *ba'po ser po*; мөб. *bavusserbu*; "шар баатар", *Scutellarica baicalensis* Georgi; 40-50 см өндөр, олон наст өвслөг ургамал, монголчууд гүүн хөх гэж нэрлэдэг. Ардын эмнэлэгт өргөн хэрэглэнэ.

БАГ I согд. *b'γ* < перс. *bag*, "цэцэрлэг", мөб. *baγ*; цэцэрлэг, ургамлын хүрээлэн. Энэ үг монгол дөрвөлжин бичгийн дурсгалд дайралддаг.

БАГ II тө. *pags pa*, *wags*, мөб. *baγ*; "арьс"; 1. толгой нүүрээ далдалсан хиймэл толгой буюу халхавч; цамын баг (цам харийхад өмсөх догшин бурхад хийгээд амьтны дурсээр хийсэн хиймэл толгой); багт наадам (толгойдоо баг өмсч наадах цэнгээн); багий нь хуу татах (далд санааг нь илчлэх); цамын баг (шавар баримал барьж, түүнээсээ цаасан хэв авч даавуу, цаас зэргийг давхарлан нааж, өнгөлж, будаж чимсэн догшин сахиус, бурхдын тэргүүний дүр буюу эсвэл цамд гарах ямар нэг амьтны байдлыг илтгэсэн дүрс); 2. *шилж* өнгөлсөн халхавч; бамбай; хуурмаг багийг хүү татах; багчин (баг шууж хийгч).

БАГ III тө. *bag*, мөб. *baγ*; (идээ); Хүний ой дурсамжийг арчин баллаж, ухаан санааг балартуулан, өөрт нь холбоотой бүхнийг

мартуулах хар өнгийн хорт идээ; баг идээ; баг идээндээ баригдсан хүн (гэр орны ажил үйлийн төрөл орооццолдсон хүн); *Гэсэр хаан өвөр дээрээ унасан рапшааны нэгэн мөндрийг авч залгиад баг идээгээ бөвлжив* (*Гэс.*).

БАГВААХАЙ тө. *pags ra* *buγi*; мөб. *baγbaqaι*; "сарьсан шувуухай"; Монголоор сарьсан багваахай гэнэ. Урт хуруунуудыг холbosон сарьсан далаачтай, өнгө хар, хулганатай адил нэг зүйл амьтан, шөнө нисдэг. Эртний домгийн ёсоор соёогоо араатанд, далаачаа жигүүртэнд үзүүлж хоёр нутагтан болохоо илэрхийлдэг.

БАГВАР тө. *pag phor~bag phor*; мөб. *baγbor*; "арвайн аяга" (төвдчүүдийн үндсэн хүнс тэжээлд арвайн гурил зонхилдгээс арвайн гурил хийдэг аягаа ийн нэрлэжээ); 1. их төлөв хус мод буюу модны үндсийг ухаж хийсэн, гадуур нь улаан, хүрэн өнгөөр ширдэж, дээр нь алтан будаг суулгаж навч цэцэг, найман тахил зэргийг зурсан хавхагтай аяга. Зочдын өмнө чихэр жимс, шар тос, чавга зэрэг амтат идээ тавихад хэрэглэнэ. 2. зэс буюу мөнгөөр бүрсэн том аяга; *Домботой халуун цайнаас мөнгөлсөн багвар аяганд хийж хүмүүст өглөө*. (*Л.Т.*) 3. *шилж* намхан багдгар гэр.

БАГЛА- түр. *bayla*; мөб. *baγla-*; юмыг боож хүлэх, бэхлэх; *Гээгийг нь баглаж аваад гүйлэн хар моринхоо суулнээс уяв* (*Гэс.*).

БАГС тө. *phag ze*, мөб. *baγsa*; "тахайн хялгас", юманд будаг сэлтийн зүйл түрхэх хэрэгсэл; будгийн багс, багсдах (багсаар юм түрхэх).

БАГЦАД тө. *dpag tshad*, мөб. *baγcad*; найман гөрш буюу нэгэн бээр; *Баруун хойт зүйт наян багцад газарт Шамбалын орон буй*. (*Л.Т.*)

БАГШ хя. *bo-si*, мөб. *baγsi*; эрдэм ном заан сургах хүн, сургагч, номлогч; ажил мэргэжилдээ дагалдуулан сургагч.

БАД I сам. *vaṭa*, мөб. *bad*; *Ficus Indica*; Халуун орноо ургадаг, нэг үндэснээс мөчирлөн гарч, мөчирууд нь бүдүүрсээр биеэ даахгүй болж газар хүрээд дахин үндэслэн тэндээсээ дахин мөчирлөн, мөчир нь бас дахин үндэслэх зэргээр газрын хөрс даган нүүн ургах том навчтай мод. Монголоор "олон хөлт мод" ч гэдэг.

БАД II сам. *vaṭa*, мөб. *bad*; Бад модны навчны дүрстэй төсөөтэй нэгэн зүйл хээ зураг, зулын цөгцний суурь болон бурхны шавдан тэргүүтэнд урласан байдаг. бадтай цөгц, бад хээтэй торго; бадла- (бад гаргах буюу гарах).

БАДАГ сам. *pädaka*, "хөлт буюу өлмийт", м.б. *bada*; 1. шүүгийн доторхи нэг мөр буюу нэг утгат хэсэг хийгээд дууны нэг түрлэг; 2. одоогийн ойлголтоор аялга холбоцын нэг хэмнэлд захирагдаж тодорхой утга илэрхийлсэн хоёр болон түүнээс дээш шадаас бүрдсэн айзам өгүүлбэрзүйн нэгж.

БАДАЛ сам. *padola*; м.б. *badul*; *Scorzonera spp*; Шар өнгийн цэцэгтэй, нарийхан иштэй, таслахад сүү гардаг, навч нь илд адил, эгц шулуухан өвс.

БАДАМГОМБО тө. *pad ma mgon po*; м.б. *badmaγombu*; с. *arvensis*; Сууриараа сум хэлбэртэй, зууван буюу өндөглөг хэлбэрийн навчистай, урт ороогч иш бүхий, том ягаан цэцэгтэй олон наст ургамал. Чөдөр сэдэргэнэ буюу чөдөр өвс ч гэнэ.

БАДАМДОВЖИД сам. *padma + tə. (pad ma) 'dab bryad*, м.б. *badmadobjid*; найман салаат лянхуа", Бадамлянхуа цэцэг найман салаа навчтай гэдэг ажээ. *Бадамдовжид шинжтэй бат сайхан талдаа баян...* (ЗУАЗ).

БАДАН I тө. *ba dan*, м.б. *badan*; 1. банжид, гурван зүйл амьтны дүрс чимэглэлгүй өлгөдөг торгомсог бөсөөр хийсэн чимэг, гурван зүйл амьтны дүрс чимэгтэйг дуаз гэдэг; Бас сум дуганын таазнаас өлгөдөг хөх, цагаан, шар, улаан, ногоон таван өнгийн бөсөөр оёсон өргөн урт тууз. Энэ нь таван гэгээний өнгөний билэгдэл; 2. тут, хиур; *Мөнх газар зүтгээ шашны бадан арван зүг дэлгэрвэй* (МУЗД-I).

БАДАН II тө. *ba dang*; м.б. *badang*; Монгол цайд ордог нэг зүйл өвс буюу цайны ургамал.

БАДАР I: бадар цэцэг тө. *tra<sam.patra*, м.б. *badur*; Модны ишийг түшин ургадаг салхины цахирмаа цэцэгтэй адил шаргалдуу цагаан өнгөтэй цэцэг.

БАДАР II: бадар хээ тө. *ra dra < sam. patra*, м.б. *badar-a*; Угтаа янз бүрийн хээ угалзын зураг дүрс. Уул хаданд ургах бадар цэцэгтэй төстэй нэгэн зүйл хээ угалз. *Бадар уталз адил бачит муу санаа* (ААЗ).

БАДАР III сам. *pattra*, м.б. *badr-a*; 1. том шар навчтай, өндөр ургадаг мөнх ногоон тураг мод, навчаар дэвүүр хийх ба бас юм бичиж болдог. 2. мөн модны навч. бадар судар (бадрын навчин дээр бичсэн судар).

БАДАР IV бадар галав, сам. *bhadrakalpa*, м.б. *badar-a yalba*; "сайн галав", одоо үе, өдгөөгийн эрин.

БАДАР V сам. *patra*, м.б. *badir*; 1. Тойдын дусал гүйх аяга; аяга тэхимлэгүүдийн зургаан зүйлийн сав хэрэгслийн нэг, шавар буюу төмрөөр хийсэн хоёр зүйл буй. Шагжмуни бурхны зарим хөрөг, цутгамалд мутартaa бадар аяга барьсан нь үзэгддэг. Бадар аяга нь хар өнгөтэй амсар хомбогор, суурь дээшээ сарвагар хэлбэртэй. Утгаа сүм хийдийн үүднээс буяны өглөг олохоор явагсад бадар аягатай явдаг байв. Бадар аяганы таван онцлог нь шавар, төмрийн аль нэгээр хийсэн, хэрээний нүд мэт хар, хаан өндөг мэт дугариг, бөх бат эдэлгээтэй, ёс горимын талаас адисласан байдагт оршино. 2. бусдаас эд юм хүсч гүйхыг нь буюу эсвэл буяны нэмэр харамж олноос гүйхыг нь; бадар барих, бадарла-; Бадар хундага (Оттон тэнгэр уулын өвөр элгэнд орших, бадар аяганы хэлбэртэй үзэсгэлэнт нуур. Бадар барьж цутглуулах гэсэн утгаар нэрийдсэн бололтой. Энэ нуурыг мөнгөн эмээл хазаартай цагаан морь буюу есөн эрдэнээр чимсэн алтан, мөнгөн мандаагаар тахиж байсан гэдэг. Харин хожуу үед 50 лангийн мөнгөн ембүү, алт, мөнгө, шүр, сувд зэрэг эрдэнээр тахидаг байсан мэдээ бий).

БАДАРЧИН самгардийн *patra* гэсэн үгнээ -чин дагавар залгасан. Бадар гүйгч хүн буюу бадар аягатан. Буян хийхээр олноос нэмэр хандив гүйж явдаг хүн. Бадарчин хавчиг үүрэгтэй, нэг буюу хоёр таяг мод барьж явдаг байв. Бадарчин нь үүрэг зорилгоороо ялгаатай байсан. а. сүм хийд буюу ихэс лам нарын зарлигаар өглөгийн эздээс эд мал бадарлан олохоор явагсад; б. сүм хийдээс оргосон доод давхаргын лам нар; в. мөргөл буян хийхээр буюу ном эрдэм сурахаар харь хол орныг зорин явагсад гэх мэт . бадарчлах (бадар гүйн хэсч явах).

БАДГАНА тө. *bad kan*, м.б. *badyan-a*; *badyan-a*; 1. хүний бисийн зүрхнээс дээш хэсэгт байдаг шороо ус хоёр махбодоос тогтсон буюу хүний хоол тэжээлийн хамгийн шимт зүйлээс үүсч бий болоод түүгээрээ төлждөг хүйтэн сэруүн чанарыг үүсгэн бий болгогч зүйл гэж эмнэлгийн судар бичигт тодорхойлсон байдаг. Шүгүүлэгч бадгана, ялзлагч бадгана, амсуулагч бадгана, хангагч бадгана, барилдуулагч бадгана гэж таван зүйл буй; 2. хүний ходоодонд тусдаг хорт хавдар, нарийн өвчин ч гэдэг; бадганатах (бадгана өвчин хүрэх).

БАДМААНЯМБУУ тө. *ra d̥ma snying po*; м.б. *badmanimbuu*; "лянхуан зүрх", Хятад, Балба, Индонези зэрэг оронд ургадаг нэг

ЗҮЙЛ МОДНЫ ҮР. Их хөлгөний ёсонд энэ үрээр хийсэн эрихийг ихэд бэлэгшээдэг, өөртөө бас уртэй гэдэг.

БАДМААРАГ сам. padmaraga, мө.б. badmaraγ-a; "лянхуан онгт", Улаан өнгийн туяа сацруулсан эрдэнийн чулуу, гоёл чимэглэлд хэрэглэнэ.

БАЗАРВААНЬ тө. badzra pa ni < сам.vajgrapani, мө.б. baγarbani; 1. Очирваань; 2. шилж.. дахин бүү үзэгд, нүдэнд бүү харагд, бүү үзэгд; базарваань хум пад (ээ бүү үзэгд!); Ээ базарваань, түшлэг сэntий дээр нь нэг том хүрэн эрээн могой хэвтэж байна гэнэ. (MAY).

БАЗАРТ: базарт хөлгөн сам. vajtāyānā, мө.б. baγartu; Очирт хөлгөн-бурхны шашны сургаал номлолын зам мөрийн нэр. *Базарт хөлгөний амь мод, Бадмасамбавагийн адисаар... бас насыг олтутай.* (Д.Р.)

БАЙ I хя. bā, мө.б. bai; харваж буудахаар босгосон шав, пай ч гэнэ. *Байндаа ч угүй, бандзандаа ч угүй (зүйр).*

БАЙ II хя. bēi, мө.б. bai; Мөрийцөн тэмцээний мөрий, шан, хөхүүлэл; морины бай.

БАЙ БАЙДИ хя. bāi bāi di, мө.б. baidi; "огт хэрэггүй", ямар ч хэрэггүй, дэмий нэг, огт үр ашиггүй. *Тэнд бай байди цаг онгтөрөөв.* (яриа).

БАЙБАЛИГ уй. baj bālīq, мө.б. bayibalīy; "баян балгас; 1250-иад жилийн өмнө барьсан уйгарын үеийн хот. Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутагт энэ хотын туурь бий. Нутгийнхан Бийбулаг гэж нэрлэдэг.

БАЙВАН тө. bas ban/big bang; хя. báifán; мө.б. bayibang; Хар, ногоон, шар хүхэр хүчлийн давсан талст. Мөнгө гууль өнгөлдөг, алт шардаг, гууль зэсийг дуутай болгоход найрлагад нь орно; байвандах (мөнгийг байвантай усанд буцалгаж өнгө оруулах).

БАЙГУА хя. bái guā, мө.б. bayiγa; "цагаан гуа", гичийн терлийн нэг зүйл ногоо болох гаймууны үндэс.

БАЙЛАН хя. bái lian, мө.б. bayilan; Хуучин цаасыг дахин боловсруулж хийсэн бүдүүлэг цаас.

БАЙЛАХ хя. bái, мө.б. bayilaqu; Эд юмаа биечлэн тоолж бүртгэх; малаа байлах.

БАЙМАН бамин,

БАЙТУУ хя. báitō, мө.б. bayitu; Юманд ор дэвсгэр болгож түрхэх нэг зүйл цагаан будаг; байтуудах (байтуугаар дэвсгэр болгон будах).

БАЙХУУ ор. байховый, мө.б. baγiqci; Халуун газар ургах үслэг цагаан уртэй, хүрэн навчтай цайны ургамал, түүнийг боловсруулж хийсэн цайны идээ.

БАЙЦАА хя. báicāi, мө.б. bayiçai; "цагаан ногоо", идээний ногоо. Орос байцаа, хятад байцаа, цэцэгт байцаа гэж ялгаатай бий. Байцай ч гэж бичнэ.

БАЙШИН перс. pīš-īwān pīš-aiwān> ap. baising>; мө.б. bayišing; Хүн суух, юм агуулах мод, тоосго, чулуу, шавар зэргээр барьсан барилга.

БАЙШИНХУР түр. baisungqura, мө.б. bayisingqor (МНТ); догшин жигүүртэн.

БАЛ I: бал мод; сам. bāla; мө.б. bal; Агар, зуун наст мод, төвдөөр gya'sing гэдэг ба үүнийг сунжуулж яншиин гэж нэрлэх ч бий.

БАЛ II сам. bala; мө.б. bala (Ков.), хүчирхэг, эрэлхэг, бат бэх.

БАЛАГША сам. plakṣa; мө.б. balagš-a; Ficus venosa; Инжрийн мод.

БАЛАХА сам. palaha, мө.б. balaq-a; "үүлэн хүчит"; Цайвар хөх зүстэй, үүлний хүч мэт хурдан явдаг морины хаан, морин эрдэнэ гэж домогт гардаг.

БАЛАШ сам. palāśa; мө.б. balaš-a (Ков.); Улаан цэцэгт мод, Vitæa frondosa; Гүргээний төрлийн мод, Cirsium reclinata Rox.

БАЛБАЛ түр. balbal; мө.б. balbal; Монгол нутагт байдаг эртний түрэгийн үеийн булшны хэдэн тал руу босгосон зэл чулуун овоо буюу газарт шигтгэсэн чулуун зэл.

БАЛДАНЛХАМ тө. dpal ldan lha mo; мө.б. baldanlhamo; "төгс цогт охин тэнгэр"; Арван догшин сахиусны нэг, цагаан дара эхийн дүр. Биеийн зүс бараан, амаа ангайж дөрвөн соёо гаргасан, эргэлдсэн гурван мэлмийтэй, үс нь боссон, хүний арьсаар цээжээ бүрж, хохимойг нь эрхилж зүүсэн, баруун мутартай очир толгойт бороохой, зүүн мутартай гавал барьсан, тэргүүндээ шүхэр бүхий догшин бурхан. Буян хишгийг урин залахын тулд битүүний орой Лхам бурхныг залж уншлага хийдэг.

БАЛДАРГАНА балчиргана түр. baltırgan; мө.б. baldaryan-a (Pac.) Уулархаг газар, уул хярын жалга судагт ургах гоньд шиг уртэй дүргэг түрүүний нам. Баавгай, гөрөөс иднэ.

БАЛДИГ тө. bal tig; мө.б. baldig; Балба дэгд гэсэн үгийг хураангуйлж нэрлэсэн нэр. Дэгдийг үз.

БАЛЖИНЯМ тө. *dpal sbyin ngyama*; мө.б. *baljinnim-a*; "цогт өглөгийн нар"; Балжинямтай өдөр ч гэнэ. Энэ өдөр нь сар бүрд гол төлөв нэг удаа тохиох бөгөөд цог буяны маш сайн өдөр, аливаа үйлд сайн гэдэг.

БАЛЖИР: балжир чулуу тө. *dpal 'buog*; мө.б. *baljog*; "цогт найрлага"; Отгон тэнгэр уулын өвөр биед, далайн төвшнөөс дээш 2500 метрт өргөгдсөн газарт Дуут хэмээх бяцхан нуурт байдаг сампинтийн эрих хэлбэртэй, эрчлээ бүхий бөөрөнхий чулуут нутгийнхан ингэж нэрлэдэг. Энэ чулуут эмийн увдистай, хоолойн өвчин, идээт бутглаанд сайн гэдэг байна.

БАЛИГА тө. *baleka*< сам. *ballika*; мө.б. *balig-a*; *Akebia quinata*; Халуун оронд ургах цэцэг навчгүй, ороонго ургамал. Зузаан харсаарал холтостой, тэр нь гашуундуу амтгай.

БАЛИАМ мө.б. *baliyam*; Балим гэдэг үтгэй гарал нэг. Сарлагийн буханд гарсан монгол үнээний гутгаар үеийн төл. Нэг дэх үе нь хайнаг, хоёр дахь үе нь ортоом, гутгаарх нь балиам болно.

БАЛИЙ сам. *balī*; мө.б. *balī*; Гурван ертөнцийг эзэлсэн мангасын хаан. Тэнгэр нар түүнийг дарж өгөөч гэж Вишну тэнгэрээс гүйсанд Вишну одой хүний дүрээр очиж тэр мангасын хаанаас гурван алхам газар гүйжээ. Зөвшөөрмөгц нь нар болж хувираад нэг алхаж дэлхийг эзлээд, хоёр алхаж тэнгэрийг эзлээд, гурав алхадаа мангасын хаан Балийг гишгэж тамд унагаж дарсан домогтой.

БАЛИМ тө. *ba lang*; мө.б. *balim*; 1. үхрийн үрсийн цацлын үгэнд гардаг үхэр сүргийг үржүүлж өстөх тэнгэр; 2. үхрийг мушиаасан нэр.

БАЛИН сам. *balī*; мө.б. *baling*; "өргөл"; Хуурч болгосон арвайн гурилаар хийсэн суварган буюу гурвалжин цац хэлбэртэй, бурхны өмнө өрөн тавих өргөлийн идээ; Догшины балин (Зүрхэн тарниийн үсэг бичсэн, шулуун, гурвалжин хэлбэртэй том балин, эргэн тойронд нь нөхөр сэлт болгож олон балин тавина); мах цусны балин (хүний биеийн гол эрхтэн хийгээд тавхай, сарвуу зэргийг дүрслэн хийж хүрнээр будсан бүдүүн ширхэгт гурилан балин. Хурал дуусахад шатаах буюу гаргаж хаяна. Гай золиг, муу ёрын идээ гэх тул үл иднэ); чөтгөрийн нүдийг балингаар хуурах (зүйр); есөн их балин (Монголын сүм хийдэд сар бүрийн 29-нд ад чөтгөр дараахад зориулан есөн их балин залдаг байв)

БАЛИНЧ балин (сам.) + ч (мо.); мө.б. *balingči*; балин хийдэг хүн. Тэр цагт хөгшин муюу ахыгаа балинчаар аваарай даа. (Л.Т.).

БАЛНАД тө. *bal nad*, мө.б. *balnad*; гэдэсний халдварт халуун хижиг өвчин.

БАЛТ түр. *palta*, мө.б. *balta*; Сүхний өөр нэр, лантууг ч бас хэлнэ.

БАЛУУ тө. *ba lu*; мө.б. *balu*; *Rhododendrons*. 3-4 метр өндөр, цагаан судалтай, тансаг анхилгат нарийн цул мод, үрийг бас балуу гэнэ. Төвдийн өндөрлөгт ургадаг, навч ба долонгоор нь хүж хийдэг. Цэцгийг даль гэнэ. Эмэнд хэрэглэнэ.

БАЛХА балаха; *Хулэг хурдан боловч морины хаан балха лугаа адил бус* (Д.Р.).

БАМ тө. *'bam*, "чийг". мө.б. *bam*; Амин дэм дутах буюу чийгээс болж судасны хана хямран, шүд буйл бусад эрхтэн хавдаж цус нэвчих өвчин. Чийг бам гэдэг өвчин тусаж... (Б.Р.).

БАМБАЙ тө. *spang spos*, мө.б. *bangboi*; "зүлгийн хүж" ; *Nardostachys jatamansi*; Ягаан цэцэгтэй, үнэр сайхан, нутын өвслөг ногоо. Үндсээр нь эмийн ханд хийнэ. Хүж өвс ч гэдэг.

БАМИН тө. *ba-men*, сам. *gavaya*, *Bos gavaelus*; мө.б. *bamin*; 1. Азийн өндөрлөг болон Төвд оронд байдаг уулын зэрлэг үхэр, зэрлэг бух. Бас гаршуулж тэжээсэн нь ч бий. Сүү шим ихтэй, эвэр нь эмийн найрлагад орлог. Хүрэн өнгөтэй байман нь энэтхэгт байдаг, урт бөөрөнхий эвэртэй; 2. үхэр лүгээ хэлбэр адил хайнагийн тугал; 3. заантай адилавтар бөгөөд хөл охор, биедээ бидэр хайртай, хамрын үзүүрт нэг эвэртэй нэгэн зүйл гөроос; хирс ч гэнэ.

БАНАГ тө. *sba nag*, мө.б. *banaγ*; "хар үст (хар гэрт)"; 1. хар сарлагийн үс саваг буюу өрмөгөөр хийсэн хавттай оройтой майхан, бас тийм бүрээс туургатай гэр. Мөн тэр гэрт суудаг зүүн хойт Төвдийн нүүдэлч овгийн нэр; 2. Монголын баруун зүгийн зарим нутагт илүү гэрийг нэрлэх нэр.

БАНАЦАН тө. *ra na se*; сам. *panasa*; мө.б. *banačan*; Хөлдөхдөө навч нь зулгарахгүй нэг зүйлийн тослог жимст ургамал, мод.

БАНД I тө. *ban da'*<сам. *vandā/vandakā*; мө.б. *band* (Ков.); Харш хорт ургамлын нэр.

БАНД II манж. *bando*<сам. *bandhuka*; мө.б. *bandu*; Цэцэг гардаггүй нэгэн зүйлийн модны үндэснээс үзүүр хүртэл хальсанд нь ургадаг журжийн адил том жимс.

БАНДАН хя. bändēng; мө.б. bandang; 1. түшлэгтүй урт нарийн исэр; 2. монгол гэрийн дотор тавих хагас тойрог хэлбэртэй богино модон ор.

БАНДИ тө. ban de<сам. vāndya; мө.б. bandi; 1. бурхны шашны ёсны анхан шатны сахилтан; 2. эрэгтэй хүүхдийг дуудах нэр.

БАНДИД сам. pañdīta; мө.б. bandida; Ухааны таван орон буюу учир шадганааны ухаан, дуун ухаан, тэжээх ухаан, урлахуй ухаан, дотоод ухаанд мэргэжсэн хүнд олгож байсан ном эрдэмийн цол. ...Саж бандид ач хүүгээ дагуулж ирсэн. (*Суба*).

БАНДУГА сам. bandhūka; мө.б. bandhuaka (Ков.); Улаан цэцэгтэй бяцхан мод.

БАНЖИН тө. spang rgyan; мө.б. bangjan; "зүлгийн чимэг"; Өвсөн дунд намар цагт ургадаг нэг зүйл цэцэг. Өнгөөрөө хэдэн зүйл байдаг; Банжингарав (тө. span rgyan dkar po, "зүлгийн цагаан чимэг", Gentiana algida; Хас хаттуур цэцэг ч гэнэ); Банжин омбо (тө. span rgyan sngon po, "зүлгийн хөх чимэг", Gentiana decumbens); Банжиннагва (span rgyan nag po "зүлгийн хар чимэг") гэж гурван зүйл бий.

БАНЗ хя. bän zi, мө.б. bangja; 1. зүсмэл хавтгай мод; 2. хууч.ялтныг шийтгэж зодох хавтгай мод, бас шир буюу хулсаар хийснийг банд гэнэ; бандзах (банзаар занчих); бандзлах (а. банд болгох; б. үслэг арсыг бандзанд ороож толийлгох).

БАНЗА сам. раїса; мө.б. banja; "тав"; банза бэлгэ = таван бэлгэ (номын төвийн бэлгэ, билиг тэгш чанар бэлгэ билиг, тус тус онох бэлгэ билиг, толь бэлгэ билиг, үйл бүтээх бэлгэ билиг); Энэ уг нь банзарагч, бандзандар зэрэг үгийн банза болно. "Данжур"-т таван ухааныг банза ухаан гэж бичсэн нь дайралдаг.

БАНЗАЛ сам. rañcāla; мө.б. bangjal~banjal; 1. Хималайн бэлээс чамбал голын хооронд, одоогийн Дели хотоос баруун хойт зүйт орших газар орны нэр. Хожуу үед өмнөд, умард Банзал гэж хоёр хуваагдсан. Энэ хоёр улс Ганга мөрнөөр зааглагдаж байв. Панчал орон ч гэдэг; 2. Банзал орон бөс даавуугаар ихэд алдаршсанаас бөс даавуут нь панчалика (банзал орны хувцас) гэж нэрлэх болсон нь монгол, төвд хэлнээ банзал болж орсон. Тэр нь лам нарын бөгсөн биеэ ороох хувцас, эмэгтэй хүний бэлхүүснээс дооших (урт, богино) хувцас зэргийг заах болжээ; 3. **шилж** садар самуун хүн.

БАНЗАЛИГА сам. rañcalikā, мө.б. banjaliga (Ков.); 1. таван өнгөт хувцасны нэр, банзал; бандалигаа ч гэнэ; 2. панчал орны;

"ba" үстгийн утсаар нэхсэн бөс бандалигаан торгоос бутсэн... (МУЗД-1).

БАНЗРАГЧ сам. pañcarakṣā ; мө.б. banjaraṇa; "таван сахьяя"; Энэ ном таван судраас бүтнэ. Үүнд: "Их мянганыг маш дарагч нэрт их хөлгөн судар", "Их ухааны тарнисын хатан", "Хутагт өөр өөр дагагч их ухааны тарнисын хатан", "Их сэргүн ой нэрт судар", "Их нууц тарнийг даган баригч судар" эдгээр болно. Монгол бичгээр banjaraṇ-a ч гэж бичдэг.

БАНЗДОО тө. spang rtsi 'do bo, Saussurea costus; мө.б. bangjado-a; Үнэр сайхан, навч наалдамхай, элтэс улаан, иш урт, цэцгийн өнгө цагаан буюу хар, цоохор, өвслөг ургамал, эмд орно.

БАНИ сам. pāni; мө.б. bani (Ков.); Очирваань гэдэг үгийн өнцгийн хувирсан хэлбэр, мутар гар гэсэн утгатай.

БАНЛАГ тө. dbang lag=сам. Indrahasta; мө.б. vanglay=banglay; Эрт цагт Хормуст тэнгэрийн хөвүүн Банбодовдонгийн гарыг мөгий толгойт ягчын хөвүүн Жижээ сумаар тас харвасанд Банбодовдон уурлан Жижээгийн гарыг илдээр цавчжээ. Тэр цагт Банбын гар газарт унахдаа ерөөлийн хүчээр доод үндэс нь гал адил, дээд навч нь илд адил "Банлаг" (эрхтийн гар) хэмээх ургамал болсон гэдэг домогтой. Монгол эмийн сударт: навч, хөл нь ногоон, хонгорцогтгүй, зууван, зөөлөн цэцэг нь хөх шар, эргэсэн манжлага адил, үр чавга мэт, үндэс нь гарын хуруу адил, үнэр улаан зандантай адил гэсэн байдал. Бас төмслөг, зууван шулуун иштэй, шовх үзүүрт навчтай ягаан буюу улаан бор цэцэгтэй олон наст өвслөг ургамлыг хэлнэ гэсэн байдал.

БАНТАН хя. bāntāng; мө.б. bantang; 1. дутуу зуурч багсарсан гурилыг үрж буцалгасан шөлтэй хоол; 2. **шилж**. алив юмны зөв буруу, эх адгийг хольж хуттан будилаантай болгосон нь; **хорш**. холион бантан; бантагнах (холион болгох).

БАНУУ тө. ba pi, мө.б. banpi; Агуйн дээврээс монцоглож үнжин тогтсон байх ба хөх, цагаан буюу цайвар шар өнгөтэй, үнээний хөхтэй адил, дотроо нүхтэй, гаднаа атираа хуниастай бас эвэр тууртайтай адил шохойн чулуулаг. Хөхөн чулуу, үнээн хөх ч гэдэг. Эмнэлэгт хэрэглэнэ.

БАНЧИН тө. pan chen<pan dida chen po; мө.б. bančin; "их бандида"; Таван ухаанд суралцаж төгссөн лам, Банчин эрдэнэ, Банчин бодг зэргээр дуудна. Бүрэлбаагийн тайлбарт үз.

БАНШ хя. biān shí, мо.б. biyangsi~bangsi; Хярсан мах, ногоо, амтлагч зэргийг багсран гурилд боож чимхээд чанах буюу жигнэн идэх хоол.

БАНШАА тө. pan shwa мо.б. bānša; "бандид малгай"; Шовгор оройтой, улаан өнгийн дотортой, шар торгомсог эдээр хийсэн гадартай, урт бүчтэй малгай. Богд Адиша болон Зонховын өмсөж байсан малгай.

БАР I тө. par; мо.б. bar; 1. зураг хөрөг, бичиг ном дармаллан хэвлэх сийлмэл хэв; модон бар, барын ном; 2. хэвлэхэд хэрэглэх тэмэр, чулуу, мод зэрэгт гаргасан зураг; барчин (а. бар сийлэгч; б. барлагч); барлах (ном, зураг дармаллах).

БАР II перс. pars~fars; мо.б. bars>(манж, тунг. barg, солон. бар, бари); түр. bars; 1. мигүй адил эрээн бидэрт арьстай, сүүн тэжээлт араатан; 2. билгийн тооллын 12 жилийн гутгаар жилийн нэр; мөн тооллын жил бүрийн хаврын тэргүүн сар; өглөөний 3-5 хүртэлх цагийн нэр (Барс жилийн барс сар гэх мэт); эр бар (хавтай чадалтай).

БАРАГ түр. barak; мо.б. bargu; Өтгөн саглагар урт үстэй, хурдан хөдөлгөөнтэй нэгэн зүйл нохой; *Балмад довтлох бараг мэт (МНТ)*.

БАРАГШИН тө. brag sun; мо.б. bargušin; "хадын хайлмал"; Өтгөн зууралдсан байдалтай элдэв органик нэгдэл агуулсан өвөрмөц хольцтой давирхайлаг хар зүйл. Хадны цус, хадны цай, хаднаас төрөгч, хадны шим, хадны ращаан зэрэг олон нэртэй. Эмд орно.

БАРАМ I бармай ; *Бармай модны сүүдээрт суу (Гэс.)*.

БАРАМ II тө. bra ma; мо.б. baram; Төвдийн лидер (үз.).

БАРАМ III тө. 'rag ma; мо. baram; 1. гүрэм хийхэд хар гурилаар барьдаг нэг зүйлийн ад чөттөрийн дурс; 2. хараал үг.

БАРАМНАС сам. paramati; мо.б. bargmanus; Цонх хаалганы завсраар гялалзсан нарны гэрэлд жирвэлзэн үзэгдэх хумхи тоос, эгэл хэсэг. Дорно дахины гүн ухаанд бүх юмыг хуваагдашгүй барамнаасаас бүрдэнэ гэж үзэж байв. Гэвч арга билгийн нэгдлээс тогтсон барамнаас байнга хувьсан хөдөлж хөгждөг гэж үздэг.

БАРАМСАЙ тө. bram ze; мо.б. baramsai = бярман; Төвд хэлний бярман гэсэн утгатай, монгол хэлнээ зөвхөн оноосон нэрийн үүргээр хэрэглэгдэнэ.

БАРАНЗАД тө. bar mdzod; мо.б. baranjad; "дунд сангийн" хадаг.

БАРАНИ сам. bharapı; мо.б. barani; Сарны зурхайн хорин найман одны нэг, монгол нэр нь Авагч элээ одон, одоо гоё хүүхэн гэж нэрлэж буй.

БАРАТА сам. varata; мо.б. barata (Ков.); Шар зөгий.

БАРВАД тө. rag ra ta; мо.б. barbad; *Hypescoum lactiflorum*; Намуу цэцгийн намын нэг наст ургамал, 40-50 см өндөр, навч хөхөмдөг, цэцэг шар өнгөтэй.

БАРИГША сам. parikṣa; мо.б. barigš-a(Ков.); Аливаа юмны бүтцийг тодорхойлох судалгаа, тойм, шинжилгээ.

БАРИШАД сам. pariṣada; мо.б. bariṣad (Ков.); Үзэл санаа, үйл ажил, аж амьдрал зэргээрээ ойр дотны хүн. Бас нөхөр, замчин, бараа бологч, шадар зэрэг утгатай.

БАРМАЙ сам. varami; мо.б. barmai; Нэгэн үл өндөр бүдүүн алимын мод. Барам ч гэнэ.

БАРМИД уй. baramid<paramit<сам. paramita; мо.б. baramid; "чанадад хүрсэн"; Бурхны сургаалын парчины аймаг дахь бодь сэтгэл буюу билэгт хүргэх ёс суртахууны шинж. Үүнд: өглөг бармид, шагшаабад бармид, хүлцэнгүй бармид, хичээнгүй бармид, дияаны бармид, билэг бармид эдгээр болно. Эдгээрт мэргэн арга, ерөөл, хүчин, бэлгэ билиг дөрвийг нэмж арван бармид болгодог. Эхний зургааг "билэг бармидын их оньсыг хураасан товч" гэдэг. Эдгээр бармидыг чанад хязгаарт хүргэх гэгээрэхүй буюу бурхан болох үндэс гэдэг.

БАРС перс. barg; мо.б. bars; Бар гэдгийн тайлбарт үзнэ үү.

БАРУНА Варуна, мо.б. barun-a (Ков.).

БАРУР тө. ba ru ga; мо.б. barur-a; Terminalia belerica; Дулаан газар ургадаг мод. Мөхлөг үртэй, эхүүн амттай, дотроо хар хальстай, тослог идээлтэй, эмд хэрэглэнэ.

БАРХАН тө. par khang; мо.б. barqan; "барын байшин"; Модон бараар ном бичиг дармаллах хэвлэлийн газар.

БАРХАСВАДИ сам. brhaspati; мо.б. barqasbadi; "их (үг)-ийн эзэн"; энэ үгийн брихати (брихас) нь Ригвээдийн дотор олонтаа дайралддаг шүлгийн хэмжээний нэр, паму нь "эзэн" болно. Угтаа Вээдийн тэнгэрсийн нэг, тэнгэрсийн багш ч гэдэг. Пүрэв, Модон гариг.

БАРЦАД тө. bar chad; мо.б. barčad; Тоттор, саад, гай зэтгэр; гай барцад; барцад цөв.

БАРЧИД = барцад; *Ноёнтон барчдаа нимгэлж, буян үйлдэх, золиг гаргах хэрэгтэй болоод байгаа юм байна. (Б.Р.)*.

БАСАР I перс. bazar; уй. bajar/badzar; монг. basar; 1. зах зээлийн газар, зах дэлгүүр; 2. хот, балгас; *Басрыг захирагч сайд* (Ков.), *Басар-а бүхий-дор бичивэй* (Турф.); 3. гацаа, тосгон.

БАСАР II барс.

БАСУ сам. vasu; тө. ba'su; монг. basu (Ков.); 1. эд бараа, баялаг; 2. агуу их.

БАТАЧИ түр. bataci; монг. bataci; малчин.

БАХ түр. baqa; монг. baq-a; Хойт хоёр хөл нь үсчиж хөдлөхөд зохицсон урт, сүүлгүй, газар уснаа явагч хоёр нутагтан. Мэлхий ч гэнэ.

БАЦАГ сам. upavasatha; монг. bačaγ (<түр. bacay); 1. шашны ёсонд нэг хоногийн сахил санваар буюу эсвэл мах тос зэрэг улаан идээ амсахгүй, гагчхүү ном бясалгал хийх тодорхой хугацаатай санваар; 2. хоол идэхгүй байхы нь. бацаг барих (нэг хоног хоол идэхгүй байх); ...ашиг төгөлдөр байсан нь...дүйцэн өдөр бацаг барьсны буян (Б.Р.); бацаглах (бацаг барих).

БАШИГА сам. vaśikā >тө. ba śa>монг. basaka~basiy; Adhatoda vasica, Jasticia ganderussa; 1. өвсөн иштэй, цэцэгт таван зүйл өнгө бий. Хэлтэс дан буюу давхраар тохиолдоно. Шовгор нарийн навчтай; 2. 20 гаруй метр өндөр, навч зулгаргач тураг мод, түүний жимсийн нэр. Жимс нь гашуун, сэруун чанартай, Хушга ч гэнэ.

БАЮУМАРАГ сам. vuomaka; монг. baumaraag; Өндөр сурлэг барилгын гоёл чимлийн хээний зүйл. Монгол бичгээр баумак гэж бичсэн ч байдаг. *Өмнө өрнөөс Эрдэнэ гарахий* (Ратнасамбхава. О.С) нэрт бодисадва ирж эрдэнийн баюумараг чимгийг узуулвэй (12 зох.).

БАЯГЗАВАА тө. spa yag itsa ba; "баягийн үндэс", Зүрхэн цэцэг гэж монголчууд эртнээс нэрлэж ирсэн байх ба баягзаваа нэрээр алдаршжээ. Эмд орно.

БИБИЛ сам. rippala; монг. bibala; Азийн халуун оронд ургадаг тураг мод. Шүүсээр нь цавуу хийнэ. Үрийт нь бодиз(үз) гэнэ. Бибала ч гэж бичдэг. Энэтхэг зан үйлийн ёсоор ариун мод гэдэг. Энэ модонд Браhma, Вишну, Mахаашуурай тэнгэр оршдог гэнэ. Бямба гаригт энэ модон дээр бүх тэнгэр хурдаг гэж үздэгээс энэ өдөр энэ модонд мөргөл үйлдэнэ. Мөн хайр сэтгэлийг дэврээж, үр хүүхэд заяж, чөтгөр шулмыг зайлцуулагч мод гэдэг.

БИВАН: биван нутас тө. pi wam (<сам.); монг. bivang; биваан (Я.Ц.); нэг зүйл нутас.

БИВАНХИРИД виванхирид; монг. Bivangkirid.

БИВЛИН тө. ri ri ling (<сам. pippali); монг. bibiling; Piper longum. Халуун чанартай ургамлын нэг зүйл үр. Гонзгойдуу урт хэлбэртэй, халуун бөгөөд эхүүн амттай, эмнэлэг, хоол хүнсэнд хэрэглэнэ. Ханиад томуунд хэрэглэнэ гэж эмийн сударт заажээ. Бибали ч гэдэг.

БИГВАН тө. pig pan; монг. bigban; байван.

БИГРАМ сам. vikrama; монг. bigram-a (Ков.); эрх хүч, чадал, эрх сүр.

БИГСҮ сам. bhiksu; монг. bigsu~bigsu; 1. гэлэн; гэрээс гарч тойн болсны нэр; *Бигсу Сумадибазар монголчлон орчуулбай.*; 2. гүйлга гүйгч, бадар баригч.

БИДАР сам. bedhara; тө. be dha ra; монг. bidar (Ков.); "хүүр босох, боссон хүүр", = ороолон (үз).

БИДУН түр. bidun; монг. bidun; "хэсүүлчин, нүүдэлчин"; Арабын нэг нүүдэлчин аймгийг түргүүд ийн нэрлэж байсан нь монгол хэлэнд "хэслэг, нүүдэл, нүүдэллэх" гэсэн утгаар хэрэглэгдэх болжээ. Бядах, бядан гэсэн хэлбэртэй болсон буй.

БИДБАЛ сам. pidbala; монг. bidibala; Бяцхан цагаан цэцэгтэй, намаг газарт ургадаг, хэлбэр саримсагтай адил нэг зүйл олон наст ургамал, үндэс нь эмд орно.

БИДҮҮ хя. bēidiub (<сам. pattra); монг. bidu; Навч нь бат бэх, хялбар гэмтэхгүй учир дээр нь юм зурж, бичиж болдог нэг зүйл мөнх ногоон тураг мод. Бадраа ч гэдэг. Бадар, бидүү хоёр нэг гаралтай үг.

БИДЭРЬЯА сам. vaidūrya; Баянхонгор аймгийн Заг сумын Загийн голын эхэнд орших нуур; Бидэрьяа нуурын чуулган (Засагт хан аймгийн чуулганыг энд хийдэг байснаас ингэж нэрлэдэг байв). Биндерьяа (үз).

БИЙВ = бийваагаас үүссэн нэр. Утга өвөрдсөн буй. Бишүүр. Бялар зэрэг үлээвэр хөгжмийн зүйлд углаж үлээх зэгс хулсаар хийсэн хушуу.

БИЙВАА сам. vīnā~bīvām; монг. biba; Сарасватий буюу Эгшигт охин тэнгэрийн барьж байдаг яруу дууны билэгдэл хөгжим. 4-6 чавхдастай хөгжмийн зэмсэг. Дөрвөн махранзын анхдуутаарх нь энэ хөгжмийг барьсан байдаг. Домгийн ёсоор энэ хааны хор чадал нь чихэнд сонсдмогц тэдгээр сонссон амьтад үхэж сонөдгөөс Бурхан багши энэ хөгжмөөр адислаж гарти нь бариулсан гэдэг. Дундад үеийн монгол бичгийн дурсгалд энэ уг цөөнгүй дайралдана. Хожуу үед пийпаа гэж бичсэн нь үзэгддэг.

БИЙР хя. *ri* (> манж. *fi*); мо.б. *bir* (тө. *rir*); Зурах бичихэд зориулсан, ишинд багц үс бэхэлсэн хэрэгсэл. Ялгаврын бийр (бяцхан бийр).

БИЛИГ түр. *bil*=(мэдэх), *bilig* (мэдлэг, ухаан, оюун); мо.б. *bilig*; авьяас чадвар, оюун ухаан угийн гаргуун; билгийн ташуур (урьд цагт ёслолд хэрэглэж байсан нэг зүйл ташуур).

БИЛҮҮ түр. *bilä* =(үрэх, хайргадах), *bilagu* (билүү чулуу, гуранз); мо.б. *bilegүү*, *bileй* (Pac.); гуранз, хайрга, хутта хайч зэргийг үрж ирлэх чулуу.

БИМАЛА сам. *vimala*; мо.б. *bimala* (Ков.); "хиргүй"; хилэнцгүй, нүгэлгүй, буруу муу үйлгүй.

БИН хя. *bing*; мо.б. *bing*; Зуурсан гурилаар хайрч хийсэн нэгэн зүйл боов. Бинтэй шөл.

БИНВАД уй. *binvad*<сам. *vinyata*<*pindapāta*; мо.б. *binyad/binvad*; Өглөгийн идээ, тойн хуврагуудад өгдөг бөмбөлөг идээ. Бинвадаар амьдрах (өглөгийн зүйлээр амь зуух); бинвад өгөх (өршөөл үзүүлэх); бинвад үйлдэх (өршөөл хүсэх); бинвадчин (өглөгийн эздийн идээг хүртэгч буюу бадар баригч, бинвадач ч гэж бичдэг); *Түүнээс нэгэн өдөр бинвадад одоод идээнийг эс олбай* (*Раш.дус.*)

БИНДАДИ сам. *vindadi~pindada*; мо.б. *bindadi*; идээн өглөгт (Ков.); гүйлгачинд хоол идээ өгөгч.

БИНДЭРЬЯА -гийн хураангуй хэлбэр; Хэнтий аймгийн умар этгээдэд орших нэг уулаар нэрлэсэн сумын нэр; биндерлэх (эрхэмлэх); биеэ биндерлэх (биеэ оторлох).

БИНДЭРЬЯА сам. *vaidūya*; мо.б. *binderey-e*; "Бидур уулаас гарсан"; *Berill*; 1. бүдэг ногоон, шар ногоон, шар цэнхэр, хөх цэнхэр туяатай нэн тунгалаг хатуу эрдэнийн чулуу. Гоёл чимлийн зүйл, ардын эмнэлэгт хэрэглэнэ. Дорнын уламжлалаар дөрвөн зүйлд хувааж иржээ. Ногоон биндеръяа (харанхуйд олон өнгийн гэрэл цацуулдаг); цагаан биндеръяа (дотор нь утас хэрсэн мэт судалтай, гэрэл цацуулдаггүй); шар биндеръяа (муурын нүд шиг шар, харанхуйд гэрэл цацуулдаг); хөх биндеръяа (хэмжээ том, талст бүхий, шөнө гэрэлтэх, ховор тохиолдох эрдэнэ); 2. монгол хэлнээ хүний нэр, газрын нэрийн үүргээр бас хэрэглэгдэнэ. *Биндеръяа уулнаа дуурэн ес сацнам* (Зуун бил.).

БИНОДА сам. *vinota*; мо.б. *vinota*; ёс номтой.

БИНС манж. *pingse*; хя. (*tien*)-*ping*; мо.б. *pingse~bingse*; Тавагт жинлүүр, пинс ч гэнэ: бинслэх (бинсээр жигнэх).

БИНТ сам. *bindu*; мо.б. *bindu*; "о" тэмдэг, дусал; 1. тооны орныг эзлүүлэх хэмжигдэхүүн байхгүй гэсэн тэмдэг; 2. бичигт балласан зүйлийг тойруулан олон бинт тавидал дахин сэргээ гэсэн утга болно; 3. монгол бичигт цэсийн зүйлийг дэс дараагаар дуудахад нэг бүрийн эхэнд тавих тэмдэг; 4. үсгийн төгрөг тэмдэг, манж төвлд зэрэг үсэгт байдаг; бинт дусал тавих.

БИРА I сам. *pira*, мо.б. *bir-a*; *Trionex sinensis wiegmann*; Гол усанд өндөгнөөс төрөгч мэлхийн язгуурын амьтан.

БИРА II сам. *vīra*; мо.б. *bir-a*; "баатар" гэсэн утгатай боловч монгол хэлнээ оноосон нэрийн үүргээр хэрэглэгдэнэ.

БИРАТИКАБУД братигабуд; Эрт нэгэн биратикабуд хорт суман ногдож үхэхүй зовлонг хуртэгсэн... (*Турф.*)

БИРГА тө. *reg ka*; мо.б. *birγ-a*; Судрын хуудас бүрийн эхийн мөрийн тэргүүнд бичдэг дүрс; ном ба багшийн дүрс. Тэр дүрс нь бурхны шашин удаан оршихын билэгдэл, шашныг баригч дээдсийн лагшин бат орших билэгдэл, нар сар, цэцэг гурвиин билэгдэл болно. Бярга ч гэдэг.

БИРД түр. *brat*<сам. *preta*; мо.б. *birid*; 1. том гэдэстэй, зүүний сүвэгч шиг нарийхан хоолойтой авч үргэлж идэхийг мөрөөдөж байдаг, идэх юм хоолойгоор нь ордоггүй, орвол тэр нь гал болон шатаж амаар нь буцалж гардаг гурван муу заяны нэг өлөн чөтгөр буюу хадарган ч гэдэг. Бирдийг шашны зурагт баруун гартаа халбага, зүүн гартаа хоолтой бадар барьсан, цүдгэр гэдэс, том нүд, ув улаан үстэй, хөхөмдөг биетэй арьс яс болсон хүн маягтай дурсэлсэн байдаг; *Бирд-тор төрж тэнсдэхүй үтүй элдэв зүйл зовлонг узвэй* (*Ул.далай.*); 2. шилж хариг харамч, маш нарийн; *Цаадхын чинь гар бирдийн сарвуу болохоор цалин мөнгөөр тэнийхгүй* (*Д.П.*); Бирдлэх (өөртөө шингээхгүй атлаа дэмий хариг харамч зан гаргах).

БИРЯНГУУ сам. *priyamgu*; мо.б. *briyangyu*; *Panicum italicum*; Бутлан ургах, навч цэцэг нь хажуу руугаа санжсан, хөх цэцэгт ургамал. Тансаг үнэртэй үрээр нь зарим газарт сүрчиг хийдэг. Эмийн ургамал. Өмхий шимэлдэг ч гэнэ.

БИШАЗИ сам. *pišasa*>тө. *bi sa rtsi*; мо.б. *bisaji~bisajī*; 1.эртний энэтхэг домогт гардаг нэг зүйл ад буюу махчин; 2. гарын хурууны ажиллагаа (адаас болж) муудах өвчин.

БИШМҮҮТ уй. *paismait*; мо.б. *bismuuta*; Цувтай адил хувцас, бишимиад буюу бишимиуд гэж ч бичдэг; *Эрдэнийн гурван бишмүүтээ өмсөв* (*Жан.*).

БИШНУ вишну; м.б. *bisnu*; бишнүгээс төрсөн (цагаан зандан); Бишнүгийн хөл (Ганга мөрөн); Бишнүгийн хөлөг (гарди шувуу); Бишнүтэн (Вишнуг шүтэгч).

БОГТ түр. *boqta*; м.б. *boγtu*; "хаан титэм, хатны толгойн ёмсгөл"; Харилцан зөвшлийн эр эм бололцоход эрийн талаас хүүхний талд өгөхөөр амласан юм, сүй богт; Боглох (а. бэрэлцсэн ёсоор хоёр эттээд гэрлэх ёслол хийх; б. засч чимэглэх, бэр гүйх).

БОГТОГ түр. *boqtaγ*; м.б. *boγtuγ*; хаан титэм; хатны толгойн ёмсгөл.

БОД түр. *bod~bob<sam.bhūta*; м.б. *boda*, *bodas*; бие бод юм; бодтой (а. биетэй, бие махбод бүхий; б. чухам жинхэнэ); бодот дөрвөн язгуур махбодын цогц; б. Хүний ухамсраас хамаарахгүй түүний гадна орших бодот юмны бүтсэн эд; в. биет юмны бүтсэн эд).

БОДВАА I тө. *ro to ba*; м.б. *boduava*; Төвдийн Пан орны чимэг болсон Баотан гэдэг газарт орших Bodvaan нэртэй уулын хэсэг овгор толгойд хийд байгуулсаар энэ нэрээр алдаршин эндээс төрсөн мэргэдийн нэрийн ёмне энэ угийг дагуулж хэрэглэх болжээ.

БОДВАА II тө. *bod ra*, м.б. *bodba*; төвд, төвд хүн; Бодваагийн гэгээн.

БОДГАЛЬ сам. *puḍgala*; м.б. *bodyali*; "дүүрэн цувралт"; 1. ёрийн үндсэн нисванисаар дүүрэн, түүнээр орчлонд залгамжлан цуврах гэсэн утгатай. Таван бодгаль (бурхад, бодисадва, братигбуд, шарвагууд, хамаг амьтан); 2. амь санаа бүхий; аливаа бодрол мэдрэлтэй бүхэн. Сав шим өртөнцийн ямар нэг ширхэг юмыг тэр зүйл юм гэж онцолсон нэр. Олноос онцлон нэг ширхэг хүн гэж нээрэхгүй заах нэр.

БОДГАЯА сам. *Bodhgaya*; Очирт суурин. Одоогийн Зүүн Энэтхэгийн Бихаар муж улсад байdag газрын нэр, Гаяагаас зургаан бээр зйтай, Бурхан багш Саарнаатаас явж энэ газарт нэгэн бодь модны доор сууж нямба хийсэн гэдэг.

БОДИГ тө. *bod tig*; м.б. *bodiγ*; "төвд дэгд"-ийг монголчууд товчоор нэрлэсэн нэр. Дэгдийг уз.

БОДИЗ алабхр. *bodeji* (<сам. *pūrajīva*); тө. *'bo de tsi*; м.б. *bodija*; *Putraṇjiva Roxburghii*; "хөвгүүний тэжээл"; Θच्युहेन навчтай, боргоцой бүхий бүдүүн мод. Нэг боргоцойдоо 108 уртэй, түүгээр

эрих хийнэ. Эрт цагт Энэтхэгт хүүхдийг өвчинөөс сэргийлж хүзүүнд нь зүүдэг байжээ.

БОДИНАР сам. *bhītāni*; тө. *'buung po*; м.б. *bodinar*; Бодинарын ад (тэнгэр, асуурь, гандир, лус, ягчис, эсруа, ракшас, бшази, бирд, күмбанди, хав заль (хараал), алгасуулагч, бидар, онгод тэнгэр, лам, арши, өвгөн, шидэт хэмээх 18 адиг хэлнэ).

БОДИСАД сам. *bodhisattva*; м.б. *bodisadu-a*; бодисадваг үз.

БОДИСАДВА согд. *bowdsib<sam.bodhisattva*; м.б. *bodisadu-a*; "бодь сэтгэлтэн", Бүдийн шашинд муу үйлсээ арилгаж, сайн үйл бүтээж, энэ өртөнцийн зовлонт амьдралаас өөрийгөө гаргах сэтгэл олж, улмаар бусдыг аврах сэтгэл төрөн гурван эрдэнээр олныг гийгүүлэн хөтлөгч хутагт хувилгаад буюу бурхдын нийтлэг нэр. Бодь сэтгэлийг олсон нь буюу хар хоргүй, амарлингүй сэтгэлтэн гэсэн утгатай. Угтаа бол ёс суртахууны дээд хэмжээг олсон чанартан болох ажээ. Бас бурхны дараа орох хир хэмжээний цашны ёсонд нэвтэрсэн хүнийг хэлнэ.

БОДИСДВ бодисадва; *Тийн атал нэгэн цагт бодисдв энэ өдөр би цэцэрлэгт уйттарлан одсугай...(12 зох)*.

БОДИСТВ бодисдв; *Бурхан бодиств нар...хялбар буюу (Турф.)*.

БОДЛАН сам. *potala*; будлан.

БОДЬ I: бодь мод; сам. *bodhi* (*vrikṣa*); м.б. *bodi*; *Ficus religiosa*; Хар өнгийн хальстай, том навчтай, нарийн голт мод, ариун мод; ...Элдүгээ бодь модны дэргэд одсугай хэмээн туурвин амуй. (12 зох.).

БОДЬ II сам. *bodhi*; м.б. *bodi*; "нигүүлсэнгүй"; Хар хорон санаагүй, төгс амирлангүй; Бодь хүн, бодь сэтгэл (хар амиа бодохгүй, хамаг амьтны тусын тул үйл бүхнийг зохицуулан зориулагч хүн буюу тийм сэтгэл); ...*номыг сонсоод сац бодь хуттийг олсон буюу (Үл.далай)*.

БОДЬ III: бодь гөрөөс; сам. *bodhi*; м.б. *bodi*; 1. байдал гахай лугаа төсөөтэй, хамар дээрээ бяцхан эвэртэй гөрөөс; 2. зээр шиг биетэй, ямаан хоншиортой, ар зоо нь бор шарга толботой, өвчүүгээ дагаад урт цагаан өнгөтэй, үс ширүүн, нарийн хар эвэртэй гөрөөс.

БОДЬ IV: бодийг нь хөтлөх (амь насыг нь бүрэлгэх); Ботид хэмээх угийг үзнэ үү.

БОДЬ V: бодь гол; бодь хөмөг; сам. *bodhi*; м.б. *bodi*; "нигүүлсэнгүй"; Баянхонгор аймгийн Шинэ-Жинст сумын нутагт

байдаг гол, хөмгийн нэр; Бодь сэтгэл төрүүлсэн газар гэж Галданбошгот ийм нэр өгсөн домогтой.

БОДЬСАД бодисад; *Хутагт, үнэхээр...төгс сэтгэлт бурхан бодьсал ажээ. (Б.Р.)*

БОЗОЛ тө. 'bo tsə li; мө.б. bojali (Ков.); Шилдэг сайн тутарга.

БОЙГОР тө. spos dkar; мө.б. boyūgar; "цагаан гүгэл", Shorea Robusta; Цагаан зандаангийн давирхай. Үнэртний зүйл, гагнуурын найрлагад орно. Хөхөн гүгэл ч гэнэ. Бойгар ч гэж бичдэг; *Шагшаабадын үнэрийг эс анхилуулаад бойгарыг тулж ямар тус болох вэ. (Д.Р.)*

БОЙДАА манж boida; мө.б. boyida; "гэрийн даамал"; Хуучны засаг ноёдын ордны аж ахуйн хэргийг эрхлэх даамал.

БОЙНОГ түр. toinoq; мө.б. boyinoy; "хүзүү, тэмээний хүзүү"; Тэмээ зэрэг том амьтны хүзүү хоолойд ургаж унжсан урт хялгасан үс, зогдор.

БОЙПОР тө. spos phor~rog phor; мө.б. boyibog~boyirög; Хүжис, үнэртэн шатааж уугиулах сав, их төлөв гурван хөлтэй; *Чи бойпор бариад утлагаар утна (Б.Р.).*

БОЙШИЛ тө. spos sel; мө.б. boyisil; Нарс майлсны давирхай газрын хөрсөнд орж он удсанаас үүссэн чулуужсан хув; *Бойшил эрих бол хуван эрих шүү дээ. (Л.Т.)*

БОЛД перс. pulad>уй. polat; мө.б. bolod; Сайтар боловсруулж, холимоггүй болгосон чанар маш хатуу төмөр. Алмас болд, ган болд гэж ялгана. Дундад эртний монгол бичигт үulad гэж бичиж байв. *Ерэн гурван жингээр хийсэн их болд сүхээ өг. (Г.с.).*

БОЛОР перс. үulur; түр. billur~үulur; манж. bolosu; мө.б. үolur; Техник болон гоёл чимлийн зүйлд хэрэглэдэг чулуу. Төрөл зүйл олон; Усан болор (тунгалаг хөхөмдөг тяятай талст бүхий чулуу, арван тавны тэргэл сарны гэрэлд гаргаж тавихад ус дааварлан гардаг гэдэг. Хятадаар сүйжин гэнэ. Нүдний шил хөөрөг зэргийг хийж нүдээ илэхэд хараанд сайн гэдэг); Утаат болор (утаа тунасан мэт өнгөтэй болор); Болор бие (нүдний дотор байх тунгалаг бие).

БОМ сам. bhoma, мө.б. boum-a (Ков.); Багш сургагч.

БОМБО тө. bon bi; мө.б. bombi; 1. манай эриний эхэн буюу Дорнод хан улсын үед дэлгэрсэн, бомбын шашны сургаал ёсоор гэрээс гарч сүмд суух хувраг; *Бомбын увдис нэг тохой болоход шулмын уур нэг жан болно. (Зүйр);* 2. эрт үед бурхны шашны шавийг нэрлэж байсан нэр; 3. Төвдийн эртний уламжлалт

бөөгийн шашин шуглаа; Бон шашин; 4. Бомбын шашинтан, хар малгайтан; *Бурхангуй газар бомбо галзуурах (Зүйр);* Жич: бумба галзуурах гэдэг нь бомбын хазгай дуудлага болно.

БОНГО тө. bong nga; мө.б. bongyu; Aconitum excelsum Rohb; Холтсон цэцгийн нам, нэг метр орчим өндөр, маш том навчтай, саглагар олон наст ургамал. Ардын эмнэлэгт хэрэглэнэ; Чоно голын бонго (Сүхбаатар, Эрдэнэцагаан сум) ихэд алдаршсан бөгөөд жилд таван янзын нэрээр таван удаа тасалж авдаг.

БОНГОР тө. bong dkar; мө.б. bongvar; "Цагаан бон"; Ихэнхдээ шар цэцэгтэй, шүүс гашуун, хортой өвслөг ургамал. Монголоор холтсон цэцэг ч гэнэ.

БОНО манж. bunasu; мө.б. buna/bona; Хар гүйлстэй адил хатуу нэгэн зүйл жимс.

БОНЧИЛГО манж. pongcikki; мө.б. bongčilgi (Ков.); Далай тэнгисийн нэгэн зүйл загас.

БООВ хя. bo bo; мө.б. boobi; Гурилаар хийсэн идээ, хайрсан боов; *Боовчин* (боов хийх мэргэжилтэй хүн).

БООДУУ хя. ráodá; мө.б. booduu; Max ногоо зэргийг хэрчих хэрэгсэл. Чийдүү ч гэнэ.

БООШИГ орос. бочка; мө.б. boosių; Шингэн буюу тослог юм агуулах мод, төмөрлөгөөр хийсэн том сав.

БОРОД сам. vorodha; мө.б. boroda (Ков.); Олон навчтай мэлрэг (малига) цэцэг.

БОРОН манж. mogong; мө.б. bogung; Зэрлэг муур (Ков.); Багахан мануулаас томхон, шилүүстэй адил нэгэн зүйл амьтан.

БОТИД тө. 'pho khrid, мө.б. botid; "егүүтгэлийг хөтлөх"; 1. өнгөрсөн амьтныг сайн төрөл олоход нь унших тусгай увдис номлол буюу амийг нь хороочдоод сүнсийг нь сайн төрөлд хөтлөх; Потид ч гэнэ; 2. *шилж.* бодь ГҮ-ийг үз.

БОТЬ тө. poti=poti<сам. pustaka; мө.б. boti; Ном зохиолын хэсэгчилсэн дэвтэр; Ботилох (боть болгох).

БОШГО манж. bosohu; үй. bosuva; мө.б. bosoqu~bosovu; "хөөгч"; Хошуу тамга, сумын захиргааны газрын алба хөөж нийлүүлэх зарлага, доод түшмэл; сумын зарлага.

БӨДНӨ мө.б. bodun-e; Оготор сүүлтэй, хөх өрөвлөгтэй, хэрүүлч зодоонч шувуу. Ятууны төрлийн хээрийн шувуу. Бүд-тэй гарал нэг уг, бүдийн шувуу ч гэнэ.

БӨРТ түр. böri~böridä; мө.б. böritü; "чоно"; 1. нохойн төрлийн сүүн тэжээлтэн махчин, чоно; Бөрт чоно; 2. цагаан, саарал өнгө

зүсэнд оролцсон хар бор толбо; Улаан нүдэн бөрт улаан морио унав. (*Гэс.*)

БРАГ тө. *brag*, мо.б. *brag*(Ков.); Хад цохио, чулуу. Барагшин гэдэг үгийн өнцөг.

БРАГРИДА сам. *prarita*; мо.б. *bragrida* (Ков.); жинхэнэ; Эртний нэтхэгийн нэгэн аялгуу.

БРАГРИДИ сам. *prakriti*, мо.б.*bragridi* (Ков.); Аливаа бүх юмын эхлэл буюу эх булаг; байгаль, эхлэл.

БРАДИГА братига; өөрөө, тусдаа (Ков.).

БРАЙБУН тө. *'bras spungs*; мо.б. *brayibung*; "тутаргын овоолго";

1. Энэтхэгийн Орисса муж улсын гол хот Катакын эртний нэр Дааньякатаа гэсэн нэрийн төвд орчуулга; 2. Төвдийн Лхас хотоос баруун зүгт 4 бээрт 1416 онд лам Жамъян Цорж Даш Балдан (1379-1449)-ы үндэслэн байгуулсан Гэлүгтба (үз) нарын хамгийн том хийд, 7-8000 оршин суугчтай, 7 дацантай байжээ. Гоман дацанд нь их төлөв монгол, Сибирийн буриад, Ижил мөрний халимагууд суралцаж байсан. Бэрээвэн ч гэж нэрлэдэг. Бас Балдан Брайбун ч гэдэг.

БРАНИ барани.

БРАТИГА сам. *pratyeka*; мо.б. *bratika*; "өөрийгөө ялсан"; Хэнд ч ул түшиглэн ганц биеэрээ бясалгал хийж сансрын эцсийн хязгаарт ухэж төрөхийн зовлонгоос салахыг хэлнэ. Бурхны шашны хоёр бага хөлгөний нэг нь братигабудын хөлгөн; *Братига номыг эрхлэн гурван эрдэнэд итгэл явуулмой.* (*Пагва*).

БРАТИГАБУД сам. *pratyekabuddha*, мо.б. *bratikabud*; "өөрийгөө ялсан бурхан". Братига.

БРАТИМОГЧА сам. *pratimokṣa*; мо.б. *bratimogca* (Ков.); Ангид тонилгогч.

БРАХМА сам. *Brahma*, тө. *tshangs ra*, мо.б. *braham-a*; Эсрүн тэнгэр. Ертөнцийн бүх юмс үзэгдлийн эх үндэс буюу тэдгээрийг төрүүлэгч гэж Энэтхэгийн гүн ухаанд үздэг.

БОР: бор дарс; түр. *bor* (<перс.*bar*); "дарс үзэмний архи"; Архи айраг холин нэрж гаргасан, эсвэл айрагт жимсний зүйл найруулж иsgэн нэрж гаргасан архи.

БРИДАСАЗИН тө. *'bri da sa 'dzin*; мо.б. *bridasazin*; "Брида газрыг баригч"; *Polygonum aviculare*; Үдийн наран адил, нарийн улаан утас мэт ойр орчны өвсийг барьцалдуулан хэлхэж ургадаг завсар буюу хооронд нь өчүүхэн цагаан, улаан цэцэг, чавганы үр

мэт, амт чихэрлэг өвс. Бас гэсэл өвс, газар хэрэгч, малгайн залаа өвс, улаан утас, алтан утас гэхчлэн нэрлэнэ.

БРИТТА сам. *vṛitta*; мо.б. *britta*; Самгарди хэлний авиазүй, яруу найргийн нэр томъёо. Монгол орчуулгад хэвээр хэрэглэсэн байдаг. Шүлэгт үеийн тодорхой тоог баримтлан зохиох ёсыг хэлнэ.

БРУГ: бруг луу ; тө. *'brug klu*; мо.б. *brug*; "луу лус"; Сүм дуганын оройд байрлуулсан нэг зүйл гөрөөсний дурс. Зүүн дээвэр дээр минь *Бруг* луу нэрт гөрөөс тоглож байсан (*Гэс.*)

БУГ: буг эрдэнэ; тө. *spug*; мо.б. *buu*; Нэгэн зүйл эрдэнийн чулуу.

БУД сам. *budha*, мо.б. *bud*; Долоон гаригийн гутгаарх нь. Лхагва; Усан гариг ч гэнэ.

БУДДА сам. *buddha*; мо.б. *buddha*; Бурхан багшийн нэр, самгарди хэлний *buddh-* язгуур нь орос хэлний будить гэдэг үгийн язгууртай гарал нэг.

БУДЛАН тө. *po ta la ling*<сам.*potala*; "онгоц баригч уул"; 1. Инд мөрний аманд байх хот, боомт хийгээд уулын нэр; 2. Лхаст байдаг Далай ламын ордон; Лхасын дүүргийн баруун хойнох гурван үзүүрт оргилд байрласан барилгууд; *Будлан уулын орой дээр бурхдын чуулган хураад...* (*МААЗ*); Поталалинг ("Будал хийд") гэсэн төвд хэлбэр нь монгол хэлэнд гапнологийн хуулиар хураангуйлагдан Будалинг болохдоо аман зохиолын зүйлст зөвхөн уулыг нэрлэх үүрэгтэй болжээ; 3. Хэнтэйн нурууны нэг оргилын нэр болон монгол аман зохиолд гардаг уулын нэр; *Бургаст голын цаадах Будлан хан уул...харагдах тул, Самбуутийн сээгээл тэр газар очжээ.* (*Д.Цэв.*)

БУЙРУГ түр. *buıgıq* (*buıgu*-"зарлигда-"+*q* (нэр бүтээх дагавар); мо.б. *buuiguu* (МНТ); зарлиг, ноён цол, командлагч.

БУЛИГААР перс. *bulıarı*; мо.б. *bulıarı*; Үхэр адууны ширийг боловсруулан гаргаж хийсэн эд.

БУЛНАЙ тө. *'bul gnas*; мо.б. *bulnai*; "өргөлийн орон"; Хөвсгөл, Завхан аймгийн хилийн заагт орших үргэлжилсэн урт нуруу ба далайн төвшнөөс дээш 2612 м өндөр уул.

БУМ тө. *'bum*; мо.б. *bum*; Арван түм буюу зуун мянга. Лагчаа буюу лагшаа ч гэнэ.

БУМБА тө. *bumra/phom* ра; мо.б. *bumba*; 1. алт, мөнгө, зэс тэргүүтнээр хийсэн рашаан хийдэг өндөр хүзүүтэй бариулгүй сав; 2. *шилж*. чандар агуулах лонх буюу хайрцааг; 3. *шилж*. хий

сийрэгжүүлэн соруулах бумбагар сав; бумба тавих; 4. бунхан; бумба бунхан хорш; бумбалах (рашаалах, оршуулах); бумбадах (бумба тавих).

БУНДАРИГА сам. *runfarikā*; мо.б. *bundariy-a*; (тө. *pad ma dkar po*); Цагаан лянхуа цэцэг; *Будангуй балчиг шаврын дундаас бундарига нэрт цэцэг ургасан мэт (МУЗД-1)*.

БУНДХОРЛО тө. *bon gta'* (*gto*) 'khor lo; мо.б. *bondo qorlo*; "Бомбын дарлагын хүрд"; Яст мэлхийн элгэн дээрх хурдэнд дээрээс доош, мөн хөндлөн буюу дөрвөн өнцгөөс хошуулдан нэмэхэд цөм арван тав болох тоог гурав гурван мөр болгон бичиж, есөн мэнгэ, долоон гариг, хорин найман од тэргүүтнийг оршуулж, яст мэлхийн эргэн тойронд арван хоёр жилийн амьтан зурж, найман хөлөл дүрслээд завсар өнцөгт нь хас тэмдэг зурсан дурс буюу нэг зүйл савдаг. Угтаа бомбын шашны дарлагын билэгдэл болгож гаргасан. Хожуу үед айл өрх тогтон дээрээ залж муу ад зэтгэрийг дарах утгыг билэгдэн хэрэглэх болжээ. Бас аян замд явагсдыг аливаа муу зүгийн хорлол, зэтгэрээс хамгаалахын билэгдэл сахиус гэдэг.

БУНХАН тө. *sprungs khan*; мо.б. *bungqan*; "цогцсын байшин"; 1. нас барсан хүний шарил, чандар агуулсан орон барилга, онгон ч гэдэг; 2. *хууч*. тайж тавиглахаар бурхны хөргийг хийж булсан шороо чулуун овоо.

БУРАМ тө. *bu gam* (<сам.*bigrat*); мо.б. *bigrat*; "чихэрлэгийн ханд"; 1. нишингэ, чихэрлэг зүйл, ногoo зэргээс боловсруулан гаргасан хар бор, хар шар, улаан бор зэрэг өнгөтэй чихэр амтат идээ, шатан ч гэнэ; шар бурам (чихрийн шаар); цагаан бурам (цасан чихэр); татмал бурам (турил тостой чанасан бурам); *Бурам хэдий амттай ч будааны оронд орохгүй (зүйр)*; 2. чихэр, шавдлын гадуурхи цан мэт цагаан зүйл; чихэр шавдлын бурам.

БУРАНТАГ түр. *burunduq*; мо.б. *burantaγ*; Энэ угийн *burgh* нь хамар гэсэн утгатай. Тэмээний буйлнаас уяж хотлох нарийн оосор; бурантаглах (тэмээний буйланд бурантаг уях).

БУРСАН уй. *bursang* (=сам.*samgha*); мо.б. *bursang*; Олон хувраг буюу сүм хийдэд сууж хурал ном үйлдэгсэд; *хорш*. бурсан хувраг.

БУРХАН сам. *buddha*; мо.б. *burgan*; 1. монгол, түрэг хэлнээ ямар нэг зурмал, сийлмэл, цутгамал бурхдыг нэрлэх ерөнхий нэр; 2. бурхан багш-Шагимуни бурхны нэр.

БУТАН I манж. *poton*; мо.б. *butung*; Архи дарсны шавар сав, ваар.

БУТАН II сам. *bhūtān*; мо.б. *butan*; Хималайн вант улсын нэг.

БУТАНИ сам. *bhūtāni*; тө. *ru' ta ni*; мо.б. *butani*; Бодинар.

БУУ I хя. *bāo*; мо.б. *biši*; Шооны нүхийг таалцан наадах мөрийтэй тоглоом. Онх ч гэдэг.

БУУ II хя. *rāo*; мо.б. *biši*; Галт сум харвах нарийн амтай зэвсэг, бүдүүн амтайг нь пуу гэнэ.

БУУ III манж. *bō*; мо.б. *biši*; буу загас = халим загас.

БУУДАЙ түр. *buγdai*; мо.б. *biγdai*; 1. цагаан турил хийдэг тариа; 2. *шилж*. цагаан бор зүстэй малын үсэн дэх жижигхэн бараан борт.

БУУЗ хя. *bāo zi*; мо.б. *bišiža*; Татсан хярсан мах ногоог элдсэн турилд боож жигнэх хоол.

БУУРЦАГ түр. *burčaq*; мо.б. *burčaγ/buyurčaγ*; Хуй дотор үрэлдэг ургамлын мөхлөг амуу.

БУУРЧ түр. *bawrsi*; мо.б. *bavurci*; 1. тогооч; 2. дэн буудал.

БУХААР түр. *biqaq*; мо.б. *biqarī*; Боловсруулж элдсэн адууны шир. Гөлөм, дэвс, гутал зэргийг хийдэг. Анх бухаар газарт хийж байсан учир тэр орных нь нэрээр нэрлэсэн учиртай.

БУХАР согд. *Vīγ'g* (<сам.*vihara*); мо.б. *biqaq*; Лам нарын хуран суух сүм орон, хийд; ...*бухар даган он сууж...* (*Турф.*); Бухар тариалин (тариа тариагүй тарианы газар).

БУШГАРМУЛ сам. *pushkaramula*; мо.б. *busγarmula*; Манын нэгэн төрөлд багтах, цагаан шилбэтэй, гашуун амттай, жижиг шар цэцэг.

БУШИЛЗ тө. *ri sél tse*; мо.б. *busilža*; *Vetiveria zizanioides*; Үзүүр нь дээрс адил, нэг ишинд 3-6 ширхэг, үндэс цагаан шөрмөстэй, үнэр сайхан, олон давхар хальстай ургамал.

БУЯН сам. *riṇya*; мо.б. *biuap*; "ариун, нандин, сайн"; 1. аз жаргал эдлэх ерөөл тавилан; 2. *шилж*. өвөг дээдсийн өмчлүүлж үлдээсэн хөрөнгө зоорь; эцгийн буян.

БҮД сам. *bhūta*; мо.б. *bud*, *buda*; Дундад эртний монгол бичгийн дурсгалд самгарди хэлбэрээр нь *bxuda-bhud* гэж бичсэн байдаг. Чөтгөр шулам, хүмүн бусын адууд; *хорш*. адас бүдэс; Бхуди (үз); Бүдийн сахиус (шулам адын эсрэг зүүх зангиа); Бүдийн шувуу (ууль, шөнийн шувуу).

БУМИ сам. *bhūmi*; мо.б. *bumi/bhumi*; Газар орон, нутаг (Ков.).

БУРИ түр. *büri/böri-böröite*; мо.б. *büri*; бор (саарал); нохойтой адил, чононоос бага, шар өнгийн чоно. Шарнууд ч гэнэ. *cogeburi* ("жижиг чоно" -цөөвөр) гэдэг угийн -büri болно.

БҮРВААБАДРАБААД сам. *rūrvabhadrapadā*; мө.б. *burvaba dirabād*; 1. сарны зурхайн ёсны хорин найман оды нэг, их суна одон ч гэнэ. Мөн Шувуун хүшүүт од ч гэнэ; 2. Энэтхэгийн намрын эхэн сар, цагийн хүрдний зуны адаг сар, хягад төвдийн намрын дундад тахиа сар, монголын наймдугаар сар.

БҮРВААБАЛГҮНЬ сам. *rūrvaphalgunī*; мө.б. *burvabalguni*; Сарны зурхайн ёсны хорин найман оды нэг, дөрвөлжин тушаа хэлбэртэй дөрвөн од бий. Монгол нэр нь Хашгирахуй цөөвөр одон болно. Бага морь од ч гэнэ.

БҮРВААСАД сам. *rūrvāshādhā*; мө.б. *burvasad/burvasad*; 1. сарны зурхайн ёсны хорин найман оды нэг. Долоон өлзийт баян одон гэж Монголоор нэрлэдэг; Бас Сулга од ч гэнэ; 2. Энэтхэгийн зуны дундад сар, цагийн хүрднээ зуны эхэн сар, хягад төвдийн хонин сар, монголын зургадугаар сар; ...*Жич бас шороо тахиа жил бурвасад сарын арван наймнаа...* (*Сув.эр.*)

БҮРНАВААС сам. *runarvasu*; мө.б. *burnavasu*; Сарны зурхайн ёсны хорин найман оды нэг. Өлзий хишгийн одон буюу Жуулчны мөр тэтгэгч одон. Бас Өглөгт охин ч гэнэ.

БҮРЭЛБАА тө. *sigrūl ba*; мө.б. *bürilba/bürili-a*; 1. ламын шашинтны дотор олны итгэл бишрэлийг хамгийн ихээр олсон, үе үед маш сонин байдлаар төрөл дүр нь тодордог бөгөөд бодгд гэгээнтний дэсийн лам, хувилгаан ч гэдэг. Бүрэлбаа нарын дотроос ихэд нэр алдар хүртсэн нь болох Далай ламыг Ядам бурхан, Хонсим бодисаддын бүрэлбаа, Банчин ламыг Авид бурхны бүрэлбаа, Жавзандамба хутагтыг Майдар бурхны бүрэлбаа, Жанжаа хутагтыг Манзшир бурхны бүрэлбаа гэж үздэг; 2. Юманд хувилж чаддаг чадал бүхий зүйл; Бүрэлбаа эм (маш чадалтай сайн эм); 3. *шилж хийсвэр ухагдахуны бодтой дурс.*

БҮС уй. *rič* (<сам.*pushya*); мө.б. *bus*; 1. сарны зурхайн ёсны хорин найман оды нэг, Бүтэхүй одон ч гэдэг. Хонины хоргол мэт турван од бий гэдэг. Бас ганц өнчин улсын эзэн одон гэх нь бий; 2. Энэтхэгийн өвлийн дундад сар, цагийн хүрднээ өвлийн эхэн сар, хягад төвдийн үхэр сар, монголын арван хоёрдугаар буюу хөхлөр сар болно; ...*шороо гахай жил бүс сарын хорин хоёрдоо олон зүйл ариун үзэгдлийг айлдаж...* (*Pag.*)

БҮСРЭГ: бүсрэг яр ; хя. *fei tsee*; мө.б. *büsürgüg*; Улайлцан барзайж гарах яр, товх яр, бусраг ч гэнэ.

БХААРАД сам. *bhārata*; мө.б. *bharad/barad*; Эртний Энэтхэгийн нэгэн хааны нэр. Энэтхэгчүүд одоо өөрсдийгүй нэрлэх нэр,

Бхаарадын удам ч гэдэг. Махаабхаарад (их бхаарад) гэдэг үгийн өнцөг.

БХУДИ бүд (үз); *Нарны гэрэл ургахуйд бхудийн шувуунууд сохрох болоюу (Turpf.)*.

БЭГТЭР түр. *bäktär*; (перс.*bagtar*); мө.б. *begter*; Дотор хуяг, даасан цэргийн хуяг; *Бэгтэр цагаан хуягаа өмсөв (Гэс.)*.

БЭД I вээд.

БЭД II тө. *be ta* (<сам.*vēta*); мө.б. *bete/beda*; Нэг зүйл жимс. Иш мод нь гүег модны адил, хальсны гадуур бүдүүн арьстай, дотроо гуч илүү үртэй, амтлаг шар устай, их ууваас согтоно. Хальсаар нь хувин, аяга, уур хийнэ. Наргил ч гэдэг.

БЭДЭС сам. *vetasa*; тө. *be ta sa*; мө.б. *bedasa/bedese*; Энэтхэгт ургадаг хулс, зэгс.

БЭЙЛ манж. *beile*; мө.б. *beyile*; "тэргүүн сайд"; Манж, Богд хаант улсын үед Монголын феодалын хэрэглэж байсан хэтэрхий дөрвөн зэргийн гутгаарх нь.

БЭЙС манж. *beise*; мө.б. *beyis*; Манж, Богд хаант улсын үед Монголын феодалын хэрэглэж байсан хэтэрхий дөрвөн хэргэмийн дөрөвдүгээр зэрэг.

БЭН хя. *bēn*; мө.б. *ben-e*; 1. эх мөнгө, бэл зоос; бэл бэн алдах (мөнгө зоосоор дутагдах); 2. үнэ цэн; үнэ бэнгүй ажил.

БЭНЗЭЧ. үз. бэнс. Бэнсэн үлгэр хэлдэг хүн.

БЭНС хя. *rep zi*; мө.б. *bense*; "дэвтэр", хягадын сонгомол зохиолын Монгол орчуулгыг Монголын хуурч үлгэрч нар үгийн уран сайхнаар улам чимэн баяжуулж, олон хоногоор үргэлжлэн хэлэх ардын аман зохиолын нэг том төрөл бий болгосныг хэлнэ. Бэнсний үлгэр нь шүлэглэсэн ба үргэлжилсэн хэлбэртэй байдгаараа онцлогтой. Хягад хэлний *zī* гэсэн нэр үүсгэх дагавар нь Монголд -sa/se болж солигддог тохиол буй тул бэнзи нь бэнсэ болсон учиртай. Халхын зарим аялгуунд энэ нэр "дууны цоморлиг дэвтэр" гэсэн утгатай.

БЭНЧИН хя. *bēn chin*; мө.б. *binčin*; Бэл хөрөнгө чинээ.

БЭРЖЭЭНХ оп. брезент; мө.б. *brezent*; Майхан, бүрээс, шалны дэвсгэр буюу бороо салхинаас хамгаалах ба нэвчихгүй хувцас, цув зэргийг хийх бэржгэр зузаан бөс. Бас брезент гэж ч бичдэг.

БЭРС перс. *farzīn*; мө.б. *berse*; 1. шатрын гол хүчтэний нэг; 2. үлэмж давуу хүчтэн; 3. эмэгчин барс.

БЭРТЭГЧИН сам. *prathagjāna*; мө.б. *bertegčin*; (*prathag* "эгэл"+*jāna* "төрөлхтөн, хүн"); 1. өтөл, эгэл жир; *хорш*. өтөл бэртэгчин; 2. амин хувна хичээсэн явцуу үзэл баримтлагч; бэртэгчин үзэл; 3. ядуу доожгүй амьдралтай хүн.

БЭРЭЭ тө. *ber ka*; мө.б. *bergū-e*; 1. зодох балбахад зориулсан нарийн моголцог мод, шийдэм, бороохой; гэсгүй бэрээ, гарын бэрээ; бэрээдэх (бэрээгээр цохих); 2. манж нарын тариалинд хэрэглэж байсан нэг зүйл хэрэгсэл.

БЭРЭЭВЭН Брайбун гэдэг нэрийн хувирсан хэлбэр. Ийм нэртэй хийд Монголд цөөнгүй байжээ.

БЭРЭЭМЭГ тө. *'bri mog*; мө.б. *berimog*; *Macrotonia euchromia*; 1. бүдүүн үндэстэй, хар бор хальстай, улаан будаг гардаг олон наст өвс; 2. мөн өвсийг тосонд чанаж гаргасан улаан тосон будаг; *Гурилаар хийж бэрээмгээр будсан* (Ц.Ц); бэрээмэгдэх (а. өвс нүдээд шар тосонд буцалган улаан болгох ;2. өвс нүдэж усанд хийж цаастай буцалган өнгийн цаас хийхийг нь).

БЭРЭЭСИЙ тө. *'bras sil*; мө.б. *beregesei*; "жигнэсэн тутрага"; шар тос, чихэрлэг амттан, үзэм зэргээр амталж хачирласан жигнэсэн тутрага, бэрээсэй ч гэж бичдэг. Уг нь хулсны навчинд боож жигнэсэн тутрагын идээг хэлдэг байж.

БЭХ түр. *bek*; мө.б. *beki*; бат бэх, бөх, хатуу чанга, хэврэг бус; *хорш*. бэх бат.

БЭХИ түр. *beki* (хя. *rek'i*); мө.б. *beki*; "ноён, эрх баригч"; 1. хаад ноёдын охины хүндэтгэл; 2. эртний ноёны зэрэг цол.

БЭЭР сам. *para(sanga)*; мө.б. *berg-e*; Найман гөршийн хэмжээ. Бараг дөрвөн газартай тэнцэнэ.

БЯЛАР түр. *bylər* (манж. *pileri*); мө.б. *bilar*; Бийв ба цартай бишгүүр.

БЯЛБА тө. *bil ba* (<сам. *vilva*); мө.б. *bilba*; *Aegle marmelos*; Өндөглөг хэлбэртэй, тун амтлаг, эмийн найрлагад ордог жимс. Навчийг Шива шүтлэгийн зан үйлд хэрэглэдэг. Нас барагсын цогцыг чандарлах үест энэ жимсний модыг шатаадаг. Гадир жимс ч гэдэг.

БЯМБА I сам. *bimba*; мө.б. *bimba*; *Momordica Monodelpha*; Хулуу хэлбэрийн хурц улаан өнгийн жимс. Уран зохиолд залуу эмэгтэй буюу үзэсгэлэнт охины уруулыг энэ жимсээр зүйрлэдэг байжээ; *Болсон бямба уруултан, бүлтийсэн чийрэг хөхтөн* (12 зох.).

БЯМБА II тө. *spen ra*; мө.б. *bimbä*; 1. долоон гаригийн зургадугаар өдөр буюу санчир; 2. нарны аймгийн нэгэн өртөнц.

БЯРГА = бирга.

БЯРДААН яриа. ор. берданка; мө.б. *birdang*, берданин (ОМТ) буу ч гэнэ. Сумыг нь нэг нэг дарж буудах буу.

БЯРМАН уй. *bramin<bramn* < согд. *pr"mn~pr'm'n<сам. brahman*; мө.б. *birman*; "Эсруагаас гарсан"; Олноо өргөгдсөн хаан, гэмтнийг цаазаар гэсгээн засаглахыг үзэж уйттар төрөөд зарим хүн ойн завсар, аглагт одож сууснаар бярман язгуур гарсан гэж эртний сударт гардаг. Эртний Энэтхэгийн дөрвөн их язгуурын анхдугаарх нь. Нийгэмд ноёлогч байр суурь эзэлж, байсан тул эрхэм язгууртанд орж байжээ. Бярманыг дотор нь: аглагт даяанчилдаг бярман, гэрт суудаг бярман, агийн ид чадлыг эзэмшил бярман гэж гурав хувааж байжээ. Бярман хүн зургаан дадгалтай нь: тахил өглөг гүйцэтгэх, үйлдэхүйд орох, ариун ном уншиж цээжлэх, нууцыг тайлах, өгснийг авах, аваходаа ухаалаг байх эдгээр болно. Бярманчин (аглаг сахигч).

БЯРУУЗАНА сам. *vairocana*; тө. *gnat par snang mdzad*; мө.б. *Birojan-a*; "маш гийгүүлэн зохиогч"; Язгуурын таван бурхны тэргүүн, цагаан өнгөөр дурслэн зурсан байдаг. Тэнгэрийн оройд орших диваажингийн хамгийн дээд хэсгийг ахлан суудаг.

БЯСМАН сам. *Vaishrāvāṇa*; мө.б. *bisman*; 1. мал баялагийн эзэн тэнгэр. Намсрай ч гэнэ; *Бясман тэнгэрийн эрдэнийн хулганын амаас буух буян хишигийг гүйнам* (Зуун бил.); 2. дөрвөн махранзын нэг.

B

ВААДАН зөрч. *wadang*; мө.б. *vadang*; Юм боож баглах дөрвөлжин бөс; ваадагнах (вааданд ороох).

ВААР хя. *wā*; мө.б. *vayag*; 1. наанги улаан шороогоор барьж, галд шатаан хийсэн сав суулга; 2. байшин барилгын дээвэр хийдэг маттар хэлбэрийн тоосго; ваарлах (а. барилгын дээврийг ваараар өнгөлөх; б. ус үерт идэгдэн газарт хөндий нүх бий болох нь); ваар бялзуухай (гэрт байгаа ваарын завсарт үүрээ засах хятрауу бялзуухай); ваарч (ваар сав хийдэг хүн).

ВАЙБРАНЗ сам. *vaibhrāja*; мө.б. *vaibarāṇja*; Узэсгэлэнт сайхан цэцэрлэгийн нэр; *Вайбранз цэцэрлэгт тэнгэрийн дууч сайхан эмстэй өдөр алгасалгүй цэнгэн жаргаж...* (Кали).

ВАЙБХАШИК сам. *vaibhaśika*; мөб. *vayibasiy*; Ялгавартай үзэл (Ков.).

ВАЙДАРБА сам. *vaidarbha*; мөб. *bayidarba*; Эртний Энэтхэгийн уран зохиолын нэг гол чиглэл. Өмнөдийнхний чиглэл ч гэдэг. Зохист аялгууч Дандины баримталдаг байсан сургууль. Энэ чиглэлийнхэн найруулгын арван эрдмийг чухалд үзэж байжээ.

ВАЙДУРИ биндэрьяа; мөб. *vayiduri*; *Алтан мэт вайдури эрдэнээр...* (Зуун бил).

ВАЙДУРЬЯА вайдури; мөб. *vayiduriy-a*; *Гарын алса мэт тэгш вайдурьяа эрдэнээр төрөлх жаламган болтугай* (Зуун бил.).

ВАЙСАКА сам. *vaiśakhā*; мөб. *vayisaka*; "бал үүсгэгч сар"; Жилийн дөрөвдүгээр сар (Ков.).

ВАЙСАЛИ сам. *vaisālī*; мөб. *vayisali*; Вайсали балгас, монгол судар бичигт олонтаа гардаг, Энэтхэгийн Бихаар муж улсын нутагт байсан Личхав аймаг улсын нийслэл байжээ. Энэ хотын Чаапаал гэдэг сүмд Бурхан багши хайрт шавь Аанандад хандаж "Одоо би гурван сарын дараа нас эцэслэнэ" гэж хэлсэн нь ёсоор болсон гэдэг. Бас энэ газарт Бурхан багши оюун билгээр мөхөс их хөлгөний зарим шавь нартаяа зориулж гутгаар сургаалаа айлдсан ажээ.

ВАЙШЕШИКА сам. *vaiśeshika*; МЭӨ YI-Y зууны үед Канада гэдэг эрдэмтний хөгжүүлсэн эртний Энэтхэгийн гүн ухааны тогтолцоо. Байгаа бүхэнд субстанц, чанар, үйлдэл, нийтлэг, онцлог, өвөрмөц, хоосон гэсэн долоон ай байдаг гэж үзнэ. Эхний гурав нь бодтой оршино, сүүлчийн дөрөв нь оюун санааны үйл ажиллагаанаас бий болно гэдэг чанар, үйлийн субстанцаас ертөнц бүрдэнэ. Газар, ус, гэрэл, агаар, хий, цаг, орон, санаа, ухаан гэсэн есөн субстанц бий гэж нотолдог. Эхний дөрвөн сувстанцын атом нь материаллаг юмыг бүтээнэ. Атом мөнх, задрахгүй, үзэгдэхгүй атлаа бүхнийг үүсгэнэ. Атом ямагт хөдөлгөөнд байна. Иймээс цаг, орон, хийд орших ертөнц бий болж, устаж байдаг гэж үзнэ.

ВАКТРА сам. *vaktra*; мөб. *vaktar-a*; Эртний самгарди шүүлгийн хэмжлийн нэр.

ВАН I тө. *dbang*; мөб. *vang*; "эрх, хүч чадал"; = авшиг.

ВАН II хя. *wáng*; мөб. *vang*; 1. эзэнт улсын засгийн тэргүүний тушаал, эртний монгол хэлэнд *ong* гэж бичдэг байв; 2. вант улсын тэргүүний тушаал. Засаг төрийн тэргүүнийг ван захирсан толгойлсон улсыг вант улс гэнэ; 3. Манж чин улсын үеийн

хэтэрхий дөрвөн хэргээний нэгдүгээр зэрэг. Богд хаант Монгол улсын үед ван хэргэм дээр "Чин ван", "Жун ван" гэсэн хоёр зэрэг нэмж байжээ.

ВАНДАН I хя. *wānduàn*; мөб. *vangdan*; Дунд зэргийн нэгэн зүйл хадаг, төвдөөр соном хадаг ч гэнэ.

ВАНДАН II бандан; мөб. *vangdang*.

ВАНДУЙ хя. *bian dòu*; мөб. *vangdui*; "шоп, сэвэг зарам"; Нэг наст буурцагт ургамал. Үр нь тэжээллэг чанартай.

ВАНЛАГ банлаг; мөб. *vanglay*; (Ц.Ц).

ВАНСЭМБЭРҮҮ тө. *spang mtshan spu tu*; мөб. *vang semberu*; Нийлмэл баг цэцгийн намын олон наст ургамал, 30 орчим см өндөр олон шилбэтэй, навч зууван, хоёр талдаа иртэй. Арын эмнэлэгт хэрэглэнэ; *Тэгээд энэ вансэмбэрүүг тэнгэрийн цэцэг гэж нэрлэсэн гэнэм.* (Б.Я.).

ВАНЧУУ хя. *wāng chū*; мөб. *vangčuu*; Ширүүн даргар артай нэгэн зүйл нэхмэл панс.

ВАРАНАСИЙ: сам. *Varanasi*, мөб. *Varanasi*; *Varuna*, *Asi* хэмээх хоёр голын нэрийн нийлэмж, Энэтхэгийн Ганг мөрний эрэгт орших балгас. Эрт үедээ Кааший ("Зулын хот") нэртэй байжээ. Шраваг нарт зориулж Бурхан багши дөрвөн үнэний сургаалаа энд номлосон ажээ.

ВАРДУ сам. *vartula*; мөб. *vardu*; "дугуй, дүргэг"; Эртний Энэтхэгийн нэгэн зүйл үсэг. Варду үсэг ("дугуй үсэг") гэдэг.

ВАРУНА сам. *Varuṇa*; тө. *wa-ru na*; мөб. *Varun-a*; Варанаси гэдэг хотын нэрд орж явваа варуна мөн; 1. Вээдийн гол тэнгэrsийн нэг, тэнгэр огторгуйн биелсэн дүр. Усны тэнгэр; 2. *Tapia cartaeva capparis trifoliata* модны нэр.

ВАРУУ хя. *wāluō*; мөб. *varu*; Тусгай хайрцагаар хийж шатааж боловсруулсан, алт мөнгийг хайлцуулах, галууны өндөг мэт жижигхэн ваар, хампар ч гэнэ.

ВАЧИР очир; мөб. *vacīr*.

ВИВАНХИРИД сам. *vivākṛta*; мөб. *vivangkirid* = лүндэн. Бодисадва нар ба шарвааг тэргүүтэн өнгөрсөн, ирээдүй, одоо гурван цагт юу болсон, болох, бодгалисын үхэх егүүтэх хийтээд хaa төрөх тэргүүтнийг, бусдын эс онон тайлсныг тодорхой зааж үзүүлсэн зарлиг.

ВИДАР сам. *vetāla*; мөб. *vidar* = ороолон. Энэтхэг төвдийн домогт гардгаар үхсэн хүний бие, булши мөдөнд орогнодог хортон сүнс.

ВИНАЙ сам. *vinaya*; мөб. *binai/vinai*; "номхотгол"; Бурхны шашны лам хуврагуудын сахил санваар, ёс журмын номлол. Винайн аймгийг судрын, шастирын гэж хоёр хуваах бөгөөд "Ганжуур"-т 13 боть бий. Эдгээрийг үндсэн судар, номлох судар, зүг зохицуулах судар (хуврагийн суралцах эрдэм) гэж ялгаж үзнэ.

ВИХАР сам. *vihara*; мөб. *viqar/viqar*; Энэ үг эхэн үедээ амралт цэнгээний газар гэсэн утгатай байв. Хожуугийн бүддизмд даяанч гэлэн хуврагууд хурын улирлын үед цэцэрлэг, агуй зэрэгт хоргодон суух газар гэсэн утгатай болсон. Бухарыг үз.

ВИШАЙ сам. *vishaya* (тө. *yul*); мөб. *visai*; Шашны ёсноо таван эрхтэнд сэргэдэх юм. Бүддийн гүн ухаанд хүний оюун ухааны бүх оногдохуй буюу гадаад орчин ахуйг хэлнэ. Монголоор орон ч гэдэг. Эрхтэн тус бүр нэг нэг вишайг мэдрэх ба эрхтэн вишай хоёр нэгдэж тийн мэдлэгийг үүсгэнэ гэж үздэг. Вишайн цанид (оюунаар ухааран мэдэж болох бүх юм); зургаан вишай (өнгө, дуу, амт, үнэр, дурс, ном); таван вишай (мэдрэхийн таван эрхтэн).

ВИШАЙТ сам. *vishayat* (тө. *yulcan*); мөб. *visayitu*; Бүддийн гүн ухаанд үзэгдэл юмсыг танин баригч сэтгэхүйг хэлнэ.

ВИШНУ сам. *vishnu* (тө. *khyab 'jug*); мөб. *visnu*; "түгээмэл орлогот"; Хинду шашны гурвал тэнгэрийн нэг, ертөнцийг хамгаалагч. Хүн амьтан хоёрын нийлэг дүрээр Дайтын хаан мангасын эзэрхийллээс ертөнцийг аварч хамгаалдаар домогт гардаг. Үүнийг нь хүн байгалийг ялан дийлсний билэг тэмдэг гэж үздэг ажээ.

ВИЯАКИРИД виванхирид; ...энэ олон бурхадад элдвээр тахиж *Divan gar* бурхнаа вияакирид өгтөлүгээ. (12 зох.).

ВЭД сам. *veda*; мөб. *ved/vid*; "мэдлэг, ухаан"; Эртний Энэтхэгийн уламжлалт төрт ёсны дөрвөн их шашдир. Тахил өглөг, магад өгүүлэл, төр сахихуй, яруу үгсийн гэсэн дөрвөн зүйл вэд бий. Эхнийх нь өндөр язгуурын тул тахил өглөг үйлдэх, хоёрдугаарх нь нэр үгсийн магадыг бүгээх, гутгаарх нь хан төр тэргүүтнийг сахих хийгээд хөгжүүлэх, дөтүгээрх нь яруу сайхан шулэглэл болно. Бурхны шашны утга зохиолд тэмдэгт ухаан, дуун ухаан, урлах ухаан, тэжээх ухааны дөрвөн зүйл шастирыг нэрлэнэ. Нийтийн ёсоор "ухааны дөрвөн орон" гэнэ. Эдгээрт "дотоод ухаан" буюу бурхны шашны гүн ухааны сургаалыг нэмж "ухааны таван их орон" болгодог.

ВЭ хя. *wei*; мөб. *vei*; Үйрмэг юмны хэмжүүр. Арван шиан нэг вэ болно.

Г

ГА: га тамга; тө. ка; мөб. үа; төвд бичгийн ка үсгийн хэлбэртэй, малын тамга.

ГАА тө. *ska*; мөб. үа; Үндэслэг иш нь шаравтар өнгөтэй, гашуун амттай, дулаан орны олон наст бутлаг ургамал. Үндсээр нь хоол хүнсний амтлагч хийнэ. Цагаан гаа_ улаан гаа, бор гаа гэж ялгаж үзнэ.

ГААДАМБА I сам. *kadamba-kādamba*; мөб. *yatamba*; *Nauclea Cadamba*; Эртний Энэтхэгийн яруу найрагт олонтаа гардаг мод, цэцгийн нэр. Тансаг үнэрт цэцэгтэй мод гэдэг.

ГААДАМБА II тө. *bka' gtams* ра; мөб. *yatamba*; "сургаал зарлиг"; Бурхны зарлигийг тэмдэглэсэн талаараа нэг ч үг үсгийг зорчихгүй, аливаа номлосон зүйл нь цөм гаадам (сургаал зарлиг) мөн гэх утгаар үүссэн шарын шашны нэг том салбар. Үүнийг анх 1038 онд Энэтхэгээс төвдөд ирсэн Адишаа богд (980-1052) үүсгэсэн. Энэ салбарын үндсэн судар болох "Бодь мөрийн зул"-ыг зохиосон, үүнд бурхны зарлиг болох "турван аймаг савын" бүх утгыг хурааж, үүнийг баримталж явбал бурхны зарлигийг дагасан хэрэг болно гэдгийг тодорхойлсон.

ГААЖУДБАА тө. *bka'tgyud* ра; мөб. *yajudba*; "зарлигийн залгамж"; Шарын шашны энэ салбарыг үүсгэсэн богд марвын багш Нарова, түүний багш Дилав нар болно. Тэд шашны ёсны номлолыг хувилгаан сэргээр шууд урьд үеэсээ уламжлан хүртсэн гэдэг. Тиймээс шашны номлол зарлигийг үе үе хувилгаан сэргээр залгамжилдаг гэж үздэг байжээ.

ГААНС хя. *gän zi*; мөб. *yangsa*; Төмөрлөг буюу модон толгойтой, хондий гуурс модоор иш хийж, хас, мана, пийсүү зэрэг чулуугаар соруул үйлдэх амны тамхи нэрж татах хэрэгсэл.

ГААРАМБА тө. *dka' rims* ра; мөб. *yaramba*; Бурхны шашны таван ухааны зиндаанд суралцан төгссөн хүнд олгох цол, аграмба ч гэнэ; *Цанидын ном үзэж төгссөн гаарамба болохын тулд 13 жил хэрэгтэй байжээ. (Л.Т.)*

ГАВАГ тө. *bka' bsko*; мөб. *yaba*; "зарлиг тушаах"; Аливаа хүнийг гадна дотнын элдэв гай барцдаас хамгаалах утгатай ном унших шашны зан үйл; Гаваг тавих.

ГАВАЛ сам. kapāla; мө.б. yabala; 1. хүний толгойн ясны оройн хэсэг; гавал эрих (108 хүний толгойн яснаас нэг нэг бөөрөнхий яс авч хийсэн тарни урихад хэрэглэх эрих); гавал аяга, гавал дамар ч гэж бий; Доржсэндэн гавал (rdo rje tshan ldan ka pa la; "Очир билэгт гавал"; даалуугаар наадахад гавал есийг дуудах гунишин); 2. адгуус амьтны толгойн оройн хэсэг; 3. тэргүүн, толгой; *Сайд бээр дээдсийг гавал мэт хундэлмуй (Цаг.лян.); 4. шилж машин техник зэрэг юмын эд ангийн таг хавхаг; гавлын жийргэвч.*

ГАВАР тө. ga bur (<сам. karpura> ар. kafur); мө.б. yabar; Синапотум camphora; 1. өндөр нь 20-50 м, голчоороо 2,5 м, хату бөх навчтай, цагаан цайвар цэцэгтэй, сайхан анхилагтай мөнх ногоон мод. Заарт мод ч гэдэг; 2. Dryobalanops aromatica; Гавар модноос гаргаж авдаг, онцгой хурц үнэртэй, талст бүхий тунгалаг бодос, эмнэлэг, техникт хэрэглэнэ.

ГАВЖ тө. dka'bci; мө.б. yabju/yabji; "арван бэрхийг мэдэгч"; Цанид дацанд суралцан шалгадаг ухаан, билэг бармид, дундад үзэл, илт ном, винайн таван боть буюу судрын аймгийг тайлбарын хамтаар дэлгэрүүлэн эзэмшиж мэргэшээд дамжаа барьж эрдмийн зэрэг хамгаалсан хүнд олгож байсан зэрэг.

ГАВИР тө. ga bra; мө.б. yabir; Шар, цагаан зэрэг цэцэгтэй, зузаан том навчтай, олон наст бутлаг ургамал.

ГАВИШАР тө. ka ri ſa ra (<сам.); мө.б. yabisar; уй. kabusara; Бурхны номд гургуулыг нэрлэх нэр.

ГАГАЛ сам. kakola (> тө. ka ko la); мө.б. yaayı; Amonum medium lour; Арутай төстэй, нимгэн боровтор хальстай, үнэр амтаар гавартай адилдуу тослог үр. Дөрвөн сайхан үнэртний нэг.

ГАГЛАХ тө. 'gag ra; мө.б. yaylaqu; "хорих, хаах" (Ю.Р.); гэг-ийн хувирсан үйл үг.

ГАДАР сам. katora (>тө.ga то ga); мө.б.yadur-a; Нимгэн төмөрлөгөөр хийсэн ялбагар гүехэн төмпөн сав, таваг; *Олон гадар тавагт идээ тавьжээ (С.Д.).*

ГАДИЛ сам. kadalī; мө.б. yađil; Banana, Musa Sapientum; Халуун оронд ургадаг олон наст бутгархаг мод. Өргөн далбагар навчтай, шилбэ нь ишээ давхарлан ороодог, жимс нь гонзгой махир хэлбэртэй, шүүслэг, амт сайтай. Шилбэ нь амархан гутаж гэмтдэг тул мөнх бусын билэг тэмдэг болгон үздэг.

ГАДИР сам. khādira; мө.б. kadir-a-yadir-a; Навч зулгарах бут мод буюу багахан тураг мод. Сарыслаг навчтай, улаан, ягаан

цэцэгтэй, үрийн тосыг саван хийхэд хэрэглэнэ. Сэндэн (үз) ч гэдэг.

ГАЖАА тө. sga skya; мө.б. yajiy-a; Hedychium spicatum; "цагаан гаа"; Иш нь дээрээ сагсгар, бор шарга өнгөтэй, дотроо цагаан, эхүүн халуун амттай нэг зүйл үндэс. Цус шингэрүүлэх, хий, чийг бамыг зайлуулах үйлчилгээтэй эмийн найрлагад ордог.

ГАЙ хя. jie; мө.б. yai; гудамж зээл; гай зээл.

ГАЙМУУ хя. gaimu; мө.б. yauimu; Гичийн төрлийн нэг ногоо. Ёзоор навчийг даршилж, үрийг талхалж хэрэглэнэ.

ГАЛАВ тө. bskal pa; мө.б. yaiba; "хувьт"; 1. дэлхий ертөнц бий болсон эрт цагийн амьтан, ургамал бүхий тунамал чулуулгийн нас; 2. Бүддийн домог зүй, зурхайн ёсонд ертөнцийн тогтох ёсны эрин хэмжээг хэлнэ. Үүнд: сав шим ертөнц үүсэхийг тогтох галав (тө. gnas skal), тогтоод эс барагдахыг орших галав (тө. phyag skal), гал, ус, хийнээс эвдрэх галав (тө. 'jig skal) бий болно. Бас мөнх тэнгэрийн хүчинд дахин тогтох үе нь хоосрох галавт (тө. stong skal) эхэлнэ гэж үздэг. Монгол хэлний ертөнц (үз) нь төвд үг бөгөөд 'jig rten буюу "эвдэрхүйн шүтээн" гэсэн утгатай. Энэ нь ертөнц үүсч, устаж байдгийг илтгэсэн гүн ухааны ойлголтыг илтгэж байна. Галавыг өчүүхэн галав, завсрын галав, их галав гэж хуваана. Их галавуудын хооронд завсрын 80 галав бий гэнэ. Нэг галав хэмээх хугацааг сударт өгүүлснээс үзвэл эргэн тойрон дочин газарт цогцолсон нэг дөрвөлжин хотод гүнжидийн үрийг дүүргэж, гурван жилийн дотор нэг мөхлөг үр авч энэ мэтээр гүнжидийн бүх үрийг авч дуусгасан үеийн хугацааг нэг галав гэнэ. Галав юулэх гэвэл орчлон ертөнцийн төгсгөлийг хэлнэ. Гал галав, салхин галав, усан галав гэвэл ертөнц тогтох буюу сөнөх цагт ямар махбодоор эхлэхийг хэлж байгаа ажээ.

ГАЛАЙ: галай амбан манж galai amban; мө.б. yalai amban (Ков); Гарын сайд (морин цэргийн хоёр дахь сайд).

ГАЛАНДАГА сам. kalandaka; мө.б. yalanday-a; 1. нэгэн зүйл бялзуухай. Энэтхэгт байдаг, сайхан жиргэдэг шувуу. Төвдөд үгүйн улмаас түүний дууг дуурайлган Зуу Адишаа бишгүүр хөгжим зохиосон домогтой. Галандага шувуу оршион гэрэлт ой (Раажгийрийн ойролцоо) нэг үзэсгэлэнт шугуйн нэр гэдэг); Галандага шувуу чинь аль л салаанд үүрлэв ээ. (МААЗДБ); 2. бор богширго, айлын гэр тойрон эргэцэгч өчүүхэн шувуухай. Хятраа бялзуухай ч гэдэг.

ГАЛБА I галав.

ГАЛБА II: галба мод = галбарбаасан; *Үзэсгэлэнт хөлийн будаг галба модноос гардаг байна.* (Кали).

ГАЛБАВАРАГШ м.б. kalbayarags; галбадурма.

ГАЛБАДУРМА сам. kalpadruma; м.б. kalbadurm-a; Галбараварас.

ГАЛБАРАВАРАС м.б. kalbaravaras (Ков.). Галбарагча.

ГАЛБАРАГЧА сам. kalpavriksa; м.б. yalbagagča; галбарбаасан; Самгардийн ksa-г тарнийн дуудлагаар гса гэж дуудаж байсан нь аман зохиолд дайралдаг; *Галбарагча зандан мод газрын хаанаас ургав аа* (МААЗДБ). Галбарагчаа ч гэдэг.

ГАЛБАРБААСАН сам. kalpavriksa; м.б. yalbarbasang/kalbabrigsa (тө. drag bsam sing); "хүслийг хангач мод"; Тэнгэрийн мод ч гэнэ. Тэнгэрийн оронд байдаг хүний уран саналгын мод учир хувцас идээ зэрэг юу санасан бүгдийг хангач гэх болсон домогтой. Арван эрдэмт мод ч гэдэг. Үүнээ: хүний хүслийг бүтээх, залбирахгүй бол бүтэхгүй, залбираас бүтэх, цагтаа бүтэх, ямар мэт хүссэнийг гаргах, барагдашгүй гарах, аттаггүй гарах, хойно нь хариу горилохгүй, сэргүүцүүлэн чадагч, амьтны алжаалыг амирлуулагч орон болсон эдгээр болно. Бас сүүдэрт нь суухад хүссэн бүхэн аяндаа биелдэг, диваажингийн таван модны нэг гэдэг.

ГАЛБИНГА сам. kalavinka; м.б. yalabingy-a; 1. таван зүйл солонгорсон өнгөтэй, эрүүний доор мушгиа чанлартай, гарди лугаа төстэй шувуу. Өндөг нь хагараагүй байхад яруу дуугаараа баясгадаг шувуу гэж домогт гардаг. Угтаа цэвэр ёс суртахуун, цэцэн ухаан, адбиш ариуны билэгдэл болсон шувуу; 2. богино иштэй, цэцэг нь галбинга шувуутай адил төстэй, өнгө цагаан, намраар цэцэглэдэг цэцэг.

ГАЛБИНГАЛИГ сам. kalavinka+liy; м.б. yalbingyaliy; Галбинга шувуутай төстэй учир ийн нэрлэжээ. Урт нь гурван тохой орчим, гардийн адил таван зүйлийн өнгө алагласан нэгэн зүйл төт шувуу.

ГАЛДАН: Галдан хийд; тө. dga' Idan; м.б. yaldan; "төгс баясгалант"; Монголчууд гандан гэж дууддаг нь төвдийн шанаган а-г н- болгон дуудсан хэрэг. Ер энэ үгийг Гаадан, Гандан, Галдан гэж өөрийн аялгаар дуудаж иржээ. Энэ нь Лхас хотоос дээш өндөр уулын оройд хориод мод газарт 1409 онд Зонхов бодын үндэслэн байгуулсан хийдийн нэр.

ГАЛИГ сам. ka-lekha; м.б. yaliy; "га-тийн аймаг". Энэтхэг төвд цагаан толгой га, ха... үсгээр эхэлдэг учир ийн нэрлэжээ. Энэ уг монгол хэлнээ харь үгийг тэмдэглэх тусгай үсгийг нэрлэх нэр болжээ. Энэ нь 1587 онд Аюуш гүүшийн зохиосон нэг зүйл монгол үсэг буюу али галийн үсэг; галиглах (галиг үсгээр тэмдэглэх).

ГАЛИНДА сам. kalanda; м.б. yalinda; Таван өнгө солонгорсон өд сөдтэй, яруу дуут үзэсгэлэнт шувуу. Агаарт нисч явахад нь өөр бусад жижиг шувууд сүрэглэн дагаж ниснэ. Үүнийг галбинга-тай эндүүрдэг гэж сударт тэмдэглэжээ.

ГАЛИНДАР галинга; м.б. yalindar.

ГАЛУН тө. bka' blong (англ.gallon); м.б. yalun; "зарлигийн ноён"; Төвдийн хуучин орон нутгийн засгийн газрын гол албан тушаалтан. Монголоор vablun, kablun ч гэж бичсэн байдаг.

ГАМАЛ сам. kamala; м.б. yamala (Ц.Ц); лянхуа, бадам.

ГАМАР сам. gamaru (тө. ки ма ги); м.б. gamagu; Болсон гөлтөнө чулуу (Ков); цагаан хас хийгээд цагаан гантиг (Ц.Ц).

ГАМБИР хя. gān bīng; м.б. yambir; Зуурсан гурилаар тосны нүнжиггүй хайрсан бин.

ГАМИДИ: гамиди үнээ; сам. kamadhenu, kamaduh; м.б. gamidi (Ков.); Хүссэнийг саах үнээ, хүссэн бүхний өгөгч хүслийн үнээ гэж Энэтхэг домогт гардаг.

ГАН I хя. gàng; м.б. yan; 1. цайвар өнгөтэй хатуу төмөрлөг; Ган нь бат бэхийн утгыг агуулах учир элдэв бузар азар нялзаж халдахгүй гэдэг. Иймд ган дөрөө, ган хэт зэрэг гангаар хийсэн эдлэл нь осгох, шархдаж цус алдахаас сэргийлнэ гэж ярилцдаг. Болд төмөр, ган болд; 2. **шилж** хатуу, чанга чийрэг; ган зориг.

ГАН II хя. gang; м.б. yang (Цин); Ус бороо нэн ховор жил, цаг улирал; **хоршган** гачиг; ган болох (ус бороо ховоршиж гандах); ган тайлах (гандаж байгаад бороо хур орох).

ГАН III хя. gāng; м.б. yang; Шингэн юм агуулах сав, том хувин.

ГАНГА I сам. gamaga; м.б. yangy-a; Иш нь газрын хөрсөн дээр ташуу ургах нэг зүйл бутлаг өвс, үнэр сайхан, эмд орно.

ГАНГА II сам. ganggachilli; тө. kang ka; м.б. gangga; Larus ridibundus. Хар толгойтой том элээ.

ГАНГА III сам. gamga "алтуур явагч"; 1. Хималайн уулаас эх аван Бангаалын буланд цутгадаг Энэтхэгийн домогт мөрөн. Сэргүүн, тунгалаг, амтлаг, хиргүй, хөнгөн, зөөлөн, ходоодонд

тустай, хоолой цэвэрлэн амгуулагч найман эрдэмт рашаан ч гэнэ; *Ганга мөрний бялзуухай Гадаа ирээд жиргэнэ* (Ардын дуу); 2. Монголын зүүн өмнөд хязгаарт орших үзэсгэлэнт нуурын нэр; Гангын эцэг (Хималайн уул); Гангыг баригч (далай); Гангаас төрсөн (алт); Ганга мөрний хумхи (а. Гангын элс; б. тоолшгүй, хэмжээгүй).

ГАНГАР тө. *gan kar*; мө.б. *yangyar*; 1. хамгийн нарийн ур хийцгэй сайн чанарын шаазан; 2. аяганы хүндэтгэл нэр.

ГАНГАЧУН тө. *gang ga chung*; мө.б. *yangya cung*; *Leonurus sibiricus*; Төвд орны уулын хадан цохионы элсэрхэг ангалд ургадаг суварга хэлбэртэй нэгэн зүйл цэцэг, эмнэлэгт хэрэглэнэ. Монгол эмийн сударт өгүүлснээр: асга хаданд ургах, дөрвөн өнцөг, найман тал дуаз хэлбэртэй үзүүр дэх цэцэг нь хонхны амыг дээш харуулсан мэт, дэвсгэр нь цагаан, улаан өнгөтэй, амт гашуун, чанар сэруүн ажээ. Цэцгийн хэлбэр байдлаар нь суварган гангачун, дуазан гангачун гэж ялгана. Амтаар нь айраг өвс ч гэдэг.

ГАНГИ манж. *ganggi* (< сам. *ganga*); мө.б. *yanggi*; 1. арван мянга; 2. Буддийн шашинд хамгийн их тооны нэр, өөрөөр хэлбэл Ганга мөрний элсэн буюу 10-ын 16 зэрэг тоо гэж үздэг.

ГАНГОЙ тө. *gan gos*; мө.б. *yangoi*; Нэг зүйл эрээн торго.

ГАНДАБАДРАА сам. *gandhabhadra*; мө.б. *yangtabadar-a*; *Tanacetum vulgare L* Навч нарийхан, иш урт, цэцгийн өнгө цайвар шар, үнэр сайхан ургамал; *Гадъ мэт гандабадраа цэцэг нь нахилзан ургамаа нь ачлалтай сайхан байдаг*. (ААЗ).

ГАНДАГААРЬ мө.б. *kanda-yari*; Ухэр бөлжиргөнө, хонин бөлжиргөнө (Ков.); Гандгаарийг үз.

ГАНДАН I тө. *rgang dung*; мө.б. *yandung/yandang*; "чөмгөн дун"; Хүний бүдүүн чөмөг ясаар хийсэн номын бүрээ буюу хөгжмийн зэмсэг. Чөмгөн бүрээ буюу ганлин ч гэдэг.

ГАНДАН II тө. *dga' ldan*; мө.б. *yangdan*; "төгс баясгалант"; Гандан хийд (Монголын Их хүрээний шашин номын хийд. 1838 онд дандрын ёсны сүм дуган барьж Гандан хийд буюу Гандантэгчинлийн гэж нэрлэжээ. Энэ хийд шашны хурал ном болон дээд номыг судлах гүн ухааны төв болж иржээ).

ГАНДАРИС: Гандирсын балгас; сам. *gandharvanagar*; мө.б. *yandaris/yandiris*; "Гандхарва балгас буюу үнэр идэштийн хот"; 1. Зэргэлгээн далайгаас хөөрсөн уур униарын дунд агаарт үзэгддэг, ойртоод очиход холдоод байх буюу эсвэл замхран алга болдог

ертөнцөд байхгүй сонин ганган хот балгас. Давхарлаг, гэр зэрэг зүйл бүрийн юмын үзэгдэх дүрс. Эртний Энэтхэгийн зурхайн судар Брихатсамхиад: Гандирсын балгас умар зүгийн агаарт үзэгдэл хаад, язгууртан, тайлгач, цэргийн жанжид нарт муу, хэрэв эдгээр дүрс шар, цагаан, хар өнгөтэй үзэгдвээс бярмануудад муу, хэрэв тут, хиур, дуаз бүхий олон өнгөт хот харагдваас ертөнцөд аймшигт дайн болж цусан далай үүснэ гэж дурдсан байдаг; 2. бодтой дургүй, хүний сэтгэл санаанд ургах, биелж үл болох хүслэнгийн юм.

ГАНДАРЬ I сам. *gandharva*; мө.б. *yangari*; "үнэр идэшт"; Зөвхөн сайхан үнэрээр хооллогч тэнгэрийн дуучин хөгжимчин. Гандарваа, гандирс ч гэж бичдэг. Төвдөөр дисаа (үз) гэнэ; *Гайхамшигт гандирсын ялга мэт* (*МУЗД-I*)

ГАНДАРЬ II ганжир-ын хувирсан хэлбэр ; Өвөрモンголын Их зуу аймагт байгаа Чингисийн онгон байрласан газрын нэр. Энэхүү өндөрлөг нь орчин тойрондоо ганжир мэт харагдах бөгөөд Чингисийн онгоны цомцог ордоны яг ар талд түпиг болсон маягтай, түүний ард Гандарийн шил гэдэг уудам газар бий.

ГАНДАРИГҮД сам. *gridhrakūta*; мө.б. *gandarigud*; монголчууд "тас цогцолсон уул" гэж орчуулж ирсэн уламжлалтай. Раажгирийн дэргэд байдаг энэ ууланд Бурхан багш хоёрдахь сургаал буюу хоосон чанарын сургаалаа айлдажээ.

ГАНДГААРЬ тө. *kanta ka ri* (< сам. *kantakari*), мө.б. *yangayari*; *Mimosa Pudica*; өгөрших нь түргэн, бургас маягийн бугархаг ургамал. Мөчрийн үзүүрт тод цайвар шар цэцэг ургана. Мод нь үл мэдэг амтлаг, гашуун, холтосны амт халуундуу, үр зөгийн бал шиг амтлаг, гоёл чимэлд болон эмд хэрэглэнэ. Гандигар ч гэж бичдэг.

ГАНДИ I сам. *ganda*; мө.б. *yandi*. харагчин тотийн нэр.

ГАНДИ II сам. *ghanta*; мө.б. *yandi*; 1. шашны ёсны гэлэн санваартны хурлын уриа мод; 2. хоёр алд хир урт, гөлийлгэж өнгөлсөн хүрэн зандан шиг цул, маш хатуу учир дэлдэхэд харангын дуутай адил дэлдүүр хөгжмийн зэмсэг; *Би угаасаа ганди мод дэлдэхээс өөр юу ч сургаагүй*. (Л.Т.)

ГАНДИЛ тө. *bka' 'grel*; мө.б. *yangdel*; "бэрхийн тайлбар"; Хатуу үгийн тайлбар ч гэдэг. Дадалтай ойролцоо боловч, бэрх нэр төдийгүй бэрх хатуу өгүүлбэрийг тайлсан нэгэн зүйл толь бичиг. Самгардиар *pancika* гэнэ.

ГАНДИР гандарваа; мөб. γandari; Найрч тэнгэрийн нэр; ...*Гандирын охидын дуунаас -бээр яруу дуутан (12 зох.)*.

ГАНДИРС сам. gandharva; мөб. γandirs; 1. хот, балгас; Энэ цагийн гандирс нуруун дээр нь өндийнө болохоор зэрэглээ нь хүртэл дэвхцэнэ. (Б.Лх.); 2. гандарис, гандарь.

ГАНДИС тө. gangs te se; мөб. gandisa; "част Кайлас буюу част уул"; Энэтхэг төвд, Монголын эртний утга зохиолд олонтаа дайралдаг Цаст Хималайн нэгэн оргилын нэр, Анавад (үз) далайн ойр буй. tese нь самгардийн desa (орон) гэсэн уг.

ГАНДОЛ сам. gandholi; мөб. gandola (Ков.); 1. өргөст хэмхийн нэг зүйл; Cucumis reclinata, Roxb; 2. анхилуун үнэртэй нэг зүйл ёвс; Cuperus rotundus.

ГАНЖИН хя. gānjiázháng; мөб. γanjing; Зуурч нухсан гурилыг хавттай модон дээр элдэж нимгэлэх ург бөөрөнхий мод.

ГАНЖИР тө. ganya ji ra (<сам. gascira); мөб. γanjīr-a; "сант охь"; Сүм дуган, орон барилга, суварга, тахилгат овооны орой дээрх төмөрлөгөөр хийсэн чимэг. Их төлөв алтадсан байдаг.

ГАНЖУУР тө. bka' bsgyur; мөб. γanjūg; "зарлигийн орчуулга"; Ганжуур нь ламын ёс горимыг тодорхойлсон винай, Бурхан багшийн сургаал зэргийг багтаасан судар дандар буюу нууц тарнийн ёс, бурхны шашны гүн ухааныг агуулсан Авидарма буюу илт номын аймаг зэргээс бүрдэх хөлгөн судар. Гол төлөв зан суртахуун, бясалгал, оюун билгийн чанад хязгаарт хүрэх тухай гүн ухааны зохиолууд бий. Бүгд 108 боть болно. Цахарын Лигдэн хааны зарлигаар 1629 онд Ганжуурыг бүхлээр нь монголоор орчуулж дуусгаад 1720 онд модон бараар хэвлэн гаргажээ.

ГАНЗАЙ хя. gan jīu; мөб. γanjai; Нэгэн зүйл хятад архи.

ГАНЛИН тө. rkang gling; мөб. γangling; "чөмгөн лимбэ"; Хүний чөмөгний яс буюу зэсээр хийсэн луу буюу матрын толгойн сийлбэртэй, 50-60 см урт, хурал номын зан үйлд үлээж хэрэглэх бишгүүр. Бас 18 наасны эмэгтэй хүний чөмгөн ясаар хийдэг. Уг чөмгөн бүрээний салаа булцуун дээр ажинай морины хамрын нүхийг дурайлган хоёр нүх гаргаж, үлээхэд түүгээр сайн морины янцгаах мэт дуун гарч, тэрхүү мориор Сухаавадийн оронд очих ёстойг билэгдсэн домогтой. Ганлинч (ганлин үлээдэг хүн).

ГАНПАНЗ хя. gān bān; мөб. γangbanja; Зуурсан гурил элдэх хавттай мод, гампанз ч гэнэ.

ГАНС гаанс (>як. гамса-ганса-хамса//эвенк. ганча.Цин).

ГАНТИГ тө. gangs thig; мөб. γanti; "цасан дусал"; Carbonas magnesiaescum terico; Шохойн чулуулгаас бий болсон хувирмал чулуу. Цагаан, улаан, ягаавтар мөн холимог өнгөтэй ч бий. Судар бичигт: жинхэнэ гантиг чулуу мөнх цаст ууланд байх ёстой гэж бичжээ. Учир нь цас мөс олон жил дагтаршин хуралдсанаас чулуужран гантиг болдог гэж үзэж байжээ. Зүмбэрийн найрлагад ордог, сийлбэр урлал хийдэг.

ГАРАА тө. dkar po; Дүг гар (дугар); Банжингарав зэрэг үгийн хоёр дахь үеийн хувирсан хэлбэр, цагаан гэсэн утгатай; Говь нутгийн дунд гаралт буурал өнгөтэй. (ЗУАЗ).

ГАРААШ ор. гараж (<фр.garage); Мөб. γarası; машин, трактор болон бусад өөрөө явагч хэрэгслийг хадгалах, тэдгээрт засвар үйлчилгээ хийх газар. Гараж ч гэж хэлнэ.

ГАРАГ I сам. graha; мөб. γaraγ; 1. долоо хоногийн өдрийг эзлэж нээлэх нэр; 2. нарны аймгийн өртөнцийн нэр.

ГАРАГ II тө. ka rigs; мөб. γaraγ; Биеийн мөч, эрхтэний мэдрэл алдагдах өвчин, гараг өвчин; хорш. гараг саа.

ГАРАНЗ тө. ka ranydza (сам. karanja); мөб. γaganja; Pongamia glabra; Verbesina scandens; Мод болон түүнд ургах могойн өндөг шиг бөөрөнхий, өнгөлөг гадаргуутай, голдуу хар хүрэн өнгөтэй, дотор халууныг хэвийн болгох эмт жимс, жимсгэнэ.

ГАРДИ сам. garuđa; мөб. γarudi; Үлгэр домогт гардаг асар том шувуу, жигүүртний хаан ч гэдэг. Бурхны номд лусын долоон эрдэнийг шингээж чаддаг гэж номлосон бий. Домгийн ёсоор бүргэд толгой, хушуу хумстай, хүн биетэй, нисч явахад нь нар халхлагдан бүрэнхий болж салхи шуурга дэгддэг гэнэ. Бас шувууны дотор эрхэм. Өмнөөс нь харахад хүн лугаа төстэй, хойноос нь харахад хилин адил, могойн хүзүү, загасны сүүл, луутгийн бидэр, яст мэлхийн ар, харцгайн эрүү, тахианы хушуугтай, өндөр нь зургаан тохой илүү. Бие нь таван зүйл өнгөтэй. Ү-түн мод биш бол суухгүй, хулсан модны үр биш бол идэхгүй, амттайхан булаг бус бол уухгүй, нисвээс түмэн шувуу дагалцмуй гэж Шагж тэмдэглэжээ; хорш гарди галбинга; гардийн бөөлжис (чүнчигноров); Энэтхэг домог болон хиндү шашинд "Вишну тэнгэрийн уналга" гэдэг. Бурхны шашны номоор, хүний замд садаа бологч өшөө хорын билэгдэл болсон хорт могойг даран сөнөөж хушуундаа зуусан, алтан жигүүрт домгийн шувуу болно. Түүгээрээ муу муухайг дараач эрэлхэг баатарлагийн билэг тэмдгийн утгатай болжээ.

ГАРМА сам. karma; мө.б. ᠴᠤᠮ—; Бурхны шашинтины дээлийн гадуур эгэлдрэглэн өмсөх номт дээл.

ГАРТААМ тө. dkar khra men; мө.б. ᠴᠤᠮᠤᠳ—; "цагаан эрээн, цагаан судалт зурагт"; Agate; Хөх, улаан, цагаан, цэхэр зэрэг өнгөтэй, нарийн үе судалтай мана буюу хагас эрдэнийн чулуу. Дорных уламжлалаар гартаамыг цэхэр бөгөөд хөх, улаан, цагаан судалт гартаам, цэхэр бөгөөд харлаг судалт гартаам гэж хоёр хуваана. Жижиг сажиг зүйл, хөөрөг, цагийн зүү хийхэд хэрэглэнэ.

ГАРТАГБАА тө. bka' rtog pa; мө.б. ᠴᠤᠮᠤᠳᠤᠳ—; "зарлигийг оногч" хэмээх ламын нэрээр нэрлэгдсэн шарын шашны нэг салбар. Гол сүм хүрээ нь Төвдийн Хамд байдаг Дэргэ хийд болно.

ГАРУМ манж. garun; мө.б. ᠴᠤᠮᠤᠳ—; Урт түрийтэй гутал. (Ков.).

ГАРЧИГ тө. dkar chag; мө.б. ᠴᠤᠮᠤᠳᠤ—; Нэгэн дараалалд жагсааж эрж олоход бэлтгэсэн цэс. Ном өгүүлэл зэргийн агуулгыг илтгэсэн товч нэрийдэл.

ГАРШ: гарш дээл; сам. kāshya; мө.б. karsa~gars; Аяга тэхимлэгүүдийн гадуур өмсөх ал шар тортон хувцас. Намжарыг үз. ᠴᠤᠮᠤ—, ᠴᠤᠮᠤ—, ᠴᠤᠮᠤ—-а гэхчлэнгээр бичсэн байдаг; Эдүгээ би тойн болж гарша дээлийг эс өмсвөөс тойны ёст бус буй. (12 зох.).

ГАРШАБАНИ сам. karsapani; мө.б. karsabani; Мөнгө зоосны хэлбэртэй ювуу.

ГАЦДАА манж. gacan (<хя. hiang tsoun); мө.б. ᠴᠤᠮᠤ—-—, ᠴᠤᠮᠤ—-—; Арван хуйнаас бүрдсэн хүн суух суурин. Зуун гэр буюу гэр бүл суух суурин. (Ков.); Хот балгасны гадна хүй хүйгээр оршисон айл (Я.Ц.); хорш. гацаа хүй, гацаа тосгон.

ГАЧЕН тө. bka' chen; мө.б. ᠴᠤᠮᠤ—; "их зарлигт"; Ном эрдэмд мэргэжсэн хүнд олгодог цол хэргэм; Бас Төвдийн Дашихүмбэ хийдийн ном эрдмийн мяндаг цолыг хэлж байжээ. Зүүн Авгын гачен Ринчин монголын хэлээр орчуулбай. (Данж.).

ГАЯА сам. Gaya; мө.б. Gaya; Одоогийн зүүн Энэтхэгийн Бихаар муж улсын нутагт оршидог газрын нэр, Бодгаяагаас холгүй. Бурхан багш энэ газарт бодь модон доор сууж урьд эс сонссон, эс ухсан гурван адилтгалиг илт болгосон тухай "Бурхны 12 зохионгүй"-д гардаг.

ГИВААН тө. gi wang/ gi hang; мө.б. givang; Шороон гиваан, чулуун гиваан гэж хоёр зүйл бий. Байгальд бэлнээр байхаас гадна үхэр, заан тэргүүтний цөсөнд байдаг чулуу. Мөн хүрмэн чулууны дотор хуралдсан улаан шар өнгийн зос шиг шороо. Гиваантай

үхэр шөнө хэвтгэрт байхдаа янцаглаж улаан шар өнгийн шүлс савиуулж, нүд нь цог шиг гэрэлтдэг гэнэ.

ГИЕГ гэг; Гүйдэг сайн гээд гиег болгож байжээ. (Ц.Д.).

ГИНЧИАНГИ хя. jīn qián ſi; мө.б. gin čiyan gi; "алтан нүдэл улар"; Өрөвлөгтөө тогосын адил ногоон нүдтэй, гургуул адил нэг зүйл шувуу (Я.Ц.).

ГИН II: гин цэцэг; хя. jīn(huā); мө.б. gin(сесег); Өглөө цэцэглэж, үдэш зулгардаг, навч яlam модны навчтай адил цэцэг лис цэцгийн адил өнгө улаан, улаавтар, хүрээ цагаан янз янз өнгөтэй нэг зүйл цэцэг.

ГИНАРИ сам. kiṁnari; мө.б. ginari; "хүмүн буюу юун"; Морин толгойтой, хүн биетэй, хүн ч биш, сахиулсан ч бус амьтан. Үүнийг тэнгэр лусын найман аймгийн нэгэн гэдэг. Гувираа буюу Намсрайн хөгжимчин ч гэнэ.

ГИН ГИ хя. jīn ſi; мө.б. gin gi; Өд өрөвлөг таван зүйл солонгорсон, гургуултай адил боловч жижигхэн нэгэн зүйл шувуу. Алтан тахиа ч гэнэ.

ГИНГИЙН: гингийн цаас; хя. jīn ſi; мө.б. ging-un; Нимгэн боловч бат бэх нэг зүйл цаас.

ГИРТИГ мө.б. girtig; Гирдиг, гирдэг гэхчлэнгээр бичсэн байх боловч хэртиг гэх нь зөв. Хэртигийн тайлбарт үзмүү.

ГИТАР ор. гитара (<исп. guitarra<гер. kithara/кифара); мө.б. gitar; Товшуур, товшуур хөгжим.

ГИЮН хя. giun; мө.б. giyun; Хүндийн хэмжээ, гучин жин буюу 18 кг, гюн ч гэнэ.

ГОВИЙН ЛХА тө. sGo ba'i lha; мө.б. ᠴᠤᠮ—yin lha; "үүдэн тэнгэр"; Таван зүйл тэнгэрээс бүрдэх учир Заяаны таван тэнгэр ч гэдэг. Эдгээр нь хүний амьдралын таван чухал зүйлийг дааж, өдөр гурван удаа харж, шөнө гурван удаа манаж авардаг гэнэ; Мө лха (охин тэнгэр - хүний зүүн суганд оршиж өнгө зүс, билэг ухааныг тэтгэгч, согоо хөлөглөсөн идэр залуу эхнэрийн дүртэй); срэг лха (амин тэнгэр - бүрэн хэрэглэлтэй хар морь хөлөглөсөн баатар эрийн дүртэй. Хүний зүрхэн тус байрлаж амийг сахин, хишиг буяныг арвижуулагч); По лха (эрийн тэнгэр - бүрэн чимэгтэй цагаан морьтой, идэр залуу эрийн дүртэй. Хүний баруун суганаа оршиж бүтээл туурвил ажил үйлсийг ивээгч); Юл лха (орны тэнгэр - мен цагаан морьтой, идэр залуугийн дүртэй, Хүний тэргүүнээ оршиж, сүр хүчин өгч, орон байрлыг ивээгч); Да лха (сүлдэн тэнгэр - цагаан хөлгийн дээр эрэлхэг байдалтай заларсан,

амарлингүй залуу эрийн дүртэй. Хүний биеийн баруун мөрнөө оршиж, цог заль хийморийг нь дэлгэрүүлэгч) гэж таван зүйл бий гэнэ. Энэ таван тэнгэр нь хүнийг эхээс төрөхийн хамт төрж, аж төрөл, буян заяаг нь насан туршид ивээн тэтгэнэ гэдэг.

ГОЛДИ сам. *koti*; мо.б. *goldi*; 1. мянган түмэн гэсэн уг. Арван сая, живаа; 2. хэмжээлшгүй, тоолшгүй.

ГОЙМОН хя. *guàmiàn*; мо.б. *γuvayimin~γoyimong*; 1. зуурсан турилыг шуур мэтэд нарийхнаар цувиж хатаасан ширхэг идээ; 2. шилж нарийн урт.

ГОЛ сам. *gola* (тө. *go la*); мо.б. *gool-a, γola*; "хүрээ, төгрөг"; Бөмбөрцгийн эргэдэг хийн зам.

ГОЛОГ тө. *go log*; мо.б. *γoluγ*; "буруу мэдэл, тэрс"; 1.угтаа хүлдэнгүй, туршил, амтлах, нигүүлсэх, хураах сэтгэл, даган баясахын зургаан голог буюу буруу мэдлийг хэлнэ. Монгол хэлнээ ("ээ голог!" гэж) хараалын утгаар хааяа хэрэглэгднэ; 2. цалгай, гэмт хэрэг, мадаг; 3. төвдийн зүүн хойт хязгаарт суудаг нүүдэлчин овог.

ГОМ I: Улаангом; түр. *qum*; мо.б. *γom*; элс.

ГОМ II: тө. *sgom*; мо.б. *γom*; "бясалгал"; гом хийх (бясалгах) нь доод, дээд гэж хоёр зүйл буй. Ертөнцийн юм үзэгдлээс оюун бодлоо тур хугацаагаар ангижуулан бясалгал хийхийг доод гом гэнэ. Энэ үед санваартан ертөнцийн юм үзэгдлийг харж үзсээр байдаг. Ертөнцийн алив юмнаас сэтгэлээ бүрэн чөлөөлж увдис олох оюуны үйлийг дээд гом гэнэ. Энэ үед санваартан сэтгэхүйн дотоод ертөнцөд оюун дүгнэлтээр шид увдисыг эзэмшихийг эрхэмлэдэг. Монгол хэлнээ гом- гэдгээс гомнох гэдэг уг үүсч ямар нэг үйлийг сэтгэлээр бодон бодож бүгээх, бясалгах гэсэн утга илтгэдэг.

ГОМБО I тө. *mgon po*; мо.б. *γombu*; "итгэл"; Махгал; Бурхны шашны ёсны арван догшин сахиусын нэг, шүтээн хангал. Биеийн дур хөх бараан, гурван улаан мэлмийтэй, тэргүүндээ таван хохимийтой, тавин толгойгоор эрих хийсэн, улаан шар үсээ хөх могойгоор, толгойгоо эрээн могойгоор, бэлхүүсээ цагаан могойгоор тус тус чимсэн бадарсан гал дунд байдгаар дүрсэлсэн байдаг. Хүн малд учрах гай цөвийг даруулахын тулд энэ сахиусыг залж ёслол хүндлэл гүйцэтгэнэ.

ГОМБО II тө. *dgon pa*; мо.б. *γombu*; "аглаг хийд" (Ю.Р.); гомбод суух, гөмбоос ирсэн (хийд буюу аглагаас ирсэн)(Ю.Р.).

ГОМИНДАН хя. *quō mīn dāng*; мо.б. *γomindang*; "улс ардын цэрэг".

ГОМШОО тө. *gom shwa*; мо.б. *γomša*; "урт чихт малгай"; Сор залах үест лам нарын өмсдөг чих өндөр, туурай хэлбэртэй шар торгон малгай. Туурай малгай ч гэнэ.

ГОН хя. *guāng*; мо.б. *γong*; дан, ганц цор ганц; *Гон бие гозон толгой (Зүйр)*.

ГОНГОР тө. *mgon dkar*; мо.б. *γonγag*; "цагаан итгэлт"; Арван догшин хангалын нэг. Зургаан мутартай, баруун талын эхний мутар нь хүслийг хангач чандмань эрдэнийн билэгтэй, дундах нь зэмсэгтэй, доод мутарт нь урин залагч дамартай бол зүүн талын эхний мутар нь эрдэнийн хур буулгасан билэгтэй, дунд талдаа хамгийг сүрээр дарагч зэсүм (үз)-тэй, доод мутартгаа ертөнцийг эрхэндээ оруулагч цалам дэгээтэй. Гонгорыг эрдэнийн хонхон чимэгтэй, их дөлөн дунд байрлах лянхуа дэвсгэр дээр заларснаар дүрсэлсэн байдаг. Бүхнийг авран сахигч догшин бурхан гэнэ.

ГОНЗ тө. *mgon ja*; мо.б. *γonji*; гонж ч гэнэ; "тахилын цай"; *Оройн уншилагын дараа манз гонзын алиныг ч амандаа хүргэхгүй байлаа (Л.Т.)*.

ГОНИР тө. *dgon gnyeg*; мо.б. *γonir*; "тахилын нярав"; Хаалганы түлхүүрч, гурван эрдэнийн эд юмсыг хадгалаагч; Хурал номын газраа балин тахил хийж, хамба цоржид хурал номынх нь үест ойр туслагч лам. Тахил тавигч; *Удсангүй гонир тахилч лам хоёр нь ирээд...эрхэм шүтээн болгов гэнэ (MAY)*.

ГОНТОГ тө. *sgong thog ra*; мо.б. *γontou*; *Erysimum altaicum*; Төрөл зүйл зуу орчим, 1-2 мөн олон настай ургамал. Навч нь луувангийн навчтай адил, нарийхан үндэстэй, ишнээсээ олон мөчир салаалсан, цэцгийн өнгө нь төлөв шар, урт дугтуйнд алтны үртэс шиг олон үртэй байдаг. Үрээс нь тос гаргана. Бас эмнэлэгт хэрэглэнэ.

ГОНХ гонхон; гонхлох (гонхон болгох); гэр гонхлох (хоёр гэр холбон барихыг).

ГОНХОН тө. *mgon khang*; мо.б. *γongqon*; догшидын байшин, сахиулсны сүм; сүм дуганы дотор гадар ямар нэг газарт өрөө тасалгаа маягтайгаар барьсан өрөө буюу асар; бурхны гонхон, үүдний гонхон гэх мэт.

ГОНЧИГСҮМ тө. *dgon mchog gsum* (=сам. *triratna*); "чухаг ээд гурав"; мо.б. *γongčoγsum* (гурван эрдэнэ); Бурхны шашны ёсонд бурхан багшийн тус бие нь Бурхан эрдэнэ, Бурхны номлосон ном

нь Ном эрдэнэ, Бурхны шавь нар нь Хувраг Эрдэнэ буюу. Бурхан, ном, хувраг гурав нь хүн амьтныг, нүгэл хилэнцийг тэвчиж сайн мөрт удирдан оруулах ба зовлонгоос салгаж Сухаавадийн оронд хүргэх тул юунаас эрхэм дээд чухаг "Гурван эрдэнэ" гэж алдаршжээ. Бурхан багш анх номын хурд орчуулахад таван хүн шавь орсноос эхлэн хувраг нар үүсч тэр цагаас эхлэн "Гурван эрдэнэ" үүссэн домогтой; *Гончигсумийн авралаар Гомбогүрийн хувилгаан боллоо.* (Д.П.)

ГООЖИН оп. Козин; м.б. үоojing; Ардын хувьсгалын дараахан үед нийслэл хүрээнд ойгоос мод авах зөвшөөрлийн бичгийг Козин гэдэг нэртэй орос хүн өгдөг байснаас сүүлдээ энэ нэр мод огтлох тухай зохих газраас олгох зөвшөөрлийн бичгийн нэр болсон гэдэг.

ГООНЬ хя. guān; м.б. үooni; Эхнэргүй буюу эхнэр нь онгөрсөн эр хүн; гон ч гэдэг.

ГООШООН хя. go xiang; м.б. үosiyang; Сайхан анхилагтай, тансаг үнэртэй; *Үнэр сайтай гоошоон хүжийгээ асааж бай даа, Алтирмаа хө (МААЗДБ).*

ГОНЬД тө. go snyod; м.б. үonid; Sagum carvi; Жижиг мөхлөг үртэй, цагаан цэцэгт ургамал. Зираа ч гэнэ.

ГОР тө. dkor; м.б. үog; "эд юм"; Сүм хийдийн эд хөрөнгө, сан хөмрөгийг зүй бусаар ашиглахын үр дагавар; гор болох, гортох.

ГОРИМ тө. go rīm; м.б. үogim; Ямар нэг юмны тогтсон ёс дэглэм, дэс дараалал, эмх журам.

ГОРЛОМ тө. skor lam; м.б. үoglam; "эргэцийн зам"; Шүтлэгтэй хот хүрээ, сүм хийдийн гадуур байх мөргөлчид, сүсэгтний тойрон эргэх зам; ...буруу номтон чи манай дацан хийдийн гороо горломын дотор бүү гишгээтүгэй (С.Д.).

ГОРОО тө. skor; м.б. үogu-a; "тойрог"; Юмыг эргэн тойрох, тойргоор эргэх, тойрох; ...гурвантаа гороо эргээд бэл рүү буулаа (ИТ).

ГОРТИГ тө. skor thig; м.б. үogti; "тойрог, дугуй"; 1. дугуй хүрээ, дугуй зураас, тэг; *Гортиг дотор байж арай боломжтуй болоод...* (С.У.); 2. дугуйлж зурах, хэмжих багаж.

ГОСОО тө. go sa; м.б. үosa; Зэрэг, хэргэм, дэс; *Анги ангийн госооны мэргэчүүдээс айж бахардсаар орж суухад* (Гэл.).

ГОХ гөхий.

ГОЧИХА манж. үöcïqa; м.б. үöcïq-a; "шадар"; Ойр дөт, дотно итгэлт; ...эзэн бодг Тэнгэр тэтгэсний гочиха бэйл (Зуун бил.).

ГОЮУ тө. go yu; хя. gāoyō/gāoyaо; бен. guva); м.б. үоуи; *Areca catechu L; Cynomorium Songaricum;* 1. хөх саарал өнгөтэй, бүдүүн шулуун ишгэй мод. Навч нь уртлаг, ногоон өнгөтэй, жимс нь гадуураа ногоогоор хучсан юм шиг байдалтай, үр нь хатуу; 2. эм бүхий хөхүүлдэг зүйл, хавдар, шарх идээт газарт наана.

ГӨРӨШ сам. krośa; м.б. körös; Таван зуун нумын зйтэй газрыг нэгэн хөрс гэнэ.

ГӨХИЙ хя. gōi; м.б. göki; Холбого, дэгээ, шижим зэргийг ишинд бэхэлж загас барих зэвсэг. Гох дэгээ ч гэнэ; гөхийдөх (гөхийгөөр загас барих).

ГУА хя. guā; м.б. үuva; Зэллэн ургах жимст ургамлын нийтлэг нэр. Тарвас, хэмх гээд төрөл зүйл олон.

ГУАЛИН тө. guōliáng; м.б. үuvaling/yüaling; 1. мөчир салааг нь шулж зассан урт бүдүүн мод; 2. дам нуруу, тайфuu ч гэнэ.

ГУАНЗ хя. guān zi; м.б. үuangja; хоол ундны газар.

ГУВЧУУР түр. qubčig; м.б. үubčıq; Улсын эрх ашгийн тулд нийтээс авах татвар; хорш. гувчуур татвар.

ГУЛДАН манж. guldun; м.б. үuldung; 1. туйпуу мод зэргээр хийсэн дугараг нуруутай хаалга; 2. гүүрийн доорхи матриулан хийсэн газар; 3. замын доогуур ус урсах нүх.

ГУЛУУЗ хя. gūlú-zí; м.б. үuluiza; 1. бог малын дэлгээгүй хөлдөөсөн бүтэн мах; 2. гулдмай хэлбэртэй юм; гулууз мөнгө; гулуузлах (хонь, ямааны маыхыг бүхлээр байлгах, гулдмай болгох).

ГҮҮ хя. gòu; м.б. үuu; 1. ус урсах суваг буюу уулын жалга ганга; 2. хөрөг зураг шил зэргийг хийж бэхлэн тогтоож агуулах хайрцааг шиг хөндий сав; 3. шилж. Эхнэр хүний ёслолын хувцас буюу гэзгэнд зүүх алт мөнгөөр хийсэн хөндий зэмсэг.

ГУУЛИН хя. gaoli; м.б. үauli; солонгос (Цин).

ГҮВИРАА сам. kuvera; м.б. үübır-a; "муу биет"; Гадна байдлаараа үзэмж муутай учраас ийм нэр авсан эд баялгийн тэнгэр. Түүнийг найман соёо, гурван хөл, ганц мэлмийтэйгээр Энэтхэг зурагт дурсэлсэн байдаг бол монгол зурагт эрдэнэсээр бөөлжигч ам цагаан хулгана гартаа барьж байгаагаар дурсэлдэг. Намсрай ч гэдэг. Энэтхэг домогт Умар зүгийг сахигч баялгийн эзэн. Хормустын эрдэнэсийн санг хамгаалагч, Химлайн Кайлас уулнаа оршин суудаг гэж гардаг.

ГҮТЭЛ тө. gu gul (<сам. guggula); м.б. үügül; *Styrax benzoin; Vatica lanceaefolia;* Зандан модны хар буюу цагаан өнгөт, үнэрт

давирхай, эмнэлэгт хэрэглэнэ. Анхилаг нь хүний сэтгэл санааны гутаг бургийг зайлцуулна гэдэг.

ГҮДИН тө. sku ṛten; мө. b. güden; "биений шүтээн"; Хутагт хувилгаадын цогцыг оршуулсан шарилын сүм; ...*Абтай хааны шарилыг суваргалсан гүдинг 1587 онд Эрдэнэзүүд болсожээ. (Д.Май)*.

ГҮЙЛНЭЙ манж. guilei; мө. güyilenei; *Mangifera indica*; Амра жимсний мод. Их навч нь ул модныхтой адил, жимс нь улнаас багаахан, амт гүйлсийнхтэй ойролцоо жимс.

ГҮЙНХУАР хя. gui hua; мө. güiquavar; Тансаг үнэрт чидун жимс, түүний цэцэг.

ГҮМБАНДИ сам. kumbhande; мө. gümbandi; Бирдийн аймагт багтах амьтан. Үүнийг бухар хийдийн галын байшинд галыг бадруулагчийн билэгдэл болгон зурдаг байжээ.

ГҮМБАРАА тө. kum bi ra (<сам.kumbhīra); мө. gümbir-a; 1. их матар буюу дуурсагч матар. Ганга мөрний матар. Гүрвэл мэт агаад том, халуун орны гол мөрөн, нуур намагт оршино. Хөл богино, ам том, шуд хүрц, биеийн урт 2-5 метр хүрнэ; 2. нүүр хүнийхтэй адил, бие барсынхтай адил, дуу нь нялх хүүхдийнх шиг, домогт гардаг нэг зүйл усны араатан.

ГҮМБУМ тө. sku'bit; мө. günbüt; "буман бие"; Угтаа арван түмэн Сэнгээнаро (Арслангийн хүрхрэлт) бурхны дүрст Майдарын хийд гэсэн утгатай. Төвд оронд байдаг, шарын шашны зургаан их хийдийн нэг. Шашны домогт гардгаар Зонховыг эхээс мэндлэхэд хүйсийг нь хайчлах үест нэгэн дусал цус газарт дуссанаас тэр газарт арван түмэн навчтай зандан мод ургаж, навч бүрд нь Сэнгээнаро бурхны дурс аяндаа тодорсон учир Гүмбум (Буман биет) хийд гэж нэрийдэх болсон гэдэг.

ГҮМДАА сам. gümuda; мө. gümuda; Сарны гэрэл туссан хийн дэлбээлдэг дун цагаан өнгөтэй, нэг зүйл цэцэг. Цагаан лянхуа ч гэдэг. Ёгт нэрийн зүйлд сараар баясагч, сарны садан ч гэдэг.

ГҮН хя. gōng (тө. gun); мө. güng; 1. феодалын байгууллын таван хэргэмийн тэргүүн зэрэг; 2. Манж чин улсын үеийн хэтэрхий дөрвөн хэргэмийн дөтгөөрх нь; 3. цэцэг өвчинеэс үлдсэн нөрөө.

ГҮНГЭРВАА тө. kun dga'ta ba; мө. güngyaraba; "хотол баясгалант хүрээ"; 1. бурхан ном, шүтээн тахилыг агуулсан модон

хайрцааг. Монголчууд хойт буюу баруун хойт зүгийг бурхан сахиусны орон гэж шүтдэгээс гэрийнхээ тэр хүндтэй зайд байрлуулдаг; 2. зарим юм агуулах сав, жааз, гуу; ...*гүнгэрваатай бурхан залж...зул асаав. (С.У.)*

ГҮНД тө. kunda (<сам.); мө. günda; гүмүда ч гэнэ. Гүмдааг үз.

ГҮНДҮҮХЭН хя. gōng dao; мө. gündükün; Төлөв томоотой, элдэв адarmaатай зангуй.

ГҮН(ДЭЭХҮН) хя. gong; мө. güngdekün; Эртний таван эгшгийн нэг, туйлын нам аялгуу.

ГҮНЖ хя. gōngzhī; мө. güngju-günju; хааны охин.

ГҮНЖИД перс. kunjut (уй. gunjid); мө. güngjid-günjid; *Sesamum indicum*; Дулаан оронд ургадаг нэг наст тослог ургамал, дэл гэж бас нэрлэнэ; *Түүний хойно нижгээд гүнжид тэргүүтнийг идвэй. (12 зох.)*

ГҮНРЭГ тө. kun rig; мө. günrig; "хотлыг ухагч буюу хамгийг мэдэгч"; Сэтгэлийг ариусган, зовлонгоос ангижрахыг ереөн унших, буддийн сургаалын гүн ухааны үндсийг хураангуйлсан номын нэр; Гүнрэг хуруулах (уг ном уншуулах зан үйл).

ГҮНТАН тө. gung-thang; мө. güng thang; Төвд газрын нэр, монгол ном сударт элбэг дайралдана. Төвдийн алдарт шүлэгч Миларайба энэ газрын хүн байжээ.

ГҮНЦЭГ тө. gung tshigs; мө. güngcēg; "үдийн цав"; Лам ноёд, ихэс дээдсийн хоол үндны хүндэтгэл, хоол, зоог; гүнцэг зооглох.

ГҮНЧҮҮ хя. gián chōbū; мө. gñngčū; Сиймгэр нимгэн нэг зүйл торгомсог барaa.

ГҮР: гүр дуу тө. mgur; мө. gürü; "хүзүү, хоолой"; Алагадаяанд сэтгэлийг хандуулахад уриалсан чиглэлтэй шашин номын санаа илэрхий туссан дуулал. Эртний энэтхэг, төвдийн утга соёлын зүтээс дамжиж ирсэн монголчуудын шашны зан үйл, ялангуяа сүм хийдийн найрын дуу хөгжмийн төрөлд үлэмж дэлгэрсэн нэгэн зүйл дууны төрөл. Гүр дууг зөвхөн шашны баяр ёслолын үеэр дуулдаг байжээ. Гүр татах гэвэл яруу дуулал зохиохыг хэлнэ.

ГҮРВАА сам. kurāva; мө. güriva; Навч нь хулс модных лугаа адил, ишний үр бүрээс гурван салаа гарах ба салаа бүр найлзууртай ургамал.

ГҮРВАГА сам. *kurbaka*; мө.б. *gürbay-a*; Самгарди яруу найрагт олонтаа гардаг улаан өнгийн тансаг цэцэг; *Гүрвага цэцгээр үсээ...чимээд...гаадамбаар шанхаа гоёном за (Кали.)*.

ГҮРГЭМ тө. *gur kum* (<сам. *kumkuma*); мө.б. *gürgüm*; *Carthamus tinctorius*; Халуун оронд ургадаг улбар шар өнгөтэй ургамал, эмд орно. Балба гүргэм, Хачи гүргэм, зом гүргэм гэх зэргээр ялгана.

ГҮРРАГЧАА сам. *gururakṣa*; мө.б. *gūrūraγča*; "багшийн сахиус"; Балба, Индонези зэрэг оронд ургадаг нэг зүйл модны үр. Эрих хийнэ. Гүррагчаа эрих бурхны шашны сүсэгтний дунд их алдартай, арслангийн нүүр төгс бүрдсэн эрих гэдэг.

ГҮРТЭН тө. *msgur then*; Аюул зовлон, ад зэтгэрийг үлдэн хөөх гэж чойжин (үз) оршин буух шарын шашны зан үйл.

ГҮРТЭНБЭ тө. *msgur then ra* (=skur bshan ra); мө.б. *gürtenbe*; Таван талтай, тал бүр дээрээ атаяа, мунхаг, омог, тачаангуй, хилэнт сэтгэлийн таван хорыг дарагч таван бурхны хөрөгтэй титэм малгайтай, хоёр шанаа руугаа унжалгатай, таван өнгийн даржин ар луугаа унжуулж, цээж бөгсөн биедээ тусгай өмсгөлтэй, хар сэлэмтэй, догшид буюу номын сахиулсан болох бурхдын тахилга ёслолыг гүйцэтгэгч хүн. Бас хүний биеийн 84 мянган нүтэл хилэнцийг арилгагч догшдын ном уншигч; *Гүртэнбэ өвчтөнгийн дэргэд шууд л номч хувцсаа өмсч эхэллээ (Л.Т.)*.

ГҮРҮ сам. *guru*; мө.б. *gürü*; багш, сургагч; эрдэмтэн, лам багш; махагүрү (*mahaguru* - ахлах буюу их багштан); Чухамдаа бол гүрү нь "хүндэд орох" буюу эрдмийн зэндмэнээр хүнд бүхнийг олж авах гэсэн утгатай. Эрдмийн хүндийг төгссөн хүнийг хэлнэ.

ГҮРЭМ тө. *sku ḥim*; мө.б. *gürim*; 1. шарын шашны ёсонд ад зэтгэр, аюул зовлон, өвчин эмгэгийг зайлцуулах гэж ном уншилага хийх зан үйл. Гүрэмч хүн өвчтэй хүнд гүрэм хийлээ гэхэд тэр хүний өвчнийг гүрмийн зан үйлээр ховсдон гаргаж урьдаас бэлтгэсэн хүн, амьтны дурсгээ зүйлд оршуулдаг гэнэ; 2. *шилж* муу үйл явуулга; гүрэмдэх (гүрэм хийх); гурван гүрэм (цаг үеийн гай барцад, өвчин, муу зүгийн хорлолыг хоосон чанарын сургаалийн үүднээс арилгах Шэйрабнимба, ган зуд, гай гарз, өвчин зовлонгоос амьтныг аврахын тулд Цагаан шүхэрт, наасны барцад тоогоо, урт наслахын билэгдэл болгож Цагаан дара эхийн магтаал зэрэг гурван номыг уншуулж засал хийлгэх ёс).

ГҮРЭМЧ гүрэм+ч; мө.б. *gürimči*; гүрэм засал хийдэг хүн; *Гүрэмч доромч лам, өргөл барьцаар өлсгөлөн (Д.Н.)*.

ГҮРЭН манж. *gürün*; мө.б. *gürün*; улс гэр; *хорш*. улс гүрэн.

ГҮҮШ хя. *guoshi*; мө.б. *güüsí*; 1. сайн орчуулагч; 2. бичиг үсэгт сайн мэргэжсэн, бичгийн хүн, бичгийн утгач.

ГҮҮШРИ тө. *gu śri* (<хя.); мө.б. *güüšri*; Юань улсын үеэс эхлэн монголын хаадууд төвдийн ихэс лам нарыг ингэж өргөмжлөн нэрлэж байжээ.

ГҮШ тө. *ku śá*(<сам. *kusa*); мө.б. *kusa-gusa-güüsí*; "муут арилгагч"; *Roa cynosuroides*; Бярманы болон бурхны шашинд бузар түйтгэрийг арилгах зан үйл гүйцэтгэхэд хэрэглэдэг дурваагийн төрлийн олон үзүүрт навчтай, нарийхан ширхэгтэй, урт иштэй ариун өвс. Мөнх өвс, өлзийт өвс ч гэнэ; *Хуримын сангийн лам...бумбанаас гүший нь авч...(С.Д.)*.

ГЭВГҮЙ гэсгүй; мө.б. *gebgüi*; Төвдийн *dge bskos* гэдгийн хоёр дахь үгийн утгвар в- үсгийг дуудсанаас ийм дуудлагатай болжээ. Гэвхүй ч гэнэ. Шашны хурлын хуврагуудыг баримтлан захирах албан тушаал.

ГЭВШ тө. *dge bséś*; мө.б. *gebsi*; "буяны садан", Цанидын сургуульд арваас дээш жил болсон, зэрэг хамгаалаагүй байгаа, таван ухаанд мэргэжсэн номтой хүний хүндэтгэл нэр.

ГЭГ тө. *bgegs*; мө.б. *gēg*; тоттор; саатуулж боогдуулах юм; *хорш*. гэг тоттор; гэглэх (гэг болох, садаа тушаа болох).

ГЭГДОР тө. *bgegs gtor*; мө.б. *gēg dor*; "түйтгэрийн балин"; Гай түйтгэрийг арилгах балин; *Гэрийн гайг арилгана гэж гэгдор балинг өргүүлэв (Гам.)*.

ГЭГОЙ гэсгүй, гэвгүйгийн өөр дуудлага.

ГЭЕГ тө. *dge gyog*; мө.б. *geyüg*; "буяны үйлчин"; Гэсгүйн туслагч, нөхөр садан; хүрээ хийдийн захиргааны гэсгүйн зарлага лам; ...бэрээ барьсан гэгнүүд зэрлэгээр дахин шаардав. (Л.Т.).

ГЭЛҮҮГБАА тө. *dge lugs pa*; мө.б. *gelügbä*; "буяны ёст"; Төвдөд тахил шүгээний ёс доройтсон тул бодг Зонхова, Брог хэмээх уулын оройд Галдан хийдийг байгуулж амьдралынхаа сүүлчийн хэсгийг тэнд өнгөрүүлэхдээ Гэлүүгбаа жаягийг тогтоожээ. Гэлүүгбаа дэг нь Жовуу Адишаагийн үзэлд тулгуурласан болохоор Гаадамбын ёс гэж алдаршжээ. Гэлүүгбаа салбарынхан шар өмсгөл өмсдөгөөс шарын шашинтан гэгдэх болсон ба буяны ёс баримтлагч. Гэлүүгбаа ёс нь гурван аймаг савын тааллын утгыг тусгасан, судар тарниийн бүтээлийг баримталсан, гурван суртахуунтай зохицсон, их хөлгөний арга билгийн зарчмыг хослуулсан байдал.

ГЭЛЭН тө. dge slong; мө.б. gelüng' (сам. bhiksu); "буян сэдэх"; Бурхны шашны ёсны нэгэн зүйл санваар. Буян сэдэх тухай багшийн өмнө авсан гутгаар амлалт. Гэлэн хүн 253 сахилыг чандлан сахина. Ламын ёсонд байсан гурван сахилын хамгийн хатуу нь.

ГЭЛЭНМАА тө. dge slong ma; мө.б. gelüngm-a (сам. bhiksuni); "буян сэдэгч эх"; Бүддийн шашны ёсны эм гэлэн, их аяга тэхимлиг ч гэдэг.

ГЭМИН хя. geming; мө.б. geming; "хувьсгалт цэрэг"; гамин ч гэнэ.

ГЭНЭН тө. dge bsnyen; мө.б. genen; "буянд ойртох, буяны садан"; Бурхны шашны ёсны гэлэн, гэцэл сахил хүртээгүй лам. Буянд ойртохын тулд багшийн өмнө авсан анхны амлалт. Увши сахил ч гэнэ. Ламын ёсонд байсан гурван сахилын хамгийн зөвлөн нь, банди сахил ч гэдэг.

ГЭНЭНМАА тө. dge bsnyen ma; мө.б. genengm-a; "буянд ойртогч эх"; увсанз.

ГЭРГАН тө. dge rkan; мө.б. geryan; "өвгөн"; Ахмад хүний хүндэтгэл буюу ахлагч, ахлах лам, ах тойн. Бас сургуулийн багшийг ч хэлнэ.

ГЭРГЭШҮНДИ сам. krakucanda; мө.б. kergesundi; ...төгс туулсан гэргэшүнди тэргүүлэн...(Зуун бил).

ГЭРДИ манж. gerudi (<сам.); мө.б. gerudi; гардийн эмэгчин.

ГЭСГҮЙ тө. dge bskos; мө.б. gesgüi; Хүрээ хийдийн хурал номын жаяг дэглэмийг шууд гардан сахиулагч, хуврагийг захирагч. Гэсгүй нь өдөр бүрийн жасаа хурал, цаг цагийн хурал зэргийг эрхэлж, дэг ёс сахиулах, дэмий үг хэлэлцэх зэрэг зохисгүй үйлдлийг таслан зогсоох үүрэгтэй; гэсгүйдэх (*шилж* эзэн нь болж завших); *морий нь хоёр нохой гэсгүйдээд идэж байжээ*. (МШХ3).

ГЭСЭР I тө. ke śar (<сам. kesāra); мө.б. geser; Rosa Laevigata; 1. (цэцгийн) туурцаг, цэцгийн доторхи үсэнцэр буюу үслэг зүйл; 2. их төлөв энэтхэгт ургадаг их бие нь хушганы модтой адил өргөслөг, цэцгийн дотор морины сүүлний хялгас шиг үсэнцэртэй, сэргүүн чанарт ургамал. Мод, үр, цэцгийг цөмийг гэсэр гэнэ. Үрийг эмнэлэгт хэрэглэнэ. Нага гэсэр, бүсба гэсэр, бадам гэсэр гэж гурван зүйл бий. Майдар бурхны зүүн мутарт байдаг цэцэг нь гэсэр цэцэг мөн. Бас сайхан бүсгүй амандаа дарс балгаж сүрчин цацахад гэсэр мод цэцэглэдэг гэсэн домог бий. Цэцэг нь дөрвөн сайхан үнэртний нэгд ордог.

ГЭСЭРИ сам. kesāri (тө. ke śa ri); мө.б. gesari; "дэлт, зогдорт"; Арслан зэрэг дэлт амьтныг нэрлэх нэр.

ГЭЦЭЛ тө. dge tshul (сам. stamanera); мө.б. gečül; "буяны ёст"; Буяны ёсыг сахихын тулд багшийн өмнө авсан хоёр дахь амлалт, сахилын нэр. Үүнд долоон нааснаас дээш хорин нааснаас доош хөвгүүн арван зүйл сахил авч тойн болохыг хэлнэ.

ГЭЦЭЛМАА тө. dge tshul ma (сам. stamanerika); мө.б. gečülm-a; "буяны ёст эх"; Буяны ёс сахих эмэгтэй хүний сахилын нэр.

ГЭЭГЭЭ манж. gege; мө.б. gege; Манжийн үеийн хаад ноёдын охин.

ГЯВААН гиваан.

ГЯДАГА сам. ketaka; мө.б. giday-a; Pandanus odoratissimus; Панданус мод, түүний цэцэг. Анхилам үнэртэй, самгарди яруу найрагт элбэг дайралдаг нэр; *Дасарна орны цэцэрлэгийг цагаан гядага цэцэг хүрээлэн бүслээд..(Кали.)*.

ГЯНДАН перс. zindan (тур. zindan); мө.б. gindan; Хэрэгтнийг хорих нүх, шорон (ДТС), хэрэгтэн ялтан хүнийг хоригоор тустай бэлтгэсэн газар (Я.Ц.); хорих байр, хар гэр. Хятадаар kien lao гэнэ.

ГЯРГА тө. ske rags; мө.б. girγ-a; 1. бүс; алт буюу мөнгөөр хийсэн хээ шигтгэсэн бүс; гярга бүс; 2. ноосон нэхмэл бүс; улаан гярга бүс.

ГЯТРУУН тө. dge mtho ri "Буянт өндөр уул"; Өвөрхангай аймгийн нутагт байдаг үзэсгэлэнт уул, тэнд байдаг рашаан булаг. Хятуун ч гэдэг.

Д

ДАА хя. dà-dài; мө.б. da; 1. их, том; Даа хүрээ; даа лам (шашны хурал захирагааны хэрэг эрхэлсэн хүн); 2. дарга; чуулган даа.

ДААВУУ хя. dā bù; мө.б. dabuu; 1. хөвөн бараа; 2. даавуугаар хийсэн эдлэл; орны даавуу.

ДААГУА хя. dà guā; мө.б. daγuva; Их гуа, ногоо; *Даагуаг идвэл амттай л байна хө хө (МААЗДБ)*.

ДААЛИН хя. dā lián; мө.б. daling; 1. хөөрөг агуулах бөс торгомсог эдээр хийсэн жижиг сав; 2. дундаа амсартай хоёр талдаа хувцас хунар зэргийг хийх булигаар, хөм, зузаан бөсөөр үйлдсэн том богц сав.

ДААЛИНБА даалин; м.б. dalingbu; Зөрүү артай нэг зүйлийн хөвөн нэхмэл бараа.

ДААЛУУ хя. dà liu; м.б. daluu; "их зургаа"; 1. хоёроос арван хоёр нүх гаргасан жаран ширхэг тоглоом, яс буюу модоор хийнэ; даалуудах (даалуу тавьж наадах); 2. мөн тоглоомын арван хоёр нүхтэй мод.

ДААМАН: дааман хаалга; хя. dā men; м.б. daman; "их хаалга".

ДААЧАА хя. da che; м.б. daciy-a; том тэрэг; ачаа бараа тээх морин тэрэг; *Арал сайтай даачаа тэргийг аваад ирээрэй, хүүхдүүд ээ (МААЗДБ)*.

ДААШИН хя. dà shēng; м.б. dasang; ачаа бараа татах бүдүүн олс.

ДААШИНЗ хя. da siyan zi; м.б. dasinja; Нимгэн бөсөөр хийсэн дан дээл.

ДААЮУ хя. dà yāo; м.б. dayuu; "нурууны тохош"; Тэмээний урд бөхөнд углан бөгтөрч, тэргэний хоёр арлыг бэхлэх тоног хэрэгсэл.

ДААЯА хя. dàyān; м.б. day-a; ганс, тамхи.

ДАВАА тө. zla ba; м.б. dava; "саран"; 1. долоо хоногийн нэг дэх өдөр; 2. нарны аймгийн нэг өртөнц.

ДАВЖИД тө. 'dab brgyad; м.б. dabjid; "найман салаат" (навчит); Малгайн орой дахь жинсний суурь, лянхуа цэцгийн найман навчны хэлбэрээр хийдэг байжээ. Тавжид ч гэнэ.

ДАГЗ тө. tag rtsa; м.б. dayja; "ар"; Амьтны толгойн ясны аршилний орчин газар.

ДАГНА- хя. dàng; м.б. dangnaqu; 1. эд юмаа барьцаанд өгөх; 2. юмыг хөлсөөр түр хэрэглэх; данжлах ч гэнэ.

ДАГСАЛ тө. tags gsal; м.б. daysal; "тодорхой учир"; тодорхой суралцсан ном судлал; дагсалзах (дагсал хаялзах).

ДАГТ тө. tag tu; м.б. daytan; "ямагт"; Ургэлжид, хэзээд; *Дагт энэ насандаа эргэх нь олонтаа узэгдэнэ. (A.X.)*

ДАГТАН дагт; *Дагтан ган зудгуй, дайн дээрмийн аюулгүй (D.P.)*.

ДАГШИН тө. dag zhing; м.б. daysin; "ариун орон"; 1. Аминдаваа бурхны орон, ариун газар; 2. ариун онгон газар ус; хорш ариун дагшин; 3. монгол орны зүүн өмнөд хязгаарт орших нуур ус, булгийн нэр; Дагшин нуур, Дагшин булаг.

ДАГЬ-ИГ тө. dag yig; м.б. dag yig; "ариун бичиг"; Монголчууд даг үйг гэж хэлж заншсан. Нэр томъёо, нэр томъёоны чанартай угс, мөн их бага таван ухаанаар зүйл болгож ухаан бүрт холбогдох үгийг төвд үгийн дэс дарааллаар багтаасан толь бичиг. "Мэргэд гарагын орон нэрт тогтоосон дагь иг нь нэр томъёоны орчуулгын толь болно.

ДАДАЛ тө. brda bkrol; м.б. dadol; "дохио тайлах"; Ёгт нэр, төвдийн хуучирсан үг, самгарди нэр, домог үлгэрийн нэр томъёо, гүн ухааны ойлголтыг илэрхийлсэн нэрийн зүйлийг ерийн үгээр хялбаршуулан тайлсан толь бичиг.

ДАДАР тө. mda'dar; м.б. dadar; Жижиг дарцаг; Салхинд хийсгэх гурвалжин, дөрвөлжин хэлбэрийн хэсэг бөс.

ДАДИВАА сам. tittibha; м.б. dadiva; Parra jakospa; Энэтхэгийн домогт гардаг шувууны нэр. Энэ шувуу далайн хөвөөнд үүрлэж атал далайн долгион ирж, үүр өндгийг нь урсган аваачсан гэнэ. Энэ тухай хангардид мэдүүлсэнд тэрээр ихэд хилэгнэн гүмбараа, лууг дарсан аж. Ингэхэд далай айж энэ шувууны үүр өндгийг гаргаж өгсөн гэдэг; ...*далайн хөвөөнд ургасан модны дээр Дадиваа нэрт шувуу үүр засаж өндөглөх ажээ (Суба.)*.

ДАДИРАБА дадиваа; *Дадираbag доромжлох болон... (Суба.)*

ДАЖГҮЙ ма. daljī aqu; м.б. dajī ügei; 1. огт хамаагүй, зүгээр; 2. гэмгүй, буруутгүй.

ДАЙ I хя. dài; м.б. dai; Модоор зүйсэн юмыг холбон тогтоох хөндөл; дайлаас ч гэнэ; дайлах (модоор зүйсэн эд юмыг хөндлөн торгож бэхлэх).

ДАЙ II хя. dài; м.б. dai; 1. ачаан дээр юм нэмэн ачиж явуулах; 2. худалдах зүйлдээ өөр юм нэмж, шахалтаар дагавар болгон өгөх; дайвар (дайж болох аар саар тээш, худалдах юмандaa өөр юм дагуулахыг нь).

ДАЙ III даа; дай гүүш.

ДАЙВАН I тө. mda' dpon; м.б. dayibong; Цэргийн дарга (Влад.).

ДАЙВАН II хя. dà ming; м.б. dayiming; "Дай Мин буюу Мин улс"; Домог үлгэрийн хаан, өртөнцийн эзэн; Баруун Монголын туульсад гардаг хааны нэр.

ДАЙЗ хя. dài zi; м.б. dayija; 1. сум хийж бүслэх буюу мөрөвчлөх уттай бүс; 2. шилбэ ороох дайс, ороолт; дайзлах (а. сумыг дайзад хийх; б. дайзан бүс ороос).

ДАЙФУУ хя. dai fu; эмч.

ДАЙЧИН: Дайчин улс; хя. *dà qīng*; мө.б. *dayičin*; "их чин"; 1. хуучин цагт хэрэглэж байсан цол; 2. Чин улсын тайлбарт үз.

ДАЛ дал мод; сам. *tala*; сам. *dal-a*; Мөчиргүй, шулун иштэй, өд буюу дэвүүр маягийн навчтай маш том мөнх ногоон мод.

ДАЛЬ тө. *da lis* (<сам.*talis*); мө.б. *dali*; *Rhododendron adamsii* Rehd; Балуу модны цэцэг. Навчис нь тансаг үнэртэй, асга хад, уулын орой хяраар ургадаг, гол төлөв ягаан цэцэгтэй, анхилам үнэртэй, шөвгөр урт навчтай, мөнх ногоон жижиг мод, эмийн найрлага, үнэртний зүйлд орно. Үнэрт өвс, *Corypha Rox* (Ков.).

ДАМ I тө. *gtams*; мө.б. *tam-a*; Арван равжим буюу 13 оронтои тооны нэр.

ДАМ II тө. *gtam*, *gtam brgyud*; мө.б. *dam*; "үг, яриа, мэдээ"; 1. дамжин ирсэн домог, аман домог; 2. **шилж** дамжигдаж, уламжлагдаж ирэх; үнэний хувь багатай юм; дамын үг (бусдаас сонссон үг); дам хүн (хөндлөнгийн хүн).

ДАМАР сам. *damaru*; мө.б. *damaru*; 1. сав шим хоёр ертөнц хоёр тийш харж оршино гэсэн бурхны шашны номлолыг билэгдсэн, утас буюу хивээр оосорлосон, хоёр товчин цохилууртай хоёр талыг ширлэсэн шашны зан үйлд хэрэглэх хөгжмийн зэмсэг. Сажуур хэнгэрэг ч гэдэг; 2. голоороо нарийн хэлбэртэй дамартай төстэй юм; машины дамар.

ДАМБАДАРЖАА тө. *bstan* ра *dar rigyas*; мө.б. *dambadarjai*; "шашин дэлгэрүүлэгч"; Одоогийн Улаанбаатарын умар этгээдэд 1765 онд Манжийн хааны хөрөнгө хүчээр II бодг Жавзандамба хутагтын (1724-1758) дурсгалд зориулан барьсан хийд. Тухайн үедээ 700 гаруй ламтай, дөрвөн дацан, 12 аймагтай байжээ.

ДАМБУР перс. *tambura*; уй. *taembura*; хинд. *tambura*; мө.б. *dambur*; Нэг зүйл чавхдаст хөгжмийн зэмсэг. Өндөр аралтай, 3-4 чихтэй, модон цартай. Домбор хөгжмийн нэр энэ үгээс гаралтай.

ДАМДИНЧОЙЖОО тө. *gta mgrin chos rgyal*; мө.б. *damdinčoyjai*; "морин хоолойтын ном дэлгэрэхүй". Бурхны шашны ёсны 10 догшин сахиусны нэг. Бие нь хар бараан, гурван ертөнцийг харах мэлмийтэй, дөрвөн арзайсан соёотой, сэгсийсэн үстэй, үхэр тэргүүнтэй, баруун муттартаа хүний араг ясан дохиуртай, зүүн мугтартаа номхотголын цалам барьсан догшин дүртэй. Буян бүгээх үүднээс урин залж тахидаг.

ДАМЖАА тө. *dam bca'* ба; мө.б. *damjiy-a*; "гэрчилсэн бичиг"; Бурхны шашны шашин-гүн ухааны судар, тарнийн номлолд шат дараалан суралцаж төгсгөх ба зэрэг хамгаалахад өгөх шалгалт.

Үүнд домын дамжаа, гавжийн дамжаа, аграмбын дамжаа, маарамбын дамжаа, зээрэмбийн дамжаа барих ёс монголд уламжлагдан иржээ. Харин сүүлийн үед "англи хэлний нэг сарын дамжаа, оёдол эсгүүрийн дамжаа" гэхчлэнгээр хэлж бичдэг болсон нь буруу болохыг тэмдэглэлтэй. дамжаалах (дамжаа барих).

ДАМЖИГ тө. *dam tshigs*; мө.б. *damjiy*; "андгайлал"; Сэжиг, эргэлзээ, мадаг.

ДАМПУУ хя. *dàng ru*; мө.б. *dampuu*; 1. эд юмыг хугацаа заан хүүтэй барьцаалан зээлдүүлэх газар; 2. **шилж** ажлаа алдсан, ажил нь замхарсан; 3. **шилж** эдэлгээнээс чанар нь муудсан, хуучирсан юм; дампуурал (а. өрөө төлж чадахгүй болоод ажил үйл нь нурах; б. ямар ч чадваргүй болох); дампуурах (дампуу болох; өгөршин муудаж чанаргүй болох).

ДАМСРАЙ тө. *gtam sri*; мө.б. *damsrai*; "тангарагийн буг"; батыг алдан амласнаа няцан буцагч.

ДАМЦАГ тө. *gtam tshig*; мө.б. *damčay*; "тангарагийн үг"; андгай бат нутыг үзүүлэн амласан үг; *Тангараг дамцгийг номлогч нь олон ч таслан хориглож барьсан нь цөн. (АХ)*.

ДАМШВАА тө. *bkra mi ses ra*; мө.б. *damiseyiba*; "өлзий бус"; *Аа дамшваа, чи надал өөрөө хүрээд ирэв ээ. (Л.Т.)*.

ДАМШИГ тө. *dam bśig*; мө.б. *damsiy*; "үг (тангараг) эвдэх"; 1. бат нутыг үзүүлэн ам алдсан үг хийгээд сахилыг зөрчих; 2. **шилж** дүрсгүй, томоогүй, зүтгүй, бүтэлгүй амьтан; *Чи...тэр муусайн дамишгуудаа захирч зандарч байхгүй яасан юм бэ. (С.Д.); дамшиглах (шилж. доог тохуу хийх, зүтгүйтэх).*

ДАМЖИНДОРЛИГ тө. *dam can rdo rje legs ra*; мө.б. *damjindorlig*; Улаан ямаа хөлөглөсөн бурхан; *Дамжиндорлиг бурхны хүлэг болсон...ямаан сүрэг чинь арван зүтээ дэлгэрээд...(МААЗДБ)*.

ДАН I хя. *dàn*; мө.б. *dang*; Арван дүүгийн хэмжээ; хоёр дан будаа.

ДАН II хя. *dān*; мө.б. *dang*; 1. ганц, ижилгүй; дан биеэр ажиллах; 2. өрөөсөн, сондгой; дан тоо; 3. давхар бус; дан тэрлэг; 4. **шилж** нэг зүйлээр бүтсэн хольцоогүй; хар ноолуур.

ДАНАН хя. *dāinán* (манж *danahun*; түр. *dana*); мө.б. *danan*; бөвөөлж шувууны өөр нэр.

ДАНДАР тө. *stan dar* (<сам. *tantra*); мө.б. *dandar*; "шашин дэлгэрэх"; Бурхны шашны номлол дахь их хөлгөний аймгийн тарнийн ёс; жудийг үз.

ДАНЖ хя. dàng zi; мө.б. danži; юм зээлдүүлэхэд барьцаалах юм; данж бариулах.

ДАНЖААД хя. dāngjia-de; мө.б. dangjiyada; 1. гэрийн эзэн, ерхийн тэргүүн; 2. пүүсийн эзэн.

ДАНЖУУР тө. bstan bsgyur; мө.б. danjur; "шаstryн орчуулга"; Бурхны шашны ном зохиолын агуу их хоёр цомирлогийн нэг, уран зохиол, толь бичиг, хэлзүй, гүн ухаан, газар зүй, урлахуй ухааны ном судар багтаасан буй. Данжуурт ухааны таван орны зохиол орсон. Данжуурыг монголоор орчуулах, хэвлэх ажлыг Жанжаа Ролбийдорж (1717-1786) толгойлж, хоёр зуу орчим гүүш оролцжээ. Нийт 225 ботид 3427 зохиол багтсан.

ДАНЗИЙ тө. bstan rtsis; мө.б. danži; Төвдийн түүхийн утга зохиолд багтах он дарааллын тусгай эмхтгэл.

ДАНИСДАА сам. dhanishṭha; мө.б. danisda; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монголоор Гөрөөчин шумнасын одон ч гэдэг. Одоо Тооно од гэж нэрлэж буй.

ДАНС хя. dān zi; мө.б. dangsa; Тoo баримт зэргийг жагсаан тэмдэглэсэн дэвтэр, бичиг; дансгүй (дансанд ороогүй, бүртгэлгүй); данстай (дансанд орсон); данслах (дансанд бичиж тэмдэглэх, бүртгэж авах).

ДАНСИЛ тө. stang zil; мө.б. dangsil; расияар чулуу (үз).

ДАНТА сам. danta; мө.б. danta sara (Ков.); Энэтхэгийн наймдугаар сар буюу Бадраапад сар.

ДАНХ хя. tónghú; мө.б. dangqu; Цай, ус зэрэг шингэнийг агуулах зэс, гуулиар хийсэн нэг зүйлийн дэвэр.

ДАНШИГ тө. bstan bzugs; мө.б. danšu; "бат оршил"; Анхдугаар бодг Занабазарт (1635-1723) анх 1696 онд түүний насан хутаг оршихын билэгдлээр зохиосон наадам. Даншигийг гурван жил тутамд нэг удаа зохиож байснаа хожим наймдугаар бодын үед жил бүрийн зуны сүүл сард өргөж, наадам хийх болсон. Халхын дөрвөн ханы аль нэг нь Богдын насан хутаг батдахын ерөөл тавьдаг байв. Ерөөл төгсмөгц ноёд, ихэс, лам нар хадаг өргөн, мөргөл үйлдэж, их наадам хийдэг байлаа; Даншиг өргөх (халх дөрвөн аймаг, их шавь таван газраас монголын шарын шашны тэргүүн Богдод урт наслахыг ерөөж, их бэлэг сэлт өргөж, эрийн гурван наадам хийдэг байсныг нь); Даншигийн цуваа (бат оршил өргөж, эд юмсыг цувруулан барихыг нь). Энэ цувааны эх нь таван ёнгийн урт хадаг уясан мөнгөн мандлаар эхэлдэг байжээ);

Долоон хошуу даншиг наадам (ХҮП зууны эхэн үед халх долоон хошуу нийлж нааддаг байсныг нь).

ДАРА: дара эх; сам. tāra; мө.б. dar-a; "тэтэлгэгч".

ДАРГА перс. darova; мө.б. dargu-a; Удирдах тэргүүлэх үүрэг хүлээсэн эрх бүхий хүн.

ДАРГАН тө. da rgan; мө.б. dargan; Нурууны үес мурийх өвчин. Гэдийх, бөхийх дарган гэж ялгана.

ДАРЖААЛИН тө. dar rgyas gling; мө.б. darjayiling; "өргөжин дэлгэрэх хийд"; Дээд төвдийн бурхны шашинтны том хийдийн нэр.

ДАРЖИН тө. dar(kyi) chun(po); мө.б. darjin; "хивийн багц"; 1. шашны ёсоор хүний тэнүүчлэн одсон сүнсийг дуудах үед нэг үзүүрээр толгойг ороож, нөгөө үзүүрийг гадаа гарган барьж байх таван ёнгийн тууз буюу хив; *Долоо хоног даржинг авч болохгүй гэж Лундэгжунай гавж згаварлав.* (Л.Т.); 2. шилж. ядуу хоосон, тарчиг; даржингийн зовлон.

ДАРИГАНГА сам. tāra+gāngā; мө.б. dariyangu-a; "тэтэлгэгч+ганга"; Одоогоос 300-аад жилийн өмнө Захын хар өндөр, хожим нь Алтан дарь овоо буюу Алтан овоо гэдэг уулын нэр болох Дарь, түүнээс холгүй орших Ганга нуурын нэрээс бүрэлджээ. Монголын зүүн өмнөд хязгаарт орших газар нутгийн нэр, бас тэнд оршин суугч ястны нэр болно.

ДАРМА = дхарма.

ДАРЦАГ тө. dar lcog; мө.б. darčoγ; 1. гурван залаа буюу бүчтэй, тарнийн үсэг дармалласан бяцхан далбаа; Хүрээ хийдийн хашааны өнцөг болон хийдийн хаалганд хатгадаг. Энэ нь хүрээ хийдээс муу зүйлийг зайлзуулах шидийн билэгдэл ажээ. хийморийн дарцаг; 2. хийсэх эдээр хийсэн иш бүхий жижиг далбаа; дарцаглах (морин дээр өндийн босч, морины хар эрчээр довтолгох).

ДАРЬ уй. dari; перс. daru; мө.б. darī; Модны нүүрс, хүхэр буюу шар хүхэр зэргийг тодорхой хувиар найруулж хийсэн тэсрэх бодос; хорш дарь хүхэр; Галт зэвсгийн цэнэг хийх энэхүү тэсрэх бодисыг чулуу гагнах, төмөр хатаах, шилээр юм цутгах зэрэг зүйлийн найрлагад хэрэглэнэ. Монголчууд түймэрт шатсан буудны дээр түнгэд, бороо орсны дараа ургасан шүүг цуглувуж, модонд хийж, усанд зуурч нухаад, хүхэртэй холин, бургасны нүүрсээр харлуулан элдэншүүлж дарь хийж байжээ. Мөн хадны шүүг усанд буцалгаж, дээр нь савх мод хөндлөн тавьж шүүг ялган

авч, хар модны нүүрс, хүхэртэй холин усанд хийж, ширгэтэл буцалгаад чулуугаар нухан, дахин буцалгаж усыг ширгэсний хойно дарь хийдэг байжээ.

ДАЦАН тө. grma tshang; мө. dačang; "хуврагийн аймаг"; Шашны ёсны лам хуврагийн сургууль ном хийх орон сүм. Үүрэг зорилгоор нь Чойр дацан, Мамба дацан, Зурхайн дацан гэхчлэнгээр ялгана.

ДАШ: даш хадаг; тө. bkra śi kha btags; "өлзийт хадаг"; Хамгийн жижиг хадаг, гялгар ч гэдэг. Цоохор даш, хээтэй даш гэхчлэнгээр ялгана.

ДАШИЙН ШОГ тө. bkra śis śog; мө. daši šoy; "Өлзий хутаг оршигтай" гэсэн ереөлийн үг боловч ярианы хэлнээ хожуу үед "огт байхгүй" гэсэн утга заах болсон буй.

ДАШИН тө. sta sing; мө. dasin; Жугангийн өөр нэр.

ДАШИНЧИЛЭН тө. bskra śes 'khyil; мө. dasinčiling; "өлзийт үйлга, өлзийт зөв эргүүлэг"; Булган аймгийн нутгийн нэгэн ул.

ДАШЛХҮМБЭ тө. bkra śis lhun po; мө. dasi lhungbu; Төвдийн Лхас хийдээс 250 мод газарт, Цан мужийн Нян голын урсгалын доод хэсэгт Зонховыг таалал төгссөний хойно түүний шавь анхдуугаар Далай лам гэгдэх Гэндэндүв 1447 онд байгуулсан хийд. ХҮП зуунаас эхлэн энэ хийдийн ширээт лам нарыг Банчин римбүүчий буюу Монголоор Банчен эрдэнэ гэж нэрийдэх болжээ. Энэ хийд нь Төв төвдөд байсан шар малгайтын хамгийн том төв болж байжээ.

ДАШМАН перс. danisman; мө. danisman; "эрдэмтэн хүн"; Лалын санваартан. Монголын дөрвөлжин бичигт гардаг үг.

ДАШНАМЖИЛ тө. bkra śis tnam rgyal; мө. dasinamjil; "өлзийт тийн ялгуугсан"; Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байдаг уулын нэр.

ДАШНЯМ тө. bkra śes nyi ma; мө. dasinim-a; "өлзийт наран"; Дашиямтай өдөр (зурхайн ёсоор сар бүрд гол төлөв нэг удаа тохиодог өлзий хүргийн маш сайн өдөр гэдэг).

ДАЯАН сам. dhyāna; мө. diyan; Нэгэн үзүүрт сэтгэлээр аглаг газраа сууж хийх бясалгал; даяанд суух (бясалгал үйлдэн суух; Бурхны шашны номлооор даяанд суувал бодол сэтгэл нь нам тайван төвлөрч, бодь мөрийг танин, ёсыг олдог ажээ); даяанч (1. даяан үйлдэх хүн; 2. махан хоол цээрлэдэг хүн); даяанчлах (даяанч болох).

ДАЯГ тө. brda yig; мө. dayūg; "дохионы бичиг"; Дохионы бичигт бүх үгийг хамруулсан байдаг ба уламжлалт нэр томъёогоор "нэр тайлсан" байдаг учир ерийн орчуулгын толь бичиг болно; Даяг үзээгүй бичээц, маяг үзээгүй зурагч (Зүйр); даяг үзээд нэрч болдогтүй янийг үзээд янч болдогтүй. (Зүйр).

ДАЯН сам. odiyāna; мө. dayang; Уржин.

ДИВААДАД сам. devadatta; мө. divadad; "тэнгэрийн өглөг"; 1. "Улгэрийн далай" зэрэгт гардаг хорлогч, саад таригч тойн Диваадад; 2. **шилж** ямарваа ажил үйл хийхэд тогтор таригч саад бологч; диваададлах (хориг болох).

ДИВААЖИН тө. bde ba can (сам. devastana); мө. divajan; "тэнгэрийн орон, амгалант"; 1. тоост өртөнцөөс бусад бурхан сахиулсан орших ариун амгалангийн орон; 2. **шилж** хүний аж төрөхөд ая тухтай нохцөл бүрдсэн орон газар, орчин.

ДИВАН ор. диван<(перс. divan); мө. divang; Хэвтэх суухад зориулсан ардаа түшлэгтэй, хажуудаа тохойлдох тавиуртай урт зөөлөн сандал; буйдан ч гэнэ.

ДИВАНГАР сам. dīrāṅkara; тө. marme mdzod; мө. divanggar-a/dibanggar-a; "зул зохиогч"; 1. маш эрт өнгөрсөн галавт номын хүрдийг эргүүлж, шашнаа дэлгэрүүлсэн бурхны нэр; *Сонсохуйяа зөвлөн яруу дуут Дивангар бурхны вияакиридийг дурдан соёрх (12 зох)*; 2. **шилж** өнө эрт өнгөрсөн, аль язгуурын; *Аль дивангарт мартагдан орхигдсон өнчин булшин дээр...хижээл хар хүн гарч ирэв (АЭ)*.

ДИГВАРАНЗ тө. sdig ra rwa can; мө. diybāraṇja; *Buitus occitanus*; Өнгө хар, зургаан хөлтэй, хөл нь үетэй, сүүлийн үзүүртээ салаа, хорт хавчууртай, наймалжаас биеэр бага хорхой. Урласан үедээ өөрийгөө ч хатгадаг, сүүлээ агсаж байдаг тул Ямаан ууцат гэж нэрлэх нь бий. Монголоор "хилэнцэт хорхой" гэж орчуулан нэрлэнэ. Ардын эмнэлэгт эмийн найрлагад орно. Дигваранзад хаттуулсан буюу шавуулсан хүний амаар хөөс цахран, амьсгал нь тасалдан үхдэг гэсэн ардын яриа байдаг.

ДИЙЗ хя. diè zi; мө. deyije; Жижиг таваг; аяганы дийз; дийзлэх (дийзэнд хийх).

ДИНАР ар. dinar; мө. dinar; Алтан зоос.

ДИНБУН din bun; мө. dingbun; Жундан торго.

ДИНВАА тө. dgeng ba; мө. dinva; "номт дэвсгэр"; Бурхны шашны гэлэн хувраг хүний мөрөн дээрээ тохчиоод авч явж, суудаг дэвсгэр.

ДИНДУГ сам. *dindūmka*; мөб. *dinduka*; Энэтхэг орноо ургах хар хушга мод; *Түүний бие нь алжааж өлсөн ундаасахуй-бээр эмгэнэнээр нэгэн диндугт модны боловсорсон үрийг олж идвээс маш амттай* (*Цаг. лян*).

ДИНШИГ тө. *ting šag*; мөб. *dingsay*; Цанхилзуурын адил хооронд нь харшуулан цохиж дуугаргах, зэс буюу төмөрлөгөөр хийсэн хоёр жижигхэн дүгрэг хөгжмийн зэмсэг, одоо бол дэнишиг ч гэж бичдэг.

ДИСА сам. *desa*; тө. *tise, te-se*; мөб. *disa* (*Ков.*); "орон"; Цастьн орон, Хималайн нурууны өндөрлөг хэсэг.

ДИСАА тө. *dri za*; мөб. *disa*; "үнэр идээгт", гандарваа; Хималайд байdag Гандхамаадан (үнэрээр согтоогч) уулын цэцэгсийн үнэрт газраас гаралтай гэж домоглодог тэнгэрийн хөгжимчин, дуучин сахиулсан тэнгэр.

ДИЦ тө. *tī tsha*; мөб. *diča*; Мөнгөлөг цайвар өнгөтэй, халуунд тэсвэртэй төмөрлөг; дицдэх (дицээр өнгөлөх, гагнах).

ДИЯАН даяан; мөб. *diyan*; дияаны идээ (баясталант идээ ч гэнэ. Хүн төрөлхтөн хувилж төрж, отгоргуйгаар дүүлэн явдаг байжээ. Тэр цагт хүн биеийнхээ гэрлээр харанхуйг арилган, цаглашгүй урт наслаж идээ ундаа хэрэглэхгүй баясталангаар идээ болгож баснаас ийн нэрлэх болсон гэдэг); дияанч (даяанч); дияанчлах (даяанчлах).

ДОГ I тө. *tog*; =ганжир; мөб. *doγ*; Юмны орой дээр чимэг болгон хийсэн зүйл; жанцангийн дог; тунийн дог.

ДОГ II тө. *ltog*; мөб. *doγ*; Онохуй, ухаарч мэдэхүй; доглох (онон мэдэх); ...абугай чи дахиал доннид доглов (*Зуун бил*).

ДОГВО тө. *ltog ra=zlog ra*; мөб. *doγbi*; "хариулга"; гай зэтгэрийг арилгахын тулд хийх хариулгын зан зүйл болон буцаах, хөөх хариулга гэсэн утгатай; ...өнөөх л гурмийнхээ номыг уншиж ой догво базаагаад эцсийн удаа сор залдаг юм гэдэг (*С.Д.*); догводох (догво үйлдэх); ...цогондой нар ном уншин догводож заналт нүдээр нэхэн харсаар хоцров. (*С.Д.*).

ДОГЖИР тө. *zlo gyur=bzlog bskyug*; мөб. *doγjir*; "няцуулагч буюу хариулагч"; 1. аливаа муу үйлийг эргэж хөрвүүлэх буюу хариулах гүрмийн зан зүйл; 2. шовх гурвалжин хэлбэр гаргаж гурилаар хийсэн балин.

ДОГЖОД тө. *rtogs brjod*; мөб. *doγjod*; "домог өгүүлэл, онол өгүүлэхүй, цадиг өгүүлэл" (сам. *avādāna*); Зан суртахууныг засах

чиглэлээр ашигласан элдэв хүн амьтны тухай өгүүллэг үлгэрийг хэлнэ. Догждын гол баатар нь ерийн хүн байdag төдийгүй бодисад ч байдаг. Монголчууд дожод гэж нэрлэж ирсний зэрэгцээ домог тууж, ухааныг өгүүлэхүй зэргээр орчуулж байсан. Угтаа домгийн шинжтэй зохиолын төрөл зүйл, туужис юм.

ДОДВА тө. *dod pa*; мөб. *dodba*; "магтаал, хүсэл"; Хүсэл магтаалын маягтай уншин айлддаг ном зохиол; *нар баруунаа гудайхад намтар додвоо айлдав*. (*Гам.*)

ДОДИГ тө. *stod gyogs*; мөб. *dodiγ*; "цээжний өмсгөл"; цээживч; Ханцуйгүй нэг төрлийн хантааз. Уг нь нүцгэн цээжинд өмсөх бөгөөд уртаараа бүсэлхийд хүрнэ. Зах, мөр нь хүрэн, урд энгэр улаан, ар нь хоёр захаараа хар, дунд талдаа гурван улаан эдээс бүгдэг. ...*Ерөнхийлөгчийн ёслолд өмсдөг малгай, бүс, додигт үнэт зүйл орсон тул улсын өмч болгох...юм байна* (*А.Э.*).

ДОЙ тө. *zlos*; мөб. *doi*; Гай зэтгэрийг арилган засах хараал жатга, тарнийн шившлэгийн зан зүйл; дой догво (хариулга, хараал хариулга); ...*дой догво хамаг бүхнийг базаагаад гурилаар хийсэн...* (*С.Д.*).

ДОМ I тө. *sdom(ra)*; мөб. *domu*; Санваар; Чойрын сургууль төгсөхөд хийх баярын хурим; домын дамжаа барих.

ДОМ II тө. *dom*; мөб. *dom*; 1. хүн өөрийн зүйл ажиллагаагаа хүрээлэн буй юм үзэгдэлтэй холbon ухаараадаа ямар нэг шидэт хүчин нөлөөлж байна бишрэх болсноор үүсч бий болсон сүсэг бишрэлийн эртний нэг хэлбэр; 2. ид шидэд биширч, түүнийг танин мэдэж, ид шидийн хүчээр хариулах оролдлого буюу эмчлэн засах арга; *хорш* эм дом; домын судар (домнох, анагаах зүйлдлийг заасан судар, энэхүү судар нь ард түмний аж амьдралд өргөн нэвтэрч зан заншил болсон буй); дом засал (цагаан, хар, алаг гурван зүйл судар ордог. Цагаан дом нь: өвчин зовлон, гай барцдыг тарни шившлэгээр дарна гэдэг. Хар дом нь: туршлага ажиглалтын хар ухаанаар дараах засал. Алаг дом нь: хар, цагааны аль алиныг хослуулсан шинжтэй); домч (арга засал хийгч); домчлох (дом засал хийх); домнох (а. өвчин зовлонг анагаах арга дом хийх; б. *шилж*. алив ажил, юмыг ор нэр хийх); домтох (ам гэмтэх өвчин).

ДОМ III хя. *duán*; мөб. *domu*; Хар дурстай, том навчтай, шар буюу цагаан цэцэгтэй, бөөрөнхий жимстэй нэг зүйлийн зөөлжэн чанартай тураг мод. Дурсаар нь олс дээс, модоор нь сийлбэр зэргийг хийнэ.

ДОМ IY тө. ldong; мө. domu; домбо.

ДОМБО тө. ldong bo~ldung mo; мө. dombo/~dongmu/ dongba; Мод төмөрлөгөөр хийсэн, цоргогүй хараатай шингэн зүйл хийх сав; домбон үрэл (машин техникт хэрэглэх зууван үрэл)^

ДОМТИ тө. dom mkhris; мө. domti; Баавгайн цөс, өтгийн шүлс; баавгайн домти.

ДОН тө. gdon; мө. dong; 1. ад, хий юм; дон шүглэх (тө. bžugs pa) (ад нөхцөх); 2. хэтэрхий дуршилтай болсон нь; архины дон, донтох (а. дон нөхцөж дэмий донгосч ярих; б. алив юманд хэт дурших).

ДОНВААНИД тө. stong pa nyid; мө. б. dongba nid; “хоосон чанар”; Бурхны ёсны төв үзэл дэх орчлонгийн юм үзэгдэл, сав шимиин өртөнцийн амьдралын өөрчлөгдөн хувьсах ёс. Хамаг юм үнэхээр бүгээгүй хоосон чанартай боловч өртөнцийн томъёоллоор бүтдэг хэмээнэ. Хоосон чанар нь огт байхгүй хоосон гэсэн үг биш, юм бүхэн салангид бус харилцан шүтэлцсэн харьцангуй чанартай оршино гэсэн санааг илтгэнэ. Харьцангуй чанар гэдгээр нь ухвал юмс үзэгдэл байнга хувьсан өөрчлөгдөнө гэдгийг хүлээн зөвшөөрсөн утгатай болно; ...*донваанидийг баримталж...*(Гам.).

ДОНГО I тө. dong ga; мө. dongy-a; 1. буурцгийн язгуурын сондуултай тураг мод. Тэгш үслэг нийлмэл навч нь цувран ургах буюу багсайн ургана. Модоор нь тэрэг, багаж хийдэг. Буурцааг жимс нь эмд орно. Үрийг алт өнгөлөх, шарах зэрэгт хэрэглэнэ; 2. нүүр угаах нэгэн зүйлийн эд, донго эм гэнэ. Шороо, хужир болон үхрийн баас зэргийг хольж зурсан угаалын эм.

ДОНЖИГ тө. don gčig; тө. donciy; мө. donjiy; “утга нэг”; Ижил, адилхан, агаар нэг, ялгаагүй; донжигтоо донжиг (адилдаа адил).

ДОНИР тө. don gnyeg; мө. donir; Мяндаг тушаалтан нарын бараа болоочин, данс даяг харгалзагч түшмэл.

ДОННИД донваанид хэмээх үгийг хураангуйлж хэлсэн нь; мө. dongnid; *Аяа, хайрхан, абутай чи доннид дөглов уу* (Зуун бил).

ДОНРОЙ тө. ldong ros; мө. dongroi; Их хатуу биш, улбар шар өнгийн чулуулаг. Эмийн найрлагад хэрэглэхийн сацуу түрхэх, зурах зэрэгт хэрэглэнэ. Чулуун шарз, алтанхүхэр гэхчлэнгээр нэрлэнэ.

ДООРОМБО тө. mdo rams pa; мө. doramba; Лавранд очиж, чулуун суудалд суун ном хаялцан хамгаалах эрдмийн зэргийн нэр.

ДОРБО мө. б. dorbo; дором-ыг үз.

ДОРГИ : Дорги яам; манж. doryi; мө. б. dorgi; Дотоод яам.

ДОРГИМ тө. dtor sgam; мө. б. dorgim; бурхан тахилын авдар.

ДОРДОГ тө. gtor bzlog; мө. б. dordoy; Няцаалт, хариулга; *Дордог сорын хурлаа тогтоол журмаар явуулав.* (Зуун бил).

ДОРЖДАН тө. rdo rje gdan; мө. dorjidan; Очирт суурин (үз).

ДОРЖХОДВО тө. rdo rje čod ra; мө. dorji čodba; “очроор огтлогч”; Аливаа гай зэтгэрийг очроор огтлохтой адил дарна гэж үздэг шашны номын нэр. Муу совин татах, муу ёрын зүүд зүүдлэх, өлзий бус явдал болох, гарз гарах, өвчин зовлонд баригдахад айлгадаг.

ДОРЖНЯЛБАА тө. rdo rje dmyal ba; мө. dorjinilba; Очир там.

ДОРЖПАЛАМ тө. rdo rje pha lam; мө. dorji palam; Очир алмаас. Асар хатуу нэгэн зүйл эрдэнийн чулуу. Янз бүр өнгөтэй, гоёл чимэглэл хийх, чулуулаг өрөмдөхөд хэрэглэнэ.

ДОРОМ тө. gtor ma (сам. bali>балин); Шашны нэг зүйл зан үйл явуулахад зорилж цагаан будаа, арвайн турил, улаан буудай тэргүүтнээр хийсэн шовх оройтой балин. Гурвалжин балин ч гэнэ. Бурхад, арши нар, чөтгөр шуламс тэргүүтнийг тайтгаруулах өргөлийн зүйл.

ДОЧИГ тө. 'dod chags; мө. doči; Юманд хэт шунан тэсч ядах нь; хуял тачаал; садар завхуул.

ДОШИЛ тө. do sel; мө. dosil; сондор.

ДӨРӨМ: дөрөм төмөр; ўй. törmé; мө. dörüm-e; Улайдмал төмөр, уялган төмөр ч гэнэ. Дундад үеийн монгол бичгийн дурсгалд гардаг.

ДӨШ тө. gru bži; мө. dösi; “дөрвөлжин чулуу”; 1. хар хүрэн өнгөтэй, хагалбаас шар зэв гардаг, хавтгай дөрвөлжин хэлбэртэй чулуу. Эмнэлэгт хэрэглэнэ; 2. Төмөрлөгийн зүйл тавьж нимгэлэх, өнгөлөх, давтан цохих төмөр хэрэгсэл; азарган дөш (мунцгар бөөрөнхий дөш); суурьтай дөш (модонд зоосон дөш); тагилтай дөш (төмөр, мөнгө нүхлэх, тав хадахад хэрэглэх дөш); тахир дөш (мөнгө хөөдөг дөш) гэх зэрэг олон янз бий. Дөш нь эрхэм багажны нэг учир алх дөш хийлгэхэд өдөр судар үзнэ. Цагаан сарын битүүний орой дөшөө хойморт залж, идээ цагаа өргөнө. Дархчуул алх дөшөө сэтэрлэдэг; 3. бие бүтцийн зүй; дунд чихний нэг жижиг яс.

ДУАЗ сам. *dva᷍a*; мөб. *duvā᷍a*; =жанцан, ялгуусны тэмдэг; эс зохилдох гурван зүйл амьтныг зохилдуулж дурслэн чимсэн байдаг. Арслан гарди хоёр, халиу загас хоёр, матар лавай хоёр тус тус зохилдон бүрэлдсэн өлзийт амьтны дурсээр чимсэн тэмдэг; Найман тахилын нэг.

ДУГАН тө. ‘*du khang*; мөб. *du᷍ang*; “хурлын байшин”; 1. хурлын сүм, шүтээний өрөө зэргээс бүтэг шашны хурал номын газар. Дуган нь их төлөв хоёр эгнүүлсэн баганаар тусгаарлагдах гурван хэсэг бүхий нэг өрөө байдаг. Багануудын хооронд лам нарын жавдан байна; 2. гэр хэлбэртэй, бүс бүрээстэй хурлын сууц; дуганч (дуганын харгалзагч).

ДУГУЛА тө. *du gu la* (<сам. *dogulagam*); мөб. *dugula*; Нэгэн зүйл өвс, эл өвсөөр нэхсэн бөсийг монголчууд шаа торго гэнэ.

ДҮЙРАА тө. ‘*grus gra*; мөб. *diyū᷍-a*; Буддийн гүн ухааны сургуульд үзэж судалдаг шалгадаг ухаан буюу цадма ригба (логикийн) зохиолын хураангуй сурах бичиг.

ДУЛАН манж. *dulan*; мөб. *dulan*; Годил шиг бөгөөд хавтгай, товоруу мэт чулуурхаг хайртай, бие урт, орой дээрээ ус гожтуудуулах сүвтэй, догшин зантай нэг зүйл далайн загас. Арыс ширүүн тул нумны сум, яс зэргийг засах ба эмээл хулдах зэрэгт хэрэглэнэ.

ДУЛБАА тө. *dul ba*; мөб. *dulba*; “усгал, номхон”; Цанидын таван аймаг сав ухааны нэг. Ламын сахил санваарын ном. Гурван хөлгөний доод хөлгөний ном.

ДУМТАА тө. *grub m̥tha*; мөб. *dumta᷍-a*; “бүтээлийн эцэс”; (сам. *siddhānta*); Уламжлалт монгол орчуулгад “тогтсон таалал” гэнэ. Өөрийн оюун ухаандaa үнэхээр мөн чанар буюу угтын ахуй ёсон үүнээс өөр байх ёсгүй хэмээн ухаанаар бүтээсэн буюу лавлан товолосны эцэс буюу товчлон хэлбэл юмын уг мөн чанар, ахуй ёсыг оюунаараа тунгаан бясалгасаар хүрсэн эцсийн шийдвэрийг хэлнэ. Буддийн гүн ухааны билэг чанарын хөлгөний таван ухааны нэг, түүхийн сурвалж бичгүүд болно. Думтаагийн аймаг нь “гадаад тогтсон таалал”, “дотоод тогтсон таалал” гэсэн хоёр хэсэгт хуваагдана. Эхнийх нь буддийн бус гүн ухааны, дараачийных нь буддийн гүн ухааны түүх болно.

ДҮН тө. *dung*; мөб. *dung*; 1. зарим сээр нуруутгүй амьтны бие хамгаалах хатуу бүрхүүл гэр; 2. дээрх бүрхүүл гэрийг засч хийсэн үлээх хөгжмийн зэмсэг. Дунг нийтийн хурал цуглалан зарлах дохио болгон үлээдэг байв. Лавай ч гэнэ. Дун нь цав цагаан, шар

цоохор, цагаан, улаан дөрвөн янз бий; Дун цагаан (маш цагаан); дун бүрээ (үлээдэг хөгжмийн зэмсэг); дун ногоо (эрчилсэн эргүүлэгтэй, жижиг дун хэлбэрийн ногоо); 3. дун дотор орших нялцгай биетэн, дунхорхой ч гэнэ. Дун нь цаас хийх, өнгөлөх зүйлийн найрлагад орно. Бас есөн эрдэнийн нэг.

ДУНБАР тө. *dung phor*; мөб. *dungbor*; “лавай аяга” (Ков.); Далайн хавчны бүрхүүл аяга.

ДУНГАЛ тө. *gdung(ma) bkal(pa)*; мөб. *dungyal*; “нуруу тавьсан” (дам); Гэрийн тоононы голын дутуй цагираг.

ДУРАН перс. *dūr*; мөб. *durang*; “хол, алс”; Алс холын бараа харах хараа зүйн хэрэгсэл.

ДУРАН АВАЙ перс. *dūrbīn*; мөб. *durang abai*; “холыг харах”; Сансрыйн од эрхэсийг харахад хэрэглэх хараа зүйн хэрэгсэл.

ДУРАНБАЙ перс. *dūrbīn*; мөб. *durangbai*; дуран авай гэсэн хоёр үг нийлж бүтсэнээс утга нь өвердсөн буй; Энгийн нүдэнд харагдахгүй бичил биетийг харах шилт дуран.

ДУРУГАА тө. *tu tu ka*; мөб. *dirtuga*; Баллига буюу шаллига хэмээх модноос буусан нэгэн сайхан үнэрт эд (С.Р.).

ДУРУСГА сам. *turuska* (манж. *durusxa*); мөб. *durusya*; *Corypha umbraculifera*; 1. навчин дээр нь бурхны шашны ариун ном бичиж байсан энэтхэгт ургадаг нэгэн мод; 2. Согвой буюу монгол хүж; үнэр тансаг, нэгэн зүйл хүж, зарим номд ерийн агар буюу бас хар агар гэдэг (С.Р.).

ДУУДАРАМ тө. *ndo dar ma*; мөб. *dudarm-a*; Дөрвөлжин модон хүрээн дотор жижиг нүх гаргаж, нүх бүрд нь жижиг зэс таваг бэхлээд өндөр ишин дээр байрлуулсан цохилуурт хөгжим. Нарийхан савхаар тус тавгуудыг цохиход сайхан аялгуу ялгарна.

ДУШМАН перс. *dušman* (тур. *dušman*); мөб. *dušman*; Дайсан, эсэргүү.

ДҮВЧИН тө. *grub chen*; мөб. *dübčin*; “их бүтээлч”; 1. их гэгээнтэн, их хутагт, бясалгагч; Дүвчин унзад; 2. *шилж* их юм мэддэг буюу бясалгагчийн дүр үзүүлэгч; их дүвчин хүн; дүвчигнэх (юм мэддэг хүн шиг сагсуурч сүржигнэх).

ДҮТ тө. *gdugs*; мөб. *düg*; Шүхэр; найман тахилын нэг, хатуу аюулын халуунаас хамгаалах сэрүүн сүүдрийг буулгахын билэгдэл гэдэг; дүт шиг эргэлдэх (хөнгөн хийсвэр, хөдөлгөөн ихтэй, тогтвортгуй).

ДҮГВА тө. *tug ra*; мө.б. *dügba*; Махтай буюу бурам тостой аглаасан будаа, тахилын идээ.

ДҮГЖИВ тө. *drug bci ra*; мө.б. *dügjib*; “зургаан арав буюу жарт”; Жарантаа бясалгах гэсэн утгатай. Хорт муу явдал, атаг санаа, шашны дайсан, тэрс номтыг дарах заслын зан үйлийн билэгдэл болгож, цаас гурил, шар тос зэргээр бүтээж, оройд нь доод гурван өнцөгт нь хохимойн дүрс хийж, тэхий дундуур нь хадаг зүүсэн сум хатгасан сүг дурс. Зүхлэг тарнийн номоор тарнидан галд шатаана. Шатсан үнсийг мөргөлчид элдэв гай зэтгэрээс бие хамгаалах увдистай гэдэг.

ДҮД тө. *bdud*; мө.б. *düd*; Шумнас, шулам; шашны ёсоор гадаад, дотоод, нууц гурван дүд бий гэнэ. Гадаад дүд нь ад сүг, гадаадад оргосон хаан, галт хөлт тийрэн; дотоодын дүд нь хоёр дэв буюу түйтгэр; нууц дүд нь үйл, хий нарийн бүдүүн тэргүүтэн ажээ. Өөрөөр хэлбэл шашны үйлстэнд хор саад хүргэгч; Бас хар дүд (*bdud nag*), цагаан дүд (*bdud dkar*) гэж хоёр зүйл бий гэнэ; дудлэх (дүд болох, хор саад болох); дүдтэх (саад хор учруулах).

ДҮЙ хя. *dúi*; мө.б. *dii*; 1. хос; 2. ойролцоо, адилхан, үеийн; нэг дүйн залуус; 3. тэнцүү, тэнцүүлэх; орчуулахад дүйх үгс сонгох; амь дүйх.

ДҮЙЗ хя. *dúi zi*; мө.б. *diiyije*; Адил, хос.

ДҮЙМЭН I тө. *btus ming*; мө.б. *düyiming*; “түүвэр нэр”; Ямар нэг төвд номын доторхи бэрх хатуу үг хэллэгийг түүвэрлэн тайлбарласан толь бичиг. Тэдгээр үгсийг уг зохиолд гарах дэс дараагаар нь хадаж тайлсан буюу дүйх утгаар нь орчуулсан байдаг. “Арвай хээрийн арван дүймэн” гэж монголд алдаршсан.

ДҮЙМЭН II хя. *dúi*; мө.б. *diiymeng*; “тохирлоо”; Хувцасны уулзвар энгэр. Монгол хэлнээ дүйлээ, таарлаа гэсэн утгатай.

ДҮЙНХОР тө. *dus kyi 'khor lo*; мө.б. *düyingqor* (сам. *kālacakra*, “цагийн хүрд”); Эртний энэтхэгт үүсч төвд монголд уламжлан ирсэн нар сар, гариг одны зурхайг илтгэсэн цаг тооны бичиг. Бандида Гунгаа-Одсэрийн төвд хэлнээс орчуулсан “Анхны дээд бурхнаас гарсан цогт цагийн хүрдэн нэрт дандарисын хаан” гэдэг зохиол энэ номлолын гол судар болно; Дүйнхорын ван (цагийн хүрдний авшиг хүртэхүй). Дүйнхорын авшиг хүртсэн хүн тэр айлгатлын гол зарчмыг насан туршидаа баримтлан явах эрх олж байгаа хэрэг юм. Ван тавих ёслол нь хамаг амьтныг нигүүлсэнгүй, сайн цагийн үйл нь бүтэмжтэй болтугай гэсэн санаа бүхий номын

хурим юм); Дүйнхорын дацан (тооны ухаан, одон зурхай, төлгө үзлэг, цагийн зурхай, мэдэл үйлдэх мэргэжил болон найруулга зүй зэргийг сурч судлах сургууль, энэ сургууль тэгсөгчдөд зээрэмбэ цол олгоно).

ДҮЙРЭМБЭ тө. *dus rim pa*; мө.б. *düyirengba*; “цагийн зэрэг”; Зурхайн ёсонд мэргэжсэн хүнд олгох эрдмийн зэрэг, зээрэмбэ ч гэдэг.

ДҮЙЦЭН тө. *dus chen*; мө.б. *düyicen*; “их цаг”; Бурхан багши бодь модны дор сууж, бясалгал хийснээр бурхны бодь хутгийг олсон ба мөн нирваан дүр үзүүлсэн өдөр. Энэ өдөр нь зуны эхэн сарын улаан тэргэл (15 нд) өдөр бөгөөд хүрээ хийд бүхэн тахил тавиг засч, ерөөл магтаал унишин, хурал ном хурдаг. Мөн бурхан багшийн их дүйцэн өдөр нь хаврын тэргүүн сарын шинийн 1-ээс 15 хүртэл болдог. Бурхан багши ид шидээ үзүүлсэн гэж үзээд 15-ны өдөр ерөөл айлтгал тавьдаг.

ДҮМ хя. *zhūmū*; мө.б. *dūmū*; Өндөр нь гурван метр илүү, зандан модны адил урт зууван навчтай, бөмбөлөг үртэй, цагаан цэцэгтэй мөнх ногоон мод.

ДҮМБЭ хя. *tóngfēng*; мө.б. *düngbū*; Их төлөв хөл барьж тусах нэг зүйл хүнд өвчин, тулай ч гэнэ; дүмбээтэх (дүмбэ өвчин тусах).

ДҮНГУА хя. *dōngguā*; мө.б. *düngüa*; Тарваастай адилхан, урт бөмбөгөр, цайвар ногоон хальстай, нарийн цагаан үстэй, чанаж иддэг нэг зүйл гуа.

ДҮНДАН тө. *gdung steng*; мө.б. *düng dang*; “дээд нуруу(мод)”; Дам нуруу, хөндлөн гулдан, хөндлөвч дүнз; хавирга нуруут тоссон их мод.

ДҮНДЭГГАРАВ тө. *ldum tig dkag po*; мө.б. *dündig ḡarbo*; Цагаан эрвээхэй цэцэг. 5-20 см өндөр олон наст өвслөг ургамал. Навч өндөглөг зууван, цэцэг цагаан, ардын эмнэлэгт хэрэглэнэ.

ДҮНЖИНГАРАВ тө. *dung skyong dkag po*; мө.б. *düngjöngyarbo*; “цагаан лавай тэтгэгч”(лус); Энэ лус, лусын хаан нь төвд, монголд ихэд алдаршсан газрын эзэн сахиулс. Улаанбаатарын өмнө этгээдэд орших Богд уулын эзэн сахиулс, савдаг; Угтаа 1678 онд Богд хан уул гэж өргөмжлөн Дунжингарав овоог босгосноос хойш ийн нэрийдэх болсон аж. *Амьтан бүхнийг жаргаасан авралтай Дунжингарав л гэнэ.* (МААЗДБ).

ДҮНЗ хя. *dūn zi*; мө.б. *düñje*; Уртаар тайрч, холтослон зассан бүдүүн мод; дүнзэн байшин.

ДҮНС хя. *dōngshēng*; мөб. *düngse*; Гансанд хийж татдаг тамхины ургамал; ногоон дүнс.

ДҮНЧҮҮР тө. *dung* ‘phyur; мөб. *düncür/düngčüür*; Есөн оронтой тоо, зуун сая буюу арван голди; Цэрэг нь гурван дүнчүүр гурван сая олон цэрэгтэй гэнэ. (Гэс).

ДҮНШҮҮР дүнчүүр; мөб. *düngsíür~düngsür*; сам. *niyuta*; сая (Ков.).

ДҮРВАА сам. *dürvə* (>тө. *dur ba*); мөб. *dürvə*; Гол төлөв гол мөрний эргээр ургадаг, ногоон навчтай, нарийн ишт ургамал. Дутуй бор өнгийн үртэй, олон салаа үндэстэй.

ДҮРЖИД тө. *dur byid*; мөб. *dürjid*; *Croton polyandrum*, *Euphorbia adenochlora*; Нэг үндэснээс олон ногоон навч, иш бөөнөөр ургадаг, үндэс хальс нь улаан буюу цагаан өнгөтэй, цэцгийн дэлбээ дерев, үр нь боөрөнхий буюу гурвалжин хэлбэртэй өвслөг ургамал.

ДҮРТОД тө. *dur khrod*; мөб. *dürtod*; Үхээрийн орон, газар; Дуртоддагва (үхээрийн газрын эзэн).

ДҮҮХЭРЛЭГ хя. *döö*; мөб. *dei*; 10,5 литртэй тэнцэх багтаамжийн хэмжээ. Арван шин багтах хэмжүүрийн нэр, будаа тариа хэмжинэ; дүүлэх (дүүгээр хэмжих).

ДҮҮГҮҮНЯН хя. *deu guniyang*; мөб. *deī güniyang*; өвсөн иштэй, өнгө улаан, амт хүчтэй, бүрээслэсэн арьстай, интоороос ихээхэн, үр их нэг зүйл жимс.

ДҮҮПҮҮЙ хя. *dóu-fu*; мөб. *deīfū*; Буурцгийн турилыг чанан хандалж, хөөсийг нь бяслаг мэт шахан царцааж хоолны хольцод хэрэглэх идээ.

ДҮШИД сам. *Tusita*; мөб. *tüśid*; *Бурхан тэнгэрийн жаргалант орон*; ...*Дүшидийн оронд гаралад байсан шиг санагдав*. (Б.Р.).

ДХАРМА сам. *dharma* (тө. *chos*); мөб. *dharm-a*; “шашин, ном, юм”; Орчлонгийн үнэнийг хүн өөрийн сэтгэлийг бүрэн таньснаар ухаарах бөгөөд хүний сэтгэлийг бүрдүүлэгч нэгж хэсгүүдийг хэлнэ. Хүн сэтгэлээ ойлгож чадвал орчлонгийн үнэнийг ухаарч байгаа нь тэр гэнэ. Үүнээс дхарма нь үнэн гэсэн утга илэрхийлдэг. Их хөлгөний сургаалаар сэтгэлийг зовлонд учруулагч цуврилт 53, сэтгэлийг амирлуулагч цуврилтгүй 55, бүгд 108 дхарма байдаг. Энэ өртөнцийн өвөрмөц шинж чанар бүхий юм үзэгдлийг баригч, бие хэл, сэтгэлийн алив үйлдэл бүрийг хэлэх ба аюул зовлонгоос

аврагч гэсэн утгаар ч хэрэглэгдэнэ. Үүгээрээ дхарма нь сэтгэлийг засах сайжруулах, ариусгахад зорьсны утга илтгэнэ.

ДЭВ тө. *grib*; мөб. *debe*; Бузар, түйтгэр, ариун биш, цөв; *хоршдэв дүй*; бузар дэв, булаг дэв; дэвийн юм (бузын юм); дэвшрэх (гай зовлон дагуулах); Дэвийт дотор нь *нисваанисын* дэв (тө. *non sgrib*); билгийн дэв (тө. *s̄es sgrib*) гэж ангилна. Үүнээс гадна таван дэв гэж байдаг нь: тачаангуйн дэв, муу санааны дэв, мунхрах дэв, хилэнгийн дэв, эргэлзэх дэв эдгээр болно. Эхний хоёр нь ёс суртахууныг суралцахад, гурав, дөрөв дэх нь бясалгал хийхэд, тав дахь нь ухаан бүхнийг мэдэхэд тус тус гай дэв бодлог ажээ.

ДЭВАНАГАР сам. *devanāgarī*; мөб. *devanagari*; “тэнгэрлэг хотын үсэг”; Эртний энэтхэгийн зарим хэлүүд болон самгарди, хинди, маратхи зэрэг хэлний бичгийн цагаан толгой. Тэнгэрийн үсэг ч гэдэг.

ДЭВЖИД тө. *sde brgyad*; мөб. *debjid*; “найман аймаг”; Бурхны шашны ёсны газар лусын найман аймаг. Үүнд лус, хаан, албин, лам, мангас, шулам, ягчис, савдаг ордог; *Баян буурал Алтай дэлхий*, лусад савдаг дэвжид найман аймаг (МААЗДБ).

ДЭВТЭР перс. *daftār*; мөб. *debter* (тө. *deb-ther*; манж. *debtelin*); цаас давхарлан үдээслэн товхисон бичигтэй буюу бичигтүй цаас.

ДЭВЭН : дэвэн галав; Дивангар гэдгийг дэвэнгар гэж хэлж бичдэг ба дэвэн нь энэ үгийн нэгэн өндөг болно.

ДЭГ тө. *sgrig pa-bsgrigs*; мөб. *dig*; “найруулах”; Дэглэх, горим, журам; *бүжгийн дэг*; дэггүй (журамгүй, дүрсгүй); дэгтүйтэх (дүрсгүй зан гаргах); дэглэх (алив юмыг эмх горимоор нь авч хэрэглэх; бүжиг дэглэх).

ДЭГД тө. *tig ta* (<сам. *tikta*); мөб. *digda*; “гашуун, гашуунаг”; *Swertia chirata*; Модны үндэс мэт нарийхан, түүний үзүүрт навчнаас үүсвэрлэн ургах хөх ягаан өнгөтэй хонхон цэцэгтэй, дэлбээ нь хэлхэлцэн олон бий. Зүлэг шарлахуйн үест ургасны дотроос өчүүхэн хар үр гарах, амт гашуун нэгэн мөн гэж эмийн сударт гардаг. Ургадаг орноор нь энэтхэг дэгд, балба дэгд, төвд дэгд гэж хуваадаг. Цэцгийн өнгөөр нь алтан дэгд, мөнгөн дэгд, зэс дэгд, төмөр дэгд гэнэ.

ДЭГЛЭМ тө. *bsgrigs lam*; мөб. *diglem*; “найруулах журам”; Журам, зарчим, хэв заншил; горим; дэглэмших (журмын чанартай болох).

ДЭДВОН тө. ded dpon; мө. dedbon; “удицуулсан ноён, худалдаачны ноён”; сартваахь.

ДЭЛ сам. tila (>tö.til); мө. dil; Sesaamum indicum; Дулаан орны маш тослог нэг зүйл ургамлын үр. Өнгөөр нь хар, цагаан гэж ялгана. Гүнжид ч гэж нэрлэнэ.

ДЭМ согд. ṭim (хя. dián); мө. deng; Энэ үг дөрвөлжин бичгийн дурсгалд dēm гэсэн хэлбэртэй байгаа. Буурчийн газар, дян буудал.

ДЭМБЭРЭЛ тө. rten 'brel; мө. demberel; “пүтэн барилдлага” (сам. pratitya); Аливаа юмс харилцан шүтэн барилсан байдаг бөгөөд үүний үндсэнд юмс үзэгдэл бүхэн өөрөө өөрийгөө бүтээсэн чанартайг илтгэнэ. Шалтгаант холбоо ч гэдэг; хорш билэг дэмбэрэл; өдрийн билэг дэмбэрэл (зурхайн ёсоор сар бүрийн өдөр тутамд 12 шүтэн барилдлага буюу дэмбэрэлийн аль нэгийг оноож, түүний сайн муугийн ялгалыг үйл ажилд тусгаж ирдгийг нь).

ДЭМЧ тө. dem chi; мө. demči; 1. сүм жасыг хамаарах шанзавын дараа орох зэрэг дэв, тушаал; 2. хууч. хошууны сангийн хэрэг ажлыг эрхлэх хүний тушаал.

ДЭМЧИГ тө. bde mchog; мө. demčig (сам. samvara); “дээд амгалант”; Нууц тарнийн ёсны хамгийн гол бурхан, гурван нигуртай, арван нэгэн мутартай, гавал сондор, хуяг дуулгатай, хоёр холөөрөө адыг бяц дарж байгаагаар дүрсэлсэн байдаг.

ДЭН I хя. dián; мө. diyān; Замд явваа хүмүүсийн буудал, буурчийн газар; дэн буудал.

ДЭН II хя. dēng; мө. deng; Хөвөнгөөр гол хийж, тос цутган ноцоож гэрэл гаргах зүйл.

ДЭНЛҮҮ хя. dēn long; мө. denglü~denglüü; Юмнаас дүүжлэх буюу гарг барьж явах бүрхүүлт дэн; *Шивээ Хиагтыг авахад шилэн дэнлүү хэрэгтүй* (дуу).

ДЭНС хя. dēng zi; мө. dengse; Алт мөнгө зэргийг хэмжих жижиг жинлүүр; дэнслэх (а. дэнсээр хэмжих; б. *шилж*. сэтгэл амгалангүй болох; сэтгэл дэнслэх; в. *шилж*. удаан хугацаагаар өлсөж зовуурилах).

ДЭРГЭ тө. sde drge; Дорнод төвдийн хот ба хошууны нэр. Ном барлаж байсан. Дэргэ данжур.

ДЭСРИД тө. sde srīd; мө. desrid; Эрх баригч, эзэн (төвдийн); Монголоор дисри гэж бичиж ч байв.

E

ЕГЗӨР сам. yogacāgva; мө. yegjör; “йогийн багш”; 1. бурхны шашны гүн ухааны дэг; 2. тарниийн номд мэргэжсэн хүн; 3. хашир догъ, хэцүү.

ЕМБҮҮ хя. yuánbǎo; мө. üivanbuu; Тусгай хэвд алт мөнгөөр цутган хийсэн гол төлөв дээд тал нь сэргээгэр, доод тал нь шувтан буюу эсвэл дэлбэгэр нэг зүйл зоос. Өлгий мөнгө буюу сүх ч гэдэг. Мөнгөний үүрэг гүйцэтгэж байсан учир лан жингээр янз бүр байсан; хулгар өмбүү (49-50 лан); ширээ цагаан өмбүү (50 лан); дуутуур өмбүү (4-5 лан мөнгө); илжгэн туруу өмбүү (5 лан мөнгө); тойгон өмбүү (10 лан мөнгө); *Арван лантийн өмбүү хараад алгаа тосдог аав уу даа*. (ардын дуу).

ЕРМА тө. gyer ma; мө. yerm-a; Халуун өвс (Ков.); 1. цагаан гаа; 2. харавтар үнсэн өнгөтэй, холтостой, өдлөг нийлмэл навчтай, хөхөмдөг ногоон жижиг жимстэй, жимс нь бор улаан, сүлү цэцгийн язгуурын нэгэн зүйлийн навч зулгарахгүй бут мод. Ирма ч гэдэг.

ЕРТӨНЦ түр. yirtinčii~yertöñčö; мө. yirtinčii (тө. 'jig rten); “эвдрэхүй шүтээн”; 1. бурхны шашны домогт гардаг орчлон дэлхий дээрх гурван ертөнц; сав ертөнц; шим ертөнц; өнгөт ертөнц; ертөнцөс (гурван ертөнцийн хамгийн том ертөнц, хөвөө хязгааргүй дэлхий дахинь ерөнхий нэр); *ертөнц дахин бээр амар сайн болтугай* (Зуун бил.); 2. газар дэлхийг оршин буй юмтай нь; дэлхийн бөмбөрцөг; 3. сансрын хязгааргүйд орших олон орчлонгийн зарим хэсэг; Нарны аймгийн ертөнц; 4. хүн, адгуус, амьтан ургамлыг нийтэд нь; хүний ертөнц.

ЕЭВЭН хя. yé bing; мө. yüvei bin 'саран боов', турилаар хийсэн нарийн боов; бор сэвэн.

Ё

ЁГТ сам. yucti; мө. yügti~yoğtu; илэрхий бус утгатай; ёгтлол (утгыг нуусан юм); ёгтлох (утгыг далдан хэлэх).

ЁДОР тө. gyo dar; мө. yodar; дарцаг; 1. хүүр оршуулах газарт хаттах мод; 2. тал хээрийн цор ганц мод; талын ганц ёдор; ёдроо барих (гүйлгачин болтлоо ядуурах). 3. гэр бүл, үр хүүхэдгүй ганц бие хүн; ёдор хүн.

ЁНХОР хя. jong; мө. yongqor (Ков.); Цэвэр торго, боловсруулсан мяндас; ёнхор утас (боловсруулсан мяндаар хийсэн утас).

ЁНЗОН тө. yongs 'dzin; мө. yongjon; “огоот баригч”; Оюун ухаан хийгээд гүн ухааныг огоот барьсан дээд хувилгаан лам багшийн цол; Ёнзон хамба (ном барих хийгээд гэгээний багш, нийтийг баригч мэргэн багш гэсэн цол хэргэм).

ЁНЧИЛ тө. gyon 'khiil; мө. yončil; “зүүнээ эргэсэн”; амны эргүүлэг нь нар буруу эргэсэн эрчлээстэй дун.

ЁНШГОЙТ хя. yuan shī kai; мө. yongsīyayitu; 1911 онд манжийн ноёрхлыг унагааж, Юан Ши кай Дундад иргэн улсын төрийн тэргүүн суусны дараа 1913 онд түүний тэргүүний дурс бүхий 7 цэнгийн мөнгөн төгрөг гаргасныг ярианы хэлэнд ийн нэрлэж байжээ.

ЁОГИНИЙ сам. yōgini; мө. yogini; Сүсэгч, мөргөлч, сүжигтэй, гэгээн.

ЁОЗ I хя. yāo zi; мө. уооја; Даалууны хоёрхон нүхтэй мод; *Aз хүү ирэхэд ёоз хүүгээр цохино*(Зүйр.).

ЁОЗ II мө. уооја; Гадна хэлбэр дурс, өнгө зүс, янз байдал; ёозгүй аашлах; янз гэдэг үгийн хувирсан хэлбэр.

ЁТОН хя. yao tang; мө. yoontong; Элсэн чихрийн шахмал.

ЁОЧИН хя. yueqing; мө. youčin; Модоор гонзгой дөрвөлжин хайрцаг хийж, гуулин утсыг хөндлөн тийш дэлдэн дуутаргах хөгжмийн зэмсэг.

Ж

ЖААД хя. jiāde; мө. jadi; Сайн бус, яс чанар муу; хуурмаг; жaad алт (хольцтой алт).

ЖААЖАА хя. jiē jie; мө. jačai; аниа, эгч; бас нас ах хүний нэрийг цээрлэж хүндэтгэн дуудах нэр.

ЖААЗ хя. jiá-zí; мө. jiuya; Мод, төмөр зэргээр сараалжлан хийсэн үүд хаалга, тавиур, гуу, хүрээ; жаазлах (жааз хийх).

ЖАБОЙ тө. rgya spos; мө. ĥaboi; “жагар гүгэл”; *Cimicifuga foetida* L; Холтсон цэцгийн намын олон наст, өндөр, өвслөг

ургамал. Шүхэр хэлбэрийн улаан цэцэгтэй, тойрсон уртавтар навчтай, их муухай үнэртэй хорт ургамал.

ЖАВА(A) сам. ĥarā; мө. ĥava; Нэгэн зүйл улаан өнгийн сарнай цэцэг; сүсэгтэн хүн цэцгээр нь эрих хэлхэн маань уншдаг; *Шингэх нарны гэрэлд жаваа цэцэг мэт час улаан* (*Кали*).

ЖАВДАН тө. rgyab rten; мө. ĥabdung; “нурууны шүтээн”; Хурлын лам нарын суудлын налуу тавцантай, олбог бүхий түшлэг. Сүм хийдийн тушаалтын зиндаанаас хамаарч суудлын өндөр, нам, олбогны өнгө ялгаатай.

ЖАВТИЙ тө. skyabs khrus; мө. ĥabtii; “авралын угаал”; Аливаа бузрыг арилгаж угаасан юм буюу түүнийг гүйцэтгэх шашны зан үйл; *шилж жавтий хүртээх* (гэсгээл шийтгэл үзүүлэх).

ЖАГАН тө. rgyags khang; мө. ĥačang; “хоолны гэр”; Сүм хийдийн гал тогооны гэр; *Хийдийн жаганд тогооч нар их нарийн идээ зоог бэлтгэсээр долоо хонов*. (*Б.Р.*).

ЖАГАР тө. rgya dkar; мө. ĥačag; “цагаан хягад”; Энэтхэг; Жагар орон.

ЖАД уй. ĥida; мө. ĥida; 1. хурц үзүүртэй урт иштэй, чичих бүлэх зэвсэг; 2. *шилж*. биеийн тамирт хэрэглэх модон иштэй, үзүүртээ төмөр шортой шидэх хэрэгсэл.

ЖАДААГУН хя. zhī~jiy+dayun (жий дуун); мө. ĥi(dayun); Эртний таван эгшгийн нэг, дууны өнгө дэд өндөр, дэд тунглагаг.

ЖАДАМБА тө. brgyad stong ra; мө. ĥadamba (сам. aśasāhastika); “найман мянгат”; 8000 шүлэг бүхий бурхан багшийн сургаал буюу “хутагт билгийн чанад хүрэгсэн найман мянгат” хэмээх хөлгөн судар. Монголчууд эртнээс өрх гэрийн шүтээн болгон шүтэж, мууг хөөх, насны хэрэг бүтээх, өлзий буян горилон үдшийн бүрийгээр гэр хотоо тойрон эргэдэг байв. Амьтан бүхэнд ачтай гэж үздэгээс санасан сайн үйлээ бүтээх, муу бүхнийг зайлуулахын тулд айлтгадаг.

ЖАДАНГА тө. byi tang ga (<сам. viđdanga); мө. ĥidangy-a; *Eugcsibe paniculata*; *Vitex trifolia*; Амт исгэлэн, халуун хурц, буурцагны дайтай үр. Нимгэн, жижиг, цайвар навчтай модонд ургана.

ЖАДИГ тө. rgya tig; мө. b. ſadig; “жагар дэгд” - гэдгийг товчоор нэрлэсэн нь.

ЖАЛАР тө. byi la; мө. ſilar; муур, мий; “...зөрүүд лүд байгаа юм. Жалар шиг зантай золиг” гэж маарамба хорсон бодлоо. (Л.Т.).

ЖАЛХАНЗ: жалханз хутагт; тө. rgyal khang rtse; “ялгуусны байшингийн орой”; Ялгуусны давхарлаг харшийн оройд ямагт номыг бясалган судаг байсан тэр үйлээр нь төвдийн Галдан хийдийн ХХҮ ширээт лам Балжиржамц (1526-1599) хэмээх эрдэмт ламыг анх цоллосон газар. Энэ алдар хожуу үед Монголд уламжлагджээ. Жалханз хутагтын монголд тодорсон анхны дүр Лувсанданзанжамцаас Дамдинбазар (1874-1923) хүртэл найман дүр гийсэн.

ЖАМАА = зам; ...их тогооны хоолыг голж хоёр ч залуужан жамааг тогооны нь дэргэд нэвширтэл зодов (Л.Т.).

ЖАМБА I тө. lcam pa; мө. ſamba; Malva sp; Иш шулуун, навч нь дугаригдуу, цэцгийн өнгө ягаандуу нэг ба олон наст ургамал. Цэцгийг эмэнд хэрэглэнэ. Монголоор халам цэцэг ч гэж нэрлэдэг.

ЖАМБА II тө. byang ba; мө. ſangba; Meloidae; Чийгтэй газарт орших цох хорхой. Хар, улаан, шар цоохор, хөх дөрвөн зүйл өнгөтэй, ардын эмнэлэгт хэрэглэдэг.

ЖАМБАРАЙ тө. ſam 'bras; мө. ſambarai; Caesalpinia bonducelle Fleming; Гилгэр бус өргөслөг навчтай, шар цэцэгтэй, хар голтой модонд ургадаг, сэгчин хөдөлгөхөд хангисарсан дуутай жимс, түүний доторхи бөвөөлжийн өндгийн дайтай тод хөх өнгийн дугариг үр. Монголоор зөвлөн үр ч гэдэг.

ЖАМЖИГ тө. skyabs ſjug; мө. ſamjig; “авралд багтаах”; Нэр хүнд, алдар; Занал өшөө хадгалбал жамжиг муутай учир шүү (Гам).

ЖАМЦ: жамц давс; тө. rgyam tshwa; мө. ſamču (сам. sindhuka); 1. Синд мөрнөөс авч байсан нэг зүйл чулуун давс; 2. Төвд Монголд ургадаг нэг зүйл чулуун давс, молор давс гэж ч нэрлэдэг.

ЖАМЬЯНМЯДАГ тө. ſam dbyans me-tog; мө. ſamiyang mida; “зөвлөн эгшигт цэцэг”; Холтсон цэцгийн язгуурын олон наст ургамал. Цэцгийн дэлбэ, цомирлогийн хамт шар буюу улбар

шар, цагаан төрөл зүйл олон. **ЖАМЬЯНГАРВУУ** (тө. ſam dbyangs dkar po, “зөвлөн эгшигт цагаан”); **ЖАМЬЯН ОМБО** (тө. ſam dbyangs sngon po; мө. ſamayang ongbu; “зөвлөн эгшигт хөх”); **ЖАМЬЯНСЭРВУУ** (тө. ſam dbyangs gser po; мө. ſamayang serbi; “зөвлөн эгшигт шар”).

ЖАМСРАН тө. lcam sring; мө. ſamsarin; Бурхны шашны ёсны арван догшин сахиусны нэг. Бие улаан, баруун мутартаяа галт илдтэй, зүүн мутартаяа нум сум бүхий, сугандаа дадар хавчуулсан есөн давхар хадаг бүсэлсэн, тавин хохимой толгойн эрийн зүүсэн байдлаар дүрсэлсэн байдаг. Жамсран нь оволзсон цусан далай дунд, зэс ууланд оршдог арзайсан дөрвөн соёотой, улаанаар эргэлдсэн гурван мэлмийтэй, хөмсөгнөөс оч бадарсан дүртэй. Монголчууд улаан сахиус гэх бөгөөд дайсныг номхоттох, амьтанд тус бүтгээлгэхэд урин зална.

ЖАН I хя. zháng; мө. ſang; Арван тохойтой тэнцүү уртын хэмжээ. Урт, өргөн, гүний хэмжээ, хос алд буюу 10 чий, 3,2 метр; **ЖАН ЖАНГИЙН ТАВАН ӨНГӨХ ХАДАГ...ГАРАВ** (С.Д.).

ЖАН II хя. zháng; мө. ſang; Урт нь нэг метр орчим, нэг үзүүр нарийн, нөгөө үзүүр өргөн ялтныг занчих зэвсэг мод; **ЖАНЛАХ** (жан банзаар жанчиж балбах).

ЖАН III хя. zháng; мө. ſang; 1. данс хараа; 2. шилж. өр шир; ...эзвэртэй хурганы жан авдаг зээ юу тэр (**ЖАН**).

ЖАН IV хя. jiān; мө. ſang; Байшин барилгын өрөө тасалгаа; **ГУРВАН ЖАН ӨРӨӨ, ГУЧИН ЖАН ХАШАА**.

ЖАН V хя. jiáng; мө. ſiyang; Хоол амтлах хачир хольцоо. Буурцгийг чанан хатуу хөрөнгө болгон давс хольж хийнэ. Амт эхүүн бөгөөд исгэлэн давслаг.

ЖАН VI: жан яр хя. zhàngyi, мө. ſang yar-a; Муу өвчин; тэмбүү, өнгөний дөтгөөр өвчиний нэр.

ЖАНАГ тө. rgya nag; мө. ſanaq; “хар хятад”; хятад; **ӨНӨӨ МУУ ЖАНАГ ӨНГӨРӨӨ БИЙ ДЭЭХӨ** (МААЗДБ).

ЖАНГУАС хя. zhýáng guā; мө. ſangyuasa; Давс, жанд дарсан ногоо, давсалсан өргөст хэмх.

ЖАНДАГ тө. sbyin bdag (сам. dhānapati); мө. ſinday; “өглөгийн эзэн”; Өглөг өгч хүндэлж байх хүн. Бурхны шашны

ёсонд бурхны номыг хичээгчид нүглийг тэвчин буян үйлдэж бодь сэтгэлтэй болохыг хүсэмжлэх үүднээс өглөг өгөхийг хичээнэ. Тэгснээр өглөгийн эзэн болно. Өглөгийн эзэн гурван зүйл өглөг өгнө. Эд агуурсны өглөг (хүнд эд бараа, мөнгө зоос өгөх); номын өглөг (номын мөр ёсоор явахыг хичээлгэх); үл айхын өглөг (аюул гамшигт учирсан буюу сэтгэлд нь аймшиг төрсөн хүнийг түүнээс нь зайлцуулж тус хүргэх) эдгээр болно.

ЖАНДАН хя. zhāngduán; мө. b. յangduan; Хүрийн будагтай ширхгээр нэхсэн нэг зүйл торгомсог бараа.

ЖАНДАМ тө. ja mdong; мө. b. յandom; Цай нийлүүлэх бүлүүртэй суулга мэт бяцхан сав.

ЖАНЖАА тө. lcang skyu; мө. յanggiy-a; “цагаан бургас”; Жанжаа нутгаас тодорсон эрдэмт лам, хутагтуудын цол өргөмжлөл. Жанжаа хутагтын 16 дүр тодорсон бөгөөд эхний хоёр нь энэтхэгт, бусад нь төвдөд төрсөн. Жанжаагийн урьд төрлийн аравдугаар үе нь алдарт Пагва лам Лодойжалцан болно. Жанжаа гэж нэрийдсэн учир нь Зонховын орны Гонлүн хийдийн дэргэд “Жанжаа” буюу “цагаан бургас” гэсэн нэг айл байсан гэнэ. Тэр айлд биеийн төрөл авсны учир мэндэлсэн орных нь нэрээр “Жанжаа” гэж дууддаг болсон гэнэ. Монголоор жангжа, жангжий-а гэхчлэн бичдэг. Гэвч хятад хэлний авиачилсан дуудлагаар жанггий-а гэж бичиж заншсан.

ЖАНЖИН хя. jiāngjīn; мө. յangjun; Цэргийн дээд зэргийн албан тушаалтан; жанжлах (а. цэргийг захирах; б. бусдыг ноёрхох).

ЖАНЛАВ тө. byin rlabs; мө. յinlab; “өглөгийн давалгаа”; адистид, хишиг соёрхол; жанлав өгөх, жанлавлах (адистидлах); Шашны ёсонд юмыг ариусгах тарни урьж шивших зан үйл явулах, адис өгөх; Гадаад дотоодын дайсан чөтөрийг номын чанараар жанлавлаад... зовлонгоос гэтэлцгээ. (Гэл.).

ЖАНЛАН хя. zhāng lāng; мө. յanglang; Жoom, хорхой, мөнгөний хорхой ч гэдэг.

ЖАНМА тө. lcang ma; мө. յangm-a; Salix viminalis; Уд бургас; зузаан дурстай, зөөлөн голтой, урт навчтай, цагаан цэцэгтэй, салаа мөчир нь их төлөв шулуун мод.

ЖАНРАЙСИГ тө. spyān ras gsigs; мө. յanrayisig; (сам. Avalokiteśvara); “нүдээр үзэгч”; Буддийн алдарт бодисадва нарын

нэг хонсим бодисадва. Будлан уулын оройд залран суудаг гэж домогт гардаг; Мэгжид жанрайсиг (монголын ард түмний тусгаар тогтнол, эв нэгдлийн бэлэгдэл, төр түмэн олны мэдмий тунгалаг байхын илэрхийлэл, энэрэл нигүүлсэхүйн ачлалыг үзүүлэх ариун шүгээн цогт эрдэнэ).

ЖАНСАГ тө. spyān gsigs; жанрайсиг гэдэг үгийг хураангуйлсан хэлбэр, үзмэр гэсэн утгатай; Жад сэлэм жансаг байгуултай... орон мөн байнаа (ЗУАЗ).

ЖАНХАР тө. dkyil 'khor; мө. յangqar; “төвд эргэх”; Хот мандлын баримал буюу сийлбэр дурс.

ЖАНЦАН I тө. rgyal mtshan; мө. յangčan; “ялгуусны тэмдэг” (сам. dvāja); дуаз; Хурал номын газар сүм дуганд байдаг бурхны шашны ялгуусны түг тэмдэг. Жанцанг гол төлөв шармал зэсээр хийж, гадна талд нь элдэв дурс товойлгон гаргадаг. Мөн ногоон, шар, цагаан, улаан, хөх зэрэг олон өнгийн даавуу бөсөөр ч хийдэг. Сүмийн оройд эсвэл дээврийн дөрвөн өнцөгт босгодог.

ЖАНЦАН II тө. rgyu mtshan; мө. յangčan; учир жанцан, “шалтгаан”, учир шалтгаан, учир начир; жумцан ч гэнэ; Учир жанцангуй юм гэж угий.

ЖАНЦАР тө. sbyang tser; мө. յangčar; “чоно өргөс”; Хар цагаан хоёр янз өнгөтэй, цагаан жанцарын иш шулуун, хөндий бөөрөнхий хэлбэртэй, үсэрхэг навчтай. Хар жанцар газраар хэвтэж ургана. Ишнээс нь улаан цэцэг гардаг, эмийн найрлагад орно.

ЖАНЧ тө. gzang bya; манж. janči; мө. յingči-յangči; 1. лам нарын нөмрөх олон хуниастай хувцас; тортон жанч (ёнхор мяндсаар нэхсэн хээнцэр эдээр хийсэн байдаг); төвд жанч (гонзгой дервэлжин хэлбэртэй бадтай); тэрмэн жанч (ноосон эдээр хийсэн); үнэгэн жанч (халиу булган хиацтай, шур сувдан чимэгтэй хар үнэгний үс зүйж хийсэн жанч); хамба жанч (хоргой захтай шар тортон хийсэн); гэсгүй жанч (шар цэмбээр хийсэн); шунлайв жанч (халzan хошоотой шар тортон жанч); жанч халах (үхэхийн хүндэтгэл уг); судар жанч (номын боолт); 2. бороонд нөмрөх ханцуйгүй хувцас, нөмрөг; борооны жанч; жанч бүс (хоёр талдаа цацаатай бүс); Бөгтөр хонгорыг унаж, бор өрмөгөн жанчаа бөгтреөд... (А.т.).

ЖАНЧИВЛИН тө. byang chub gling; мө. յangčubling; “бодь тив, хийд”; Төв аймгийн Архустайн нутагт байдаг рашаант газар;

Домгийн ёсоор Жанчив гэлэн гэдэг хүн олж нээсэн гэх ба Жанчив гэлэнгийн рашаан гэсэн ардын тайлбар бий.

ЖАНЧИВШИН тө. *byang chub sing*; мө.б. *jangčubsing*; Бодь мод; Зайсан өндөр толгойтой, жанчившигийн модтой гэнэ. (МААЗДБ).

ЖАС тө. *sbyi sa*; мө.б. *jsisa*; “нийтийн газар, олны өмч”; 1. хурал номын сан хөмрөгийн газар, цогчин жас, их жас гэхчлэнгийн нэртэй байсан. **хоршжас жав**; Жас нь утгаа хийдийн аж ахуй болно. Жасын зэрэгцээ сан гэж байсан. Сан нь сүм хийдийн мяндагтан дээд лам нарын аж ахуй болно; 2. сүм суварга босгох, ном судар барлах бүгээлгэх зэрэг шашин шүтлэгийн холбогдолтой ажил үйл явуулахад зориулж бэлтгэсэн мал хөрөнгө.

ЖАСАА тө. *sbyi sa*; мө.б. *jsisiy-a*; Шашны зан үйл ёсоор айл өрх өөрийн бурхан сахиусыг тахиж хишиг буянаа дуудуулах тахилга; жасаа даллага.

ЖАСЭР хя. *rgya ser*; мө.б. *jsaser*; “шар хягад”, орос; Чи тэгэхэд буруу номтой жасэрийн бузар эм домоор буяndaа цөв оруул гэдэг чинь юу билээ. (Б.Р.).

ЖАХОР тө. *rgya hog*; мө.б. *jaqor*; Төвд нутагт байгаа монгол гаралтай ястан.

ЖАЦ тө. *rgya tshwa*; мө.б. *jača*; Далайн уснаас буюу хаднаас гардаг шил мэт тунгалаг, зөөлөвтөр, амт маш ширвог, эмийн найрлагад ордог нэгэн зүйл давс.

ЖАЯГ тө. *bca' yig*; мө.б. *jayūj*; “хуулийн бичиг”; Сүм хийдийн лам нарын дотоод цааз буюу дүрэм журмын бичиг; *Тэднийг хутагтад мөргүүлэх жаяг тоогоосон билээ.* (ИТ).

ЖИВАА тө. *byi ba*; мө.б. *jiva~jiba*; Тооны нэр, арван сая, голди.

ЖИДҮН манж. *jidun*; мө.б. *jidün*; 1. уул, нуруу; 2. Хянган давааг бас жидүн даваа гэж байжээ.

ЖИЖҮҮР оп. дежур; мө.б. *jižigür*; Ээлжийн журмаар үүрэг гүйцэтгэгч хүн; **жижүүрлэх** (жижүүрийн ажил хийх), дежур ч гэнэ.

ЖИЙЖҮҮ мө.б. *jižou*; Хятадын Жий жоу хотын нэр. Энэ хотод үйлдсэн мөнгөн эдлэлийг жийжүү мөнгө гэдэг байв; **жийжүү** хазаар, жийжүү дөрөө.

ЖИМС түр. *jemis*; мө.б. *jsimis*; “ид-”; Ургамлын идэж болдог амтлаг үрийн алим.

ЖИН I хя. *gēng*; мө.б. *jing*; 1. шөнийн цагийг хэмжих нэгж, нэг шөнийг таван жинд хуваана; 2. **шилж** төмөр, гууль зэргээр хийсэн дохионы хэрэгсэл; **жин цохих**.

ЖИН II хя. *zhéng*; мө.б. *jing*; дүл, гол; **жин үд**.

ЖИН III хя. *jīn*; мө.б. *jing*; 1. хүндийн хэмжээ; **бисийн жин**; 2. хүндийн хэмжээний нэгж; арван лан нэг жин болно. 600 граммтай тэнцэнэ; 3. хүнд хөнгөнийг жигнэх дэнстэй адил бөгөөд том, иш түүхай бүхий хэмжүүр; 4. **шилж** аян, тээвэр; аян жин; жинлэх (хүнд хөнгөнийг хэмжүүрээр хэмжих); **жинчин** (жин тээврийн хүмүүс); **жигнэх** (жинлэх);

ЖИН IV: **жин тан** : хя. *tíng-dang*; Ажил явдалд хэрэг болох юмыг бэлтгэн зэхэж яг таг болгох; **Юмаа жин тан болго**.

ЖИНАН тө. *ṛjes gnang*; мө.б. *jinang*; “даган соёрхол”; Билэг чанар лугаа төгөлдөр авшиг өгөхийг олсны хойно бурхан тэр хийгээд түүний бие, зарлиг, сэтгэл, эрдмийн үйлсийн чадлыг дуртгахын тулд бүтээх соёрхол өгснийг хэлнэ гэж бурхны номд тайлсан байдаг. Товчоор хэлбэл, тухайн бурхныг бясалгах эрхийг өгдөг тарниийн ёсны зан үйл.

ЖИНЖҮҮ хя. *jīng zhū*; мө.б. *jinjüy*; “хүзүүний сувд”; хүзүүнд зүүдэг эрхи мэт чимэг.

ЖИНЛҮҮР **жинIII** (а. хүнд хөнгөний хэмжээг жигнэх хэрэгслийн нийт нэр; б. жин хэмжүүр).

ЖИНС хя. *tsin zi*; мө.б. *jingse*; Манж чин улсын үед ноёд түшмэдийн зэрэг хэргэмийн ялгаагаар малгайн оройд хадах дог мэт бөмбөгөр юм. Голдуу бадмараг, шүр, биндэрыяа, номин, болор, алт, мөнгө, шил, чулуу зэрэг есөн зүйл байжээ.

ЖИНСРЭГ тө. *sbyin sreg*; мө.б. *jingserig*; “өглөг түлэгч”; Түлэх шатаахын хүндэтгэл үг, галд шатаах өргөлийн зан үйл; Буг чөтгөр, ад тийрэнг ухсан нүхэнд унаган халуун тос цутгтан дээрээс нь ухрийн нойтон ширээр таглан эр бяртай найман хүн дарж сөнөөдөг шашны зан үйл. Бас ад шуламс шүтлэсэн гэж хүнийг амьдаар нь шатааж доошоо нарийссан нүхэнд мод сараалжлан өреөд тос асган шатааж алах зан үйл; **жинсрэгчин** (жинсрэг цутгадаг хүн)

ЖИНТҮҮ хя. zhěn tou; мө. b̥intüü; Эд бөсөөр уут сав хийж, дотор нь хөвөн, өд буурцаг зэргийг чихсэн, хүний дэрлэх, түших хэрэгсэл.

ЖИР тө. spyig; мө. b̥ir; Ерийн, энгийн.

ЖИРҮГВА тө. byi rug ba; мө. ſ̥iguþa; Чагтан навчтай, шулуун иштэй улбар буюу шар цэцэгтэй, үнэр анхилмал, жижиг хатуу жимстэй нэг зүйл олон наст өвслөг ургамал.

ЖИРҮН: жирүн гэгээн тө. ḡe drung; мө. ſ̥irüng; Хутагт нарын нэгийнх нь хүндэтгэл нэр.

ЖОВГОН тө. cog bu; мө. ſ̥obχang; Төвдийн лам хуврагууд шашны даяаны дасгал хийхээр аглаг газар луу авч явдаг байсан ганц хүний жижиг дөрвөлжин майхан.

ЖОД тө. gcod pa; “огтлохуй”; зод.

ЖОДВОН тө. cod pan; мө. ſ̥odbon; “үет цомцог”; манжлага, титэм; хөх, цагаан, улаан, шар, ногоон таван өнгийн эдээр оёж, ширсэн дамрын уяа; ...lam миний дамрыг нэг хадаг доогуур оруулаад авчирч жодвонд нь залгаж өгсөн. (Ц.Д.).

ЖОДГОР тө. gcod gur; мө. ſ̥odgar; “жодын майхан”; Даавуугаар дөрвөлжин босоо хэлбэртэй хийсэн оромж. Жодгорын түүргэн хэсгийг ижил хэмжээтэй 4 тал даавууг зах захаар нь нийлүүлэн оёно. Мөн оройн хэсэг нь хошуулдан эсгэсэн 4 хэсгээс бүтнэ; Ширчин, бяцхан жодгорт гол тулэхэд нойр хүрч...унтаад өгчээ. (Б.Р.).

ЖОДОО тө. ḡuya do; мө. ſ̥odoo; Нарсны язгуурын мөнх ногоон шилмүүст мод.

ЖОМОЛУНГМА тө. jo-mo glang ma-jo-mo lung ma; мө. ſ̥omulungm-a; Балба, Хятадын хил дээр орших дэлхийн хамгийн өндөр оргил 8848 метр өндөр. “бургасны эзэгтэй”.

ЖОНОН хя. cen wáng; мө. ſ̥inung; “эрх баригч ноён”; Хааны туслагч, монголын баруун түмний эрх баригчийн цол.

ЖОНОНБАА тө. jo nang ra; мө. ſ̥onangba; XIY зууны эхээр Сажабаас салбарас салсан шарын шашны нэг салбар, Жонон хийдэд суудаг, энэ хийдийн сургаалыг дагагч нарыг ингэж нэрлэдэг. Гол сургаал нь ертөнцийн аливаа орших үндэс болдог үнэн ном бол егүүтгэлгүй мөнх орших бөгөөд хүний ертөнцийн ухаан билгийн дээд шүтээн болно. Түүнийг илрүүлэхэд

тарнийн суртахууны ёгын бясалгальд суралцах хэрэгтэй гэж үздэгт оршино.

ЖОНХУУ хя. jiāng-hu; мө. ſ̥ongqu, ſ̥ongqiu; Юм наахаар шингэн буцалгасан гурил; жонхуудах (юманд жонхуу түрхэх; жонхуугаар наах).

ЖОНШ тө. cong zhi/cung zhi; мө. ſ̥onši; Жоншины төрлийн чултуулгийн ерөнхий нэр; Хайлур жонш, шохойн жонш, хээрийн жонш гэж ялгана. Бас эмийн сударт эр жонш (шохойн жонш); эм жонш (хайлур жонш); жонш (гөлтгөнө); хөвгүүн жонш, охин жонш гэхчлэн олон зүйл байдгийг дурджээ.

ЖООТУУ хя. jué tou; мө. ſ̥ootuu; газар ухах, эрэх зэвсэг.

ЖОР тө. sbyog dpon; мө. ſ̥og; “холих, найруулах”; 1. эмийн найруулга, хэрэглэх аргыг бичсэн хуудас; **Жор мэдэхгүй ламаас зовлон үзсэн чавганд дээр** (Зүйр.); 2. **шилж**. юмны найрлага ба хэрэглэх арга; хоолны жор.

ЖОРВОН тө. sbyog dpon; мө. ſ̥orbon; Ангийн дарга, тэргүүлэгч, ахлагч; **Даамал жорвон нь тэргүүлэн удирдсаар** (Ц.Ц.).

ЖУГАН тө. ci gang; мө. ſ̥uχang; Газар дороос гарах цагаан өнгийн нунтаг шороо, сэрүүн чанартай, амтгүй. Шороон гиваантай газраас олдоно. Бас мөсөн дээрх гурил мэт беөгнөрсөн цагаан шороог усны жуган гэнэ. Дашин ч гэдэг.

ЖУНГАА тө. skyung ka; мө. ſ̥ungχ-a; Улаан хошуут, чогнуун, турлиах; Dyrrocax.

ЖУНЖАА хя. zhuan jia; мө. ſ̥unjia-a; Тусгай мэргэжлийн өндөр зэрэгтэй хүн, эрдэмт багши.

ЖУНЗ хя. zòng zi; мө. ſ̥ungja; Улаан чавгатай хольж агашасан тутарга будаа. Угтаа бол хулсны навчинд боосон нэг зүйл идээний нэр.

ЖУУЗ хя. jiāo zi; манж. kiyoo ja; мө. kiyuuja~ ſ̥iyyuja~ ſ̥iyya/ ſ̥iycja; “дамнуурга”; 1. хүн сууж явах дамнуурган сүйх; 2. хоёр хүний туухайчлан барилцсан хоёр гар; жуузлах (жуузад сууж явах; гараараа жууз хийх).

ЖУУХ хя. zháo; мө. ſ̥uu; Хааны зарлигийн бичгийн хүндэтгэл.

ЖУУЦАЙ хя. jiécái; мө. ſ̥učai; Амт гашуун нэг буюу хоёр наст өвслөг ургамал. Навчийг давсалж иднэ. Гаймуу ч гэнэ.

ЖҮГДЭР тө. gtsug tor; мө.б. јügdür; “толгойн өмсгөл”; 1. дэл хэлбэртэй туг үс буюу бурхан багшийн тэргүүний оройн үснир (үз); 2. жинсрэг цутгах, ван айлдах зэрэгт өмсөх хар хилэнгээр хийсэн, хүний үсийг санагдуулам шовгор малгай.

ЖҮД тө. rgyud; мө.б. јüdva; “үндэс”; (сам. tantra); Дандрын сургаал, номлол; Шүтээн сахиусыг урин залах хийгээд агийн ёсны зан үйл гүйцэтгэх мөргөл ёслолын ном. Эдгээр нь Ганжуурын дотор том байр эзэлдэг. Дөрвөн аймагт хуваана. Үүнд: тэнсэлгүй жүд (сам. anuttara-tantra; тө. bla med rgyud); ёгийн жүд (сам. yogatantra; тө. rnal 'byor rgyud); үйлийн жүд (сам. kriyatantra; тө. bya ba rgyud); явдлын жүд (сам. caryatantra, тө. spvod rgyud); жүдийн дацан (тарнийн ухааны гол онол үндэслэлийг сурч судлах сургууль, тарнийн дацан ч гэдэг. Энэ дацанд тачаангуй дүртэй ядам бурхдыг байрлуулсан байдаг. Энэ сургууль төгсөгчид аграмба, тарнич цол авдаг); жүдийн хамба (тарнийн дацангийн даа лам).

ЖҮН хя. zhóng; мө.б. јüng; 1. дэлдэж хөгжимдөх хонх шиг хөгжмийн зэмсэг; 2. уриа дохионы том хонх; 3. хананд өлгөдөг том цаг.

ЖҮНЗ хя. zhōng zi; мө.б. јüngje; архины жижиг хундага, эрхийвчин хундага ч гэнэ.

ЖҮНС хя. zhung se; мө.б. јüngse; Тогоруу шувууны өөр нэр.

ЖҮРҮР тө. skyu ru ra; мө.б. јürgür-a; crataegus; Emblica officinalis; Нэг зүйл долоогоны үр. Урт модлог голтой, навч гахайн ширх мэт, сэруун чанартай, хар буюу цагаан үртэй, бас голын хажуугаархи ой шугуйд ургадаг, их навчтай модны гашуун үрийг ч хэлнэ. Бас имидий ч гэнэ.

ЖЭВОН тө. gje dpron; мө.б. јibon; *Богд ноён; ...жэвоныг зорьж энэ мэдээг хүргээр одох хэрэгтэй...(Х.Т.)*

ЖЭШТ сам. јyeṣṭha; мө.б. čisda; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг, монголоор тэнгэрийн жишими одон гэнэ; Одоо хонгорцог од гэж нэрлэж буй. 2. Энэтхэгийн зуны эхэн сар, цагийн хүрднээ хаврын эцэс сар, хятад төвдийн зуны дунд морин сар, монголын тавдугаар сар. Цэсдаа ч гэж бичдэг.

3

ЗААДАГА сам. јātaka; мө.б. јadaγ; Cucculus melanoleucus; Хөхөөний төрлийн нэг зүйл бялзухай. Нисч явахдаа орж буй хурын дуслыг шүүрэн ундаалдаг, цэвэр үнэнч дурлалын билэгдэл болсон шувуу гэж домогт гардаг.

ЗААДУУР заазуур мө.б. јažaduur.

ЗААЗ хя. zhā zi; мө.б. јažāja; Бусаддаа үл хүрэх шаар юм; зааз мал (муу мал).

ЗААЗУУР хя. zhádāo; мө.б. јažājsh; Нэг талдаа иртэй бөгөөд өргөн ишнээс нь нэг гараар барьж юм хэрчих багаж. Угтаа ногоо хөшиглөх хутга гэсэн утгатай.

ЗАВАА тө. rtsa ba; мө.б. јaba; “эш үндэс”; Бурхны шашны бурхан болох зам мөрийг шүүн барьдаг гүн ухааны дотоод сургаалын таван үндсийг нэвтэрхий мэдсэн хүнд монгол газарт өгч байсан алдар. Халхын Их хүрээний номч гавж Лувсандамдин (1867-1937)-ыг “Заваа Дамдин” гэж өргөмжилж иржээ.

ЗАВРУУЦ тө. tsabs ru tshwa; мө.б. јabṛiṣa/jabru(Ков.); Нэгэн зүйл давс. Эмийн сударт заахдаа ус, хаднаас гардаг, цагаан өнгөтэй шөвгөр үзүүртэй гэсэн байдаг.

ЗАВХРАЛ тө. tsab hral; мө.б. јabqaral; 1. их тачаалт сэтгэлээс болж сэргэнтэн ааш авир задгайрсан нь. Гэлэнмаа нарын бүдүүн гэм хийгээд тойдын дур байдал доройтон хурьцлыг шүтэн зөөлөн наалинхай, ичгүүргүйгээр явж толгойгоо чичигнүүлэх, үе гишүүнээ хөдөлгөн, үгсээ эндуүрэх зэрэг бие, хэлний авир аашал гэж хуучин судар бичигт тэмдэглэсэн буй; 2. шилж. хүний ажил явдал буруудах гажуу сөргүү болсон нь; завхай, задгай, ужид гэсэн утгатай; хорш. алдаа завхрал; завхрах (а. ажил үйл гажуу болох; б. уул манан сарних; в. аливаа юм үгүй болох, алдагдах; г. сарних, хулжих, нойр завхрах; е. завхайрах, задгайрах).

ЗА БИВЛИН тө. rtsa ri pi ting; мө.б. јa bibiling; Бивлингийн нэг зүйл, монгол нутагт ургадаг.

ЗАГАР сам. sakora; мө.б. јakar-a; Perdix rufa; Ятууны төрөл, гүмдаа цэцгийн бал уугч шувуу. Эртний энэтхэгийн яруу найрагт сайхан нүдтэй бүсгүйг загарын нүдтэй гэж зүйрлэн бичсэн байдаг. Хахилаг, хур шувуу ч гэж нэрлэх нь бий. Зарим толь бичигт

“хөхөө ба ногтруу хэмээх тэргүүтнээ таних олон боловч алийн мэт бөгөөс нэгэн цагаан шувуу мөн болой” (СР) гэж тэмдэглэсэн байдаг; *Тийн боловч загарын нудэт тэр нь эдүгэд миний зүрхэнд наасад оршин амуй* (Дан).

ЗАГАРВАДИ сам. *sakravarttin*; мө.б. *zakravardi*; “хүрдэн орчуулагч”; Бурхны номд амьтан найман түм насалж байх цагт буюу Хорвоожүг бурхны үест ийм нэрт хаан байсан гэж гардаг; *Бас хаан олон боловч Загарвардийн хаан мэт хаан цөөн* (Д.Р.).

ЗАГДАМ мө.б. *ÿaydam*; жавдан гэдэг үгийн хазгай дуудлага; Алаг загдмын дотор болж, алтан тоононы бүрээс болтугай (ЗУАЗ).

ЗАД I түр. *ÿada*; уй. *yadu* (<перс. *ÿādū*; “илбэ, шид”); мө.б. *ÿad* Бороо хур орох зэргээр тэнгэрийн байдал гэнэт хувирах үзэгдэл; шувуун зад (шувуу буцах үед цас бороо орох); задын чулуу (а. үхэр, гахай зэрэг амьтны цөсний чулуу буюу гиван; б. *шилж* шинэ чулуун зэвсгийн олдвор); задын өвс (нэгэн зүйл эмийн ургамал, үүгээр яс махны гэмтлийг анагаахад хэрэглэдэг байжээ); зад урих (задын чулуут тусгай модон саванд хийж, дээрээс нь ус хийн булхуулж, хур бороо хүссэн уншилага зан үйл үйлдэхийг хэлдэг байжээ).

ЗАД II түр. *jad*; мө.б. *ÿad*; 1. бусад гадны хүн; 2. харь газар орон; задын газар (харь газар); *жадаран* (овогтон) гэсэн үг нь *жад+аран* (харийн иргэн(ард) гэсэн хоёр үгээс бүрдэх бөгөөд энэ нь дээрх зад мөн.

ЗАДЬ сам. *jātī*; мө.б. *ÿadi*; *Myristica fragrans*; Халуун орны анхилам сайхан үнэрт, сэвсгэр хөх навчтай, жижиг шар цэцэгтэй, урт нь төө орчим нэг зүйл модны үр, цэцэг. Эмэнд хэрэглэхээс гадна сүмд мөгий оруулахаас сэргийлж хүжинд хольж хэрэглэнэ. Монголоор цэс өвс ч гэдэг.

ЗАЙ тө. *rdzas*; мө.б. *ÿai*; 1. зарим нэг язгуур махбод; 2. зарим юманд хэрэг болох эд юм; эд зайд; ...гай зэтгэрээс биеэ хамгаалах увидис зайд болно гэж итгэдэг байлаа. (Л.Т.).

ЗАЙСАН хя. *zǎixiáng*; мө.б. *ÿayisang*; 1. Юань улсын үе дэх дотоод ордны ноёны зэрэг дэв, сүүлд нь хаанд бараалхах, хааны зарлиг бичгийг орчуулан хянах, түүх шастир зохиох зэрэг үүрэг хариуцагч гэсэн утгатай болсон; 2. хошуу нутгийн нэг зүйл зэрэг дэв; 3. шавь нарыг захирах, засаг захиргааны хэргийг эрхлэн шийтгэлцэх Шанзавын дараах албан тушаал, захиргаа шашны албыг хослон илэрхийлнэ; Сул зайдсан (ажил эрхэлдэгтгүй зайдсан);

lam зайдсан (сүм хийдийн дацан жасад ажилладаг хүмүүс. Хурал номын зардал, lam нарын цав хүнс нийлүүлэх, данс тооцооны ажил эрхэлнэ); хар зайдсан (шавь ардыг захирч дацангийн доторхи засаг захиргаа, алба татвар, зарга хэрэг зэрэг тамгын газрын асуудал эрхлэх хүн); 4. монголын нэгэн овог.

ЗАЛАН манж. *ÿalan*; мө.б. *ÿalan*; “үс”; 1. Манж чин улсын үеийн зангиас нэг дэс илүү түшмэлийн зэрэг; 2. нэг ангийн цэргийг нэг залан гэдэг. Хошуудад их төлөв хоёр залан цэрэг байв.

ЗАЛЬ сам. *ÿála*; мө.б. *ÿali*; 1. гал, дөл; галын заль (бадрангуй дөл); заль бадрах (гал өрвөлзөх); *Ган тэмөр тулганц галын залийг бадруулж...*(ЗУАЗ); 2. илбэ, ховс, арга бач; *хорш*. арга заль; зальч (жилбэг).

ЗАМ тө. *ja* та; мө.б. *ÿam-a*; “цай чанагч, цай базаагч”; 1. сүм хийдийн жасын тогооч лам; жасын зам; 2. *шилж* тогооны гэр.

ЗАМАГ оп. замок; мө.б. *ÿamuš*; Бууны сумыг гол төмөрт оруулах ба хонгиог хөөж гаргадаг хэрэгсэл; замаглах (бууны замгийг хийж бэлтгэх).

ЗАМАР манж *ÿamu*; мө.б. *ÿamur*; тө. *mdzo mo nūr*; Нохойн хошууны үр жимс, өнгө улаан, амт сайтай нэг зүйл жимс; Замар цэцэг (бугаар ургадаг, ишиндээ сондуутай, улаан өнгийн сайхан үнэрт цэцэг).

ЗАМБА I тө. сам ра; мө.б. *ÿamba*; Бут богино, навч зузаан, зоосон цэцэгтэй, гилгээнэсэн хээтэй, улаан, цайвар улаан, цайвар хүрэн турван янзын өнгөтэй ургамал.

ЗАМБА II: замба гүрвэл тө. *tsangs ra*; мө.б. *ÿamba*, *Aqama*; Биеийн хэмжээ янз бүр боловч том нь ургаараа 25-30 см, өргөн нь 3-5 см, толгой дээрээ олон хатуу товруутай, хөх буюу ногоон саарал өнгөтэй мөгий гүрвэлтэй төстэй гүрвэл. Хүн харвал цээжээ өндийлгэн, товруу хуягаа арзайлган, сүүлээрээ газар гуядан, амаа ангайлган ухасхийн сүрдүүлдэг. Замба зараа, хадны гүрвэл, их гүрвэл гэхчлэнгээр нэрлэдэг. Монгол Алтайн цаад говийн Цагаан богд, Атас, Ээж хайрханд элбэг тохиолдоно.

ЗАМБАА тө. *tsam* ра; мө.б. *ÿamba-а*; сам. *camra*; Талхалж хуурсан арвайн гурил; Энэтхэгийн зүүн Хачид орших Чамба оронд арвай их тариалдаг байснаас төвдчүүд арвайг тэр нутгийн нэрээр нэрлэх болжээ.

ЗАМБАГА сам. sampaka; мө. ѡамбаү-а; Мөнх ногоон бутлаг мод, түүнээс дэлгэрдэг хуйт цэцэг; Зандан модны мөчир шиг, замбага цэцгийн дэлбээ шиг дэлгэрч яваа. (ЗУАЗ).

ЗАМБАРАА тө. gtsang spra; мө. ѡамбараү-а; “ариун”; эмх цэгц; хорш. эмх замбараа; замбараагүй (gtsang spra med pa; ариун бус; эмх цэгцгүй, эх толгойгүй).

ЗАМБИР сам. jambhira; мө. zambhir-a (Ков.); Нимбэгийн мод.

ЗАМБУУ сам. ѡамбүү; мө. ѡамбүү; Цагаан цэцэгтэй, гонзгой бөөрөнхий жимстэй, хар үртэй мөнх ногоон сөөг мод буюу бутлаг мод. Энэ модны навч нь усанд унахдаа зам зам гэж дуугаргах ба усанд удсанаар Замбуу мөрний алт гэгдэх юутай ч адилтгашгүй сайн алт болдог гэж хуучин тайлбар бичигт гардаг. Энэ модны нэрээс эртний энэтхэгийн нэр болох Замбуугив үссэн ажээ.

ЗАМБУУЛИН тө. dzam bu gling; мө. ѡамбуuling; Замбуу нь самгарди, лин (тив) нь төвд үг болно. Замбуугив.

ЗАМБУУТИВ сам. ѡамбуudvira; мө. ѡамbutiv; “Замбуу модны тив”; Замбуу нь энэтхэгт ургадаг модны нэр, тэр модны нэрээр зөвхөн энэтхэгийн хагас арлыг нэрлэж байсан нь яваандаа манай дэлхийг нэрлэх нэг нэр болжээ. “Арван буянт номын цагаан түүхэнд”: “Сүмбэр уулын дөрвөн зүгт дөрвөн тив бий. Түүний өмнө зүтийн тив нь Замбуу могоор билэг болгосон тул Замбуугив гэнэ. Замбуу гэдэг үг нь Мапам далайн баруун захад байх Замбуу гэдэг модны нэр, үр нь боловсроод усанд унахдаа “зам зам” гэсэн дуун гарч унаснаас тийн нэрийдэв. Замбуугив хөх өнгөтэй, эд агуурс, нас жаргал нь бусад тивүүдээс бага. Гэвч сайн юм олон. Замбуугивд Жагарварди, братигбүд, Шигмуни гурван дээд ирсэн. Тивийн төвд гурван цагийн бурхны орон Магадха бий. Ганга мөрөн мэт дөрвөн их мөрөнтэй. Цаст уул мэт уулстай. Замбуугивд 500 өчүүхэн тив, 18 их орон, 1000 өчүүхэн орон бий. Хүний язгуур өвөг адил бус, 360 зүйл, адил бус хэлтэн 720 бий гэсэн байдал; Замбуугивийн зургаан чимэг (Бурхны шашин-гүн ухааны сургаалийт хөгжүүлсэн чойрын ухааны онолын сэтгэлгээний бүтээлүүд туурвисан Нагаржунай (Лүдэв), Асанги (Тогмид), Аръядэва (Пагва лхая), Васубандха (Егнин); Дигнага (Чоглон), Дхармакрит (Чойдог) нарын жагарын мэргэдийг ийн нэрлэдэг).

ЗАМЛИН замбуулингийн хураангуйлсан хэлбэр; Замлин хорвоогийн жамаар өтлөхдөө...харих наасаа элээдэг гэнээ (Б.Я.).

ЗАМПАР тө. tsam phor; мө. ѡампрог; “замбайн аяга”; Арвайн гурил, идээ хийх аяга; ...шар тостой арвайн гурил нэгэн зампар дуурэнг өгөхөд тэд...идэж...уулцааж эхлэв (Л.Т.).

ЗАМТИ тө. rtsa mkhris; мө. ѡамти; “цөс өвс”. Навч сэргсэрг хөх, цэцэг нь жижиг, шар, урт нь төө хир, мөчир олонтой, таслахад сүү гоождог. Цэцэг нь гандахдаа үс шиг цайж, хийсэн замхардаг. Амт гашуун, эмнэлэгт хэрэглэнэ;

ЗАМХАГ тө. tsam khug; мө. ѡамцау; “арвайн уут”; Амсар талдаа хуниастай, арвайн гурил агуулах ууг сав.

ЗАН хя. zhǎng; мө. ѡang; Гутал шаахайн уланд шир зэргийг давхарлан хадах буюу нааж бэхэлсний нь; зан тавих, загнах.

ЗАНАГА сам. janaka; мө. ѡanaka (Ков.); Буурцаг, вандуйн овгийн хонин буурцаг; Энэтхэгийн өмнөд орон-Мон газрын жижиг ногоон буурцаг; Занага буурцгийн төдийхөн эрдэмгүй бөгөөтөл (МУЗД-1).

ЗАНГИ манж. ѡanggin; мө. ѡanggi; 1. Манж чин улсын үеийн монгол хошуудын сум буюу харуул, өртөө зэргийг захирагч хүний тушаал; 2. хууч. баатар, жанжин. (хя. чжанцзин).

ЗАНДАЛЧ(ИН) сам. cañḍāla; мө. ѡangdalci; “жигшмэрт хүн, яргачин”; Дээрэмчин, тонуулчин зэрэг муу үйлээр явагч.

ЗАНДАН сам. candaña; мө. ѡangdan; Sirium myrtifolium; 1. дулаан орноо ургадаг анхилам үнэрт мод. Тосоор нь үнэртэн ба эм хийнэ. Цагаан, улаан, хүрэн зандан гэж ялгана. Түүвээс сайхан үнэр гарч хиймарь сэргэнэ гэдэг. Хуучны ном бичигт Энэтхэгийн Малая уулын зандан ихэд алдартай гэж гардаг. Навч нь бэржгэр, луугийн нүдний навчтай адил, их бие нь цул бат бэх, үнэр ариун, өнгө хүрэн улаан. Харин цагааных нь үнэр маш ариун. Бас Энэтхэгийн далайн арал ба Зонховын ихсийг булсан газарт ургасан домогтой; Салаа зандан модонд нь сарны тухай тусна даа (Ардын дуу); 2. шилж бат бэх, хүдэр чийрэг; залуу зандан нас, занданшуулах (ихэс дээдсийг нас барахад шарилыг хатааж алт зэрэг зүйлээр бүрхэх).

ЗАНДМАНЬ чандмань; Хөвсгөл аймгийн нутаг Дэлгэр мөрний ойр байх газрын нэр.

ЗАРАМ I уй. jarma; мө. ѡarm-a; 1. хуурсан будаа зэргийн үйрмэг хэмхдэс; 2. хуурч болгосон гурил; зарам гол (нарийлан шигшээд үлдсэн бүдүүн хэсэг).

ЗАРАМ II сам. carma; мө.б. јарт-а; “арьс”; Усгүй буюу тачир үстэй арьс; зарман дээл; монгол хэлнээ энэ уг бас сармай гэсэн хэлбэртэй болж хувирсан буй.

ЗАРЛИГ түр. јrlq~yarlıq; мө.б. jarlig; “хааны тунхаг”; 1. улсын эрх барих газраас гаргасан хуулийн чанартай шийдвэр; 2. хаан хүний хэлсэн, зарласан уг болон бичиг; 3. хүндтэй хүний хэлсэн уг.

ЗАСАГ түр.yasa; мө.б. јasay; “хууль цааз”; 1. улсын захиран удирдах дээд газар; 2. ямар нэг юмыг засч сайжруулах, журамлах арга явуулга; 3. хууч албат ардыг захирагч эзэн.

ЗАСУУЛ түр. yasagul; мө.б. јasayul; Хишигтэн, бөх барилдуулахад даган зааварлах хүн.

ЗАЯ тө. dza ya (<сам. jaya); мө.б. zay-a~jay-a; “ялгуусан”; бүрэн алдаршсан, төгс ялсан; Заяны гэгээн, Заяны хүрээ, Зая бандид; “сайтар ялгуусан” гэсэн утгатай; Бизъяа (vijaya) гэдэг оноосон иэрийн -зьяа нь энэхүү Зая мөн болно.

ЗИДРАГАА сам. citraka (> тө. tsi-tra ka); мө.б. zidray-a; Capsicum annuum L; Олон төрлийн ургамлын нэрд явдаг боловч гол төлөв чинжуут нэрлэдэг. Поваари ч гэдэг.

ЗИНДАА тө. 'dzin grwa; мө.б. jinda; 1. хийдийн дацанд нэгэн ангид шавилан суух нэг үеийн улс; 2. нэг зэрэг дэв; *Хамбын олбог зааж, өөрийн зиндаанд суулгав* (*Д.П.*).

ЗИРАА тө. zi ra; мө.б. zir-a (Ков.); cuminuin; Гоньд, хар зираа, цагаан зираа гэж хоёр зүйл бий.

ЗОГДОР түр. јоуду~јоудур; мө.б. јоудур; “тэмээний хүзүүний урт ноос”; Тэмээний хүзүү хоолойд ургасан урт хялгасан үс; бас арслангийн хийг ч хэлнэ. Төвд хэлний gtsugtor (“орой, зулай, шанх”) нь ч нэг гаралтай байж магадгүй. Учир нь уйгар, түрэгт жигүүртний өрвөлөг, малын хүзүү хоолойн үс ноосыг бас нэрлэх утгатай.

ЗОГЛОМ тө. соу la ma; мө.б. јоулам; Улаавтар өнгийн нэг зүйлийн чулуулаг, эмд орно, жоглом ч гэж бичдэг.

ЗОД жод; тө. gsod; зодын ном (зоч болохын тулд үздэг ном, жаяг. Зодын ном нь бүгд эрх тэгш, эв найртай аж төрж, хийж бүгээж, орчлонгийн муу заяанд төөрсөн болгонд сайн төрөл олгож, жаргалангийн оронд хүргэхэд чиглэгддэг); зодоч (зод тавьдаг хүн).

ЗОМ: зом гүргэм тө. mdzo mo; мө.б. јоти; гүргэмийн нэгэн зүйл; Энэ чинь зом гүргэм байна. (*Л.Т.*)

ЗОНДОН хя. zhüängduàn; мө.б. ѡongdon; Торго, жижиг алтан луутай торго, тинбун ч гэдэг. (*харьц.* тө. dpyod ldan). Магнаг хоргойн дотроос хамгийн үзэмжтэй нэхмэл болно.

ЗОНДОР хя. zhüängtöö; мө.б. ѡongdor; 1. хааны сангийн тариалангийн түрүү ахлагч; 2. тосгоны ахлагч, ахмад настан нь.

ЗОНХОВ тө. tsong kha~tsong-kha ра; мө.б. zongqāba; “Сонгинотын ам”; Гэлүгбаа нарын сургуулийг үүсгэсэн, шарын шашны их багш Лувсандаагва нь 6-р равжунгийн улаагчин тахиа жил (1357) Хөх нуурын Гүмбүм хавьд байдаг Зон ха буюу “Сонгинотын ам” гэдэг газарт төрснөөр түүнд хайлласан нэр. Зонхов уул (Дамбадаржаа хийдийг анх барьж байгуулахад хойт уулын энгэрт нь гантиг чулуугаар 5 метр өндөр Богд Зонхов бурхныг жижиг сүмийн хамт барьснаас хойш уг уулыг Зонхов уул гэх болсон).

ЗОО: зоо замбуулин; тө. lho; мө.б. јо; “өмнөд”; угтаа лхо замбуулин гэсэн үгийн халтирсан хэлбэр; шашны ёсоор замбуулинг дерев хуваадгийн нэг нь.

ЗООРЬ хя. јiào~yáo; мө.б. јоүогi; Байшин гэрийн дор буюу юмгүй газарт ухсан юм хадгалах нүхэн сав; 2. шилж, эд хөрөнгө; зөөр; зоорь~зөөр.

ЗОС хя. zheshi; мө.б. јosu; Исэлдсэн төмрийн хүдэр буюу исэлдсэн мангани, наанги широо зэргийн холимог бодис, голдуу будаг хийнэ.

ЗОТОЛ(ХАН) тө. gtso tho lha; мө.б. јotol; “гол өндөр хайрхан”; Даригангын талархаг газарт тогтсон сөнөсөн галт уул, үнэмлэхүй өндөр нь 1425 м. Энэ ууланд зориулсан сангийн тусгай судар бий.

ЗОЧ зод тавьдаг хүн; зодоч гэдэг үгийн хураагдсан хэлбэр. Зодын ном үзэж зоч болно. Үүний тулд 108 хоног хоол ундаа сойж, жодгор авч нүүдэллэн нямба хийнэ; *Хэрмэл зоч нарыг утгээр явуулахгүй байвал зохих юмсан гэлээ* (*Б.Р.*).

ЗӨН хя. zhüän, мө.б. јöng; Тоосго, шатаасан туйпуу.

ЗУДАА тө. tsu ta (<сам. cuta); мө.б. zuda; Ганц хөлт хүмүн бусыг хэлнэ. Мөн тэдний суудаг орны нэр. Тэнд хоёр хөлтэй хүн очвоос зудаа нар тэднийг эрэмдэг амьтас хэмээн шоолдог домог бий; *Холгуй төвдийн хүмүүн болохоос холхи зудаа нар бус* (*А.Х.*).

ЗУЛ сам. јvála; мө.б. јšla; “гал, дөл”; хятадаар бас zhü (гэрэл, гэрэлтүүлэгч) + la (балуус, лав) гэнэ. Хөвөнгийн голыг тосонд тавьж шатаан хэрэглэх гэрэл; зул сар (билгийн улирлын өвлүүн тэргүүн сар); зулын хорин таван (сүм хийдийн хурдаг хурлыг

улирлаар явуулдаг бөгөөд өвлийн тэргүүн сарын хурал өндөрлөх өдөр. Хурлын үед зул мандааж, Зонхов бодын гэгээн сүлдийг ерөн, зан үйл гүйцэтгэж "Бодь мөр" буюу Ламрим хурна).

ЗУУ тө. јо-жо бо; мо.б. јши; "эзэн бодгос"; 1. дээдэс. Бурхны шашны ёсонд бурхны хөрөг дүрсийг хэлнэ. Зуу шигмуни (бурхны биеийн шүтээн); Зандан зуу (Бээжингийн Юн Хэ бүрэлдэхүүнд багтах зандан modoор бутээсэн сүм, бурхан); Эрдэнэзуу (Монголын эртний нийслэл Хар хорины дэргэд 1586 онд Автай хааны байгуулсан шарын шашны монгол дахь анхны хийд); Гол зуу (аливаа хийдийн төвд орших гол сүм); 2. шарын шашны том зүтгэлтэн, эрдэмт хүний нэрийн өмнө хүндэтгэлийн үргээр хэрэглэнэ. Зуу Адиша.

ЗУУХ хя. zào huo; мо.б. јшиq-a; Гал түлэх тусгай хэрэгсэл, төмөр зуух, шавар зуух гэж байна.

ЗУДАА сам. cūdā; мо.б. züda (Ков.); Орой, оргил; толгойн оройн тут үс.

ЗУДААМАНИ сам. cuđamañi; мо.б. zudamani; "оройн эрдэнэ"; шар өнгөтэй, нүдний дүрс мэт хээтэй, халааж улайсхад хагарч ан цав гардаггүй чулуу. Эмд хэрэглэхийн зэрэгцээ хар даран зүүдлэхэд зүүдийг хариулах тустай гэж бэлэгшээдэг.

ЗҮМПРЭЛ тө. rdzu 'phrul; мо.б. јümbürel; Рид хувилгаан, зүмбэрэл ч гэдэг; Зүмпрэл бүтээлийн дээдийг хүссэн мэргэдийг нааш ир хэмээн урин дуудаж... (МУЗД-1).

ЗҮН хя. zhōng; мо.б. јöng; Төмөр гууль зэргийг хонх мэт сэнжтэй хийсэн дэлдүүр. Хөгжмийн зэмсэг. Жүн буюу алтан хөөрөг ч гэнэ. 2. уриа дохионы том хонх. 3. хананд өлгөх том цаг.

ЗҮРЭМ манж. culmen; (тө. bsur ma); мо.б. јürm-e (Ков.); нарийхан жижиглэн зүссэн юм.

ЗЭВ хя. sieou (тө. btsa'ba); мо.б. јibe-žibi; 1. төмөрлөгийн зүйлээс исэлдэж гарсан хаг; 2. төмөрлөг зүйлийн бал; 3. улаан шавар.

ЗЭД тө. 'byed; мо.б. јed; "түгээл"; 1. өглөгийн эздээс сүм хийдэд өргөсөн зүйлийг шашны ёсны хурлын лам нарт барих түгээл; хорш. зэд пог; 2. цалин хөлс; ...хүүхдүүд өөр өөрийн орон нутгийн хийдүүдээс сард 2000 жаахан гаруй төгрөгийн зэд авна. (АЭ).

ЗЭДЭР сам. citra; мо.б. zidr-a; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг; монгол нэр нь Бугын эврийн агуй одон; Одоо Тэргүүн дагуул од гэж нэрлэж буй; 2. Энэтхэгийн хаврын дунд

сар, цагийн хурднээ хаврын эхэн сар, хятад, төвдийн хаврын эцэс луу сар, монголын гутгаар сар.

ЗЭНДМЭНЭ мо.б. zendmün; халх. чандмань; 1. чандмань эрдэнийн нэг төрөл буюу таван зууван дугуй дүрсээс бүтнэ. Тэгш таван хүсэл буюу харах, амтлах, үнэрлэх, сонсох, хүртэх таван мэдрэхүйн баясал цэнгэлийг хангахын утгатай; *Баттай зэндмэнэ эрдэнэ баруун мутартгаа атгаад...* (МААЗДБ); 2. ховор нандин буюу үнэт эд, эрдэнэ.

ЗЭСҮМ тө. rtse gsum (сам. trisula); мо.б. јesüm; "гурван үзүүрт"; Шива тэнгэрийн барьdag гурван үзүүрт сэрээн зэвсэг; ...баруун мутартгаа гурван үзүүртэй зэсүм бариад хүлээж суулаа. (Л.Т.).

ЗЭЭЖИН тө. rtse can; мо.б. јejen; "оройт"; Шанаг нарын өмсдөг алтан шармал малгай.

ЗЭЭЛ хя. јie; мо.б. јigele; 1. эд юмыг дараа буцааж өгөх буюу төлөхөөр бусдаас гүйж авах юм; өр зээл, зээл авах; зээл тавих, зээлэх (хожим төлөхөөр бусдын юмыг авах; шилж бусдын нэр барих; нэр зээлэх).

ЗЭЭРЭМБЭ тө. rtsis rim pa; мо.б. јeramba; "зурхайн зэрэг"; Тооны ухааны дээд мэдлэг эзэмшиж хүнд олгодог байсан эрдмийн цол; *Шар зурхайд мэргэшиж, шалгарсан зээрэмбэ тодордог* (Гам).

ЗЭЭТҮҮ хя. јie-toi; мо.б. јegetüü; Нэг талдаа үзүүртэй, негөө талдаа онгитой, ишилж газар эрж цавчих багаж; зээтүүдэх (зээтүүгээр цохих).

И

ИГҮҮШИН тө. yu gu sing; мо.б. igüsing; Cacalia hastata L; Нийлмэл цэцгийн язгууртай олон наст өвслөг ургамал; Навчит ой, ойн зах, нугад ургана. Ардын эмнэлэгт цэцэг навчийг хэрэглэнэ.

ИД ридийн хувирсан хэлбэр; мо.б. idi; Шашны ёсны ер бусын чадал; ид шид.

ИЛ тур. il; мо.б. il; орон газар.

ИЛБЭ сам. yelvī; мо.б. yelvi; ховс; бааш; *Илбэ-дор адил аргадагч буй* (12 зох.).

ИЛБЭЭС түр. ilmek; мө.б. ilbegesün; il- “өлгөх, гогдох” + mek= дэгээ, гогцоо; 1. загас барих өгөөш; 2. хавх зүүхэд сүргийг торгох тэвх (Я.Ц.).

ИЛД тө. ral gri; мө.б. ildü ; Төвд дуудлагаар нь зарим газар арилди ч гэнэ. Хуй гэрт дүрж зүүх сэлэмнээс арай бага хутга; дам илд (том илд).

ИМАН БОР: тө. iman šing; мө.б. iman boru; Нэг зүйл мод.

ИН I хя. niān; мө.б. ing; Аму тариа талхалж цайруулах дугариг чулуу; индэх (ингээр тариа цайруулах); *Ингээ буулгаад илжтээ алав.* (Зүйр).

ИН II хя. ing; мө.б. ing; Хүндийн хэмжүүрийн нэр, хоёр дан нэг ин болно.

ИНАЛ түр. inal; мө.б. inal; Эзэн хаан.

ИНАЛЧИ түр. inalči; мө.б. inalči; Хаад, ван гүн.

ИНАНГИ манж. inenggi; мө.б. inanggi; Давхтай адил толгойтой, биеийн байдал улаан, ташуур хэлбэртэй, сүүлний үзүүр нь нарийн урт хоёр салаа, далайд орших загас.

ИНГЭЛ хя. yingwū, мө.б. inggel; Үг хэлж чадах тоть шувуу; *Навч цэцэг мөчирлөөд, начин ингэл жиргэжээ (Паж).*

ИНИНЧ түр. inanč; мө.б. inanča; Монгол хэлний ünenči гэдэгтэй гарал нэг байж магадгүй; итгэл; эрхтэн дархтан, ноёны цол (МНТ).

ИНДРА сам. Indra; мө.б. indar-a; “эрхт”; Энэтхэгийн домогт гардаг өртөнцийг хамгаалагч дээд тэнгэр. Дайнч хүчийг агуулсан аянга цахилгаан тэнгэр. Тэнгэр газрын завсрлын зайд оршидог гэдэг. Монголоор Хормуст тэнгэр ч гэдэг. Түүнд зориулсан 300 орчим дуулал байдаг, бусад тэнгэрийнхээс ч олон.

ИНДРАНИЛ сам. indranīla; мө.б. indranīl-a; “эрхтэний хөх” = Индраагийн хөх эрдэнэ; Оюу цэнхэр өнгөтэй, нарны гэрлийн эсрэг хөхөмдөг буюу тунгалаг хөх гэрэл сацруулах, бөс даавуугаар бүрхвээс шүхэрлэсэн хөх гэрэл тодорч үзэгдэх, эмэнд ордог ховор үнэт эрдэнийн чулуу. Ариун шударга сэтгэл төрүүлдэг, аюул хилэнгээс зайлцуулдаг гэж билэгшээн үздэг. Ногоон хас ч гэнэ.

ИНДҮҮ хя. yündöö; мө.б. ingdeü; Халааж бөс барааны атираа хуниасыг тэндийлгэн илүүрдэх төмөрлөг хэрэгсэл.

ИНЖ хя. inđe; мө.б. inđi; Охинд өгсөн хүн буюу охиноо хүнд өгөхөд дагуулж өгсөн зүйл бүрийн юм. Хүннү үгэнд хатныг янзи гэж байв.

ИНЖААН хя. yín jiàng; мө.б. injiyang; Алт мөнгөний дарх хийдэг хүн, алтч.

ИНЖИР ир. injir; мө.б. injir; Дулаан орны мод, түүний шүүслэг амтат жимс.

ИНЗАНА сам. ĵñāna; мө.б. inzan-a; Мэдлэг ухаан, билэг ухаан.

ИНТООР хя. ing tao’ (манж. ingtori); мө.б. ingtoor-a (Ков.); ingtoor (Я.Ц.); Модонд ургадаг нэг зүйл амтат жимс, улаан цагаан хоёр зүйл бий.

ИНЧ сам. accha; мө.б. ingči; 1. няс; 2. эрхий ядам хоёр хурууг агшин зуур хавирах хэм.

ИНЧДЭЛ сам. acchata; мө.б. inčiddel; Инчдэхийн дуу гаргах хэм, ирмэлийн арваны нэг хувь. инч- гэдэг үгнээ -дэл монгол дагавар залгаж үүсгэжээ; инчдэх (а. няслах, шавдах; б. эрхий хурууны өндгийг мөн гарын бусад хурууны өндөгтэй нийлүүлж хавсарч хавиран дуугаргах).

ИОГА тө. yo-ga < сам. yoga; мө.б. uoga; “лав учирсан”; Эртний энэтхэгийн гүн ухааны тууштай 6 системийн нэг дандрын ёсны бясалгын ном. Энэ ёсны үүднээс сэтгэл зүй, бие махбодоо залуурдан захирах практик хичээлийн систем; Ламын иога (бурхан багшийн адилаар лам нарын бясалгал үйлдэх арга хэлбэр).

ИРВЭС түр. irbič~irbız; мө.б. irbis; Барстай адил, бие бага, дүгрэг бидэртэй, сүүн тэжээлт араатан. Мигуйн намд орно.

ИРД рид; ид шид; оргилсон түүдгийн гэгээн цацral нь ончтой сайхан баясгах ирдтэй (МШЯН).

ИРУДИ манж. irudi; мө.б. irüdi; Улгэр домогт гардаг хойт зүгийн гарди шувуу.

ИРШИМБА тө. gyer ſing ba; мө.б. irsimba, Scrophularia incisa Weinm.; Олон наст ургамал. Иш нь дөрвөн талттай, нэг метр орчим өндөр, навч зууван дугуй хэлбэртэй, цэцэг нь зөвлөн, үзэмж муутай бор ногоовтор өнгөтэй, жимс зууван өндөглөг дугтуйтай, үр маш зөвлөн олон ширхэгтэй буй. Ардын эмнэлэгт хэрэглэнэ.

ИСГАНДИ тө. skandhi (<сам. skandhi); мө.б. isgandi~isyandi (МГО); Нэгэн зүйл адын нэр.

ИСЭР хя. yi zi; мө.б. iseri; Түшлэггүй мухар сандал.

ИТЭМ манж. iten; мө.б. item; Хоёр настай үхэр буюу бяруу. Итэм бяруу гэвэл тутал бяруу гэсэн утгатай болно; ...утэл явахад итэм бяруу мэт яв (Зуун бил.).

ИЧ манж. iča; мо.б. iča; Далайд байдаг ясгүй нэгэн зүйл загас. (Ков.).

К

КАКУБА сам. kakubha; тө. dba'bo sing; мо.б. kakuba; Баатар мод (Ков.); Terminalia alata glabra; XIII-XIV зууны үеийн монгол бичгийн дурсгалд kakubi гэсэн хэлбэрээр дайралдаг.

КАНДАЛ сам. kandala~kandali-kadali; мо.б. kandali (Ков.); Дал модны маягийн ургамал.

КАНДАР сам. kandara; мо.б. kandar-a (Ков.), Агуй, хонгил.

КАНДИГ сам. kañṭhaka; мо.б. kantig; Бурхан багш тойн болохоор гэрээс гарахдаа хөлөглөсөн сайн морины нэр; ...энэ чимэг хийгээд **кандиг агтыг эцэг хаанд авч одож өгөөд энэлгүүлснээ наманчилмуй хэмээтүгэй** (12 зох.).

КАНИГА сам. kanikā; мо.б. kanika (Ков.); Донго гэдгийг үз.

КАРКАД сам. karkata; мо.б. karkada (Ков.); хавч, дигваранз.

КАРША гарш; ал карша дээл (12 зох.).

КАУШИГА сам. kausika; мо.б. kausiga (Ков.); “Күша буюу гүш өвсөн дээр сууж буй”; Хормуст тэнгэрийн нэр.

КАЧАЛИНДИГА сам. kācīlindika; мо.б. kačalindiga; Зөөлөн нэхмэл бөс барааны нэг зүйл.

КАШИБ сам. kasyara; тө. 'od srung; мо.б. kašib; “гэрэл сахигч”; Бурхны шашны ёсноо амьтан хоёр түм наслах цагт Кашиб буюу Гэрэл сахигч хэмээх бурхан газар дээр үзэгдсэн гэдэг домогтой. Бас энэ замбуутивд үзэгдсэн мянган бурхны гутгаарх нь гэдэг.

КАШИГА сам. kāsika; мо.б. kasiga (Ков.); Каashi (Варанаси)-д хийсэн нарийн нэхмэл, ёрөг.

КИНАРИ гинари; *кинари хийгээд лусууд-бээр ул ольюу.* (Турф.).

КИНМУНИ сам. kanakamuni; тө. gser thub; мо.б. kingmuni; “Алтан чадагч”; Бурхны шашны ёсноо амьтан дөрвөн түм наслах цагт заларч ирсэн бурхан.

КОРАН: коран судар (оп. koran) < араб. qur'ān; Исламын шашны ариун ном. Шашин, зан суртахуун, ахуй байдал, хууль зүйн хэм хэмжээг агуулсан шашин-бясалгалин эмхтгэл.

КУМААР сам. kumāra; мо.б. kumar-a (Ков.); Идэр залуу, орь залуу.

КҮМБА сам. kumbha=тө. bum pa; мо.б. gumba=bumba; Бумба, хумх.

КРАКУЧАНДА сам. krakuchanda; тө. 'khor ba 'jug “орчлонг эвдэгч”; Бурхны шашны ёсоор амьтан хоёр түм наслах цагт энэ ертөнцөд ирсэн дөрөв дэх бурхан.

Л

ЛААГУУ хя. la gau; мо.б. laguu; Ботгирсон хоол ундны зүйл, заваарсан зуурмаг юм.

ЛАВ I нан. lab; мо.б. lab; “их, гүн, олон, их, яг”; 1. гүнзгий; 2. бат бэх, мөчид биш; 3. үнэн, магад, худал биш; лавлах (магадлан асуух); лавтай (магадтай).

ЛАВ II хя. lab(< хя. la); мо.б. lab; 1. лаа; лав зул; 2. газраас гардаг нэг зүйл тос; лав тос лаа хийнэ; 3. **шилж** нааж бэхлэхэд зориулсан лац мэт наалданги зүйл.

ЛАВИР тө. bla bre; мо.б. labri; 1. гэр өргөөний хоймрын шүгээний өмнүүр хөндлөн ташаалан татсан хөшиг; 2. бурхад хувилгаад лам нарын суух суудал, орны дээгүүр татах нэг зүйл чимэг хэрэгсэл; 3. бөөгийн бэлхүүсээр бүслэх чимэг.

ЛАВРАН тө. bla brang; мо.б. labrang; “ламын ордон”; 1. Брайбун хийдийн Гоман дацангийн ширээт лам байсан их ламтан Агваанзундуйн (1648-1722) дорнод төвдөд үүсгэн байгуулсан шар малгайтны том хийд. Энэ хийдэд Монголчууд эргэл мөргөл их хийдэг байжээ; 2. хүндтэй лам, хутагт хувилгаадын суух орон байр; Монгол хэлнээ лаврин гэж хэлж бичих нь ч бий.

ЛАВШАА орос. лапша; мо.б. labša; Хэрчсэн мах, тасалсан гурилтай шөлтэй хоол, гурилтай хоол; мянтууз ч гэнэ.

ЛАВШИГ тө. la ra śa-la-pa-sag; мо.б. labši~labashi; 1. захгүй ёст дээл; Төвд хэянээ нөмгөн өмсдөг гадуур хувцасны нэг зүйл; 2. тэрлэг, эрэгтэй хүний зуны дээл.

ЛАГ сам. laksā; мо.б. lay (Ков.); 1. зуун мянга, бум; Лагш буюу лагча ч гэнэ; 2. их, асар том; лаг тоо, лаг том.

ЛАГА хя. lóugū~lálágū; мо.б. laγu; 1. цохтой адил, бяцхан далаачтай зун дуугарах нэг зүйл хорхой; 2. хүний толгойд гарах хатигнаас том нэг зүйл яр.

ЛАГАЙ тө. bla gos; мо.б. layai; “дээд хувцас”; Бурхны шашны гэлэн хүний гадуур нөмрөх улбар шар өнгийн тэрмээр хийсэн номын хувцас.

ЛАГАР тө. *gla sgar*; мө.б. *lagar*; хөнгөн чанартай, үндсэргэг ширхэгтэй нэг зүйл мод.

ЛАГУУ хя. *la ku*; мө.б. *layu*; бяцхан далавчтай хорхой (Ков.); лагуу яр (толгойн хатиг).

ЛАГЧ манж. *laşa*; Далайд оршдог, толгой хамшгар, хайрсгүй, хэвэл томтой, 50-60 см урт, жирийн загасныхаас том бөгөөд шаравтар элэгтэй нэг зүйл загас.

ЛАГШ(АА) сам. *lakṣa/lakcha*; мө.б. *layşa*; Арван түм буюу зуун мянга, бум ч гэнэ. Монголоор *laşa* ч гэж бичдэг.

ЛАГШИН сам. *lakṣaṇa*; мө.б. *layśin*; 1. биеийн хүндэтгэл, биеийн байдал; *хорш*. бие лагшин; лагшин чилүүр (биеийн байдал таагүй); 2. бурхны биед байх сайн бэлгэс; лагшин найраг (бурхны биеийн гучин хоёр лагшин, наян найраг); гурван лагшин (номын лагшин, төгс лагшин, хувилгаан лагшин). *Мэгжид жанрайсиг бурхны ... лагшиг хуудас алтаар алтдах ажил дуусчээ (А.Э.)*.

ЛАДАГ тө. *la dwags*; мө.б. *laduy*; "уулын (давааны) ам"; Монгол хуучин ном сударт *mag ogn* гэж нэрлэдэг нь төвд үг болно. Энэтхэгийн Жамму Кашмир мужид харьялгахаа Хималайн вант улсын нэг. Эрт цагт Байгал нуур, монголын говиор нутаглаж байсан гэдэг. Зан заншил, соёл, амьдрал ахуйн хувьд төвдтэй тэстэй учир "Бага төвд" гэдэг.

ЛАДУУ тө. *la du* (<сам. *laḍḍu*); мө.б. *ladu*; Элдэв амт хольсон боорцог буюу эрс буурцаг няцлан, тогтуус, бор шарилжийг иsgэлэн усанд найруулж хийсэн холимог идээ.

ЛАЗАН тө. *bla btsong*; мө.б. *laṛāṅg*; "чалчих"; Аливаа үйл ажилд ямагт хөшүүн хойрго; лазагнах (залхуурах).

ЛАЗУУ хя. *lājāo*; мө.б. *laši*; Нэг наст өвслөг ургамал. Үр жимс бөмбөгөр, гашуун амттай. Чинжүү ч гэнэ.

ЛАЙ I хя. *lāi*; мө.б. *lai*; Хог тоос, буг буртаг, шавар шавхай; лайдах (худгийн доторхи хог буртгийг цэвэрлэх).

ЛАЙ II тө. *las*; мө.б. *lai*; 1. үйл зовлон; *хорш*. үйл лай; *Лайл баригдсан Жүгдэр өвгөн л хэцүүдэж дээ, зайлзуул.* (З.Б.); 2. төвөг, яршиг; бөөн лай; *лай болохоор зайд бол* (Зүйр).

ЛАЙЖ хя. *līqì-zì*; тө. *li chí*; мө.б. *layījī*; Бөмбөгөн нумны адил нэг зүйл жимс.

ЛАЙМУУЗ хя. *lāimó-zì*; мө.б. *layimuu*; Гүжир гүтгэлэг, гөрдлөг.

ЛАЛ тө. *kla klo*; мө.б. *lalu*; "тэрс үзэлт"; 1. УП зууны үед өрнөд Арабт үүссэн шашин. Сургаал нь "Коран" хэмээх сударт байх ба хүй нэгдлийн шашин, иудаизм, эрхүүд шашин, зороастризмын үзлийн элементээс бүрдэнэ. Түүний үндэс нь тэнгэр газрыг бүтээгч бөгөөд өртөнцийн бүх үйл явдал, хүний хувь заяаг шийдэгч нэгэн тэнгэрт бишрэх шүтгэг юм. Тэр тэнгэр нь Аллах. Бүхнийг энэ тэнгэр мэднэ гэдэг. Аллах бурхны өмнө боолын ёсоор хүлцэнгүй байхыг номлодог. Сүсэглэсэн нь диваажинд очиж, сүсэглээгүй нь тамд очно гэдэг. Сүсэгтэн нар нь өдөр бүр уншлага үйлдэн, мацаг барьж, мөргөлийн газарт очин мөргөл хийх ёстой гэнэ; 2. бурхны шашнаас чанга буруу урvasan гадаад номтон, тэрсүүд; *Эс тэгвэл буруу даваагаар орж лал болох биш үү.* (Л.Т.).

ЛАЛАДА сам. *lalāta*; мө.б. *lalada* (Ков.); магнай, дух.

ЛАЛАР сам. *lalātanetra*; мө.б. *lalar*; "магнайн нүд"; Магнай буюу цохондоо ганц нүйтэй гэсэн үг. Эртний энэтхэгийн Махешвар тэнгэрийн гуншин. Монгол хэлнээ "хар лалар, лалрын амьтан" мэтэст хараалын утгаар хэрэглэгдэж явдаг.

ЛАЛИДА сам. *lalīta*; мө.б. *lalida* (Ков.); Цэнгэлэг, хөгжим; Лалидабазар гэдэг нэрийн өнцөг.

ЛАМ I тө. *bla ma*; мө.б. *blam-a, lam-a, lama*; "эрхэм дээд, их багш"; 1. Аврал адистидийн эзэн, лам багш хэмээх нь авралын орон, амьтныг зовлонгоос ангижруулагч, амгаланд хүрэх аргыг заагч, хутгийг соёрхогч, бурхан лугаа ялгалгүй шүтээн. Одоо цагт нийт хувраг, санваартан нарыг нэрлэх болжээ; *хорш*. лам хувраг; Даа лам (их лам, шашны хурал номын захиргааны хэрэг эрхлэх хүний албан тушаал); хамба лам (шашны хурал номын үйлийг толгойлон удирдах хүн); хар лам (христос шашны лам); лам шувуу (ангир шувуу); лам хорхой (жижигхэн шар цоохор нэг зүйл нисдэг хорхой); ламархаг (ламархуу, ламын шинжтэй); ламархах (хэт лам зан гаргах); ламархуу (лам маягтай); ламтан (ламын хүндэтгэл, хувилгаан ламтан); ламтах (ламын хурлын үйлийг тэргүүлэх); ламхай (лам хүний хүндэтгэл); ламшууд (лам шинжтэй); ламбугай (ламхай).

ЛАМ II: лам гөрөөс; оп. лама(<исп. *Lama*); Тэмээний намын салаа туурайтан амьтан, ялгаатай нь бөхгүй, тэмээн гөрөөс ч гэнэ.

ЛАН хя. *lāng*; мө.б. *lang*; Хүндийн хэмжээ, арван цэн нь нэглан; *Тавин лангийн ембүү, дуутуур хэмээх гулдмай мөнгө...гарав* (С.Д.).

ЛАНГУА хя. nánguā~lánguā; мөб. languya; Хулууны язгуурын зэллэн ургах нэг наст өвслөг ургамал ба түүний гуа, навч нь таван сэrvээтэй буюу зүрхэн хэлбэртэй, гуа нь бөөрөнхий, үр гонзгой, үрээс нь тос гаргана. Нангуга ч гэнэ.

ЛАНГУУ хя. lángū; мөб. languu; Дэлгүүр худалдааны газрын барааны өмнө тавих хашилага, хорго, бас бараа таваар хамгаалах хориг; *Та нар тэгж байж наад лангутаа мөргөчихөв* (С.Д.).

ЛАНДАРМА тө. glang dar ma; мөб. landarm-a/langdarm-a; “үхэр Дарма”; 1. Төвдөд IX зууны үед төр барьж, бурхны шашныг төвдөөс ул үндэсгүй устгаж арилгахаар оролдсон хааны нэр. Уг нэр нь Дарма боловч лан (үхэр, мал) гэсэн хараал үгийг нэрийн урд залгаж Ландарма буюу (Үхэр) Мал Дарма гэж хочилжээ. Ландармын тухай домог бий. Эртний энэтхэгт Бурхны шашны нэг сүм байгуулж аравтайлах үест тусалсан барьсан бүх хүнийг шагнажээ. Гэтэл цусаа урстал ус зөөсөн нэг үхэр ямар ч шан хүртсэнгүйдээ ихэд гомдох турав хоногийн дараа үхжээ. Түүний сүнс Төвдийн Ландарма хаан болж хувилсан гэдэг. Тэр хаан сүм хийдийг нурааж, ном судрыг нь галдан, лам хуврагийг нь хядаж эхэлжээ. Бурхны шашны Хашин хаан нэг жилийн цагаан сараар хааны ордны гадна цамын бүжиг тоглож нийтэд үзүүлэх үест нууцалсан хутгаараа Ландарма хааныг чичиж алжээ. Ландармын сүнс нь усан шуламс болон хувилж сүмийн дэргэдэх уулын оройд оршиж, сүм рүү бузар бургийн үер буулгадаг болжээ. Гэтэл нэг лам: “энэ бол Ландармын сүнс мөн” гэсэнд олон түмэн түүнийг дарах гэж ад чөтгөр, араатан жигүүртний баг өмссөнд усан шуламс тонилжээ. Хашин хаан Ландармыг алсан ёсоор бүх үйл нь бүтжээ. Үүнээс хойш IX зууны үеэс төвдөд цам үүссэн гэж үздэг болсон байна; 2. шашны дайсан, тэрс номтон; хараал уг.

ЛАНЖУУ хя. lan zhou; мөб. lanžuu; Нэгэн зүйл винтов буу.

ЛАНЗ тө. (<сам. gañjā) lan dza; мөб. lanža; 1. Балбын буддистуудын дунд хэрэглэж байсан ногар үсгийн гоёон өөрчилсөн хэлбэр; ланз үсэг; 2. нэгэн зүйлийн үсэг мэт хээ; ланз хээ; ланзан тамга.

ЛАНТАНЗ тө. lang thang tse (хя. làngdàng-zì); мөб. lantanža; Ягаан шар цэцэгтэй, сүрхий үнэртэй, хортой нэг наст зэрлэг ургамал. Навч, цэцэг, жимсийг ардын эмнэлэгт хэрэглэнэ. Зэмбэ буюу тэнэг өвс ч гэж нэрлэнэ.

ЛАНТУУ хя. lántou/láng-tou; мөб. lantuu; Цохиж балбахад хэрэглэх лантгар толгойтой зэвсэг. Модон лантуу, төмөр лантуу гэж ялгана.

ЛАНЦУЙ хя. lángchui; мөб. langčui; Хоёр талдаа иртэй, хурц үзүүртэй, мэс заслын хутга.

ЛАНЧИГ тө. lan chags; мөб. lančig; 1. төвөг, саад, уршиг яршиг; ер төлөөс урьдын муу үйл үр; хорш лай ланчиг; Чи мөн ланчигтай амьтнаа гэж Чанцаал хэлэх угээ олж ядав (З.Б.); 2. аливаа муу үйл үйлдэгсдийн гэм нүглийг дэнслэн шүүх нэгэн зүйл ад.

ЛАРЗ тө. gla rtsi; мөб. larži; “хүдрийн заар”; Бие гүйцсэн хүдрийн эрэгчин болох гирээний хүйсний хажууд байх сайhan үнэрт булчирхай. Өрнө дорнын ардын эмнэлэгт ариутгал эм болгож, үнэртний зүйлд өргөн хэрэглэж иржээ.

ЛАХ манж laha; мөб. laq-a; Хамшгар толгойтой, хайрсгүй, гол мөрнөө орших нэг зүйл загас. Хадран загас, багаахай, шөрөг ч гэж нэрлэдэг.

ЛИВГАН тө. le brgan/le brgan; мөб. libergan/libyan; 1. намуу цэцэг; ливган өнгөт (бүдэг улаан); 2. элэгний нэг зүйл өвчин.

ЛИВГАНЗ тө. le brgan rtsi; мөб. libyanža; Ливганы шим буюу намуу цэцгийн шүүс шүлт.

ЛИДЭР тө. sle tres; мөб. lider; Sophora flavescens; Амтлаг, исгэлэн, тослог, сэрүүн чанартай нэг зүйл ороонго ургамал. Хий, халуун харшилахад рашаан болдог гэж эмийн сударт өгүүлсэн байдаг.

ЛИЙ хя. lí; мөб. li; Уртын болон талбай, хүнд хөнгөн, зоос зэргийн хэмжүүр. Зуун лий нэг ямх; Зуун лий нэг мүү, зуун лий нэг цэн, зуун лий нэг мөнгө.

ЛИМБЭ тө. gling bu; мөб. lingbu; Хулсаар буюу гуулиар хийсэн, хуруугаар дарах зургаан нүхэн даралттай, хөг аяс нь маш зөвлөн, яруулаг, исгэрэх байдалтай сонсогдох хөгжмийн зэмсэг; эр лимбэ (хийц бүдүүн, богинохон, үлээхэд хатуу шинжтэй); эм лимбэ (хийц нарийн, үлээхэд зөвлөн хөндлөн бишгүүр ч гэдэг).

ЛИН I хя. líng; мөб. ling; Нэг зүйл торгоны мод болон тэр модны зүйлээр хийсэн торгомсог бараа.

ЛИН II тө. gling; “тив”; Төвдийн Амдоо нутгийн Хөх нуур, Хатны голын эх орчим, монгол, төвд, уйгар нар урьд нутаглаж байсан газрын нэр. Лин оронд XI зуунд Гэсэрийн тууж зохиогджээ.

ЛИНС хя. líng-zi; мө. lingse; Панснаас зузаан нягт нэхсэн нимгэн тортон нэхмэл.

ЛИНХҮҮ хя. leang kou mi; мө. liyngkü; “хоногийн амуу”; үрлэн буюу хөц будаа.

ЛИТ I тө. le'u tho; мө. liteü~lit; Хуанли; цоморлиг; бүртгэл; цаг улирлын тооны бичиг.

ЛИТ II тө. li khri; мө. liti; Нүдний улаан оо будаг.

ЛИОХ хя. liohu; мө. lioqu; Цэнгэг усанд орших зэвэгтэй адил нэг зүйл бяцхан загас.

ЛИУ хя. liao; мө. liü; Бордоо, тэжээл, батрага.

ЛИШ тө. li sí; мө. lisi; Syzygium aromaticum; Лишийн мод; цэцгийг лишийн цэцэг, башир цэцэг, хадаасан гэхчлэнгээр нэрлэнэ. Өнгө бор, амт исгэлэнхэн, халууттар, хадаасан хэлбэртэй нэг зүйл үр.

ЛОВОН тө. slob dpron; мө. lobon; 1. шашны ямар нэг дацан хурал номын үйл удирдах хүний албан тушаал; 2. ямар нэг үйл ажлыг удирдан зааж сургах багш, сургаалын багш.

ЛОВУУ хя. luofú; мө. lobuu; Нэгэн зүйл бялзухай.

ЛОВХ тө. slob mkhas; мө. lobqai; “мэргэн багш”; Бичгийн утгач; Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын баруун хойш 80 км-т Бүрдний голын зүүн хойт биед байх 130 см урт хар чулуугаар хийсэн хүн чулуу, ловх ноён гэдэг.

ЛОДРО сам. lōdhra; мө. lodru-a; Bassia Latifolia; Эртний самгарди яруу найрагт гардаг цэцэг. Монгол хэлнээ орчуулгагүй хэрэглэсэн буй; ...Лодро цэцгийн оо түрхэж цайвгар болоод...(Кали).

ЛОЗВАА тө. lo tsa'a~lo tsa'aba (<сам. loca); “ертөнцийн мэлмий”; самгарди бичгийн дурсгалыг орчуулдаг төвд орчуулагч нарт өгч байсан нэр хүндтэй цол. Хэлмэрч, орчуулагч хүний хэлний эрдмийг “ертөнцийг харах нүд” гэж үлгэрлэдэг байжээ.

ЛОМБО оп. пломба, (< фр. plomb, “хар туталга”; мө. lombu; 1. бараа таваарт тавих туталган тэмдэг; 2. битүүмжлэх лац; ломбодох.

ЛОО хя. ló, lóbu; мө. lo; Нэг зүйл тортон барааны нэр, шаа торго ч гэнэ.

ЛООВУУЗ хя. lǎowō-zí; мө. lobuuya; хүйтэн сэрүүн цагт өмсөх үстэй малгай.

ЛООЕЭ хя. lǎo-ye; мө. looye; 1. ноён, түшмэл; ноён гэдэг үтгэй гарал нэг байж магадгүй; 2. өвөө, өвгөн, өндөр настан.

ЛООЛОЙ манж. lolo; мө. loloi; шагай, тагалцаг, гахайн тагалцаг.

ЛООМИ хя. lǎo mǐ; мө. loomi; “хуучин амуу”; Бүтнэж хөшиглэсэн тутарга амуу, буюу хуучин ургацын амуу, хоног амууны нэг овог. Хуучирч хүрэвтэр өнгөтэй болсон тутарга амуу.

ЛОДНӨ хя. luobchún; мө. lötün-e; Бүднэ шувууны ангаахай.

ЛУВААНЖАЛБА: Луваанжалбын рашаан; тө. klu dbang rgyal ro “Лусын эрхт ялгуутг”; Улаанбаатарын умар этгээдэд орших Чингэлтэй уулын өмнө талын өндөр улаан уулын шувтрах үзүүрт байдаг рашаан. Лус савдгийн хорлол болсон, сүнс сүлд нь зайлсан хүмүүс арга засал хийлгэсний дараа энэ рашаанаас хүртвэл бие нь сайжирдаг гэж үздэг байжээ.

ЛУЙВАР тө. bslus rag; мө. luyibag; “хуурах, хуурагдах”; Гэр, гүжир, гөрдөл, хилс; луйвардах (а. хүний юмыг гүжрээр булаан авах; б. булхайцах); луйварчин (буудын юмыг гүжрээр булаан авагч).

ЛУНДАА тө. lung rta; мө. lungda; “салхин морь”; хийморь; Айл гэрийн цог залийг бадруулдаг гэж хэжимтэй морин дээр хүслийг хангагч чандмань эрдэнэ ачсан зураг бүхий бяцхан дарцаг. Гэрийн бүслүүрт хавчуулан салхинд хийсгэдэг. Монголчууд лундааны дарцгаа лундаа буусан өдрөө хийсгэдэг заншилтай байв.

ЛУНТАН лүнтэн; Лунтан өөргүй хоёр нүдэнд нь лус болоод савдаг баясмаар (МААЗДБ).

ЛУС тө. klu; мө. lus; 1. Бурхан шашны домгоор хүн толгойтой, мөгий хэлбэрийн биетэй газар дэлхий, уул усны эзэн, хүмүүн бусын амьтан. Мөгий буюу морьтой хүний дүрээр зурж тахих явдал ч байжээ. Уул тайх ёслол нь лус тахих ёслол болно; хорш лус савдаг; 2. найм гэсэн тооны ёт нэр. Бурхны шашны ёсонд газар лусын найман аймаг гэж бий. Эдгээр нь: лус, хаан, албин, лам, мангас, шулам, ягчис болно.

ЛУУ хя. lóng/lún; тө. klu; мө. luu; Луу лус хоёр гарал нэгтэй; 1. Дунд галбын үед байсан аварга гүрвэлийг эртний домогт ийн нэрлэж байв; 2. жилийн тав дахь нь; луу жил; 3. хаврын сүүл сар; 4. цагийн зурхайн 7-9 цаг; луугийн нүд (жимс); луугийн дуун (аянга); Эртний дүрслэх урлагт луут бугын эвэртэй, үхрийн чих, тэмээний толгой, төгрөг нүд, мөгий хузүү, загасны хайрс, барсын шийр, харцгайн хумстайгаар дүрсэлж байжээ.

ЛУУВАН хя. luó bo; мө. luubang; Тоонолжин цэцгийн язгуурын нэг буюу хоёр наст өвслөг ургамал. Махлаг том үндэстэй түүнийг хүнсэнд хэрэглэнэ. Улаан лууван, цагаан лууван, гашуун лууван гэхчлэн олон зүйл бий.

ЛУУГАР хя. lù; мө. lūnqār; Гол зам, аян жингийн их зам, тэргүүр.

ЛУУЖИН хя. lúojīng; мө. luužing; Зүг чиг заах багаж.

ЛУУС I lò zi, luo zi; мө. laŋusa~luusa (зөрчид. lao-sāh; манж loso); Илжиг гүү хоёрын дундаас гарсан эрлийз адuu, хачир ч гэнэ.

ЛУУС II хя. liǎng; мө. laus; Шар хүрэн өнгөтэй нэг зүйлийн хулгана.

ЛУУХААН хя. lao han; мө. looqan; 1. настай хүн, хятад өвгөн; 2. шилж хятад хүн.

ЛУХАН: лухан жимс; тө. lo hang (<хя.); мө. luqang; Нанхиад ар үрийн адил, олон давхар арьс хальстай нэг зүйл жимс.

ЛҮГРҮҮ тө. lug rwa smug; мө. lügrü; “хүрэн хуцын эвэр”; Хүрэн, улаан, шар гурван онгийн цэцэг. Шар улаан нь уулын аманд, хүрэн нь чулууны завсар ургана. Нэг мөчрөөс гурван навч ургана. Тэр нь хуцын эвэр хэлбэртэй, матигар цэцэгтэй. Эмнэлэгт хэрэглэнэ.

ЛҮД тө. blud=glud; мө. lüde~lüt; 1. хүний өвчин зовлонг өөр дүрээр орлуулан хөөх байдлаар гүйцэтгэх гурилаар хийсэн хүний дурс, золиг ч гэнэ; 2. нас барсан хүн, тэдний ар гэрийнхэнд зориулж унших бага хэмжээний уншлагын ном. Лүд уншсаны дараа тухайн хүний аз хийморийг зөгнөн гурван ерөөл уншина. Тэдгээр ерөөлийг унших үест тухайн хүний дээрээс үр тариа цацна; 3. хараалын уг; ээ хар лүд; ...тун ч гөжүүд зөрүүд лүд байгаа юм (*L.T.*); лүдтэх (лүд золиг болох).

ЛҮЙЖИН тө. lus sbyin; мө. lüyijin; “биээ өгөх”. Үхээрийн бузар оршсон болон буг чөтгөр, ад шулам шүглэсэн газарт тэдгээрийг тонилгохоор зоч лам хонх дамар дуутарган, ном унших тусгай зан үйл гүйцэтгэх ёс; лүд гаргаж луйжин тавьсаар... (*MAY*).

ЛҮМБИНИЙ сам. Lumbinī; мө. lümbini; Одоогийн Балба Энэтхэгийн хилийн заагт байх газрын нэр, энэ газрын цэцэрлэгт нэгэн сал модны дор Сиддхаарт зуны эхэн сарын арван таванд (МЭӨ.624 он) ертөнцөд мэндэлсэн гэдэг.

ЛҮН I тө. lung; мө. lüing; “эш, зарлиг”; 1. бошго, удирдуулсан зарлиг, эш үндэс; лүн тавих (ламын увдисаар тухайлж тодорхойлсон номыг тодорхой ариунаар шавийн чихнээ уншсаны хүчээр, номын авьяас тавьснаар тэр бүтгийг нь шамдалгүй мэддэг болгож өгөхийг хэлнэ); 2. гол, үндэс; судар дандрын лүн.

ЛҮН II тө. flung; мө. lüng; “хий, салхи”; Лүн хайрхан, Лүнгийн даваа...гэх мэт монгол газрын нэрд орж явдаг, мөн энэ нэрийг орчуулж Салхит ч гэдэг.

ЛҮНДЭН тө. lung bstan; мө. lüngdün; Өнгөрсөн, одоо, ирээдүйн иууц далд үйл явдлыг илэрхийлэн өгүүлэх зарлиг бичиг; зарлиг эш, бошиг ч гэнэ; эш лүндэн, бошиг лүндэн, хорши зарлиг лүндэн; Энэ сургаал лүндэнг бичиж дэлгэрүүлбэл, нэг гэрийн гамшиг зовлон өнгөрч болно. (*B.P.*).

ЛҮНДЭЭ = лундаа; мө. lüngde.

ЛҮНРИГ тө. lung rigs; мө. lüngrig; “боштыг ухагч”; Хутагтын зарлиг (лүн), аршийн мэдлэг (риг) хоёрыг хослуулсан хүн; Лүнриг Дандар (XIX зууны сүүлч XX зууны эхэн үед амьдарч байсан Сайн ноён хан аймгийн Далай вангийн хошууны нэрт оточ).

ЛҮНТИД тө. lung khrid; мө. lüngtid; “эш хөтөлбөр”; Зааж байгаа номоо багш нь шавьдаа эш жишээний хамт тайлбарлах үйл явц.

ЛҮНТЭН тө. lung tang; мө. lungteng/lüngtün; харьц. хя. long tang; Sapindus mīkorossii Gaerth; Энэтхэгийн савангийн мод хэмээх бүдүүн голтой буурцагт модны өндөглөг жимсний доторхи гялгар хар үр. Цамын баг, бурхны мэлмий, эрхи зэргийг хийнэ. Мөн эмд орно; Лүнтэн хар нүд (тас хар нүд); Хар лүнтэн мэлмийтэй хамба ноён...таниг урин залан дуудна. (*МААЗДБ*).

ЛҮҮ хя. löü; мө. lüü; цуудас, туйванг сүлжин цаас давхарлан хийсэн сав; лүү хөнөг (шингэн юм хийх том сав); архины лүү (архи их уудаг хүн).

ЛХААРАМБА тө. lha ram pa; мө. lharamba; “Лхасын зэрэгтэй” = “шалгарсан”; Төвдийн Лхас хийдэд номын дамжаа барьсан гавьж. Лхас гэдэг үгийн Лха, равжамба гэдэг үгийн - рамба хоёр нийлж бүтсэн нэр.

ЛХА тө. lha; мө. lha; “тэнгэр”; Лха таван тэнгэр; Баруун талаас харвал Баян Лхагийн шавдагтай (*МАЗУАЗ*).

ЛХАГВА тө. lhad ra; мө. lhauba; Буд; долоон гаригийн гутгаарх нь.

ЛХАРЖИ тө. lha rje; мө. lharjī; “тэнгэрийн эмч”; Хамгийн мэргэн отчийг эрхин бодг болгон хүндэтгэн өгч байсан цол. Мөн Төвдийн Лхаст маарамбын хамгийн дээд цол хамгаалсан мэргэдэд өгч байжээ; Лхаржи Лувсанданзанжамц (1639-, монголын ууган оточ нарын нэг. Төвдийн Лхас, Дашихүмбэд 22 жил сууж ном үзсэн анагаах ухааны хэд хэдэн ном бичсэн мэргэн хүн).

ЛХАС тө. lha sa; мө. lhasa; “бурхны газар (орон)”; МЭ-ний УП зууны тэргүүн хагасаас буюу Соронзонгомбо хааныг төр барьж байх үеэс ийн нэрлэж ирсэн Төвдийн нийслэл хот; далайн төвшнөөс дээш 11600 фүүтийн (тохой) өндөрт оршидог.

ЛХАЧИНВАНДАД тө. lha chen dbang bstod; “их тэнгэрийн авшиг хүсэхүй”; Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших дархан цаазтай уул, нутгийнхан навчит вандан ч гэдэг. Их тэнгэр гэдэг нь Махадева тэнгэрийн нэр юм.

ЛЭНСРЭЙ тө. gleng bsras; мө. lengsrei; “яриа эвсэх, нийлүүлэх”; Бурхны шашны гүн ухааны мэргэжих гавж нарт Төвд, монгол оронд олгож байсан цол; *Törc цогт Барайбун хийдийн лэнсрэй гавж...гачен Ринчен (Данж)*.

ЛЯНГА тө. ling ga(<сам. linga); мө. lingy-a; “билэг, тэмдэг, ичрэг, озгой”; Эртний энэтхэгийн хинду шашинд Шива тэнгэрийг билэгдсэн эрийн билэг байв. Бурхны шашинд золигт гаргах буюу жинсрэг цутгах зан үйлийн дагуу тухайлан дарах ад чөтгөр, гай тогтор, тэрсүүдийн шашинтныг дуурайлган гурилаар хийсэн буюу цаасан дээр зурсан дурс. Нүгэлт хүнийг золигт гаргахад дурсийнх нь хажууд түүний хувцасны тамтаг, үс хумс зэргийг дагалдуулна. Тогтоосон зан үйл ёсоор уг дурсийг хэсэглэн хэрчиж, даран сөнөөсний билэгдэл болгон сүм хийдээс гаргаж хаяна; 2. гурилаар хийсэн бяцхан балинг дотор нь хийж оршуулдаг жижиг төмөр сав; ...аймгуудыг лянгын дотор оршуулав. (Гам).

ЛЯНХУА хя. lianhua; мө. lingqu-a; Усанд ургах олон наст өвслөг ургамал. Том дүргэг навч нь усан дээр хөвөх буюу усны мандлаас дээш цухуйн ургах хоёр зүйл бий. Цэцэг нь гүн улаан, цайвар улаан, цагаан өнгөтэй, үнэр анхилмал, бадам ч гэдэг.

M

МА: эхийн ма тамга; тө. ma; мө. ma; Төвд бичгийн үсгийн дурстэй, малын тамга.

МААДАЙ хя. mādāi; мө. madai; Бүдүүн ширхэгтэй олс буюу химээр нэхсэн уут сав.

МААЖИН хя. mābūi; мө. mažing/mažajin; 1. будаг зуурах, ширдсэн зүйл өнгөлөх тос, маалинга буюу олсны тосоор хийнэ; 2. олсны тос.

МААЛУУ хя. mā lōu; мө. malu; Жижигхэн лүү; маалуутай архи.

МААНЬ сам. manj; мө. mani; 1. бурхны шашны ёсны нэг зүйл уншлагын ном; Эрихийг барьсан нь олон ч маанийг уншсан нь нэгэн хоёр (A.X.); 2. нууц тарни, арвис тарни, тогтоол тарнийг цогцлуулсан Жанрайсиг бурхны зургаан үсэгт зурхэн тарни; дүнчүүр маань (дурдсан тоогоор уншваас их амгалант тариалингийн оронд лянхуа цэцгээс хувилж төрөөд бурхан болж төрнө гэдэг); маанийн үрэл (эрдэнийн үрэл); огторгуйн маань (чандмань, зэндмэнэ зэрэг үгийн өнцөйт орсон үгийн хувирсан хэлбэр; огторгуйн эрдэнэ буюу нар гэсэн үг).

МААПААН хя. mā-fan; мө. mafang; Төвөг яршиг, яршиг удах нь; будилаан.

МААРАМБА тө. sman rams ra; мө. magamṭa; Төвд эмнэлгийн эмчилгээний арга ухаанд мэргэшсэн хүнд олгох эрдмийн зэрэг, тэр арга ухаан хэмээгч нь хий, шар, бадгана гэдэг гурван муу гэм хөллесэн 404 өвчин үүсгэх, 8000 гаруй шалтгаан, түүнийг анагаан тэтгэх ёсыг хэлж байгаа ажээ. Оточ гэж ч нэрлэдэг.

МААТААН манж. matan; мө. matang; Жимсний амтат идээ (Ков.); үр тариаг янзалж нуршин болгож хийсэн бохь мэт наалданги чихэрлэг идээ (Я.Ц.).

МААХАЙ шаахай; хя. mā hai; мө. maqai; Гутлаас богино түрийтэй шаахай; хилэн маахай.

МААХУУР хя. māhiār; мө. maquar/maqir; Голдуу үрийн тосонд болгосон мушгиа боов.

МААЮУЗ хя. māgū-zī; мө. mayuṣja; 1. эмээлийн дээр давхцаж хэрэглэх буяхан дэвсгэр; 2. юм агуулж ачих, дундаа амсартай бага шиг сав; мааюузлах (эмээл дээр давхацлан тохох).

МААЮУР хя. mā yār; мө. mayuug; Үрийн тосонд гол төлөв чанадаг нэг зүйл нарийн боов.

МААЯА сам. māyā; мө. may-a (Ков.); 1. заль мэх, илбэ ховс; 2. Шагжамунийн эхийн нэр.

МАГ тө. smag; мө. may; Зарим номд аглиг, заримд нь мойл гэж оноон тайлсан бий.

МАГАДА сам. *magadha*; мөб. *magada*; Эртний Энэтхэгийн нэг улс, одоогийн Бангаалийн өмнө тал, Ганга мөрний урд талд байжээ. Бурхны шашны мандсан гол төв. Энэтхэг домогт Замбуутивийн дунд оршдог гэж өгүүлдэг.

МАГАР матар; мөб. *magar~magar-a* (Ков.); Угтаа самгардийн *makara* болно. **Magar cap** (Энэтхэгийн долдугаар сар).

МАГНАГ хя. *mänglöng*; мөб. *mangnu*; Алт мөнгөн утас оруулж нэксэн ман мөгийн хээтэй нэг зүйл торго, магнаг дээл.

МАГУР сам. *mukura>tə*. *ma ku ra*; мөб. *magur-a*; толь (Ков.).

МАДАГ тө. *madaγ*; мөб. *madaγ*; "үсгийн алдаа"; алдаа, ташаа; *хоршалдаа* мадаг.

МАДИ сам. *mati*; мөб. *mati/madi*; Оюун ухаан; ойлгох чадвартай; Сумати буюу Сумади (Сайн оюут) гэдэг нэрийн өнцөг.

МАДИГ тө. *smad gyogs*; мөб. *madiγ*; "бөгсний хувцас"; (lam нарын) бөгсөн биеэр өмсөх гадуур хувцас, бансал.

МАДРОСВА тө. *ma dros pa*; мөб. *Madrosba* (Ков.); "эс бүлээдсэн нуур"; Аниавад, Мапамын тайлбарт үз.

МАДУРИГА сам. *madhurika*; мөб. *madhuriga~maduriga* (Ков.) Гоньд (үз).

МАДХЬЯМИКА сам. *madhyamika*; Бүддийн гүн ухааны дөрвөн том урсгалын нэг. "Мөнхийн хязгаар", "тасархайн хязгаар" хоёрыг тэвчиж төв дунд нь зогсож байна гэж үздэгээр нь нэрлэжээ. Энэ урсгалын гол онол нь "хоосон чанар" ба "шүтэн барилдлага" хоёрын салшгүй нэгдэл, мөн чанарыг тодорхойлсонд оршино.

МАЖИЙХ тө. *ma skye ba*; мөб. *tauγuqu*; "үл амьдрах"; үхэх, нас барах.

МАЙДАР сам. *maiγya/maiγrā*; мөб. *mayidari*; "элэгсэг, ивээл, ээлт"; Ирээдүйн цагийн бурхан; **Майдарын таван ном** (Төвдийн уламжлалаар Майдар бодисадва бичсэн гэдэг домогтой. Майдар Түшидийн орноос ирж Арьяасангад айлдсан йогачарын чиглэлийн сургаал. а). Илт онохуйн чимэг (сам. *abhisamayalamkāra*, тө. *mgong rtogs rgyan*); б. судрын аймгийн чимэг (сам. *sutralamkāra*; тө. *mdo sde'i rgyan*); в. Умын тийн үйлдэгч, (сам. *madhyantaviphangā*; тө. *dbu ma gnāt 'byed*); г. Жудийн ламын дандар (сам. *uttaramantra*; тө. *rgyud bla ma*; д. ном хийгээд номын чанарыг тийн үйлдэгч (сам. *dharma, dharmata vibhangā*; тө. *chos dang chos nyid gnāt 'byed*) болно; Майдар эргэх (ногоон моринд хөллөсөн тэргэн дээр Майдар бурхны дүрийг залж, жил бүр хийдийг гороолох шашны байр ёслол үйлдэх. Ингэснээр бурхан ертөнц дахиныг

тойрон ивээл өршөөлөө хүртээж байна гэж үзнэ. Ёслолын эхэнд Майдарын таван номыг залж явна).

МАЙМАА хя. *mäi mai*; мөб. *mayimai*; Худалдаа арилжаа; наймай, наймаа ч гэнэ.

МАЙМААЧИН хя. *mäi mai cheng*; мөб. *mayimačin*; 1. худалдааны дуурэг (тосгон); 2. худалдаа эрхэлдэг хүн.

МАЙХУА хя. *méi huā*; мөб. *mayiqu-a*; (сам. *mahuā*); Цанхуйн язгуурын баавтар тураг мод, заримдаа бутлан ургана. Найлзуурын дурс ногоон, навч гүйлснийхтэй адил, цэцгийн өнгө цагаан буюу ягаан, таван хэлтэстэй, анхилам үнэртэй, эрт цэцэглэдэг, жимсийг мэй гүйлс гэнэ. Монголоор тэргүүлэгч цэцэг гэдэг.

МАЛИГА сам. *mallikā* (тө. *mal li ga*); мөб. *malīy-a*; *Jasminum sambas*; Түяхан иштэй, олон салаатай, цайны навч шиг навчтай, цагаан өнгөтэй, хүйс бяцхан, үнэр сайхан, үдшийн хирд цэцэглэх нэг зүйл цэцэг.

МАМ I тө. *ma mo*; мөб. *mamu*; 1. шашны ёсны эм шуламс; 2. хараал уг; ээ мам гэж!; 3. *шилж* эх үндэс, тулаам; өвсний мам.

МАМ II лам буюу блама-гийн хүндэттэл уг.

МАМБА: мамба дацан тө. *sman pa grwa tshan*; мөб. *mamba(dacang)*; "эмчийн дацан"; Шашны ёсны лам хуврагийн эм, эмнэлгийн сургууль хийх орон сүм.

МАМУУНА манж. *mamidun*; мөб. *mamuun-a* (Я.Ц.); *mamun-a*; Молтогчин туулайтай адилавтар, бараан өнгийн амьтан.

МАН хя. *mäng*; мөб. *mang*; Шаргал зоотой, цагаан хэвлэйтэй, толгой урт, ам их, хэлний үзүүр хоёр салаа, гол усны ойр, ой модонд орших нэг зүйлийн хоргүй аварга мөгий. Арьсаар нь хуур бүрнэ.

МАНА манух; мөб. *manu*.

МАНАЛ тө. *sman lha*; мөб. *man lha*; "эмийн бурхан"; оточ бурхан; *Man lhagийн чого уншиж муу зовлонгоос арилаад...*(Гам.).

МАНАС сам. *mānasa*; мөб. *manas*; Маансароовар нуур; Чамайг үзэвч, *Manas сайхан нуураа уг санах бий* (Кали).

МАНАТАГЖАН тө. *ma nu khrag can*; мөб. *manutayjin*; "цуст мана".

МАНГААЛАМ тө. *mang ga lam*; (сам. *maṅgala*); мөб. *mangyalama*; "өлзий хутаг"; Их төлөв ном судрыг төгсгөхөд бичдэг өлзий билэгдлийн уг.

МАНГАЛ сам. *maṅgala*; мөб. *mangyal*; "өлзий"; Сайны хувьт, зол жаргалан, энх эсэн; ...гэртээс гарах болбаас *мангал хаалгаас*

гарах хэмээгдэж, тэр хаалтыг-бээр таван зуун хүмүүнээ түлхвээс ул нээгдэх (12 зох).

МАНДАА тө. manda; мө.б. mandaγ-a; Шашны ёсны тахил тавигийн дугуй суурь.

МАНДАЛ тө. ma nda la, <сам. maṇḍal> мө.б. mandal; 1. шашны ёсноо бурхан лам зэрэгт өргөх тахил тавиглал; *Тэд тэгээд...мянган лангийн мандал өргөж гэнэ. (С.Д); 2. тавцан; 3. өнгөн буюу гадна тал; түвшин; мандал өргөх (таван өнгийн няндар хадаг өргөж, бас таван хошуу малыг онголж сэтэрлэн, таван тарианы дээж зэрэг олон зүйл өргөхийг хэлнэ).*

МАНДАР сам. mandāra=Devavrikṣa; мө.б. mandar-a, Erythrina Indica; 1. Диваажингийн таван модны нэг. Тэнгэрийн мод хийгээд түүний цэцэг, шүрэн мод ч гэдэг; Мандарваа; ...*мандар модны таатай сүүдэрт...цаг ямагт цэнгэл наадам хийнэм (Кали.); 2. нэг наст өвслөг, хорт ургамал. Цэцэг, навч, үр нь эмд орно.*

МАНДАРВАА сам. mandārava; мө.б. mandarau-a; 1. мандар; 2. холтсон цэцгийн язгуурын бут мод. Зулгарахгүй, салаалсан урт навчтай, цэцэг нь улаан, хүрэн, цагаан зэрэг өнгөтэй, унэр анхилмал, цоморлиг нь том, гоёлын ургамал, цэцэг; *Идэр насан гэгч нь мандарваа цэцгийн адил (Д.Н.).*

МАНДИР сам. mandira; мө.б. mandir-a; Энэтхэг орноо ургах нэг зүйл мод.

МАНЖ I хя. manzhou; mañju-, 1624 оноос эхлэн хятадыг эзлэн байсан Чин гүрний нэр; Хятад улсын цөөн тоот үндэстний нэг.

МАНЖ II тө. mang ja; мө.б. manji; "олны цай"; Шашны хурлын үеэр гэлэн хуврагуудад өгдөг цай, манз ч гэдэг; цав манж; *Ерөөл гүйсны өргөл барьцанд манж оруулахаар эцэг нь амлажээ. (Л.Т.).*

МАНЖИН хя. mán jīng; мө.б. manjīng; Тоонолжин цэцгийн язгуурын хоёр наст өвслөг ургамал. Махлаг улаан цагаан үндэстэй. Түүнийг нь давсалж иднэ.

МАНЖИР тө. manyajīr<сам. manjīra>мө.б. manjīg; "өлмийн бэлзэг"; Хэлбэр нь элэг зүрхний адил атирадсан, цацарсан гэрэлтэй, элдэв олон өнгөтэй хатуу чулуу. Ясны халууныг дарна гэж эмийн сударт гардаг.

МАНЖУГОША сам. mañjughosha (тө. 'jam dbyangs); "зөөлөн эшигг"; Манзшир бурхны нэг дүр. Цагаан арслан дээр сууж, цагаан лянхуат суурин дээр байрласан баруун мутартаа ралди, зүүн мутартаа лянх барьсан, биеийн өнгө улбар шар. Монгол ном

судрын эхэнд "намо гуру Манжугоша" гэж байдаг нь энэ бурханд мөргөл үйлдсэн хэрэг юм.

МАНЗ манж : манзач (цай хоол хийгч лам нар).

МАНЗШИГА сам. mañjushika; мө.б. manjusika; R.cordifolia L. Мөнгөн цацагт цэцгийн адил, цав цагаан өнгөтэй, чигжүү хүйстэй нэгэн зүйл цэцэг.

МАНЗШИР сам. mañjusīt; мө.б. manjusiri; "зөөлөн цогт"; Бурхны шашны дөрвөн их бодисаддын нэр; Манзшир эзэн (Манж Чин улсын хаан).

МАНИ сам. mañi; мө.б. mani; Эрдэнийн чулууны нэр.

МАНИН тө. ma ning; мө.б. manin; Бэлэг эрхтэн саармаг. Эр эм бэлэг хосолсон буюу эсвэл ээлжилж эр эм бэлэгтэй болох хоёр зүйл бий; *хорш. манин саармаг.*

МАНТУУ хя. mán tou; мө.б. mantau; Гурилаар эсгэж, жигнэж хийсэн нэг зүйл идээ.

МАНУ I сам. manu; мө.б. manu; "сэтгэл"; Ману хүн; Хүний төрлийн язгуур удам гэдэг Брахмагийн 14 хүүгийн нэг.

МАНУ II тө. ma ni; мө.б. manu; Цанхуйн язгуурын мөнх ногоон буюу заримдаг мөнх ногоон, асан ургах бут мод. Цэцэг анхимал, үнэс нь эмд орно.

МАНУУХАЙ сам. manushya; мө.б. manuuqai; "хүн"; 1. махчин амьтдаас сэргийлэх зорилгоор малын хотны захад босгосон шон модонд дээл хүрэм мэтийг нөмөргөсөн хүний дурс; 2. *шилж.* чадал овсгоо муутай, эрх мэдэл дульхан хүн; хүн биш мануухай.

МАНУХ тө. ma-ni hu; мө.б. maniqu/maniq-a; Улаан шар өнгийн мана. Бас янз бурийн өнгөтэй, хөөрөг зэрэг зүйл хийх, хатуу чанартай, хадан цагааны төрлийн чулуу, бас гон ч гэнэ.

МАНТАР сам. mantra; мө.б. mantar-a; "сэтгэлийг аврахуй"; Хамаг амьтны сэтгэлийг зовлон ба шалтгаан сэлтээс аварч үйлдэх нь, тарни ч гэдэг.

МАНХАГ тө. sman khug; мө.б. mangqaγ; "эмийн уут"; Эм хадгалах хунаистай таарцааг мэт сав, манх ч гэдэг; *Миний санаахад эрхмийн манхагтай эм дотор хүний ухаан мэдээг балартуулдаг эм бий болов уу (Б.Р.); манхаглах (манхагт хийх).*

МАНЧИН тө. sman chen; мө.б. mančin; Aconitum bajcalense Fürcz; "их эм"; Холтсон цэцгийн нам, болцуут үндэстэй, том хөх цэцэгтэй, 50-70 см өндөр олон наст өвслөг ургамал. Монголоор Байгалийн хорс ч гэдэг.

МАНШИЛ тө. man sel; мө. mansel; Гал болор буюу мэшил. Хамгийн сайн нь лавай лугаа адил, өнгө цагаан, өөрийн гэрлээс тэр даруй гал гаргах чадалтай гэдэг.

МАНЬ сам. mani; мө. mani (Ков.); Үнэт эрдэнийн чулуу, эрдэнэ; ногоон мань (маргад); манийн зул (нар).

МАПАМ тө. ma pham , ma phan, ma dros pa; "үл бүлээдэгч"; Анавад далайн нэрийн төвд орчуулга, нарны түяанд халж бүлээсдэггүй гэсэн утгатай, Кайлас уулын өлмийд орших хоёр жижиг нуурын нэг болно. Төвдчүүд mitsho ma pham (до мапам-мапам далай) гэж нэрлэх бөгөөд энэ нэр орчин цагийн хинди хэлнээ чоомаапана болон хувирсан буй; *Мапам их далайн дундах матар загасны ходоодоор хийсэн цавуу...* (MAA3).

МАРАЛ түр. maral (<хя. mou lou); мө. maral; Эм буга буюу согоо; гурван марал (одны нэр); марал цэцэг (нийлмэл цэцгийн язгуурын өвслөг ургамал. Шар өнгийн сагсархуу цэцэгтэй, навчны доод талд цайвар ногоон).

МАРВИН манж marbingga; мө. marbing; Нэг зүйл нутас шувуу, марвин нугас гэнэ.

МАРГАД сам. markaṭa; мө. maragad/marṭad; Устай шаазанд хийхэд ус нь нов ногоон болж харагдах тунгалаг ногоон өнгөтэйг нь хэлнэ. Үүнээс гадна улаан маргад, хөх маргад, сэргүүн маргад гэсэн гурван зүйл бий гэнэ. Эмд хэрэглэнэ. Алыг дарах зорилгоор гоёл чимэглэлд хэрэглэдэг гэсэн домогтой. Чулууны охь болох ногоон чулуу ч гэнэ.

МАРГАСАР сам. mṛigasīrṣa; мө. margasar/mergeśir; "гөрөөсний толгой"; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг болох гөрөөсний тэргүүн дурсгийн гурван одны цогцлол. Шулуун өнгө зөөлөн одон ч гэдэг; 2. Энэтхэгийн өвлүүн эхэн сар, цагийн хүрднээ намрын эцэс сар, хятад төвдийн хулгана сар, монголын 11-р сар; ...усан морин жил маргасар сарын арваны шөнө хулгана цагт мэндэлвэй. (Сув.эр).

МАРЗ тө. ma ḡi tshwa; мө. maṛja; Мал гөрөөсний идэж долоох марсаа, хужиртай газар; марзад суух (буга гөрөөс хужир мараанд ирэхийг отон суух).

МАРМАА: мармаа сугас; манж marma; мө. marm-a; Зарам загасны төрлийн хэндэл загастай адилавтар, улаавтар бидэртэй загас.

МАРМАН манж. marmān (хя. manman); мө. marmang; Хулгана биетэй, лаг мэлхийн толгойтой, нохойн дуутай нэг зүйл сонин амьтан, шөнийн гөрөөс ч гэдэг.

МАРТАН тө. dmar khra; мө. martan; "хөвөөт улаан"; Улаан дэвсгэрт нарийн зураасаар татсан хөрөг, зураг.

МАРУЗ тө. ma ḡi tsī; мө. maruci (Ков.); Эмийн нэр, марз.

МАРУТ сам. maruta; мө. maruda; Салхи шуурганы тэнгэр.

МАТАР сам. makara; мө. mātar; 1. эртний энэтхэгийн домогт гардгаар матар биетэй, заан тэргүүгэй, гөрөөсний эвэртэй далайн мангас. Хинд шашинд бол Варуна тэнгэрийн хөлөг хийгээд одны 12 ордын нэг болно. Бурхны шашин, түүнээс өмнө үеийн шашинд дээд зиндааны бурхад буюу матар толгойтой дүрслэгдсэн байдаг бараа бологод; 2. Дулаан оронд оршдог хэвлээр явагч том амьтан, усны мангас ч гэдэг; Матрын зам (дэлхийн халуун бүсийн өмнөд хэсгийн зааг, уртраг шугам); матарлах ("матар" нэртэй сэтгүүлд муугаар шүүмжлэн гаргахыг хэлж байжээ).

МАХААТМА сам. mahātmā; мө. mahatam-a; "агуу их сүнс"; 1. Хинду шашинтны домог үлгэр, шашин судлалд гардаг ертөнцийн сүнсний нэг; 2. орчин үеийн энэтхэгт агуу их нийгмийн зүтгэлтэн, онцгой хүндтэй хүний нэрийн өмнө хэрэглэдэг хүндэттэл үг.

МАХААЯНА сам. mahāyāna; мө. mahayān-a; "их хөлгөн"; Бүддийн гүн ухаан, ялангуяа хоосон чанарын ухааныг голлоой судалж, хамаг амьтны сайн сайхны тусын тулд мэддэг чаддаг бүхнээ зориулах тухай гүн ухааны нэг урсгал. Их хөлгөний зам "билигийн чанад хязгаарт хүрсэн хөлөг", "нууц тарнийн очирт хөлөг" гэсэн хоёр хэсэгт хуваагдана. Энэ хоёр нь дээд төрөлхтөнд багтана. Бүддийн гүн ухааны хамгийн дээд оргилд хүрэх арга зам нь хоосон чанарын ухааныг судалж мэдэхэд оршино гэдэг.

МАХАМУТАР сам. mahāmūtra; мө. mahamudr-a; Их мутар-Бурхны газраас харин үл няцах хоосон чанарыг оносон бэлгэ билгийг олохын нэр; *Махамутрын шидийг магад олох болтугай* (Д.Р.); төвдөөр чагжа чен по (phyag rgya chen po) гэх бөгөөд чаг нь хоосон бэлгэ билгийн чанар, жа нь орчлонгоос тонилохуй, чен-по нь дээрх хоёрын хамтдаа үйлдэл үзүүлэх утгыг илтгэнэ гэж тайлсан байdag.

МАХАРАЖА уй. maqarač; согд. my'g's<сам. mahārāja; мө. maqaraca; Махранз.

МАХАРАНЗ махранз.

МАХАСАДВА сам. mahāsattva; мөб. maqasadu-a; "их(баатар) сэтгэл"; Хамаг амьтныг гэтэлгэхийн тулд тэнсэлгүй бодил оршиноы нэр.

МАХБОД сам. mahābhūta; мөб. maqabod; "их үүсэл"; 1. материаллаг ертөнцийн таван үндсэн бүрэлдэхүүн буюу широо, ус, гал, хий, огторгуй болно. Гэвч эртний энэтхэгийн шарвак (материалист)-үүд огторгуйг хасаад ертөнцийг "дөрвөн их махбод" гэж ойлгож байжээ; 2. Түмэн бодсын бүтсэн эд; бие цогц; язгуур махбод (ердийн химийн аргаар үл задрах энгийн бодос); 3. амьд бодсын биеийн цогц; бие махбод (харилцан зохицон хөдөлж ажиллах эрхтэн бүхий амьтан буюу ургамал).

МАХГАЛ сам. mahākāla; мөб. maqagala; "их хар"; Ухлийн эзэн буюу Махгал бурхан. Гурван толгой, зургаан мутгартай их ид хүчтэй сахиулс.

МАХЕШВАРИ сам. Mahesvari; мөб. mahisvari, makisvari; "их баялаг эрхт"; Ертөнцийг бүтээсэн тэнгэр гэж домогт гардаг. Махашуварий ч гэдэг; *Махашувари тэнгэрээс болсон магад төгс цогт галын хаан* (Зуун бил.).

МАХИ тө. ma he (< сам. mahisa); мөб. maki; Bulalus arneph; Ухрийн язгуурын амьтан, усны үхэр ч гэнэ. Толгой хайнагийн толгойтой адил, бие үнсэн саарал өнгөтэй; *Матар гарди хошуутан, махи үхэр толгойтон* (12 зох.).

МАХОРАГИ тө. ma ho ra ge (< сам. mahorage); мөб. maqoragi (МГО); Хэвлээр явагч газар орны эзэд, лусын нэр.

МАХРАНЗ сам. mahāraja; мөб. maqaraṇja; "их хаан"; Тэнгэрийн дөрвөн хаалга буюу ертөнцийн дөрвөн зүгийг сахигч сахиулсныг дөрвөн махранз гэдэг. Шашны ёсны үйл сахигч их хаад болох Вирудхака нь өмнө зүгийг, Вирупакша нь өрнө зүгийг, Вайшрааван нь умар зүгийг, Дхритараштра нь дорно зүгийг тус тус сахигч гэнэ. Дандрин мөргөл ёслолд урьдаас зориулсан мандлын төвд, язгуурын таван бурхны нэг-Бяруузана буюу түүнийг төлөөлөх бурхныг байрлуулж түүний дөрвөн зүгийн сахиулс болгож Амгаасэд (умар), Раднаасамбхав (өмнө), Акшобхья (дорно), Аминдаваа (өрнө) бурхныг бас залсныг хэлнэ.

МАХУА хинд. mahuā; мөб. mahu-a; Bassia Latifolia мод; Цэцгийг нь дарс хийхэд болон хоол хүнсэнд хэрэглэдэг. Үр жимснээс нь тос гарган авдаг халуун орны мод; *Цэцэглэсэн махуа мод нойрсож байна* (ГМА).

МАЦАГ сам. upavasatha; мөб. masay; Зургаан бармидын дөтүгээрх болох шагшаабадын дүрэм ёсоор сар бүрийн найман, арван таван, гучинд мах идэхгүй, үдээс хойш идээ идэхийг цээрлэх санваар. Нүүнээ сахих ч гэдэг; мацаг барих (мах идэхгүй өнжих санваар сахих); мацаглах (мацаг барих); мацагтай (мах иддэггүй хүн).

МАЧИН БОМРА тө. gma chen 'bom ra; "хатан голын эхэн"; Хатан голын эхэнд байдаг алдарт уул, тахиж шүтэж байжээ. Монголчууд нутаг усныхаа зарим алдарт уулыг энэ уулын нэрээр нэрлэж байсан нь бий; ...*Тэр бол мөсөн уул Мачин Бомра хаан уул биш үү* (ГЭс.).

МАШАГ сам. maśaka; мөб. masaga; Эртний энэтхэг жин хэмжүүрийн нэр.

МАШУУ тө. ma shu ba; мөб. masīu; "үл шингээхүй"; Хоол хэтэрснээс шингээхгүй болж дотор гэдэс өвдөх өвчин; машуудах (хоол хэтэрснээс хodoод эвгүйцэх); машуутах (машуу өвчин тохиох).

МАЯРАА сам. mayurā; мөб. mayar-a/mayuuri; (хя.moyuло); тө. gma ūya; Тогосыг бурхны номд нэрлэх нэр. Энэхдэгчүүд Эгшигт охин тэнгэрийн уналга, хайр сэтгэлийн билэг тэмдэг гэнэ. Бас могойг даран сөнөөдгөөр нь эрдэм ухааны билэг тэмдэг ч болгодог. Тогосын тайлбарыг узмүү.

МАЯГ I тө. ma yig; мөб. mayu; "эх үсэг"; 1. аливаа юмны эх, үлгэр, загвар, хэлбэр, дүрс; *хорш*. үлгэр маяг, загвар маяг, хэлбэр маяг, дурс маяг; арга маяг (арга хэлбэр); 2. гажуу зөрүү ааш авир; маяг гаргах; 3. яршиг төвөг буюу муу ааш авир; маяггүй (а. жигтэйхэн их; б. аяг ааш нь олдохгүй); маяглах (а. маяг загвары нь буулах; б. зөрүү зан ааш гаргах; в. юманд маяг оруулах); маягт (маяг бүхий; хүснэг); маягтай (маяг загвартай; ааш араншин муутай).

МАЯГ II тө. smad gyogs; мөб. mayu; мадиг; Лам нарын доод биеэр өмсдөг бансал маягийн хувцас.

МИЕГНЭХ манж. meyen; мөб. miyegnekü; "ангি, бүлэг"; ...хахуун тэхүүн өвөгчүүд нь хань ханиндаа миегнэж... (Зуун бил.).

МИЙ хя. mao; мөб. mii; 1. муурын дуугарах дуун ба муурыг дуудах аялга; 2. муурын өрөнхий нэр.

МИМААНС сам. mimānsa; мөб. mimansa; Энэтхэгийн түн ухааны тууштай системийн нэг, нийгэм шашны үүрэг болох дхармаг хэлбэрэлтгүй сахин, кастаар цээрлэсэн зүйл, зан үйлийг

биелүүлэхэд голлон анхаарах ёстой гэж үзнэ. Дхармыг мөрдсөнөөр бодгаль хүний хүсэл эрмэлзлэлээс шалтгаалахгүйгээр бүрэн ангижирч болно.

МИН: мин царцаахай, мин эрвээхэй; хя. ming; мөб. ming; Тариа төмсний хортон шавьж. Мин царцаахай томорсноор мин эрвээхийй болдог.

МИНЖИН I тө. ming can; мөб. mingjin; "нэр(нэг)-т"; Талийгаачийн дурийг орлуулан цаасан дээр барласан дурс, хөдөөлүүлэх үед нь хэрэглэнэ.

МИНЖИННАГВА тө. ming can nag po; мөб. minjin nagba; "хар нэрт" = lug mig nag po ("хар хонины нүд"), Pyrethrum altaicum (Herd) O.ei B.Fedtsch. Нийлмэл баг цэцгийн язгуурын олон наст өвслөг ургамал. Эмийн сударт тахал ба хорыг анагаанаа гэж гардаг. Алтайн шиваантиг ч гэдэг.

МИНЖИНСЭРВЭ тө. ming can gser po; мөб. minjin serbe; "шар нэрт"; Jnula britanica L; 15-20 см өндөр шулуун шилбэтэй баг цэцгэгтний бүлийн олон наст өвслөг ургамал, түүний цэцэг. Навч нь хоёр талдаа иртэй, цэцэг нь шар өнгөтэй, эмнэлэгт хэрэглэнэ. Одоогийн нэр томъёоны толь бичигт "Британы зоосон цэцэг" гэж нэрлэсэн нь үзэгдэнэ.

МИНТҮГ тө. mi 'khrugs ra; мөб. mingtug; сам. Aksobhya; 1. Акишиби бурхан; 2. дүнчүүрээс дээш таван оронтооны нэр, минчог ч гэнэ.

МИНЧҮҮ хя. mián chóu; мөб. mincii; Нэг зүйл торгомсог бараа, мяңчуу ч гэнэ.

МИРАЖА тө. me+ra'dza; мөб. mirađa/miranđa; Мянранз; галайхан; Түмэн улаан адту бий. Тэр дотор миража мэт улаан морь бий (Гэс.).

МИС тө. mi se'u; мөб. mise; Бөөрөнхий хэлбэртэй, нарийттархан, гашуун амтат нэг зүйл жимс.

МИСИР ўй. Misir<араб. Misr// тө. mi-ser; мөб. misir; Эртний Египетийн нийслэл.

МИХИР: михир сар тө. mi ki ri (<сам.); мөб. mikiri; Энэтхэгийн есдүгээр сарын нэр. Ашууваний сар.

МОВЬ манж. muwi; мөб. mobi; Өндөр иштэй модны шавдлын навчтай адил навчтай, хавар цэцэглэдэг цагаан буюу улаан хүрэн өнгөтэй анхилам үнэрт хонхон цэцэг.

МОЛЦОГ түр. bıncıık/bıncıaq>(ор.бунчук); мөб. molčuū ~tončuū; "морины хөмөлдрөгт зүүсэн цааг чимэг"; 1. хазаарын

хөмөлдрөг,сагалдрагт унжуулсан улаан өнгийн цааг"; 2. зарим хонь, ямаа, гөрөөс, тэргүүтний хүзүүнд унжсан гозгор бөөрөнхий зүйл; 3. шувууны толгойн чандар; молцоглох (юмнаас молцог мэт зүүгдэн тогтох); молцог элс (хэсэг хэсгээр төвийн тогтсон элсэн бөөм; хожуу үед газрын нэр болон шилжсэн).

МОМИН номин; мөб. momin.

МОНА: Мона уул сам. tuni; мөб. ton-a; "богд, арши"; Өвөрモンголын Хөх хот, Бугатын араар үргэлжилсэн урт уул нуруу, Мона хан, Монан хан, Мони уул гэхчлэн нэрлэдэг, Энэ нь Богд уул гэсэн утгатай; Эзэн Богд Мона хошуут үзээд зарлиг болдуун... (А.то).

МОНДИ тө. mo 'dre; мөб. mongdi; 1. эм зэтгэр, золиг, хөлчин чөтгөр; муу монди ; 2. муу этгээд, танхай; Мондийн гэмин бүгж тайж мэднэ гэж хаширласан ч юм уу (Б.Я); 3. хараалын үг; монди монди!

МОНШ(ИН) тө. rmongs zhin; мөб. mongsin; Мунхаг, ухаан муутай, тэнэг манггуу.

МӨӨГ хя. mb gu; мөб. mögü; Ой шугуй буюу хөвдөрхөг газар ургах бактерийн төрлийн ургамал, заримыг хүнсэнд хэрэглэнэ.

МӨХРҮҮ манж. muhuru; мөб. mökerü; Гам загасны эм.

МУЖААН хя. mū-jiang; мөб. mujiyang; Модны дархан, модоч.

МУЛУЙ тө. mu la (<хя.); мөб. mishi; Нэг зүйл жимс.

МУНАГ тө. mun nag; мөб. tupaγ; "хав харанхуй"; 1. зөнөг; зөнөг мунааг; 2. буруу гажуу өтөлсөн нь; Мунагууд нь мухар өөд, муунгууд нь над өөд харцгаав (MAY); мунаглах (а. зөнөглөх; б. буруу өтлөх); мунах (зөнөх, нас доройтох); мунагтах (зөнөг байдал гаргах).

МУНД сам. munda; мөб. munda (Ков.); Уяман, нойтон хамуу, хүчгэнэ, мундас ч гэнэ. Бөгс орчинд хэсэг газарт бөөгнөрөн гарах хатиг.

МУНИ сам. muñi; мөб. tuni; 1. даяанч, гэгээнтэн, мэргэн; 2. чадагч; Шагжмуни (Шагжийн чадагч).

МУНХРАХ тө. rmongs pa; мөб. mungqaraqu; "тэнэг, мунхаг"; Ухаан дордож муудах; мунхартлаа согтох.

МУТАР сам. mudrā; мөб. mutur; "тэмдэг"; Гарын хүндэтгэл; Мутрын адис хүртэх улс уу (Б.Р.); Махамутар (их мутар), тангарагийн мутар, номын мутар, үйлсийн мутар гэж дөрвөн зүйл бий; мутарлах (а. гараар барих хүндэтгэл; б. гарын үсэг зурахын хүндэтгэл).

МУУР хя. māo; мо.б. mūg-a; Мийн язгуурын сүүн тэжээлт, тэжээмэл мийг гэдэг амьтны эр.

МУУТУУ хя. mī tī, māo tai (māotōuzhi); мо.б. mī tī-mūtū; Бийрээр бичихэд тохиромжтой нэг зүйлийн зөвлөвтөр үслэг цаас.

МҮТЭД тө. smug rdo; мо.б. mügđe; "хүрэн чулуу"; Зосон будаг.

МҮГЭЗ тө. smug rtsi; мо.б. mügđe; "бор шар, улбар шар"; Улаан давирхай буюу шүүс. Улаан будаг гардаг ямар нэг ургамал; энгэсэг. Жив чулуу ч гэнэ.

МҮҮ хя. mī; мо.б. mī; Тарианы газрын хэмжээ. Нэг мүү газар нь өргөн гурван хос, урт арван найман хос алд (нэг га газрын арван зургааны нэг); мүү царцаа (тарианы үр иддэг хорхой).

МҮҮЛ сам. mīla; мо.б. mul; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монгол нэр нь Хан хүмүүн төрж үхэх одон. Бас Онгоц одон ч гэнэ. Мул, мол гэхчлэнгээр ч бичдэг.

МЭГ сам. magħa; мо.б. mig; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг, дайсны од ч гэнэ. Мөн Албины цалмаар хүлэх од буюу Их морь ч гэдэг. Энэ нь зургаан од байх ба дүр нь хушуу мэт; 2. Энэтхэгийн өвлийн адаг сар, цагийн хүрднээ өвлийн дунд сар, хятад, төвдийн хаврын эхэн барс сар, монголоор хувь сар гэнэ. Мэг ч гэж бичдэг.

МЭГЖ хя. mīzhī; мо.б. megħi; Дөрвөн наснаас дээших эм гахай.

МЭГЗЭМ тө. dmigs brtsem; мо.б. migjēm-megzem; Уул нь Зонховын магтаал шүлэг; монголоор "алдарт магтаал" гэнэ. Уншлага, тарни.

МЭЙРЭН манж. meiġen; мо.б. meiġen; "мөр"; 1. Манж чин улсын үеийн хошууны ноёдын гутгаар зэрэг, захирагчийн хавсралч; 2. хошууны цэргийн захирагч; хошууны тамгын газрын бичиг хэрэг эрхэлдэг албан тушаалтан. Мээрэн ч гэж бичдэг.

МЭЛИГ түр. malik; мо.б. melig; Улсын эзэн, ван ноён.

МЭЛИЦЦА сам. mleccha (тө. kla klo); мо.б. melicca/melizza (Ков.); Бүдүүлэг, зэрлэг, тэрсууд.

МЭРГЭШИР маргасар.

МЭЧИД сам. tecida; мо.б. tečid; 1. хорин найман одны нэг; 2. од гэсэн үтгэй хоршин одод гэсэн утга илтэнэ.

МЭШИЛ тө. me sel; мо.б. mesil; "галт шил" (=сам. suryakāntamani "наран чулуу, наран болор"); Тунгалаг цагаан өнгөтэй, гар хүрэхэд хүйтэн атлаа нарны гэрэлд барихад гол гаргах чадалтай шил. Бас хараа зүйд хэрэглэдэг хоттор буюу

гүдгэр гадаргатай шил буюу тунгалаг эдийг хэлнэ. Мишил ч гэдэг. ...алсаас татах мишил шиг санагдана (**МШЯН**).

МЯГМАН I тө. mig mangs; мо.б. migman; Гурван зуун жаран ширхэг, хоёр өнгийн юмаар тусгай хөлөгт өрж хоёр хүн харилцан хаалцаж наадаа тоглоом.

МЯГМАН II тө. mig sman; мо.б. migman; "нүдний эм"; = хар өнгө; Хар чулуу, расияр чулууны нэр. Гялалзсан хар өнгөтэй, харыг нь хагалбаас зуун зүү зэрэгцүүлсэн юм шиг гэрэл сацардаг, харын хэмжээ нь бурхны тэргүүний үснир мэт гэж эмийн сударт гардаг. Ясны хим барилдуулах увдистай гэдэг.

МЯГМАР тө. mig dmar; мо.б. mīumāg; "улаан нүдэн"; (сам. angāraka, mangala); 1. долоо хоногийн хоёрдугаар өдөр; 2. нарны аймгийн нэг ертөнц болох марс.

МЯДАГБАДАМ тө. me tog padma; мо.б. midaybadm-a; "Бадам цэцэг"; Дулаан оронд ургадаг өргөст харганын иштэй, цагаан ягаан хоёр өнгөтэй сэнгэнэм үнэрт цэцэг; ...мядагбадмын сэнгэнэм сайхан үнэр анхилахад...миний нутаг ийм л сайхан гэж бардамнан сайрхах мэт(З.Б.).

МЯНДАГ тө. ming 'dogs; мо.б. minday; "нэр алдар хүртээх"; 1. бурхны шашны ёсны эрдмийн цол ба зэрэг тушаал; гавж мяндаг; 2. **шилж**. ямба явар; мяндагтан (шашин гүн ухааны сургууль төгсгөж нэрд гарсан эрдэмтэд, тушаалтан буюу шашин номын нийт боловсролыг улам дээшилгүүлэх үүрэг бүхий хариуцлагатан).

МЯНТУУЗ хя. miān tiāo zi; мо.б. mintuuža; Зуурсан гурилыг элдэж нимгэлэн нарийн хэрчиж хийсэн хоол.

МЯРАНЗ мираж; Галайхан, галын тэнгэр; *Хатуут зөвлөтгөч галын хан мяранз...*(Зуун бил.).

МЯО I хя. miau; мо.б. mīuo; Хуучин цагт сүм дуганыг нэрлэж байсан нэр.

МЯО II хя. miau; мо.б. mīuo; Арван мүү хэмжээтэй газар.

H

НААГ сам. nāga; мо.б. naga; нага.

НАВДАГ тө. gnas bdag; мо.б. nabday; "орны эзэн"; Газар усны онгон сахиулсан; уул усны навдаг савдаг.

НАВС тө. gnab bza'; мо.б. nabsa; "өмсгөл"; 1. бүмбаны өмсгөл; 2. хувцасны хүндэтгэл; бурхны навс; навс мөргөл (аргын тооллын хориод оны үес үзэмчин ван Сономравдан Богдын

хүрээнд ирэхдээ Далай ламтай учирч их хэмжээний өргөл барьц өгсөнд Далай лам ном тавьж, адис хүртээн өөрийн хуучин ханцуйгүй шар дээлээ хариу болгон барьжээ. Энэ номт дээлийг нь Вангай сүмд залж жил бүрийн билгийн улирлын шинийн хоёрт Манж Дайчин улсын журган яамнаа нэрс данстай зургаан их хийд сүмийн нэртэй лам нарыг урин залж их хурал хуруулдаг байжээ. Олон мөргөлчид тэр навс дээлэнд мөргөдгөөс навс мөргөл гэх болжээ. Тэр үеэр мянган цагаан морьтны дадлага авдаг байв; навсгар (шилж энд тэндээ унжиж навсарсан юм, элбэг хэлхгэр хувцас); навсанах (дэмий дагаж хоргоох).

НАГ тө. *nag*; мө.б. *nay*; "хар, бараан"; **нагийн хар** дуунаараа **хаширалдаад...**(Ц.Ч.)

НАГА I сам. *nāga*; мө.б. *naga*; Нүүр цөөрөм гол мөрөн, газар доорхи ертөнцөд амьдардаг, могой хүн хэлбэрээр төсөөлөгддөг домгийн амьтан. Бас лус гэдэг хүмүн бусын амьтан. Нагаража=нагаранз (лусын хаан).

НАГА II: *naga* цэцэг; сам. *naga*; мө.б. *naga*; цагаан өнгөтэй, зургаан хэлтэстэй, шар тууцигтай, навчгүй нэг зүйл цэцэг.

НАГАБУСБА сам. *nāgaruṣṭra*; мө.б. *nagabuśva*; "лусын цэцэг"; *Mesua Roxburghii*; Агуусвааг үз.

НАГАР I: *nagar* үсэг; сам. (*deva*)*nāgarī*; мө.б. (*deva*)*nagar*; (тэнгэрийн) үсэг; Эртний энэтхэг үсэг, дэванагар ч гэдэг. МЭӨ УШ зууны үед бий болсон гэж үсэг зүйч нар үздэг. Самгарди, хинди, маратхи зэрэг энэтхэгийн олон хэлнээ хэрэглэдэг цагаан толгой.

НАГАР II сам. *nagara*; мө.б. *nagar*, *nagīr*; хот (Ков.).

НАГАРАЖА сам. *nāgarāja*; мө.б. *naga gaṛa*; Лусын хаан.

НАГБАМ тө. *snag būm*; мө.б. *naybūm*, *naybām*; Бэхийн сав.

НАГВАН нагбам; мө.б. *naybūn*.

НАГЧАДАР нагшадар; мө.б. *naγčadar*.

НАГШАДАР сам. *nakṣatra*; мө.б. *nagsadīr~nagsadar*; "одны эзэн"; Сарны зурхайн хорин найман одны нэр; **Хорин найман нагшадар хийгээд гучин түмэн голди тоотон одноор тахиулагч буюу чи.** (Зуун бил.).

НАЖИД тө. *nad byed*; мө.б. *najīd*; "өвчин үүтгэгч"; Зовлон бэрхшээл; **наждид** болох; **наждидлах** (зовлон зүдгүүр учруулах, зовоох).

НАЙДАНЖУДЭГ тө. *gnas brtan bṣu drug*; мө.б. *nayidanjüdög*; "арван зургаан батдахуй"; Бурхны шашныг сахина гэж ам авч

сэтгэлийн муу дайснаа дарахаар бясалгал хийсэн 16 архадын нэр; **Найман Намсрай шиг баян**, **Найданжуудэг шиг өнөр.** (Зүйр).

НАЙМАА мө.б. *nayimai*; 1. маймаа; **наймаачин** (худалдаа хийдэг хүн); **наймаалах** (арилжаа хийх); 2. хуучин цагт дотор газрын хүнийг нэрлэж байсан нэр.

НАЙРАНЖА: Найранжа мөрөн; үз . **Няранзана мөрөн** сам. *Nairanjana*. Магадха орны нэгэн гол.

НАЛ перс. *lāl* (хинд. *lāl*); "улаан"; сам. *nīla*; "хөх"; тө. *nal*; мө.б. *nal*; Улаан өнгийн эрдэнийн чулуу, бадмаараг ч гэнэ. Зарим толь бичигт, өнгө улаан хүрэвтэр буюу, улбар хүрэн бөгөөд тунгалааг лавай дээр тавихаас лавайд галын өнгөтэй гэрэл тусна гэжээ. Ал, гал зэрэг үгтэй утга гарлын холбоотой; **Ал нал алтан чимэг..**

НАЛАНДА сам. *nālānda*; мө.б. *nalanda*; Энэтхэгийн Патна хотоос зүүн зүгт 2 өртөө, төмөр замын Нааландаа өртөөнөөс 1,5 бээр зйтгэлтэй газарт байсан эртний энэтхэгийн Магадха улсад байсан алдарт хийд, сургууль, Нааландын их сургууль МЭ У-ХП зууны хооронд Азийн шилдэг том сургууль байв. Энэ сургуулийн 1000 азарын дотроос судар шастирын ухаанд мэргэжсэн 100, гuchaад төрлийн ухаанд мэргэжсэн 500, тавиад ухааныг судалсан 20 хүн байжээ. Эдний туурвисан 150 орчим зохиол монгол шүнхэн Данжурын 17 ботийг эзэлдэг. Хятад, төвд, солонгос, япон, монгол, бухаараас оюутнууд суралцдаг байсан гэдэг. Тус бүр нь долоон давхар Раднаасаагар (Эрдэнийн далай), Раднааранжак, есөн давхар Раднаададхи (Эрдэнийн өглөг) хэмээх 3 том номын сантай байжээ. 1303 онд лалынхан галдан шатаажээ. Бурхан багшийн зарлиг айлтгал, тайлбарууд ихэнх нь үрэгдэж, үлдсэнийг нь эмхэлснээр Ганжуур хэмээх 108 боть, Данжуур хэмээх 225 боть болсон ажээ. Монгол, төвдөөр энэ нэрийг Наланда, Наландар, Налендра, Наленда, Нарендра, Налиндар, Налада гэж олон янзаар бичсээр иржээ. Зүй нь Наланда гэвэл зохино. Төвдөөр бас *nalada* "үргэлжид өгөгч" гэж ч орчуулдаг. Гэвч нала нь төвдөөр "зэгс", да нь "өгөх" гэсэн утгатай. Эхний үгэнд м дагавар залгаж түүний дор да-г холбосноор м нь н болж нааланда болсон. (юм бичих) "Зэгс өгөх" гэсэн утгатай хэмээн Зонховын Ламримын тайлбарт дурджеэ.

НАЛИНА сам. *nalina*; мө.б. *nalin-a*; *Nelumbium Speciosum*; Самгарди яруу найрагт олонтаа гардаг үзэсгэлэнт цэцэг.

НАЛИНДАР тө. *na-len-dra*; <сам. *nālānda*; Налендра, Наландаг үз.

НАЛИШАМ тө. na le sám (сам. nalisam); мө. b. nalisam; Mesua roxburghii; 1. анхилуун үнэрт цэцэгтэй намхан мод, түүний цэцэг; 2. Piper nigrum; хар чинжүү.

НАМААЗ перс. namāz; Лалын шашинтан хүний өдөр бүр үйлдэх таван удаагийн мөргөл.

НАМИНЧЛАХ сам. namaste; мө. b. namān(čilaqu); "шүтэх"; 1. бие, хэл, сэтгэл гурваараа бишрэл хүндэтгэлээ илэрхийлж, толгой бөхийн, алга хавсан хоргүй сэтгэлээ илтгэн залбирах нь; 2. аливаа муу үйлдэлдээ гэмшин учлал эрэх нь; нүглээ наминчлах.

НАМБАА намба; мө. b. nambay-a.

НАМБААНАЦААГ тө. gnām pa snatshogs; мө. b. nambayaṇasū; "элдэв зүйл"; Элдэв янзын юм; намбаанацгийн юм ярих.

НАМБА тө. gnām pa; мө. b. nambā; "дүр"; 1. байдал төлөвөөр төв ихэмсэг, түвшин аятай; Нас намбы нь бодоход над шиг охинтой баймаар юм. (Д.П.); 2. шилж дүр төрх, гадаад байдал нь төв үзэмжтэй.

НАМГАР тө. gnām dkar; мө. b. nambār; "машид цагаан"; Цагаан өнгөтэй хадгийн нэр; Намгар хадгийг барьж намайг ерөө гэж хайлласан юм бизээ. (ЗУАЗ).

НАМДАГ I: намдаг сан; тө. gnām dag; мө. b. namday; "тийн (ариун) ариутгал"; Шарын шашны их сангийн нэг, замбуутивийн ердийн их үндсэн сан ч гэж нэрлэдэг. Уул овоо тахих, сүлд хийморь сэргээх, бурхан шүтээн болон гол тахих, хурим найр хийх, үхээрийн бузар арилгах зэрэгт уншихийн нийтэд алдаршсан сан; Найрын хийморийг мандуулна гэж намдаг сан талбиулав. (Гам.).

НАМДАГ II намдог.

НАМДОГ тө. gnām rtog; мө. b. namdoγ; "асар аттаг"; хардал сэрдэл, сэжиг эргэлзээ, дамжиг, тээнэгэлзэл; юманд битгүү тааварлан хардах; Сэцэн мэргэн хэрэгтүй цаг, сэжиг намдог хэрэгтэй цаг (МАЗЧ-I).

НАМЖАР тө. snam spyag; мө. b. namjāg; Лам нар хурал хурах, ном унших зэрэгт өмсдөг тоо тогтоол бүхий хэсэг бөсөөр зүйж ёёсон шар хүрэм буюу карша дээл. Бас бурхны шашны гэлэн хүний орхимж мэт нөмрөх нэгэн зүйл давхац хувцсыг хэлнэ.

НАМЖИЛ: намжил арур; тө. gnām rgyal a-ti-ra; мө. b. namjāl; "тийн ялгуусан арура"; Оточ Манла бурхны мутарт байдаг ар үр; Намжил ар үр сайн боловч орходой мэт нь бус. (Д.Р.).

НАМЖИР тө. gnām 'byug; мө. b. namjōg; Ихэмсэг зан авир байдал; намжиртай харах; намжирдах (ихэмсэг сүр дүр үзүүлсэн зан байдал гаргах; нүд ширэвхийлгэн зангах); намжиртай (намжир ихтэй, маяг даягтай).

НАМНАН тө. gnām snang; мө. b. namnang; "сайн гэрэл" Булган аймгийн Хутаг-Өндөр сумын төвөөс баруун тийш 15 км зайдай орших уулын нэр; Намнангийн хүрээ (энэ уулын өвөрт байсан хүрээ).

НАНХИАД хя. nan jiā; мө. b. nankiyad; Өмнөд Сүн улсыг эрт цагт нангтиасаа буюу нангтиас гэж байснаас ингэж нэрлэх болжээ.

НАМО сам. namo; мө. b. namo; Наманчлан мөргөх; намо гүрү (их лам багшид мөргөе); Намо Буддая, Намо Дхармая, Намо Сангхая (төвд, монгол судрын эхэнд байдал Бурханд мөргөе, номд мөргөе, Хуврагт мөргөе гэсэн үг. Өөрөөр хэлбэл Бурхан багш, түүний сургаал, хуврагуудад залбиран мөргөе гэсэн самгарди хэллэг. Гурван эрдэнэ ч гэдэг.

НАМСРАЙ тө. gnām thos sras; мө. b. namsarai; "асар сонсогчийн хөвгүүн"; Умар зүгт оршдог, орчлон өртөнцийг баяжуулагч тэнгэр. Монголчууд Бясман тэнгэр ч гэдэг. Энэтхэгээр Кубера буюу манайхны дуудлагаар Гүвираа болно. Монголчуудын дунд арван хангай гэж алдаршсан догшин сахиусны нэг. Намсрайн бисийг алтан шар өнгөөр дүрсэлдэг. Баруун мугартай дааз, зуун мугартай эрдэнээр бөөлжсөн хулганатай. Хэвтэж буй арслан дээр хагас завилан суусан байдаг. Намсрай сахиусыг элбэг баян амьдралын билэг тэмдэг болгон биширдэг.

НАМТАР тө. gnām bar tha=rnam thar; мө. b. namtar; "тийн тонилох, бүрмөсөн тонилхуй"; 1. Дээд төрөлхтөн хэмээх хутагт хувилгаад нарын амьдралыг орчлонгоос чөлөөлөгдөн ангижрах зам мөн гэж тэд амьдралын түүхийг ингэж нэрлэжээ. Өөрөөр хэлбэл, бурхан бодисад нарын сансар өртөнцөд төрөөд бодь хутгийг олж сансраас бүрмөсөн тонилж нярваанд орших хүртэлх явдлыг үзүүлсэн зохиол, намтар тэнэ насны үйл явдлыг өгүүлдэг. "12 зохионгуйн үйлс" гэдэг зохиол нь Бурхны 12 үйл явдлыг онцлон өгүүлсэн намтар болно; 2. шилж төвд, монголд энэ үгийн утга өргөжиж хүн, юм үзэгдлийн амьдрал ахуйн товч түүх, олон нийтийн зүтгэлтэн, алдарт хүмүүсийн үйл явдлыг нэрлэх болсон; хорш түүх намтар; намтраа дуудуулах (муу үйл хийж явснаа

сөхүүлж тоочуулах); 3. аливаа зохиол, тууж; "Саран хөхөөний намтар".

НАНДИН тө. nang brten (харьц.сам. nandin; "баяр хөөр"); м.б. nandin/nangdin; "дотоод шүтээн"; 1. үнэтэй, олдошигүй ховор чухаг зүйл; **хорш** нандин жиндэн; 2. эрхэм, ариун, дархан; нандик сэтгэл.

НАНЖВАНДАН тө. gnam b'eu dbang ldan; м.б. nanopjivangdan; 1. нууц тарнийн хөлгөний дотор гардаг долоон самгарди үсэг ба гурван зураг дүрсээр бүтсэн арван зүйл утга илэрхийлсэн томъёолол; 2. гол төлөв оршуулгын ёслолд хэрэглэдэг нар, сар, үсэг бүхий нэгэн зүйл хадаг.

НАНЖИН хя. nān jīng; м.б. nanopjip; Нандин, гоёмсог, гангтан, хээнцэр, сайхан; **нанжин** чавга (нэг зүйл сайхан чавга); **нанжин гахай гөлөм** (нэг зүйл хээнцэр хийцийн гөлөм); Хуучин цагт Хятадын Нанжин хотоос ирдэг байснаар нь уг хотын нэрээр тодотгон нэрийдсэн бололтой.

НАНЗАД: нанзад хадаг тө. snang mdzad; м.б. nangjad; "дотоод сангийн" хадаг.

НАНЧИД тө. nang mchod; м.б. nangčid/nangčod; Архины хүндэтгэл, эрт үед өргөл цацлын архийг нэрлэж байжээ.

НАНШИД нанчид (ч~ш).

НАРГИЛ сам. narikela; м.б. nargil; Халуун оронд ургадаг өдлөг навчтай өндөр мод. Үр жимснээс нь тос, самар гардаг.

НАРТАН тө. snar-thang; м.б. nartan; Төвдийн Дашихүмбэ хийдээс баруун хойт зүгт бээрийн цаана усан тахиа жил (1153 он)-д анх байгуулагдсан Гаадамбын чиглэлийнхний алдарт хийд Дайчин улсын үед төвд "Ганжур", "Данжур"-ын модон барын хэвийг энэ хийдэд барласан нь машид алдаршсан түүхтэй.

НАУРЫЗ каз. наурыз (<перс. navaroza); "шинэ өдөр"; Хижрийн тоолол, лалын шашинтны шинэ жилийн баяр.

НАЦАГ тө. sna tsogs; м.б. naṣiū; "элдэв"; 1. зүйл зүйлийн, янз янзын элдэв; ...*Нацаг зандан домбонд нь шуутээд тавьдаг нь энэ* (АЗА).

НАЦАГДОРЖ тө. sna tshogs rdo ḥje; м.б. naṣiūdorjī; "элдэв очир"; (сам. visvavajra); 1. язгуурын таван бурхны тавдугаарх нь болох Амгаасэд буюу Дондовын гарг байдаг эрхин үйлс хүчиний билэгдэл болгон зөрүүлсэн очир; 2. юм хумыг чимэглэж зурах, будах, сийлэх мэтээр гаргасан хээ; **нацагдорж** хээ; **нацагдоржтой**

зодог (зөрүүлсэн очир оёж хатгасан буюу хеёж, урлаж чимсэн зодог, очиртой зодог ч гэнэ).

НАЯАГРОДА сам. nyāgrodha; м.б. nayagrodha; Ficus religiosa; Модны хажуу тийш сунасан мөчрийн урт нь уг модны өндрөөш ургасантай тэнцүү байдаг нэг зүйл энэтхэг инжир мод; **Энэ наяаградхада** модон миний цагт надын чинээ бөлгөө (Раш.дус).

НАЯД сам. nauya; м.б. nayad; Тооны нэр. бүм.

НИЛ сам. nīla; м.б. nil; "хөх, цэнхэр"; Индранил гэдэг угийн өнцөг; нил эрдэнэ, нил хөх.

НИМБЭГ сам. nimbuка; м.б. nimbege; Мөнх ногоон модонд ургадаг анхилам үнэртэй, хатуу хальстай жимс; **нимбэгийн хучил**.

НИН ШОШ тө. snying zho'sa; м.б. ning šoša; "зүрхэн буурцаг"; Prunus sp; Халуун оронд ургадаг, иш том, навч зузаан, цэцэг цагаан, жимсийн яс нь зүрхэн хэлбэртэй, үр нь хортой ургамал. Эмнэлэгт хэрэглэнэ. Жимсийг лис, чавга ч гэнэ. Зарим тольд (С.Р) зэрлэг чавга гээд модны жимс өнгө улаавтар, цөмөө бөөрөнхий, амт нь хүчтэй, цэцэг шаравтархан ногоовор гэж тодорхойлжээ.

НИНЖ тө. snying ḥje; м.б. ningjī; "энэрэх, нигүүлсэх"; өршөөнгүй, нигүүлсэнгүй; Орчин цагийн монгол хэлнээ нинжин гэж буруугаар бичиж заншчээ. Угтаа бол нинжийн (сэтгэл) гэх нь зөв.

НИРВААН сам. nirvāna; м.б. nirvan; "гаслангаас нөгчигсөн, гэтлэх, тонилох"; 1. орчлон гэдэг хүлээнээс ангижрах буюу хутагтын дөрвөн үнэний гурав дахь зовлонгоос тонилох. Нисванисын үндсийг тасалж, орчлонд дахин шинээр төрөл олохыг хааж, урьдын муу авьяасыг гэргээхгүй бол зовлонгоос ангижирна гэж үзнэ. Бага хөлгөний ёсоор бол үхэх, өөд болох, мөхөхийг хэлнэ. Их хөлгөний үзээр бол хувилгаан бие нь нирваанд нөгчсөн гэнэ. Бурхны номын бие хийгээд төгс жаргалангийн бие нирваанд нөгчих ёс үгүй гэдэг; **нирваан** дур үзүүлэх (сансрэйн амьдрал дахь зовлонг үүсгэгч муу дур хүсэл, тачаалаас туйлбартай хагацааж, оюун ухааны үнэнд хүрч гэгээрэхүйн туйлд очих; Эрхэм хүн насан эцслэхийг бас хэлнэ).

НИСВААНИС нисванис.

НИСВАНИС түр. nizvani (<согд. nyzb'ny) <сам. nisañja-nisvana-nisvāna; м.б. nisvanis; хорт муу явдал, гаслан зовлонгийн уг шалтгаан, орчлонгийн үйл үрийн хүлээс. Нисванисын зүйл олон. Түүний үндэс нь тачаангуй, уур хилэн,

омог, шунал, мунхаг, сэжиг, мөнх, тасархай, дээдлэн үл барих, эвдрэх эдгэр арван зүйл болно. Нисванис төрөхийн шалтгаан нь өөрийн зүг тачаангуй бусдын зүг шунал төрүүлж, муу нохрийг шутгэн, буруу үзэлд автагдахуй болно. Нисванис үүсвээс сэтгэл доройтон, буруу үйл үйлдэн, нирваанаас холдож буянаа барна гэдэг.

НИТИШАСТИР сам. *nītisāstra*; мө.б. *nītiśasdir*; "ёсны шастир"; Зан суртахууны ном.

НИШАН перс. *nīšan*; мө.б. *nīšan*; "шинж, тэмдэг, ор мөр"; Тамга; *Зарлигийн ёсоор ал нишант бичиг өгвэй (Улаан тамгат бичиг) (турф)*; хас нишан (хас тамга).

НИЯД сам. *nīyata*; мө.б. *nīyud*; (Ковзуун мянга буюу бум) Их тооны нэр, арван хоёр оронтой тоо. Арван их тэрбум; их нияд (арван гурван оронтой тоо).

НОДЖИД ножид, мө.б. *nodjid*; *ном бурхнаас тэрсэлж нолжид хорыг үйлдэгч (Гам)*.

НОЁН хя. *lāo* уе; мө.б. *noyan*; 1. цэрэг засгийн дээд тушаалтан; 2. хуучин нийгэмд боол зарц бологсад эznээ дуудах нэр; 3. Зэрэг тушаалтны хүндэтгэл; ноён Ерөнхий сайд; 4. оргил, орой; ноён нуруу; 5. шатрын гол эзэн; ноёныг шалах.

НОЖИД тө. *gnod byed*; мө.б. *nojid*; "хорлогч"; Егөө, хорлол; аливаа үйл ажилд саад хорлол тарих; ножидлох (егөөлөх, хорлох).

НОМ согд. *nwm* (< герег. *nomos*); мө.б. *nom*; "шашны сургаал, хуул"; 1. ном бичиг, бурхны шашны судар; 2. махбод хийгээд сэтгэц зүйн шинж тэмдгүүдийн эгэл жирийн маш зохистой үзэгдлийн үндэс суuriйг тэмдэглэсэн бүлдийн гүн ухааны нэр томьёо болох дхарма.

НОМИН тө. *ni min*; мө.б. *nomin*; Голдуу хөх цэнхэр өнгөтэй цагаан толбо буюу судалтай, эмэнд болон гоёл чимэглэлийн зүйлд хэрэглэдэг эрдэнийн чулуу, есөн эрдэнийн нэг.

НОРОВ тө. *nog bi*; мө.б. *nogbi*; "эрдэнэ"; Чандмань; үнэт эрдэнийн чулуу буюу ямар нэг үнэт зүйл.

НОРОВЛИН тө. *nog bi gling*; мө.б. *norbuling*; "Эрдэнийн хийд"; Дорнод аймгийн нутагт байдаг уулын нэр, одоогоос 8000 жилийн өмнөх хүнийг суугаагаар нь оршуулсан оршуулга эндээс олдсон. Бас Хэнтий аймгийн Бат-Ширээт сумын нутагт байх Монголын хурлийн үеийн онцлогийг илтгэсэн дөрвөлжин булш бүхий уулын нэр.

НҮГНЭЭ тө. *bsnyung gnas*; мө.б. *nüngnei*; "чилэн ахуй"; Төвдөөр бас *bsnyen gnas* ч гэдэг. Хоол унд идэж уухгүй, тэвчээр сахин бясалгал хийж чилүүр эдлэхийн нэр. Сар бүрийн шинийн нэгэн, арван таван буюу аль нэг өдөр мацаг барих санваар болно. Энэ санваарыг сахихад алах, хулгайллах, садарлах, худал уг хэлэх зэрэг үндсэн дөрвөн нүгэл болон архи уух, дуу бужиг, засан чимэх, өндөр суудал эдлэх зэрэг нийт найман нүглийг сахина. Энэ санваарыг авах ёсон нь үүр гэгээрэхэд босч багшийн буюу бурхны хөргийн өмнө гурвантаа мөргөж доод судалд сууж маргааш өглөө үүр гэгээртэл сахилын үйл гүйцэтгэнэ. Бас зарим хүрээ хийд хаврын дунд сард шүтгэнээ тахиж, адаг сараас лам нар нь арван зургаа хоног цугларч, бясалгал үйлдэн хатуужил сахидаг байв. Найман нүгнээ өнгөрвөл хуврагийн нүгэл арилна гэдэг.

НҮНЖИГ тө. *snum 'jug*; мө.б. *nünjig*; "тос орох (халдах)"; 1. тослог, өөх тос их; нүнжигтэй хоол; 2. **шилж**. яс чанар; нүнжигтэй эд; 3. **шилж** хариг харамч бус зан, элбэгжүү зан; нүнжигтэй хүн.

НЬЯА сам. *nuaya*; МЭӨ П-Ш зууны үед логикийн сэтгэхүйн хуулиуд дээр боловсorsон эртний энэтхэгийн гүн ухааны хэвшмэл нэг тогтолцоо. Энэ сургаал ёсоор материаллаг өртөнц атомаас тогтоно. Атомуудын хослолоос бүх юм үүснэ. Ийшвар бурхан, санааны эрхэм дээд үндэс мөн тул атомуудын хослолыг бий болгож, орчлонд буй үй олон сүнсийг атомтой холбох буюу салгаж байдаг. Гэхдээ сүнс, атом хоёрын алиныг нь ч бүтээгч биш гэж үзнэ.

НЬЯАГРОДЖА наяагродха

НЯМ тө. *nu i ta*; мө.б. *nim-a*; 1. долоон хоногийн долдугаар өдөр буюу Адъяа гариг, бүтэн сайн өдөр; 2. наран гариг.

НЯМБА I тө. *nim-ra* (<сам. *nimra*); мө.б. *nimba*; *Azadirachta Indica A.Juss*; Өргөн урт навчтай, хонгорцогт модныхтой адил шир цэцэгтэй, жимс гашуун мод. Оршуулгын ёслолд навчийг нь зажилдаг. Чийт мод, ширт мод ч гэж нэрлэдэг. Зарим тольд: Энэтхэгээс бусад орноо үгүй боловч эмч нар алтанцэцгээр орлуулан буй. Зарим нэгэн нь алтан гагнуур ба гагнуурын модоор танин барина (*C.P.*) гэжээ.

НЯМБА II тө. *nim ra*; мө.б. *nimba*; Шашны ёсны бясалгал; самди, даяан ч гэнэ.

НЯМБАВАР сам. nimbavara; мөб. nimba-var-a (Ков.); Шүрэн мод.

НЯМДАН манж. nimadan; мөб. nimadan; Бяцхан нарийхан навчтай, нягт хатуу судалтай, уул завд ургадаг нэг зүйл мод.

НЯН тө. gnyan (< сам. niyan); мөб. niyan~ning; 1. өвчин үүсгэгч хорт микроб; бичил биет; *Нэг хүй салхин дотор ярны бөөн нян оршино.* (Д.Н.); 2. халдварт хижиг өвчин.

НЯНДАР тө. snyan dar; мөб. nindar; "сонорын торго" буюу айлтгалын хадаг; 1. Чин сэтгэлээсээ үнэнчээр дэвшүүлсэн өргөлийн торгон хадаг; 2. Бурхны өмнүүр татах хөшиг.

НЯРАВ тө. gnyer ba; мөб. nirba; Эд хогшил хөрөнгө зөөрийн эрхлэгч, сан хадгалаагч; ...гүзээ ихтэйгээрээ нярав болов уу? (MAY).

НЯРАНЗАНА сам. naiganjanā; одоогийн нэр нь nīlānjanā; мө. niranjan-a; Энэтхэгийн Уттар прадеш муж улсын нутагт орших голын нэр.

О

ОВЬЁС орос. овёс; мөб. obiyasu; Хавар тарьж намар хурааж авдаг ургамал, үрээр нь мал тэжээнэ; **овьёслох** (майд овьёс идүүлэх).

ОГИУ оюу; ...шур огиу шигтгэсэн хуйтай сэлэм...агсжээ (Б.Р.).

ОДИЯНА сам. odiyana; Уржинханд буюу дагинасын орон; *Улийт сансраас салалцаад одиянад учирья.* (Д.Р.).

ОЛБОГ түр. olmag~olbog, ol "суух"+bog(mag)="суудал"; мөб. olbo; Эсгийг цэмбэ, торго зэргээр өнгөлж хийсэн хүн суухад зориулсан дөрвөлжин дэвсгэр.

ОЛМОСИ тө. 'ol mo ses; мөб. olmosi; Achyranthes bidentata; Нэг зүйл өвс, түүний үр, цэцэг, эмд орно.

ОЛОНЦ манж. oloncu; мөб. olonču; Нэг зүйлийн шилмүүст ургамал. Улаавтар цэцэгтэй, исгэлэн ус хийнэ.

ОЛХОН манж. olhon; мөб. olqon; "хуурай газар"; Гол мөрний доторхи арал. Хожим нь дов толгой гэсэн утгатай болсон; *Нэгэн хүрээ шороо орхисон нь төмөр олхон хэмээх дов буюу* (Ш.т).

ОЛХОНУУД манж. olhonu; мөб. olqonud; Монголын нэг овог аймгийн нэр. Олхо бүхий Олхондо голын саваар нутаглаж байснаас ийн нэрлэх болжээ.

ОМ сам. aum (<тө. om); мөб. om; Ариун хандлага ба ерөөлийн уг. Мөргөл уншлага хийгээд шашны зан үйлийн эхлэлд хэлнэ. Ом нь а,у,м гурван үсгээс бүгэх бөгөөд эдгээр нь гурван вээд (Ригвээд, Саамавээд, Яжүрвээд)-ийн билэгдэл гэнэ; Ом свasti сиддам (aum svasti siddham- эх болсон хамаг амьтан энх амгалан болтугай гэсэн утгатай. Бурхны шашин монголд нэвтэрснээс эхлээд, монгол бичиг, судрын эхэнд энэ хэллэг буюу үүний орчуулга ("ом сайн амгалан болтугай) бичигдэх болжээ.

ОМБОДОВДОН тө. sngon po stob ldan; мөб. ombudobdan; "хүчит хөх"; Оттон тэнгэр зэрэг уулын гүн хөмөгт Идэр гурван есийн хүйтэнд ургадаг хөх цэнхэр өнгийн цэцэг. Нутгийн ардууд омботавдан буюу овоотавдан ч гэдэг.

ОМБУУ манж. omolo; мөб. ombu; Хүүгийг хүүхэд, ач буюу омфол ч гэнэ.

ОНИГОО орос. анекдот; Инээдтэй уг, наргиантай яриа, хөгтэй явдал.

ООХ манж. ooħa; мөб. ooq-a; Бие хавтгай, ам их, нарийн хайртай нэг зүйл загас. Алгана ч гэдэг.

ОЧИР орос. очередь мөб. oočeg; Ээлж, дараа, дэс дараалал.

ОР тө. 'or; мөб. or; Суваг, хаван зэрэг утгатай. Хий, шар, цус, бэтэг, бэртсэн хорын гэж таван ор буй. Энэ нь халуун ор, хүйтэн ор гэж хоёр хуваагдана.

ОРД(ОН) түр. ordu; мөб. ordu; 1. хүндэтгэвэл зохих хүний орон гэр; **хорш** орд харш; 2. төрийн эрх барих газрын алба явуулах байр; 3. олон нийтийн хуран цуглажад зориулсан томхон барилга; 4. **шилж** ашигт малтмалын зүйл гарах нөөц бүхий уурхай; 5. **шилж** хэсэг бүлэг одны оршин байх газар буюу одны гэр; одны орд.

ОРИМ манж. orima; мөб. ogim-a; Далайд орших гутаарь загасны нэгэн зүйл.

ОРОГ тө. sngo rog~rog; мөб. ogiu; "зэвхий, саарал"; Үнэсэн буюу зэвхий өнгө зүс; **хорш** орог саарал; орог зусаг (бэлчээр сүйтгэдэг нэг зүйл хулгана).

ОРООЛОН тө. go langs; мөб. orolang; "боссон хүүр"; 1. үхсний сүг сүүдэр; буг четгэр; босоо ороолон; *Ооно хүрээд ирвэл замы нь заагаад өгье дөө, ороолон хүрээд ирвэл чамайг заагаад өгье дөө* (Я.Ц.); 2. их дүрсгүй, зүтгүй; Энэ ороолонгоос боллоо. (MAY).

ОРТОГ түр. ortag; мөб. ortu; хань хамсаа; ортог барив (Мукад).

ОРХООДОЙ манж. orhoda; м.б. orqodai; хүн орхоодой, хүн эм, үндсийг дорно дахины эмнэлэгт зүйл бүрийн өвчин эмгэг засахад хэрэглэх алс дорнодод ургах өвсөрхөг ургамал. Үндэс нь хүн хэлбэртэй.

ОТ түр. ot; м.б. od-; гал, өвс зэрэг олон утгатай боловч монгол хэлнээ бие даан хэрэглэгдэхгүй, харин үгийн язгуур үндэс болж явдаг.

ОТОГ түр. otaγ; м.б. otaγ; "орон сууц, цачир"; 1. анчин гөрөөчний уул ойд буудалласан газар; 2. хуучин цагт харьяат албатыг хэсэг болгон хувааж байсан засаг захиргааны нэгж.

ОТОР түрэг хэлний от- язгуураас үүсгэсэн уг. Өвс бэлчээрийн соргог сайхныг дагаж мал сүргээ авч хөнгөхнөөр нүүдэллэх нь; оторлох (а. отроор явах; б. шилж биеэ хайрлан алив ажлаас хойш суух); оторчин (отор хийх айл).

ОТОЧ түр. otači (эмч, өвсөн эм баригч); м.б. otači; Оточ гэдгийг түрэгт "галч" гэсэн утгатай байснаа утга шилжин оч, гал, зүү, төөнө тавьж эмчилдэг хүнийг хэлэх утгатай болсон гэж зарим эрдэмтэд тэмдэглэсэн буй. Бидний бодлоор от буюу өвс ногогоор эм хийж байсан учраас түүгээр эмчлэгч хүнийг оточ гэх болсон байх; *хорш* эмч оточ; оточлох (эмчлэх, анагаах).

ОТЧИГИН түр. ottegin~otčigin; м.б. odčigin; "галын (ot)+эзэн ноён (čigin=tegin); 1. Чингис хааны оттон дүүгийн нэр. Эртний монголчууд бага хүүгээрээ гал голомтоо сахиулдаг байснаас ийн нэрлэжээ. Энэ уг хожим нь оттон (odqan "галын хан")-оор солигджээ.

ОЦОЛ тө. 'od gsal; "тэгээн гэрэл"; Дорноговь аймгийн Чойр хотоос зүүн өмнө этгээдэд орших уулын нэр, Энэ уул ац хэлбэртэй хоёр уул байдаг тул нутгийн ардуудын яриагаар Ац уул - нэр Оцол болсон гэнэ. Энэ уулын сангийн судар эдүгээ уламжлагдан иржээ.

ОЧИР уй. včir (<согд. Всг<сам. vaṛja); м.б. včir; 1. хоёр талд нь тав таван үзүүр гаргаж хийсэн, ном хурахад хонхтой зэрэгцүүлэн хэрэглэх нууц тарнийн увдистай хөгжмийн зэмсэг. Бурхны шашинд энэ хоёрыг ариун тангарагийн дээдийг бүтээгч арга билгийн хэрэгсэл ч гэдэг. Очирын үзүүрүүдийн уулзвар задгай бол догшин, битүү бол амарлингийг гэнэ. Элдэв-Очир нь дэлбээгээ хумисан лянхуа мэт, дөрвөн дэлбээ нь дөрвөн тив, дөрвөн зүгийн билэгдэл ажээ. Хонхыг зүүн гартаа барьж дуугарган шүтээн бурхан, хүссэн зүйлээ урин ирүүлэх, очирыг

баруун гартаа барин дохиж сайнныг нь тогтоон мууг хөөн зайлцуулдаг. Хонхыг дуу чимээний хүч, очирыг чимээгүйн хүч болгон хэрэглэнэ; очир гүйлгэх (юм хүмээ алдсан, гээсэн хүний гарыг угааж, арц хүжсээр ариутгаад баруун гарти нь улаан оосортой очир аттуулж, булчинг бөсөөр ороон баглаад моринд мордуулж, гуртэмбэ хүн ном уншсаны увдисаар очир нь тэр хүний уг юман дээр нь авч очуулдаг гэх шашны зан үйл гүйцэтгэх; гэхдээ энэ нь нутаг нутагт бага зэрэг ялгаатай байжээ). 2. Бат бэхийн билэг тэмдэг; очир алмас (мащ хатуу эрдэнийн чулуу; Эзэнт хааны төр очир уул мэт батдаад... (ИТ); 3. баяр баясталангийн бат дээд; Эгнэйт очир цэнгэлээр эгүүрд хамт жаргая (Д.Р.); очир тамга (адил талт хоёр жишүү дөрвөлжний дунд бяцхан дугуй гархи бүхий малын тамга); очир залаа (малгайн оройн чимэг); очир жинс (аюул бүхнийг дарах, сайн бүхнийг бэхлэн чадах билэгдлээр хийсэн Богд хаант Монгол улсын хааны титмийн жинс); Эрдэнийн очир одон (Богд хаант улсын анхны одон).

ОЧИРВААНЬ сам. vaṛgarāṇī; м.б. včirbanī; "гартаа очирт"; Хамаг бурхны арвис эрдмийг нэгэн дор хураасан, шумнасын аймгийг дарагч их хүчтэн, нууц тарнийн бурхан. Монголын Оттон тэнгэр уулыг Очирваанийн сахиустай гэдэг. Бас монголчуудын дунд арван хангал гэж алдаршсан догшин сахиусны нэг. Мутартай очиртой, биеийн өнгө хөх, гурван мэлмийтэй, хөмсөгнөөс нь оч бадарсан, гурван орныг номхотгох нарны гэрэл биеэс нь бадарсан, баруун мутартай таван хорыг дарах таван салаа очир барьсан, зүүн мутартай цалам барьсан, улаан дэвсгэрт лянхуа дээр оршидогоор дүрсэлдэг. Богд Очирваань (Отгонтэнгэр уулыг 1828 онд дархан цаазтай болгож ийн нэрийдэх болжээ).

ОЧИРДАРА сам. vaṛradhara; м.б. včirdar-a; "очир баригч"; Бурхны шашны хоёрдугаар дияаны (бясалгалын) бодисадын нэр.

ОЧИРТ суурин; сам. vaṛṭāsan=; тө. rdo ḫje gdan; м.б. včir tu saγurin; Дорждан; Бурхан багшийн илт туулсан бурхан болсон газар Гаяа буюу Богдаяа, бурхны шашинтны итгэлээр энэ газрыг "өртөнцийн хүйс" гэдэг. Анх Сиддхаарт нь МЭӨ 589 оны зуны эхэн сарын 15-нд Няранзана мөрнийг гаталж, баруун эрэгт нь гараад Очирт сууринаа бодь модны дор суун Бурхны хутгийг 36 насандaa олж Будда буюу Бурхан гэгдэх болжээ.

ОЧИРТ: очирт хөлгөн; базарт хөлгөн.

ОЮУ тө. guy; м.б. oguu; огуу; Хөх ногоон өнгийн эрдэс. Шигтгээ, гоёл чимэглэлд хэрэглэх есөн эрдэнийн нэг. Оюу эдлэл муу цусыг цэвэршүүлж, эргэлтийг сайжруулна гэж эмийн сударт гардаг. Төвдийн гюү-гийн өмнө о залгаж үүсгэжээ.

Θ

ӨГӨРЦИЙ орос. огурцы; м.б. ögürčeı; Хулуугийн намын таримал ногоо, иддэг, гонзгой ногоон үр жимстэй. Өргөст хэмх ч гэнэ.

ӨЛӨГ уй. ölüg/тур. ölük (öl- "үхэх"); м.б. ölüg; "үхмэл, сөнөмөл, үхдэл"; 1. өвдөх юмгүй атлаа доройтох өвчин; 2. түүхий эд; **хорш** эд өлөг; 3. **шилж** булаш бумбанаас гарсан эд агуурс; эд өлгийн зүйл.

ӨӨВӨН хя. wo-peng; м.б. öbüng; Өвсөн овоохой, өвсөн гэр.

ӨӨДӨН хя. wōdūàn/wútóng; м.б. ögedeng; Хилэн мэт нэхээстэй нэг зүйл торгомсог бараа; өөдөн гутал; энэ уг монгол хэлнээ үйтэн (хуар) болж хувирсан буй.

ӨРМӨГ тур. ötmök; м.б. örtmög; Ноосон давхац, цэмбэн дээл; Нэг зүйл бүдүүн бараа.

ӨХҮЙ хя. kié-kié; манж. gege; м.б. öküi; Авга эгч, нагац эгч.

П

ПААЛАН хя. falang; перс. farang; м.б. falan; 1. нүүрсхүчлийн натри зэрэгт туталга цайрын исэлдлийг хольж шатаасан шилэрхэг будаг шиг бодис буюу тунгалаг биш шил, будаг; 2. шүдний гадуурх бүрээс; пааландах (юманд паалан гүйлгэх); паалантай (паалан түрхсэн нь).

ПАВАН тө. pha wang~pha wang long bu; м.б. pavang; паван чулуу, аммонит.

ПАГС тө. phag sa; м.б. faysa; "гахайн мах"; сэмж адил өнгөтэй, хундаганы хирийн, галд төөнөж идвээс амт гахайн махтай адилдуу жимс.

ПАЙ хя. fai; м.б. fai; даалуу.

ПАЙЗ хя. pái-zi; м.б. pauija; 1. тусгай үсэгтэй шошго, голдуу мод төмөр зэргээр хийдэг. Гэртэй ч гэнэ. пайз нь угтаа алт, мөнгө, хүрэл, модон дөрвөн янз байсан; пайзтан (жирийн ард иргэдэд

алба үүрэг өгч, санд орох орлогоос авах хүн); 2. уралдааны морины пайз.

ПАНЖАЛ бансал; панжал улсын бярманы хөвгүүн гагцаар хамаг дайсныг дараав гэх (Зуун бил.).

ПАНЗ хя. fān zi; м.б. panja; Наймаа, дамын худалдаа хийж хожоо олох арилжаа; панзлах (панз хийх); панзчин (дам наймаа хийгч).

ПАНС хя. (fāngchóu), fāngsī; м.б. pangsa; Нэг зүйл нимгэн торгомсог бараа.

ПАНХАЙ хя. pang hié (>манж. pangkhai); м.б. pangqai, далайн хавч (Ков.).

ПАРСИГ сам. pārasīka (>тө. par sig); м.б. parsig, перс. (Ков.).

ПАРЧИН тө. phar phyin (=pha rol tu phyin pa); м.б. parčin (=pāramita)= бармид.

ПАЯН тө. phan yon; м.б. payan; "тус эрдэм, ач тус"; 1. Бурхны шашны холбогдол бүхий цадиг туужийг уншиж шүтэхийн ач тус; Доржжодын паян; 2. **шилж** хөг, шившиг; паянтай хүн.

ПЕНДУАН хя. ping duàn; м.б. pengduan; Аргүй гилгэр өнгийн торго, яндуантай адилавтар.

ПИГҮҮЖ орос. бигуди (<фр. bigoudi); Ус буржийлгахад зориулсан хуванцар буюу төмөрлөгөөр хийсэн гуурслаг хэрэгсэл. Эр нөхрийнхөө хажууд пигуужтэй ... биттий харагдаарай. (Н.Г.).

ПИЙЖҮҮ хя. ri ſiöü; шар айраг (хятад).

ПИЙПЛАА сам. bívām (хя. ri-pa); м.б. ripa; Чавхдаст хөгжмийн зэмсэг, утгаа бийваа хөгжим; пид пид гэсэн дуутай учир пийпaa гэх болсон гэх буюу утсыг нь гадагш татахыг "би", дотогш татахыг "ба" гэж нэрлэсэнээс биба гэдэг болсон хэмээн тайлбарладаг. Энэ нь үнэмшил муутай тайлбар. Бийвааг үзмүү.

ПИЙЦҮҮ хя. fēi cùi; м.б. ričüü; Хөөрөг, соруул зэргийг хийх ногоон өнгийн чулуу.

ПИЙЛЭН тө. phi ling (Ю.Р.); м.б. piling, англи.

ПИЙШИН орос. печь, печка; м.б. pišing; Шавар, тоосго зэргээр барьсан гэр халаах буюу хоол унд хийх хөндий зуух.

ПИН хя. péng; м.б. peng; 1. малын хороо, жүчээ, саравч; 2. гэрийн адар, тааз.

ПИНС хя. ping zi; м.б. pingse; Тэгнүүр хэмжүүр; пинслэх (пинсээр хэмжих); бинс.

ПИНТҮҮ хя. píngtú; мө. b. pintüü; "тэгш толгой"; Толгойн үсийг тэгшлэн тайрсан нэг зүйл маяг.

ПИУ хя. piào; мө. b. riucci; Гэрч тэмдэг болгон хэвлэсэн буюу бичсэн зурvas цаас, билет ч гэнэ; Эдний пиу бичтийг шалгаж уз (С.Д.).

ПИЯЛАА сам. piyala; мө. b. piyala; Ариун инжрийн мод; ficus religiosa.

ПОВААРИ тө. pho ba ris~pho ba ril; мө. b. pobari, Piper nigrum L; Дулаан орны ургамал, иш тухан, навч ногоон, үр нь гашуун, халуун амттай, үр нь хоолны дуршил оруулдаг эмийн чанартай. Хар чинжуу, бурш ч гэнэ.

ПОВООР поваари.

ПОГ тө. phog; мө. b. pog; "цалин, хөлс"; 1. сан жасааны түгээл; пог түгээх; хорш зэд пог; 2. хувь түгээл.

ПОЖУР тө. ro či ga; мө. b. pojig; аятайхан амттай, цөмийг ховхлон иддэг нэг зүйлийн жимс.

ПОЛООВ ор. плов; мө. b. polob; Цагаан будаатай хуурга.

ПОЛОГ тө. pho log; мө. b. polog; Хэтэрхий их идсэнээс болж хоол шингэхгүй болох нь; пологтох (полог болох); Төвд хэлнээ гэдэс өвдех гэсэн утгаар хэрэглэгдэнэ.

ПОЛОСА манж. polori; мө. b. polosa; Том дугариг сагс.

ПООЛУУ хя. rō-loo; мө. b. pooluu; Бургас зэргээр сүлжин хийсэн дугариг хэлбэртэй сав.

ПРАКРИД сам. prakrita; мө. b. paragirda; Эртний энэтхэгийн дөрвөн хэлний нэг, энгийн хэл.

ПУН хя. fén; мө. b. pun; Хүндийн хэмжээ; лангийн зууны нэг буюу 0.37301 граммтай тэнцэнэ.

ПУУЖИН хя. rào zhang; мө. b. ruijing; 1. цаасаар ороосон дарь, баяр найрын үеэр дуугаргах цаасан буу; 2. буудсаны дараа агаарт тод ёнгө гарган нисэх тусгай сум.

ПҮН хя. fēn; мө. b. pun; 1. зоосны нэгж, төгрөгийн зууны нэг; 2. уртын хэмжээ, тохойн зууны нэг; 3. нэг ямхыг арав хуваасны нэг хувь.

ПҮНЛҮҮ хя. fèng lù; мө. b. pünglüü; Урьд цагт түшмэдэд тусгай журмаар олгож байсан тогтмол сул цалин. Угтаа Манжийн хаан монголын феодалуудыг өөрийн түшиг болгох зорилгоор 1733 онд тусгай зарлиг гарган тэдэнд өгч байх болсон ажээ; Ийм юм хийж пүнлүү хүртэх ч гэж дээ. (С.У.).

ПҮНТҮҮЗ хя. pun tiáo zi; мө. b. püntüüje; "сур будаа".

ПУНХУАН хя. fènghuáng; мө. b. püngquang; гарди шувуу.

ПУРШ ор. пружина; мө. b. pürši; Уян хатан ган ороомог; пүрштэй (пүрш бүхий).

ПУРЭВ I тө. phur bu; мө. b. pürbü; "гадас" (сам. Brihaspati); 1. Долоо хоногийн дөтгөөр өдөр буюу бархасбадь гариг; 2. Нарны аймгийн нэг ертөнц.

ПУРЭВ II тө. phur ra; мө. b. pürbü; Хүрлээр цутгаж хийсэн, очир бариултай турвалжин шар хутга; Муу ад зээтэрийг дарах сор залахад сороо гал руу чулуудаад хойноос нь хар хадагтай пүрвээр хий дүрэх байдал үзүүлэх зан үйл гүйцэтгэдэг.

ПҮҮ хя. fù; мө. b. ri; Зуны аагим халуун цаг; **ПҮҮ** халуун; пүүгэм халуун (пүү гэмээр халуун).

ПҮҮГЭЭ хя. pū gài; "дэвсгэр, ор дэр"; Аян жин, аялал зугаалгаар явахад авч явах тусгай сав буюу хайрцагт агуулсан гудас хөнжил зэрэг зүйл.

ПҮҮЗ хя. bī zi; мө. b. piiče; 1. феодал, ноёдын хүрэмний ар өвөр тал, мөн мөрөн дээр хадаж байсан дүргэг буюу дөрвөлжин хэлбэртэй ямбаны тэмдэг; 2. торго дурдангийн дээрх төгрөг хээ угалз.

ПҮҮС хя. pù zi; мө. b. piiše; "худалдааны гэр"; 1. орон сууцны үүдэн дээр байгуулсан лангуу буюу бағавтар дэлгүүр, муҳлаг; 2. хэд хэдэн худалдаа үйлдвэрийн газрыг нэг эзний захиргаанд нэгтгэснийг нь; пүүз ч гэнэ.

ПҮҮСҮҮ хя. püüsü; мө. b. piiüsüü; Хээгүй гилгэр торго.

ПЭЛДЭН тө. 'phel gdung; мө. b. peldung; Нуудэнд хийх дун адил үрэл эм. Сайн ламын цогцосноос гарна гэдэг. Бурхны шүншигт хэрэглэнэ.

ПЭНС хя. rén zi; мө. b. pengse, төмпөн, пэнз ч гэдэг.

ПЭНСЭЛДЭЙ манж. fengsekou; мө. b. pengseldei; Аяга, том биш таваг.

ПЯЛ манж. fila; мө. b. pila; Таваг, бяцхан ялбагар таваг.

ПЯНЗ хя. piān zi; мө. b. piňje; Эгшигт хайрцгийн аялгуу, дуу бичлэгтэй зээрэнцэг дүргэг.

P

РААХ сам. ráhu; мө. b. gaqu; Нэгэн зүйл од. Энэ одны тухай домог бий. Тэнгэрсийн хаан Хормуст рапсаан хуваах үедээ

тэнгэрийн хөвгүүн Сарыг харуулд гаргажээ. Гэтэл Асурийн эрхт Раах рашаан хүртэхээр тэнд сэм ирсэнийг Сар олж таниад Вишну тэнгэрт хэлжээ. Вишну түүнд рашаан хүртээхгүй гэж хүрдээрээ дэлдсэнд Раахын хүзүү тасарсан авч үхсэнгүй. Сарыг зааж өглөө гэж Раах хилэгнэн чамайг тэргэл болоход чинь барьж иднэ гэжээ. Түүнээс хойш сар тэргэл болоход Раах залгивч биегүй тул хоолийгоор нь гардаг болжээ гэсэн домогтой. Үүнийг нь дорно дахинд сар хиртэх гэж үздэг. Раах барих гэвэл нар сар хиртэхийг хэлнэ.

РАВДАМ тө. *rab bkr̥ams*; мө.б. *rabdam* (Ков.); Тооны нэр, маш дэлгэмэл буюу арван цагчиг; их равдам (тө. *rab bkr̥ams chen po*) - их маш дэлгэмэл буюу зуун цагчиг, зуун тэрбум.

РАВЖАМ равдам; мө.б. *rabjam*.

РАВЖАМБА тө. *rab 'byams pa*; мө.б. *rabjamba*; "маш хэтэрхий";

1. Төвдийн Гүмбум хийдийн гүн ухааны дацанд олгож байсан эрдмийн дээд зэрэг; 2. их эрдэмтэн; Чойрын арван гурван шатыг бүрэн дамжиж төгссөн, бурхны шашны гүн ухааны онолын номд нэвтэрхий мэргэжсэн хүнд олгодог эрдмийн зэрэг.

РАВЖУН тө. *rab ti byung ba*; мө.б. *rabjung*; "машид гарсан, сайтар гарсан"; Од гариг, орчлон ертөнцийн тогтцыг гаргадаг жарнаар тоолох ёс - цагийн хүрдний номлол (үз. Дүйнхор) энэтхэгээс төвдөд дэлгэрч, жарны тооллын анхдугаар он болох 1027 оны улаагчин туулай жилийг ийн нэрлэж байснаа сүүлдээ жаран жилийн ерөнхий нэр болжээ. Равжунгаар тоолоходоо улаагчин туулай жилээс эхлэн хар зурхайн үндсэн таван махбод мод, гал, шороо, төмөр, ус эдгээрийн өнгийг илтгэх хөх, улаан, шар, цагаан, хар өнгийг эр эмээр хуваан арван хоёр жилийн дарааллаар тоолсоор улаан барс жил хүртэл жаран жил болгодог. Энэ жаран жил тус бүрдээ онд ондоо нэртэй.

РАВТАМ равдам.

РАДНА сам. *raina*; мө.б. *radn-a*; Эрдэнэ; *радна эрихийг татсан ранза галын хаан-дор мөргөмүү*. (Зуун бил.).

РАДНАСАМБАВ сам. *rainasambhava*; мө.б. *radnasambaba*; "эрдэнэс гарахуй"; Язгуурын таван бурхны нэг.

РАКШАС сам. *rakṣas*; мө.б. *ragṣas*; Мангас, махчин; Ригвээдэд гардгаар бол энэ нь эртний энэдхэгийн нэг үндэстний нэр аж. Хожим нь харгис түрэмгийгээр муу хойхорын нэр болж мангас гэсэн утгад шилжжээ. Эр ракшасыг хар бие, улаан үс, ногоон нүйтэй, эмийг нь сайхан зүстэйгээр дүрсэлсэн байдал. Их төлөв

хүн амьтанд хор хүргэж, тэднийг иддэг, ой шугуйд байдаг шуламс гэж энэтхэгчүүд үздэг; *Гэсэр богд ракшасын оронд гэрээ мартсаар сууж эс ирэв* (*Гэс.*).

РАМ арам.

РАНЗА сам. *rāja*; мө.б. *ganja*; Хаан, богдос; *ранза галын хаанд мөргөмүү* (Зуун бил.).

РАСИВАР расияар; мө.б. *rasivar*; *уснир нь расивар мэт харватар* (*МГО*).

РАСИЯАР сам. *rasiyag*; мө.б. *rasiyag*; Мягман чулуу. Зарим судлаачид манж үг гэсэн нь ташаарал болно. Монгол бичигт расивар гэж бас тэмдэглэдэг нь монгол бичигт яа-г ва-гаар солин бичсэнээс болжээ.

РАХУ раах мө.б. *gaci*; *Дэлхийн харанхуйг гийгүүлэхэд нь рагу эс учирвал сайн сан аа* (*МУЗД I*).

РАШААН сам. *rasāyana*; мө.б. *rasiyān*; 1. Тарнийн зэргээр адислан үүсгэсэн амсах буюу угааваас бузар түйтгэр арилгаж, цаглашгүй энх амгаланг үүсгэх ариун ус; рашаагнах (шашны ёсоор рашаанаар шүршиж ариутгах); *рашааны хур* (амтат хур); ...эдүгээ *амытныг гэтэлгэхийн тулд ухэлгүй рашааныг эрэн одмий* (*12 зох.*); 2. өвчин эмгэгт тустай эрдэст ус; халуун рашаан; 3. цэцэг өвчиний цээрлэсэн нэр; улаан рашаан, цагаан рашаан; *рашаантах* (бодоо өвчнөөр өвчлөх, цээрлэсэн нэр); 4. мал идснээс хордож өвчлөх хар буурцагтай дотор нь өт байдаг гэх нэг зүйл хорт өвсний цээр нэр. Энэ өвс хур бороо ихтэй жил ургахгүй, бас газар болгон гарахгүй. *рашаантах* (энэ өвсийг идснээс хордож өвчлөх, адуунд тусахдаа нүд нь солиршин, хараа гөлрөн хуруугаа хүргэхэд ч мэдрэхгүй болж, дороосоо бусгах, таталдаа зэрэг шинж тэмдэг илэрнэ гэж хуучуул ярилцдаг. Өвчилсөн боловч өвс идэж, ус уух ба рашаан өвс идсэн газар луугаа гүйдэг гэнэ); *рашааны барилдлагат өдөр* (зурхайн ёсоор наасны хүч арвижуулах, рашаан эм найруулах, угаал, усан засал үйлдэх, бэр авах, худ ураг төрөл садан бололцох, худалдаа арилжаа үүсгэх зэрэг үйлст сайн өдөр гэдэг); *рашаант хумх* (Эрхин бодисадвын соёрхлоор бүтсэн адист рашааныг агуулагч бурхны хумх).

РАХУЛИ сам. *rāhula*; мө.б. *rahuli*; Раах нь гаригийн нэр. Шагимунийн хөвгүүн бөгөөд арван найман ахуй шүтээний нэгийн нэр. Рахули эхийн хэвлэйд зургаан жил болоод мэндлэхэд яг сар хиртсэн цаг тохиолдсон тул Рахули гэж нэрийдсэн аж.

РИВАДИ сам. revatī; мө.б. rivadi; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монголоор үр таслагч одон. Одоо Дэлгэрүүлэгч од гэж нэрлэдэг.

РИД сам. riddhi; мө.б. rid; 1. ид; шашны ёсны шид, хувилгаан; авьяас; хорш. рид шид; эрт цагт огторгуйгаар явагч рид хувилгаант нэгэн эм бий ажтуу (*Раш.дус.*); 2. гайхамшиг; рид үзүүлэх (гайхамшигийг бүгээх).

РИЙМЭД тө. ge ta ti; мө.б. remed; Бурхны шашны ёсонд муу зүгийг ивээн тэтгэгч охин тэнгэр; *Хүн, тэнгэр, риймэд гурвины эзэнтэй* (*ЗУАЗ*).

РИНБҮҮЧИ тө. rin po che; мө.б. rinbuči; "их эрдэнэ"; 1. Төвдийн Дашлхүмбэ хийгээд Лхас хийдийн тодорсон хувилгаан нарт олгож байсан цол; 2. Бурхны шашинтын тодорсон эрдэмт хувилгаан.

РИНСЭЛ тө. ring bsrel; мө.б. rinsil; "өнид хадгалах"; шарил; *Мөн бурхан багшийн ринсэл тэргүүтэн ч бий аж*. (*АЭ*).

РИШИ сам. rsi (risi); мө.б. riši; арши.

РОРОМА сам. goguma; мө.б. gogum-a; Тоглогор биетэй, хүзүүндээ уут шиг хоёр хөх ургасан, нүд гэрэлтэй, эвэр уртлаг, сүүл ба үс нь хоньтой адил гөрөөс.

РИЛБҮ тө. ril bu; мө.б. rilbu; үрэл; рашааны рилбү; ...зүсэр хур орж, маанийн рилбү ч өөрөө..дэлгэрэн түтж гайхамшиг болов. (*Рав.нам*); рилу ч гэж бичдэг.

РОГИНИ сам. rohinī; мө.б. roginī; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монголоор баян хүнийг угүйрүүлэгч одон буюу Чөлөөт эх одон гэнэ. Сүүлийн үед Ровагини гэж бичдэг нь буруу болно.

РҮРҮ тө. ru ru (<сам.); мө.б. rugu; буга; элт гөрөөс (*Ков.*).

РҮҮЖИН тө. rus pa'i ḫguan; мө.б. ḫuijīn; "ясан чимэг"; шилдэн догшдын хувцанд зүүж унжуулдаг хүний буюу зааны ясаар хийсэн хохимой толгой чимэглэл; зургаан рүүжин (толгой, чих, хацар, бугалга, бугуй, хөл зэрэгт зүүх чимэглэл); зааны ясан рүүжинтэй дээл.

C

СА: шороон са тамга; тө. sa; мө.б. sa; Төвд бичгийн үсгийн хэлбэртэй малын тамга.

САА тө. gza'; мө.б. sa; Ямар нэг эрхтнийг ердийн ажиллагаагүй болгох мэдрэлийн өвчин, саа дайрах (саа өвчин тохиох); *саа гаригийн хорлолууд амарлисан сайхан өлзий учрал бүрдсэн саваагүй хэдэн үтсийг айлтгая* (*ГЭЛ*).

СААРИЙ хинд. sārī; Энэтхэг эмэгтэйн, биеэ ороож нэг захыг мөрөн дээгүүрээ давуулж өмсөх хувцас, урт нь 5-7 м.

СААРНААТ сам. sāraṇātha; Варанасын балгаснаас умар зүг долоон бээрийн цаана орших бурхан шашинтын алдарт мөргөлийн газар, Очирт суурин ч гэдэг. Энд Бурхан багш анх дөрвөн үнэний номлоо айлдаж олон шавьтай болсон гэдэг. Энэ газар нь монгол сударт Гөрөөст ой нэртэй дайралддаг. Бодисадваа нарын нэгэн домогт Бодисадваа нь урьд төрөлдөө Гөрөөст ойд гөрөөсний хан байсан ба өөрийн амийг өргөл болгож нэгэн хээлтэй гөрөөсний амийг аварсан тухай гардаг. Иймээс энэ ойг саар буюу сааранг (гөрөөс) + наатх (эзэн) = Саарнаах гэж нэрлэх болсон домогтой. МЭ-ий ГҮ зууны үед Саарнаатхад дөрвөн том суварга, таван бухар хийд байжээ. ҮI зууны үед Хүннү нар, XI зууны үед Махмуд Газнавий, 1194 онд цэргийн жанжин Күгүб Уддийн (нар) тус тус довтолж үнсэн товорг болгожээ.

СААРЬ тө. sag ri (<перс. sagrī); мө.б. sayari; морины зооны арьс.

САВ I сам. sava (loka); мө.б. saba (ертөнц); "бүх ертөнц"; Амьгүй бодисын ертөнц, гадаад ертөнцийг хэлнэ. Самгарди хэлний сав гэдэг үгийг хэвээр авч лөөг (loka) гэсэн үгийг ертөнц гэж орчуулан хэрэглэжээ.

САВ II перс. sabu; мө.б. saba; Том шавар домбо, ваар.

САВ III: сав үсэг; тө. gzab yig; мө.б. sab üsüg; "цэвэр үсэг"; Төвдийн таталган биш бичиг.

САВДАГ тө. sa bdag; мө.б. sabday; "газрын эзэн"; 1. газар орны эзэн; газрын савдаг, лус савдагтай газар; Дарханхаан уулын савдаг; *Манай нутгийн савдаг болох хоёр улиас бий* (*МААЗДБ*); 2. шилж саваагүй зантай, элдэв юманд оролцох зантай; савдаг элээ (саваагүй); савдаглах (саваагүй зан гаргах); савдах (савдаг зан гаргах).

САВАН фр. sabon; мө.б. sabung; Юм угаахад зориулсан өөх тос, шүлтээр хийсэн усанд уусдаг хатуу буюу нялцгай зүйл; савандах (саван түрхэх, савангаар угаах).

САВРАЙ тө. sa 'bras; мө. sabarai; Гол иш нь дунд зэрэг өндөр, навч арцны төстэй модонд ургах хонины хорголын дайтай, орог хөх өнгийн хатуу исгэлэн амтлаг жимс, түүний үр эмийн найрлагад орно. Чийрэг үр ч гэдэг.

САВСАГ савдаг гэсэн угээс авианы сэлгэцээр үүссэн үг. Юм юманд хүрэлцэх оролцох зантай буюу хээнцэр завхай гэсэн утгатай.

САГ түр. sak; мө. say; сэрэмж, болгоомж; *Би ерөөс сагтай байсныг ч мэдсэнгүй (Ц.Ц.)*.

САГА сам. vaisākha (>тө. sa ga); мө. say-a; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг; 2. нэг зүйл ад.

САГС манж. saksu; мө. sayṣu; сүлжмэл хайрцаг, сав.

САД араб. sad; уй. sät; тө. sad; мө. sad; цаг; алтан сад.

САДАГНАГВА тө. za dag nag po; мө. saduū naύbo, Lophanthus chinensis; 30-35 см өндөр, бат бэх мечирлэг иштэй олон наст өвслөг ургамал. Навч зууван хэлбэртэй, цэцэг хөх өнгөтэй. Ардын эмнэлэгт хэрэглэнэ.

САДАН сам. sādhu/sadhu/sadu; мө. sadun, sadu; Ойрын төрөл, төрөл төрөгсөд, анд нөхөр, амраг хань, сад ч гэнэ.

САДВИС шадвис.

САДГА түр. sadaka; мө. saday-a; 1. сийлмэл буюу баримал хүний дурс. Гол төлөв бөө нэрийн онгод ороход хэрэглэх цаасан хүний дурс, сахиулс залах, ад чөтөрийг тонилгох, өвчин эмгэг засах зэрэгт хэрэглэж байв; 2. үхэгсдийг оршуулахад эд юм, мал зэргийг дагалдуулж оршуулах ёс.

САЖА тө. sa-skyu; "цайвар шороот" - төвдийн Үй Зан орны Бомбори уулын цагаан шороот газрын нэр, эндээс урьд цагт олон алдарт номын мэргэд төрсөн; Сажа бандид Гунгаажалцан, Сажа лам.

САЖАБАА тө. sa skyu ra; мө. sajaba; "цагаан шороот"; Шарын шашны нэг салбар, Сажа нутгаас үүссэн анх Гончижалбо гэгч язгуур угсаат хүн 1071 онд Сажа сүмийг байгуулсан тул энэ салбарын нэр үүсчээ. Сажабаа салбарын гол сургаал нь судар тарниг уялдуулан, төв үзлээр тарнийн хөлгөний үндсэн утгын тайлбар болгож, тэрчлэн судрын хөлгөний бодисадваагийн таван мөр, тарнийн хөлгөний дөрвөн аймгийг барилдуулан бясалгадагт оршино. ХШ зууны үеийн монгол хаад эл салбартай нягт харилцаатай байсан.

САЖИН орос. сажень; мө. sajing; Хуучин оросын хэмжүүр, 2,13 метргэй тэнцүү.

САЗ хя. shāi zi; мө. saja; Юм үрэх цэвэрлэхэд зориулан шүүр гарган хийсэн хавтгай төмөр; шигшүүр, элхэг.

САЙВАН хя. cái fēng; мө. sayibung; Хувцас хунаар үйлдвэрлэх оёдолчин, үйл хийгч.

САЛ сам. sāla (тө. sa la); мө. sala; vatica robusta; Энэтхэгт ургадаг нэг зүйл мөнх ногоон тураг мод. Нарийн агар модны адил навчтай, цагаавтархан дурстай нэгэн зүйл мод. Шувуу суудаггүй, хорхой төрдөггүй, маш ариун мод гэдэг; *Сал модонд салбар шувуу өндөглөв гэнэ (ААЗ)*.

САЛМААНДАР манж salmandara; мө. salimandar; Хөл богино, үс шар хар бидэртэй, бие урт, чийглэг газарт төрдөг амьтан.

САЛУУ сам. sālu; мө. salu; салуу тутарга; Домгийн ёсоор салуу тутарга маш амттай, нэгэнт ургасныг эрт хадваас үдэш нь ургаж, үдэш хадваас өглөө нь ургах, үүнийг идсэн цагаас хүн шээж баах болж, эр эм бэлгэ эрхтэн ургасан гэнэ. Бурхны шашны номд гардгаар хүн төрөлхтөний анхны тариа идээ.

САМ I тө. 'tshams; мө. sam (Ков.); "завсар"; чөлөө учрал, даяан; самд суух (бясалгалд дасгалжих).

САМ II хя. hia mi; мө. sam (qoruqaï); Далайн жижгэвтэр хавч, сам хорхой.

САМАТА сам. samata; мө. samada (Ков.), Тэгш чанар, адил тэнцүү, ижил.

САМАНДБАДРАА сам. samantabhadra; мө. samandabadir-a, "бүхнээ сайн, хотолд сайн"; 1. бурхны шашны анхдугаар диян, бясалгалын нэр. Хамаг сайн үйлийн хувилгаан бодисадва. Лянхуа цэцгэн ширээн дээр заларч, баруун мутартаа бумба, зүүн мутартаа лянхуагийн шилбэ барьсан дурстай; 2. нэг зүйл үгийн сүлжээний хурд. Дөрвөлжин хүснэгтэд байрлуулсан үсгийг уг дөрвөлжингийн дөрвөн өнцгөөс хойш урагш, дээш доош, нар зөв, нар буруу, ташуу жишүүгээр уншихад адил дуудлага бүхий шулэг болж уншигдах нэг зүйл үгийн сүлжээ. Самандбадраагийн хурд гэдэг.

САМБАА сам. sambhaga; мө. sambaγ-a; 1. сэхээ завдал, чөлөө зав, завшаан; самбаагүй (сэхээ завдаагүй); самбаачлах (а. бусдын эзгүйд нь юмыг эдлэх; б. чөлөө зав гарган хийх); 2. хүч чадал, бие ба ёс суртахууны чанд байдал; биеийн самбаа (биеийн хүч); бусдын самбааг мэдэх (хүний санааг мэдэх); сэтгэлийн самбаа (сэтгэлийн хүч); самбагаа ч гэнэ.

САМБАНДХА сам. sambandha; мө.б. sambandha (Ков.); барилдлага; хэлхээ холбоо, уялдаа, бясалгал.

САМБАР сам. sambhara (тө. sa 'bris); мө.б. sambar-a; "юм бичих бяцхан самбар, хоёр самбартай тэмдэглэлийн дэвтэр" (Влад); юм бичиж зурах хавтгай зүйл; чулун самбар; самбар хаалга (нимгэн банзан хаалга); хүндэт самбар (сайшаал, муушаал зэргийг тэмдэглэхэд зориулсан хэрэгсэл).

САМГАРДИ сам. samskrta; мө.б. samyardi; "сайтар найруулсан хэл"; МЭ-ний VI зууны үеэс хэрэглэсээр ирсэн эртний энэтхэгийн хэл. Сонгодог самгарди, вээдийн самгарди, их туульсийн самгарди, буддийн самгарди гэхчлэнгээр хөгжлийн үе шатаар ялгаатай. Хуучин сударт самгарди нь гучин гурван тэнгэрийн хэл гэж гардаг. Монголчууд энэтхэг хэл, тэнгэрийн хэл, сайтар найруулсан хэл, самсгрида гэхчлэнгээр нэрлэж ирсэн; самгардич (самгарди хэл утга зохиолын мэргэжилтэн).

САМДИ сам. samādhi; мө.б. samadi; Нэгэн үзүүрт сэтгэл; дуу чимээ гаргалгүй наманчлан бясалгах шашны зан үйл, даяан ч гэнэ; самди даяан (наманчлан бясалгах, тажутуут огоорох).

САМДОГ тө. za ta tog; мө.б. samduγ; Тагтай авдар сав; хорш. хайрцаг самдог; Цахар аялгуунд авс гэсэн утгатай; монголоор охь хайрцаг ч гэдэг.

САМПИН хя. suànpán; мө.б. sompin/sampin; Эрхин тоолууртай тоо бодох тусгай хэрэгсэл; бодох мохлаг; сампиндах (сампингаар тоо бодох); сампин гэр (хажуугийн өрөө буюу хоёр жигүүрийн өрөө).

САМУДРА сам. samudra; мө.б. samudr-a; "далай, тэнгис"; Давст нуур (Ков.).

САН I хя. cāng; мө.б. sang; 1. хууч. хутагт нарын хувийн аж ахуй; арвин сан (дотоод сан, хутагтын бурхан тахил, нандин эд агуурс мандал, даншиг, өргөл барьц авах, түүнийг хадгалах, зарцуулах ажил эрхэлнэ); бадрах сан (гадаад сан, мал сүрэг адлуулах, гэгээний орд өргөө барих, хурал номын зардал нийлүүлэх зэрэг ажлыг хариуцна); 2. улсын мэдэл, өмчид холбогдох зүйл; сангийн яам (улсын мөнгөн хөрөнгө, түүний эргэлт, төсөв зээллэг зэргийг хариуцах яам); хорш. сан хүү; 3. ховор чухаг зүйл хуримтлуулсан газар; сан хөмрөг; 4. шилж их үнэтэй, маш алдартай зүйл; хүү-г үз.

САН II тө. bsangs; мө.б. sang; "ариутгал"; 1. асааж унгасгах шашны ёсны ариутгал; Алтан дэлхийг сан тавьж номхотов (Гэс).

2. аливаа нэг тахилгат уулс, усыг тахих үест унших ном, сангийн судар ч гэнэ.

САНВААР сам. sampāra; мө.б. sanvar; Муугаас зайлах сахилга гэсэн утгатай. Шашны ёсны сахилын үүрэг; Санваар сахисан лам хүн эхнэр авах ёсгүйг чи мэднэ (С.У.); гурван санваар (ердийн төрөлхтөний санваар, нууц тарниийн санваар, бодисадва нарын санваар болно); санваартан (шашны ёсны сахилтан).

САНГА сам. samggha; мө.б. sangga; Буяныг туршигч.

САНГАС(ВАА) тө. sngas pa; мө.б. sangyasa; төвд үгийг нь үсэгчлэн буулгасан дуудлага болно; 1. тарнич, тарнийн үсиг бясалгач нар нь үсээ авахуулдаггүй байжээ; Сангасваа нь аливаа үйлийг урьдчилан хэлж, гай барцдыг зайлцуулах үүрэгтэй. Ийм увдисыг дөрвөн махаранзаас авсан гэдэг. Бөөгийн адил хувцаслаж, хэнгэрэг дэлдэж чойжин буудаг. 2.azar, сангас лам (сагсгар сэгсгэр урт үстэй); сангасваагийн гарг мэс гялсхийв. (С.Э.); З.сэгсгэр үс; хачин бараг хувцас өмсөөд нүүр рүүгээ хар хялгасан сангасваа унжуулжээ. (Л.Т.).

САНГРАМ сам. saingräma; мө.б. sangram; Бурхны үед энэтхэгийн нэг том худалдаачин ялагч хэмээх ойн хүрээлэнг худалдан авч бурхны суух ариун орон болгон өргөсөн ордон. Төвдөөр гүнгэрваа гэнэ. Санграм нь "бурхны оршин суух ордон" гэсэн утгатай.

САНДАН тө. zangs dung; мө.б.sangdung; Том зэс бүрээ; аварга будуун сандангууд арын мөрт хүнгэнэж байна (Гам).

САНДУЙ тө. gsang 'dus; мө.б. sangdui; (сам. sri guhya samadha); "нууцын хураангуй"; Ганжуурын "Жүд"-ийн аймагт багтах 17 бүлэг бүхий (дандрын) эмхтгэл; сандуйн жүд ("нууц хураангуйн үндэс" - Бурхан багшийн сургаал. Энэ ном байсан газар хүн байтугай нохой ч бурхны хутаг олно гэж монголчууд хэлэлцдэг. Талийгаачийн хойт төрөлд зориулан уншдаг ном).

САНДУУ I хя. shàndāo; мө.б. sanduu; Хадуур мэт бөгөөд их, өвс хадах урт иштэй нэг зүйл багаж.

САНДУУ II сам. samtāna; мө.б. sangduu; Диваажингийн таван модны нэг.

САНЖАА тө. sangs rgyas; мө.б. sangjai; "сэргж дэлгэрсэн"; Бурхан багш буддаг төвдөөр нэрлэсэн нэр. "сан" нь мунхгийн нойроос сэrsэн, жай нь мэдлэг ухаан нь нийтэд дэлгэрсэн гэсэн утгатай.

САНКЬЯ сам. sāmkhya; мөб. sanggi-a; "тоотон"; 1. МЭ-ний I зууны үеийн энэтхэгийн мэргэн арши капила-гийн үндэслэсэн гүн ухааны нэг систем. Үүнд ахуй ухамсар хоёр харилцан дулдуйдаж хамаг юм үүсэхийн үндэс болно, үссэн юмс 25 зүйлээс бүрэлдэнэ гэж үздэг байжээ. Асанги гэдэг үгийн -санги боловч монгол хэлнээ энэ хэлбэрээр тэмдэглэгдсэнгүй; 2. хүний амин сүнс ба сэтгэцийн тухай зөн совингийн мэдлэгийн үзэл санаа үндэс нь болсон "Махабхаарад" туульсад гардаг үзэл баримтлалын нэг, йогийн сургаалын нэмэлт тайлбар.

САНЛАМ тө. gsang bla ma; мөб. sanglam-a; "нууцын лам"; Төвд, монгол бурхны шашны сүм хийдийн тарни судлах дацангийн даа лам.

САНЛИН тө. zangs gling; мөб. sangling; зэс бүрээ.

САНСАР I сам. saṃśāra; мөб. sansar; "орчин эргэлдэхүй"; 1. бурхан шашны номд гардгаар хамаг амьтны үхэж төрөх зовлон нь эх төгсгөлгүй, үхээд төрж, төрөөд үхэж энэ мэтээр ээлжлэн тэргэний дугуй (хүрд) мэт орчин эргэлдэж, тэр зовлон нь үлэшгүй их далай мэт ажээ. Орчин эргэлдэхийн утгаар нь монголоор "орчлон" гэнэ. **сансын далай** (зургаан зүйл хамаг амьтны үхэх төрөхийн зовлон, тэр зургаан зүйл амьтан нь там, бирд, адгуус, асури, хүн, тэнгэр нар болно. Эдний үхэх төрөх нь төрөл арилжин ээлжлэн явагддаг гэж үздэгийн учир сансрын далай буюу сансрын хүрд гэнэ. Хожуу үед сансрын далай нь тоост ертөнц, сансрын хүрд нь шашны ёсны нэг зүйл зургийг нэрлэх болжээ); **сансын үзэгдэл** (ертонцийн аливаа үзэгдэл); **зүйл зүйлийн сансрын үзэгдэл зүүд илбийн мөн чанартай** (Ч.А.); 2. манай дэлхий дээрх хүнхэр бөмбөлөг, орон зай; **Гүүн зэлэн дээр хөлд орсон Монголын иргэн сансарт нислээ** (Б.Я.).

САНСАР II тө. seng gser; мөб. sansar; "шар арслан"; Дорноговь аймгийн Чойр хотоос холгүй орших уулын нэр, Оцол сансар ч гэдэг. Угтаа сэнсэр гэсэн нэртэй байсан нь Оцолсансар гэж нийлүүлж дуудсанаас хувирч өөрчлөгджээ. Энэ ууланд зориулсан "Сэнсэр хэмээх уулнаа орших газрын эзэнд сан тахил өргөх ёс эрдэнийн эрих хэмээгч" нэртэй сангийн судар бий.

САНСКРИД сам. samskr̥ta; мөб. samskrīda; Монголчууд энэхдэг бичлэгийг дагууласхийн галиглаж бичдэг, дуудахдаа санскрид гэдэг байв. Самс - гэдгийн с-ийг орхин дууддаг ёс байснаас самгрида самгарди болсон буй. Иймд санскрид,

самгарди хоёулыг тэгшээр хэрэглэж иржээ. Самгардийн тайлбарыг үзмүү.

САНХАМ тө. bzang ham; мөб. sangqam; "сайн хүчт"; Дагшин орны хүж, агар, зандангийн үнэртэй төстэй анхилам үнэрт ургамал. Архангайн Хоргын Чандмань толгойд ургадаг, халуун орны шувуудын сангасаар үр үндэс нь дамжин ирж нутагшин ургасан гэж нутгийн өтгөс хуучилдаг.

САНЧИР сам. śānaīścara; мөб. saniścīr; "алгуурхнаа хөвөгч"; Бямба, шороон гариг, үзэсгэлэнт од ч гэнэ.

САРАСВАТИ сам. svarasvatī; мөб. sarasvati; "эгшигт охин тэнгэр"; Дуун ухаан, яруу найргийг ивээн тэтгэгч бурхан.

САРИГ түр. sariy; мөб. sariy; Шар, цайвар шарга; *сариг цагаан ингэний яриг цагаан ботго*.

САРИГА сам. sārikā; мөб. sariga; Энэтхэг шаазгай; ...*сарига, тогос тэргүүтэн элдэв шувууд дэвсрэн...*(12 зох.)

САРМАЙ 1. зарам; мөб. sarmai; сармай дээл; 2. **шилж** үс мутай, халцай, шалчгар.

САРТА сам. sārtha; мөб. sarta; арилжаа, худалдаа, худалдаачин.

САРТАВААХЬ сам. sārthavāha; мөб. sartavaki; "худалдаачныг хөөгч ноён, удирдуулсан ноён"; 1. далайн жуулчны тэргүүлэгч; далайн гүнээс шүр сувд эрэх худалдаачны хөлгийн ахлагч; 2. **шилж** зам заагч, удирдагч; удирдан жолоодогч; төрд сургах улсын их жолоодогч. Сартваахь Ленин; 3. **шилж** билгүүн ухаанд газарчлах номч мэргэн багш; номч багш; их номч; *Монгол бичиг соёлын сартаваахь ...Ринчений мэндэлсний...оиг тэмдэглэнэ.* (Сон).

САРТАГТАЙ сартуул; сартуул эрэгтэй, Сартагтай баатар, Сартагтайн суваг.

САРТАГЧИН сартуул; *Тогтола бэх сартагчин хонины суул зувчиж явж... (МНТ)*.

САРТУУЛ түр. sartaul; мөб. sartaūl; Ах Чингэсийн чулууны бичигт тэмдэглэгдсэн энэ үг sarta (эртний дунд азийн суурин иргэд) + aul (айл, тосгон) гэсэн бүтэц утгатай болно. Зарим судлаачид Сарт(ай) + уул гэсэн үг гэж тайлсан ч бий. Угуул утга нь торгон замын өрнө зүгийн худалдаачин болно. Эртний түрэгчүүд дунд Азийн суурин иргэдийг sart гэж хэлснээс үссэн үг гэдэг. Энэ нь эртний энэхдэгийн сартаваахь гэдэг үгийн сартай холбосон хэрэг юм. Хожуу үед түрэгчүүд худалдаачин гэсэн утгаар хэрэглэж иржээ. Монголчууд Төв Азийн иран хэлтнийг

хэлж байснаа хотон, уйгар, тангад зэргийг нийтэд нь нэрлэх болж улмаар Дунд Азийн иргэд, худалдаачныг нэрийдэх болсон буй.

САРХАД түр. sarkut; sarquд; 1. архины хүндэтгэл нэр; 2. тахилын үлдсэн идээ.

САРЬДАГ түр. saritay; мө.б. sariday; sari (нүцгэн) +taγ(уул)="нүцгэн уул"; Мөнх цасан хучлагатай нүцгэн оройт уул; Уулын хөвчийн өндөр оргил.

САТИН орос. satin; мө.б. satin; Нэгэн зүйл бөс бараа.

САХИЛИГ мө.б. sakiliy; Шаакья овгийн гишүүн. Монгол хэлнээ уйгар хэлбэрээр орж иржээ.

САЧИЙ хя. sé qí; мө.б. sačii; "чанар"; Монгол ярианы хэлнээ чадал, чансаа зэрэг утгаар хэрэглэгдэнэ; *Хорсол тайлж, чадлаа узэлцэх сачийгүй* (З.Б.).

САЯ тө. sa ya; мө.б. say-a; мянган мянга, арван бум.

СВАСТИКА сам. svastika; мө.б. svastika; Агийн ёсны загалмайн тэмдгийн нэр. Үүнийг эрдэмтэд Пали хэлний (su)+ (ti)=svasti гэсэн хоёр үеийн нийлэмжээс үссэн билэгдлийн тэмдэг гэж үздэг. su нь "сайн", "asti" нь "энэ бол" гэсэн утгатай. Хожуу үед svastika нь нар болон нарны тахилгатай холбогдон + (ийм) хэлбэрээс үссэн гэж үзэх болжээ. Хүн байгаль хоёрын шүтэлцээний өлзий хутгийн сайн билэг тэмдэг гэдэг. Бас Вишну тэнгэрийн дөрвөн мутрын илэрхийлэл ч гэнэ. Свастикин огтололцлын цэг нь үссэл туурвилыг билэгдсэн гэхийн хамтад Браhma, Вишну, Махеш, Ганеш тэнгэрийн нийлэг дүр гэж тайлбарладаг. Вээдийн тайлбараар бол свастика нь ертөнцийн дөрвөн зүг болон тэдгээрийг төлөөлсөн Агни (гал), Индра (аянга), Варуна (хур), Соом (сар) дөрвөн тэнгэрийн билэгдэл гэдэг. Ашока хааны үеийн тайлбарт үзвээс энэ нь үсгийн хэлбэр + байсан, тэр нь Браhma гэсэн утгатай ажээ. Хожим нь + хэлбэр нь болж үүнээс болж, "сайн сайхан" гэсэн утгатай болсон гэнэ. Бурхны шашинтнууд нар бол Сүмбэр уулыг (нар зөв) тойрон эргэлддэг гэсэн үзэлтэй холбон тайлбарладаг. Хас гэдэг үгийн тайлбарт үз.

СИЙЛҮҮ хя. sì liū; мө.б. siliū; "дөрөв зургаа" гэсэн утгатай. Даалууны дөрвөн улаан, зургаан цагаан нүхтэйг хэлнэ; *Сэмбэн нэртэй сийлуү бумбан нэртэй ращаан* (МААЗДБ).

СИМНАНЦ уй. simnanča; мө.б. simnanča; Чавганц гэсэн үгийн хэлбэр; *Тэр охиноо есөн төрлийн эзэн симнанцаад шавь болговай* (Улдалай).

СИЯАН хя. xian; мө.б. siyan; Хошуу амбаны цэрэг; *Амбан сияаны цэрэгт амлагдан мордоо хө* (МААЗДБ).

СКАНДА сам. skanda; мө.б. skanda; Дайны тэнгэр. Домгийн ёсоор Шива тэнгэр дуслаа галд хаясанд илчтэй тэр дусалд нь галайхан тэсч ядаад, Ганга мөрнөө хийжээ. Тэгтэл Мичид одны зургаан дагина, Гангад угаал үйлдэж байснаас тэр дуслаас зургуул нэг нэг хүүтэй болоод хожим тэр хүү нь нийлж, тогос унасан зургаан толгойтой, арван хоёр хөлтэй Сканда тэнгэр болсон гэдэг. Энэтхэгийн Девагирийн хавьд Скандин тахилын сүм буй.

СОВААДИЙ сам. svāti; мө.б. sovadi; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг, Бүтээгч одон ч гэдэг. Одоо салхины эх хэмээн нэрлэж буй.

СОГ(ВО) тө. sog ro; мө.б. soγbu; Төвдчүүд монголыг ийн нэрийдэж ирсэн нь монгол бичгийн дурсгалд оржээ; Согво ринбүүчий.

СОГД согд. sγw b ; мө.б. soγda; Дунд Азийн баян бүрдээр нутаглаж байсан улс, одоогийн Тажигийн дээд өвөг.

СОГОГ түр. soyuk; мө.б. soγu; "хүйтэн сэргүүн"; Согог ус; ...*Улуг тагийн Согог уснаа бүхүй-дор хүрч...* (МНТ).

СОГОО түр. sγin~soγin; мө.б. soγu; марал, бутын эм нь; соогоон чих (урт навчтай, цагаан өнгөтэй, аятайхан нэг зүйл зэрлэг ногоо).

СОГОР уй. sokus; мө.б. soγug; "хатгалдаан, тэмцэлдээн"; *Тэр согорт Мэргэдийн Тогтоагийн Худ чулуун хоёр хөвгүүн тэнд бүрүн иргээн аваад хагацаж* (МНТ).

СОГОЦ манж. sohoco; мө.б. soγuci; Бие урт, цээж бөмбөгөр, сүүл хавттай бөгөөд хайч хэлбэртэй, цайвар цагаан, далайд орших нэгэн зүйл загас.

СОЁГ тө. gsol gyog; Зарц үйлчлэгч, гал тогооны үйлчин; *Богдын соёг хэдийн бараа туруутуй яваад өгчээ. (Б.Р.)*

СОЁМБО сам. svayambhu; мө.б. soyombu, soyongbu; "өөрөө гарсан"; 1. Өндөр гэгээн Занабазар 1686 онд эртний энэдхэгийн ланз үсгээс сэдэвлэн үүтгэсэн цагаан толгойн эхний титэм үсэг. Энэ титэм үсгийг анх мутрын тэмдэг маягаар хэрэглэж байжээ. Гэвч соёмбод монголын эртний сүлд болох нар, сар, галын дурсийг багтаасны дээр дэлхий эртөнц, орон зай, цаг хугацаа тэргүүтнийг билэгдсэн гүн утгатай тул Монголын тусгаар тогтололын билэгдэл болгож 1911 оноос монголын төрийн сүлд болгосон. 2. сав ертөнцийн оршилыг билэгдсэн шороо, ус, гал,

хий, огторгуйг дурслэн, бас шим өртөнцийн буюу хүний биеийн бүтцийг тусгасан үсэг. 3. Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын билэгдэл болгож төрийн сүлдний төвд болон төрийн далбаан дээр урласан билэг тэмдэг.

СОЙВОН тө. gsol фрон; мө.б. soyibon; "айлтгалин багш"; Хутагт хувилгаадын шадар бараа бологчдын ахмад тушаал; сойвон лам; *Хутагтын дэргэд... донир сойвонгууд зогсчээ (С.Д.)*.

СОЙЗ хя. shuā zī; мө.б. sova᷍a; Услэг зүйлийг иш бариулд хавчуулан тааруулсан арчих, зүлгэх, түрхэх, цэвэрлэх хэрэгсэл; сойздох (сойзоор арчих, зүлгэх, цэвэрлэх).

СОЛГО солгой-той гарал нэг. Солонгос (зүүнээ орших улс); солго цаас (солонгос цаас).

СОЛГОЙ түр. sol; мө.б. soluyai; "зүүн"; 1. хүний биеийн зүүн талын, баруун талын; 2. нар буруу эргэсэн; солгой ёс (буруу ёс).

СОЛХ тө. sol kha; мө.б. solq-a; тайлга; аливаа мандал, сүм, хувилгаан, онгод тэргүүтнийг тахихуй нь; сан солх; идээ будааны дээдээр зочлон сан солх тавиулж.. (А.Д.).

СОМРОНЗ тө. so ma ga dza (сам. somarasa), мө.б. somraṇja; Cannabis sativis; Нарийхан голтой, өчүүхэн навчтай, цэцэг нь танпрамтай адил, гурвалжин дугтуйн дотроос жижигхэн үр, бөөрний дурсэнд нь солонго мэт оготны дурстэй, Энэтхэгийн өмнөд Мон орноос ирдэг ургамал. Зарим хүн Ашока модны үр ба олсны үр, чонын хонхцог зэрэгтэй эндүүрдэг гэж Сумадирадна тэмдэглэсэн. (С.Р.).

СОНОМ: соном хадаг; тө. bsod nams; мө.б. sodnam; "буян"-ны хадаг, дунд хэмжээний хадаг.

СОР I тө. zog; мө.б. sor; Өвлийн улирлын сүүл сар буюу цагаан сарын өмнөхөн шашны дайсан тэрсүүдийг дарах, сайн үйлсийг арвижуулах билэг болгож, чөтгөрийн идэш буюу амин золиг болгон хаядаг балин. Тэrs номтны ёс, шашин лугаа дайсагнагчидтай тэмцэн нящаагч догшид бурхны магтаалаар уул ёслол эхлэх хурлыг сорын хурал гэнэ. Энэ хуралд сор хэмээх гурвалжин дүрсийг оруулж, зул хүж тойруулан асааж, балин жалсайгаар чимдэг. Тарни, ерөөл уншиж эцэст нь сорыг шатаана; сорын таваг (хоёр шургааг модны голд тавьсан царан дээр сор залах хүнийг хүлж, сор залах нүхний дээр тавин тос цацан шатаах).

(Бодинарын) гавал сор (бүтэн нойтон толгойг муу зайгаар дүүргээд сор болгон хаяхуй).

СОР II: сор тамга; тө. 'sor; мө.б. sor (tamγ-a); Чойнжин тамга.

СОРОГШИН тө. srog śin; мө.б. sorguśin; "амин мод"; 1. сүм хийдийн гол суварга болгон хус модоор хийсэн багана; ...алтан шар сорогшин бухий олон цагаан суварга ярайн үзэгдэх ажтуу (С.Д.); 2. шавар шуумал баримлын голд хийх дервөн тал мод.

СОРОЛ тө. srol; мө.б. sorgolu; Бор, цагаан, улаан гэж өнгөөр нь гурав ялгана. Цагаан соролын үндэс нарийн, навч цэцэг цайвгар улаан түяатай, үнэр сайхан, дугтуй шиг хавтгай үртэй бол бор сорол нь бор түяатай цайвар навчтай, цэцэг улаан, үндэс нь цагаан өнгөтэй, богинохон аж. Улаан сорол нь олон салаа иштэй, иш бүхэндээ зууван бөөгнөрсон навчтай, үр цэцэг ширүүн, өнгө улаан, үндэс нь хүний уушгийг санагдуулам авч хар өнгөтэй, хурц үнэртэй буй. Эмд орно.

СРИГА: срига бялзуухай; сам. sriga; Канар бялзуухай ч гэдэг. Шав шар өнгөтэй сайхан донгодлог шувуу.

СУВАДИ沙发上.

СУВАРГА уй. suvarga; мө.б. subuγ-a; Бурхны шашны хүндлэл, дурсгалын хөшөө буюу үнэт зүйлс агуулах уран барилгын нэг зүйл. Бас хэмжихүй ухааны дүрсүүд болох дөрвөлжин, дугуй, хагас дугуй, гурвалжин, соёмбыг давхарлаж үелүүлэн босгосон сүм хийдийн тахил мөргөлийн шугтээн. Бурхны шашинд дөрвөлжинг газар, дугуйг ус, гурвалжинг гал, хагас дугуйг огторгуй, соёмбыг хий гэж үздэг. Бас йогийн практикт босоо байрлуулсан эдгээр дүрсүүдийг хүний биеийн ажиллагаа хийгээд сэтгэц зүйн удирдлага хуримталсан цэгүүд гэдэг. Эдгээр цэгүүд эрэмбэ дарааллаараа бие биеийн дээр үелэн дарснаар хүнийг бясалгалын дээд цэгт хүргэж улмаар хүн сансарт аяндаа шингэнэ гэж номлодог ажээ; Суваргалах (а. суварган дотор агуулах; б. шилж. хүч тарга сайтай тэмээний хоёр бөх эгц босоо болохыг нь).

СУГАР сам. śūkra; мө.б. suγar; "хөрөнгө, дусал"; Баасан, Төмөр гариг ч гэнэ.

СУДАР сам. sūtra; мө.б. sudur; "товч"; Энэтхэгийн гүн ухааны үзлийн гол утгыг илтгэсэн оновчтой үг буюу түүний эмхтгэл гэсэн утгатай; 1. зохиолын утгын оньсыг цөөн үгээр үзүүлсний товч хураангуй; 2. Бүддийн шашны зохиолыг Винайн аймаг, Авидармын аймаг, Судрын аймаг гэж гурав хуваасны гутгаарын нэр; 3. Бүддийн зохиосон Их хөлгөний зохиолыг судар, дандар гэж хоёр хуваасны нэгдүгээрийн нэр; 4. аливаа ном, бичиг, түүх шастир; 5. Үдээс хадаасгүй урт хөндлонгөөр дэвтэрлэсэн ном

зохиол; удам судар (угсаа удам); нутаг судар (газар нутаг); сударчлах (ном бичгийг судар маягтай хийх).

СУДАРСАН сам. *sudarsana*; "сайхан үзэмж"; сударсан балгас Энэтхэг домгоос үзвэл Сүмбэр уулын оройд орших Хормуст (Индра) тэнгэрийн хот ажээ. Төвдчүүдийн уламжлалаар бол Энэтхэгийн өрнө буюу өмнө зүгт байх Бодгаяа, Виндхья уулнаа байдаг гэнэ. Заримууд нь Уржингийн орноо (Ужжайн) байдаг гэнэ. Монгол ном зохиолд энэ нэр цөөнгүй дайралдана. Гучин гурваны Сударсан балгас (Сүмбэр уулын оройд 33 тэнгэр буй гэж шашны домогт гардаг. Үүнд, эдийн 8 тэнгэр, нарын 12 хөвгүүн, 11 догшид, Ашуванийн 2 хөвгүүн, Тэнгэрийн эрхт хормуст эдгээрийн суудаг алгаар бүтээсэн тансаг балгасыг хэлдэг гэнэ).

СҮЙХ манж. *sūqa*; м.б. *suyiq-a*; Өдлөг буюу сийлмэл хэрчлээс бүхий том навчтай, шар буюу цагаан цэцэг гардаг, анхилам үнэрт нэг зүйл шарилж. Навчаар нь улавч хийдэг; Сүйхан чулуу (сүйхны навчтай адил хөх өнгөтэй чулуу).

СУЛТАН араб. *sultān*; м.б. *sultan*; "захиран эзэмшигч"; 1. Дундад зууны үеийн монгол хэлнээ лалын шашинт улсын хаан, ван гэсэн утгатай байсан; 2. Судан улсын өөр нэр.

СУМ(АН) : суман мод тө. *mdzo mo śin* (<хя. *su mu*); м.б. *sumun*; Халуун оронд ургадаг хурэн өнгийн мод, гоёмсог эдлэл чимэглэл хийнэ.

СУМАРАН манж. *sumari*; м.б. *sumarang*; Хөхөө шувууны өөр нэр. Дуут задуулай ч гэнэ. Сумаран бялзуухай ч гэдэг.

СУМУР сүмбэр; м.б. *sumur*; Эртний түрэг хэлэнд орсон хэлбэр нь сумир ч гэнэ. ...Ганц сүлхарнай *Сумур тагийн дээр гарваас...*(Зуун бил).

СУНТАГ тө. *gzungs thag*; м.б. *sungtay*; "тарни тогтоолын утас"; Таван өнгийн утсаар томж хийсэн бүдүүн угас, бариулын нэг үзүүрт нь дотроо ном дармалласан хуйлмал цаастай, гонзгой бортого шиг хэлбэртэй зүйл. Түүнийг бас мөнгөн матрын амаар ч гаргаж ирэх нь бий. Сунтагч лам түүнийг барьж хүний толгойд адис хүртээнэ; *Ta нар сунтийн адис хүртэх үү?* (Б.Р.).

СУМЬЯА сам. *soma*; м.б. *sumiy-a*; 1. зөрөг цэцгийн намын ороонго ургамал, домгийн ёсоор бурхдын ундаа хийдэг гэнэ; 2. Даваа, Саран гариг ч гэнэ.

СҮНДҮЙ тө. *gsang 'dus*; м.б. *sangdai*; "нууц хураангуй"; Бурхан багшийн сургаал, 34 бүлэгт ном. Хүний жил орох, мэнгэ

голлох, суудал өнцөгдөх, өвчин зовлон, өөрт болон өрөөлд гачаал, зовлон зэрэг тохиовоос айлтгадаг. Мөн орчлонгийн хамаг амьтны зовлонг нимгэлэх нигүүлсэнгүй сэтгэлийн үүднээс олны тусад айлтгадаг.

СУРГАНДИ сам. *sūryakānta*; м.б. *surkandi*; Маш тунгалаг цайвар улаан өнгөтэй, дотроо тор мэт судалтай эрдэнийн чулуу, эмийн зүйлд хэрэглэнэ.

СУРГАР тө. *sur dkar*; м.б. *surγar*; *Ledum palustre* L, Мөнх ногоон өнгөтэй, нарийхан навчтай, эхүүн үнэртэй сөөг ургамал. Голдуу уулын орой, хушийн ой, намагт ургана. Эмд орно; Эд таваарын бурхныг ариун бусаар бузарлаваас...сургарын үнэрээр арилгах болоу. (Б.у.).

СУТАЙ түр. *sutai*; м.б. *sutai*; су+тай "уст уул"; Монгол Алтайн нурууны нэг оргил, далайн төвшнөөс дээш 4226 м өндөр, мөнх цаст уул.

СҮТ тө. *gzugs*; м.б. *süg*; "дүрс"; хий хоосон; *хорш*. сүт сүнс; хий сүт (шашны ёсонд биегүй атлаа сүрхий чадалтай амьтан мэт зүйл); сүт болох (турж эцэн хүн дүрсийн төдий болох); зураг сүт (хад чулуунаа сийлсэн эртний дүрс зураг).

СҮГМЭЛ тө. *sug smel* (<сам. *suksmaila*); м.б. *sügmil*, *Elettaria cardamomum*; Өдлөг том навчтай, анхилмал шар цэцэгтэй, зургаан талтай уутанцар бүхий, гашуун амттай үртэй өвслөг ургамал. Энэтхэг, хятад, мон (Бутан, Сикким) орны гэж гурван зүйл бий. Дөрвөн сайхан үнэртний нэг гэдэг.

СҮЙ: сүй мана, хя. *shui*; м.б. *süi*; усан мана; мана чулууны нэг зүйл; *Сүй манан хөөрөг даалин дундаа эргэлдэнэ* (ардын дуу).

СҮЙЖИН хя. *shuijing*; м.б. *süijin*; усан болор; сүйжин хөөрөг.

СҮЛ тө. *su-lu*; м.б. *sülu*; Хурц үнэртэй, шулуун иштэй, шар цэцэгтэй өдлөг навчтай олон наст өвслөг ургамал. Харбор ч гэдэг.

СҮМБУМ тө. *gsung 'bum*; м.б. *süngbum*; "буман зарлиг"; Хуучны төвд, монгол эрдэмт мэргэдийн зохиосон бүрэн зохиолын эмхэтгэл; *Агаангэндэнгийн сүмбум*.

СҮМБЭР: сүмбэр уул; сам. *sumegi*; м.б. *sümbür*; Монгол бичгийн дурсгалд *sumur*, *sümır*, *sümer*, *sümür* гэхчлэнгээр бичсэн байдаг. Утга нь "жавхлант", үгчилбэл "үзэсгэлэнт Мерү"; 1. бурхан шашны домогт Замбуутивийн төвд оршигч асар том уул гэж гардаг. Ах сав ертөнц тогтоход хоосноос хий мандал, түүний дээр усан мандал, түүний дээр алтан мандал (дэлхий) бий болоод

Дээр нь сүмбэр уул, долоон алтан уул, төмөр уул, мөн долоон цэнгэлийн далай, нэгэн хужирт далай үүсэн төв, дунд нь сүмбэр уул цогцолсон домогтой. Сүмбэр уулын өндөр нь найман түмэн бээр, дөрвөн эрдэнэсээр бүтсэн дөрвөн талтай гэдэг. оройд нь гучин гурван тэнгэр, дунд нь дөрвөн Махранзын тэнгэр оршидог гэж түүх сударт тэмдэглэсэн буй. Зарим домогт Сүмбэр уулын эргэн тойронд дөрвөн том тив байдаг гэж гардаг. Зүүн талд нь Үлэмж биет (сам. Purvavideha; тө. lus 'phags), өмнөд талд нь Замбуутийн (сам. jambudvīpa, тө. dzam bu gling), баруунд нь Үхэр эдлэгч (сам. Godaniya, тө. ba lang spyod), хойно нь Умрын муу дуут (сам. uttarakuru, тө. byang sgra mi snyan) байдаг гэнэ. Эдгээрийн хажууд бас найман жижиг тив бий гэсэн байдаг; 2. Манай дэлхий; 3. сүндэр, сүрлэг; Сүмбэр Алтайн уулсаа хүн бүхэн сэтгэлдээ хүндлэн тээж буцав (Д.П.); сүмбэрлэх (а. сүмбэр уул шиг болох; б. сүндэрлэх).

СҮМЭН тө. sna ma; мө. sümen; Төвдөөс нь авиаачлан буулгасан үг. Нэгэн зүйл цэцгийн нэр; Сүмэн цэцгийг хэдий бүрхвээс-бээр сайн үнэр нь хотолдор хурмуяа (*Соном*).

СҮМЭР сам. sumetu; мө. sümet; Сүмбэр уул.

СҮМҮР мө. sümür; Сүмбэрийн эртний хэлбэр.

СҮНДАР сам. sundar; мө. sündar; Сүрлэг сайхан, үзэсгэлэн төгс.

СҮНДЭРЬЯА сүндар; Сундэръяа зандан эвэртэй... үхэр сүрэг (ЗУАЗ).

СҮНШИГ шүншиг.

СҮРЬЕЭ тө. sūg ua (<сам. sūguua); мө. süriy-e; "нар"; 1. Энэтхэг домог үлгэрт гардгаар нарны тэнгэр сахиулсан. Вээдийн гол тэнгэр бурхны нэг, гэрэл дулааны эх булгийг өгөгч; 2. нэг зүйл хорт микроб орсноос уүшги, дотор бөөр ялзрах буюу яс үжрэх өвчин; Удалгүй түмэн хүнд сүрьеэ тархаж нэг дусал шүлснээс алтан аминууд сүйтэв (Д.Н.).

СҮХ хя. xiăokè; мө. süke; Эртний үед мөнгөн юмбууг хэлж байв. Мөнгөн зоос, өлгий мөнгө нэг мөнгөн сүх тавин лантай тэнцэнэ.

СЭ: сэ мод; тө. bse (sing); мө. se (modun); Тошлог шар модны төрлийн бутлаг мод.

СЭВРЭЭ тө. gzig ri; "ирвэст уул"; Говь-Алтайн нурууны гутгаар эгнээнд Нэмэгт уулаас зүүн тийш 60 км сунан тогтсон дтд.2437 м.

СЭВЭГ = тө. gzeb~sig ru; мө. sebeg; 1. хулс бургасаар сүлжин хийсэн сагс; сийрсэн сэвэг; 2. хөвсгөр.

СЭЛБЭ: Сэлбэ гол; тө. bsil ba; мө. selbe; "сэруүн"; Сэруүн гол гэсэн утгатай, хорш сэруүн Сэлбэ; Туул голыг усаар сэлбэдгээс энэ нэр нь сэлбэх гэдэг үгээс үүсэлтэй гэж зарим хүн үзсэн нь нутлагдаагүй зүйл; Сэлбийг өгсөвэл сэруүхэн дээ (*Ардын дуу*).

СЭЛНЭН тө. sil s̥yan; мө. silnen; яруу хөгжим буюу дэлдэх хөгжим. Байдал нь цан лугаа баахан төстэй авч цар түүний бариул нь цангийнхаас том, хүрээ дэrvэгэр, дотор талд нь маанийн үсэгтэй байдаг.

СЭЛЭМ манж. sele(me); мө. selem-e; "төмөр юм"; Байлдаанд хэрэглэх том хутга адил зэвсэг; Сэлмэн эвэр (урагш хандсан хурц үзүүрт урт эвэр); сэлэмдэх (сэлмэр цавчих).

СЭМБЭРYY тө. se 'bgi; мө. singberü; Punica granatum L; анар; Халуун оронд ургадаг тахиралдсан иштэй, том навчтай, үзэсгэлэнт цагаан цэцэгтэй, модонд ургадаг жимс. Энэ жимс хатуу зузаан хальстай, доторо олон жижигхэн улаан үр, мөхөг бүхий, бор хүрэн өнгөтэй.

СЭМБЭРЭМ тө. ser sprengs; мө. semberem; Шарын жагсаал, хуврагийн жагсаал, тойдын жагсаал; Далай лам, Банчин бодг хийгээд шашны хутагт дээдсийн морилон ирэхэд шарын лам хуврагууд хөгжим болон хүндэтгэлийн дээд ёслолоор угтах зан үйл.

СЭМДЭН тө. seng gdong; мө. semdem; "арслан нүүрт".

СЭНДРYY сэндэр.

СЭНДЭН тө. seng ldeng; мө. sengdeng; Acacia catechu willd (сам. khadira); 1. бүдүүн голтой, гахайн хялгас шиг ширүүн том навчтай, сэруүн чанартай, үнэр сайхан, амт ялимгүй гашуун нэг зүйл зандан мод. Халуун оронд ургадаг, эмийн ханд хийдэг. Улаан зандан гэж нэрлэдэг ч улаан, цагаан, шар гурван зүйл өнгөтэй. Энэ модоор дамар хийж ирсэн бөгөөд их сайхан дуутай болдог; 2. модон хувин.

СЭНДЭР сам. sindhura~sindura; 1. улаан хонд, шунх; 2. рашааны шавар, сэндрүү ч гэдэг.

СЭНТИЙ тө. seng khre; мө. sengtei; "арслант тавцан"; Газар тэнгэрийн завсарт шашин номын аливаа дайсны омгийг үхүүлж, ад хорлолыг номхотгон дарж байгааг билэгдсэн улбар шар зогдорийт дөрвөн цагаан арсланг баруун урд хөлөө дээш өргөсөн,

бусад хөл нь доош тулж байгаагаар урласан яндар бүхий дөрвөлжин тавцан буюу хүндэтгэлийн суудал. Далай лам, Банчин эрдэнэ, Халхын богд нар болон хийдийн тэргүүн лам нар хурал номын үйл бүтээхэд залран суудаг.

СЭРА тө. *se-ra*; Сэра хийд; "зэрлэг сарнайн орон"; Төвдийн Лхас хотоос умар зүтг 3 мод газарт 1419 онд байгуулсан томоохон хийд.

СЭРБУМ тө. *gser bum pa*; мө.б. *serbum*; "алтан бумба"; Нэг зүйл бумба.

СЭРДИГ: ямаан сэргиг; тө. *gser tig*; мө.б. *serdig*; *Saxifraga hirculus* L; Хурц шар цэцэгтэй, олон наст өвслөг ургамал. Өндөр уулын бүсэд ургана.

СЭРЖИМ тө. *gser sgyims*; мө.б. *serjim*; "алтан ундаа"; Бурхан тэнгэрт тайх, жич сацал хийх архи цайны зүйл; *Өнөөх төвд сэргжмээ өргөж гүйцээд...Насанбатын зүт айсүй ажээ.* (Б.Р.); сэргжимлэх (сэргжим өргөх).

СЭРЖМЯДАГ тө. *gser gyi me tog*; мө.б. *serji miday*; "алтан цэцэг"; *Magnolia champaka*; *momordica cochinchinensis*; *Alnia sonin* нэртэй сэргжмядаг цэцэгтэй...*Говь Гурван сайхан мину зээ* (ЗУАЗ).

СЭРҮ тө. *bse ru*; мө.б. *serü*; 1. бодь гөрөөс; тэнгэрийн тураг (Ков); 2. хирс; 3. **шилж** нэгийн тооны илт өгүүлэх нэр.

СЭРШ тө. *srid zhi*; мө.б. *sersii*; "сансрыйг амирлуулагч"; Цоохор хээтэй нэг зүйл богино хадаг.

СЭРЭЭ тө. *sri*; мө.б. *seriy-e*; "бүг"; чөтгөр, шуламс буюу ад шуламс шүглэсэн хүнийг бурхны номоор дарж номхотгох нэрийдлээр шатаах, хөнөөх шашны зан үйл; *Яагаад ...энэ хуухнээр сээрээ дараах болов oo?* (Мон.дом).

СЭТЭР тө. *tshe thar*; мө.б. *seter*; "мөнхрөхүй"; Малыг бурхан сахиусанд өргөж дархлан, газар, тэнгэр, ургамал, үүл, гол тэргүүтнийг билэгдсэн шар, хөх, ногоон, цагаан, улаан таван өнгийн хив хадгийг тэр малынхаа үс хялгасыг оролцуулан томж, хүзүүнд нь уяж зүүн эдэлгээнд хэрэглэхгүй онголох шашны зан үйл. Онгон ч гэж хэлдэг. Өөрөөр хэлбэл, аливаа малыг номын сахиулсанд амийг нь даатгаж мөнхрүүлснээр амийг нь тасалж үл болох зан үйл. Сэтэрлэхдээ ном уншуулж, арц хүжээр ариутган бас тусгай сахиус бүтээж зүүх нь ч бий. Энэ нь мал сүрэг үржих, баяжихын билэг тэмдэг болжог. Мөн хүний хувь төөрөгтэй холбоотой хийморийн сэтэр, тэнгэрийн сэтэр ч гэж байдаг; сэтэр зүүх (хоосон нэр зүүлхийлэх); сэтэртэн (а. сэтэр бүхий; сэтэртэн

сүрэг - сүсэг бишрэлээр ямар нэг бурхны хөлөг болгосон буюу уул усанд өргөж хив хадаг зүүсэн мал. Богд хан, Хэнтий хан, Отгонтэнгэр ууланд зориулсан сүрэг; б. **шилж** эрхтэн, дархтан, их эрх мэдэлгэй эд этгээд).

Т

ТААР түр. *taγar*; мө.б. *taγar*; 1. ноос олс тэргүүтнээр нэхсэн бүдүүн нэхмэл нэг зүйл эд; 2. бүдүүн өрмөгөөр хийсэн тампуу, шуудай.

ТАВ түр. *tar*; мө.б. *taba*; "хүсэл, зоргоор"; тохь тух; тавгүй (тохь тухгүй); тавгүйдэх (хэтэрхий тохигүйдэх); тавгүйрхэх (ая тухгүй зан байдал гаргах); тавгүйцэх (тавгүйрхэх); **хорш** тав тух.

ТАВААР түр. *tabar~tavar* (харьц.ор. товар); мө.б. *tavar*; 1. эд бараа; 2. худалдахад зориулсан ном; 3. өртөг бүхий, нийтэд худалдах, худалдан авах замаар хуваарилагдах хөдөлмөрийн бүтгээгдэхүүн.

ТАВНАН манж. *tabunang*; мө.б. *tabunang*; 1. тайж ноёдын хүргэний хүндэтгэл үг; 2. Манжийн хаанаас гүнж авсан хүн.

ТАВЦАН уй. *tavčang* (<хя. *tao chang*); мө.б. *tabčang*; "хаан ширээ, ариун газар"; 1. суух хэвтэхэд зориулсан вандан; 2. тайз; 3. төмөр замын буудлын талбай, өндөрлөг.

ТАГ I түр. *taγ*; мө.б. *taγ*, "үүл"; 1. эргэн тойрны орчноос өргөгдсөн өндөрлөг газар; *Найманы Буйрут хаан Алтайн өвөр Улут таг* (Өндөр уул. О.С.); *зорин хөдлөв* (А.то); Сүмүр таг (Сүмбэр уул); 2. уулын хавтгай буюу тэгш орой; уулын таг ; Энэ үг монгол газрын нэрийн бүрэлдэхүүнд орохдоо урьдах хойтох үг, нөхцөлтэй нийлж үндсэн утгаа алдсаныг Байтаг (Баян уул); Тагна зэргээс мэдэж болно.

ТАГ II тө. *khrag*; мө.б. *taγ*; наяд, нагшдар, арван оронтой тоо, арван миллиард; таг тиг ч гэнэ.

ТАГНАХ хя. *tan*; мө.б. *tangna*; Ажиглах, турших, хянах; **хорш** тагнах турших; чагнах-тай гарал нэгтэй.

ТАГСИГ: Тагсигийн орон; тө. *stag gzig*; "барс ирвэсийн орон"; Эртний Перс орныг төвдчүүд ийн нэрлэж байсан нь монгол түүхийн бичгүүдэд дайралддаг. Одоогийн Тажиг(стан) орны нэр ч үүнээс үүдэлтэй.

ТАГТ манж. *taktu*; мо.б. *taytu*; 1. давхарлаг гэр, байшин. Ханандаа цонхтой асар маягийн байшин; *хорш*. тай тагт, асар тагт; 2. босоо оройтой туургатай майхан.

ТАЖ МАХАЛ перс. *tāj*(ар.) + *māhal*(хинд.) *Tajamāhal*; "титэмт ордон"; Энэтхэгийн Ааграа хотоос зүүн өмнө зүтг 2 мод газарт, Жамуна мөрний эрэгт орших (Их моголын эзэн хаан Шаахжахан хатан Мумтаздаа зориулж босгосон) цагаан гантиг бурхан-орд.

ТАЙ хя. *tái* (тур. *tai*); мо.б. *tai*; Монгол хэлнээ байшигийн дээд талд барьсан асар буюу харуул манааны өндөрлөг. Түрэг хэлнээ уул, уулын орой гэсэн утгатай. Монгол газар усны нэрийн бүрэлдэхүүнд (Тайшир, Хантай, Тайхар, Алтай) ч орсон буй; 1. яриа илтгэл хийх, тогтолт үзүүлэх тавцан, тайз ч гэнэ; 2. харуул манааны бяцхан цамхаг; 3. байшин барилгын оройд барьсан асар; 4. ертөөний буудаллах газар.

ТАЙВАН I хя. *dai-fou*; *ta-fou*; мо.б. *tayibang*; Амбан, сайд, түшмэл (Ков.).

ТАЙВАН II хя. *tài píng*; мо.б. *tayibung*; 1. энх эсэн, амар амгалан; *хорш*. энх тайван; 2. нам сэлүүн, нам талбиун.

ТАЙВУУ хя. *tàibǎo*; мо.б. *tayibuu*; Хуучин цагт хааны туслах, тайфу-гийн дараах түшмэлд олгож байсан цол. Мөн хааныг залгамжлагч хөвгүүнийг заан жолоодох туслах түшмэлийн цол.

ТАЙГА I түр. *taiga*; мо.б. *tayiy-a*; Ой хөвч бүрхсэн өндөр аглаг уул нуруу; *ой тайга*; таг, тай-гаас үссэн уг.

ТАЙГА(Н) II: тайган нохой ; хя. *tai ha*; мо.б. *tayyan* (*noqai*); Урт хөлтэй, тачир үстэй хурдан анч нохой.

ТАЙГАН хя. *tài jiān*; мо.б. *tayiyam* *tayyan*; Урьдын цагт агтуулж, хааны өргөөнд зарагдан явах хүн.

ТАЙЖ хя. *tài zi*; мо.б. *tayijī*; "хааны агь"; Засаг ноён; Хан буюу ноёны угсаа залгамжлагч.

ТАЙЗ хя. *tái zi*; мо.б. *tayizi*; Жүжиг шии тоглоход зориулсан тусгай тавцан.

ТАЙЗУ хя. *tài zǐ*; мо.б. *tayizu~tayijū*; Эзэн бодг Чингэс хааны цол.

ТАЙЛИАН хя. *tai lian*; мо.б. *tayiliyan*; Нэг тал нь гилгэр, нөгөө тал нь аргар нимгэн цаас; *Номын хөмрөгт маань тайлиан цааснаа ...бичсэн...ерөөлийн эх буй* (ИТ).

ТАЙФУУ хя. *tàifù*; мо.б. *tayifu*; "их тэтгэгч"; Хуучин цагт хааны туслах тайшийн дараах цол.

ТАЙХУ хя. *tài-hou*; мо.б. *tayiqyu*; Хатан эх.

ТАЙШ хя. *tiā shi*; мо.б. *tayishi*; 1. хуучин цагт хамгийн хаан, улсын эзний дараах эрх мэдэлтнийг нэрлэж байв; *Миний арван хөвгүүдийн дотроос Хадаан Тайшид өгүүл (А.то)*; 2. Тайфуугаас дээгүүр, хааны туслах түшмэл; 3. хаан ор залгах хүүг заан залах түшмэл.

ТАЙШИР тур. *tai+sam. srı, taistı*; тайга, Алтай, Хантай, Хэнтий (Хэнтэй) зэрэг үтийн өнцөг болох түрэг гаралтай тай (уул) гэдгийн араас самгарди гаралтай Ширэндэвийн Шри (Цогт) залгаж "Цогт уул" гэсэн утгатай нэр үүсгэжээ.

ТАМ тө. *tha ma*; мо.б. *tamu* (<сам. *tāmas*); 1. шашны ёсны гурван муу заяны нэг. Нүгэлт амьтны сүнсийг цээрлүүлэн зовлонгоор тарчилгах аюулт орон. Тэр орны эзэн нь Эрлэг номун хаан болно; Найман халуун там (басхүү эдгээгч там, хар шугамт там, хураан эвдэгч там, эмгэнэгч там, ихэд эмгэнэгч там, гаслагч там, маш гаслагч там, чөлөөгүй там); 2. *шилж* зовлон, бэрхшээл; зовлонт орон; *Би өөртөө алба хааж, үйл тамаа үзэж байна (С.У.)*; 3. маш гүн нүх; *Уулыг тал болтол, талыг там болтол ноцолдов (Я.Ц.)*; *Өгөр толгой би...өөртөө там ухжээ. (Д.П.)*.

ТАМГА түр. *tamqa*; мо.б. *tamy-a, tam-*; "төөнөх, цоноох"; 1. мал адгуус, эд юманд тэмдэг болгон хайрах төмөр хэрэгсэл; 2. засаглах эрхийн баталгаа болох сүлд бүхий захирлага тэмдэг; 3. терийн хэрэг шийтгэх газар; 4. хөзийн нэг зүйл дүрс тэмдэг; тамгалах (тамга дарах); тамгат(тамга бүхий); Монголд овгийн тамга, малын тамга, өрхийн тамга гэж байв.

ТАМПРАМ тө. *thang 'phrom*; мо.б. *tamporam*, *Physochtaina Praealta*; Цэцэг нь цайвар шар, үнэр нь эхүүн олон наст хорт ургамал. Цагаан тампрам, хар тампрам гэж хоёр зүйл бий. Эмийн найрлагад ордог.

ТАМТУМ (там тум) тө. *khram thum~мо.б. tam tum*; Хагас хугасхан, бүдэг бадаг; ...тулхуур цоож шажигнахыг там тум мэдэв (Д.Нам).

ТАМАА манж. *tama*; мо.б. *tam-a*; Шаахайн ул мэт хавтгай хэлбэртэй, өчүүхэн толгойтой хоёр талдаа нүдтэй далайд оршидог нэг зүйл загас.

ТАН I хя. *tāng*; мо.б. *tang*; 1. ургамлын зүйлийг нүдэж хийсэн хандалж уудаг бүдүүн ширхэгтэй эмийн бэлдмэл; *хорш*. эм тан; *Тангад цэмбэн дээлээс нь тангийн үнэр ханхална (МААЗДБ)*; 2. шөлтэй мянтууз, сүмс шөл; шөлөн тан.

ТАН II хя. tān; мо.б. tang; Гол мөрний урсгалын ус татуурсан элс чулутай газар; голын тан; тандах (гүхэн усанд онгоц завь газардах).

ТАНА перс. dāna; түр. tana; мо.б. tan-a; "сувд"; Чимэглэлийн зүйлд хэрэглэх, зарим дунгийн доторх солонгон өнгөтэй хатуу эд.

ТАНГА тө. thang ka; мо.б. tangy-a; Хөрөг; хавтгай (даавуу, зотон гэх мэт) юманд аливаа юмны төрх, дур байдлыг гарган хийсэн зураг; *хорш*. хөрөг танга.

ТАНДАРАМ хя. tāng tōumā; мо.б. tandaram-a; Банхгар хоншиортой, бөс түрийтэй, арьсан зулагтай, дан ширэн ултай нэг зүйл гутал. Голдуу ул зулаг нь үргэлж байдаг. Тандам ч гэнэ.

ТАНДАХ тагнах; мо.б. tangdaqu; *хорш*. тагнах тандах.

ТАНС хя. tān zi; мо.б. tangsa; Хөвөн ноос зэргээр нөхсөн хөнжлөөс нимгэн хүчлага, бүгээлэг; ноосон танс.

ТАНСАГ түр. tangsuq; мо.б. tangsuγ; tang- "ер бус, гайхамшиг"; гайхам хачин, гайхалтай, гайхамшигт сайхан.

ТАНТАН хя. tāntōng; мо.б. tangtang; Цэр нуулимсны сав, нялбуур ч гэнэ; хогийн тантан.

ТАНХАГ тө. thang khug; мо.б. tangquy; "тангийн уут"; Тан агуулах хуниастай хүүдий, манхаг. Бас замбаан гурил хийх савхи, илгээр хийсэн утыг ч хэлнэ.

ТАНШИГ манж. tangśig; мо.б. tangśiy; Биеэсээ урт сүүлтэй, барс лугаа адил нэг зүйл араатан.

ТАНШИМ тө. tang them; мо.б. tangšam; "доод хувцас"; Лам нарын өмсдөг хүрэн тэрмээр хийсэн бансал хэлбэрийн хувцас, таншин ч гэдэг; *Олон нуталаат таншимдаа оосортой чибирийг дүүжилсэн...*(Гам.).

ТАРВАС ир. tarbuzah; перс. tarbuza; хинд. tarbuz; мо.б. tarbus = шийгуа.

ТАРВАЧИМБА тө. thar pa chen po; мо.б. tarbačemba; "ихэд тонилгогч"; Хүн хилэнц нүглээ арилгаж бурхан болох аргыг номлосон буюу талийгаачийн хойтын буянд зориулан дээд оронд түргэнээ төрөхөд нь өлзий билэг бодон айлтгах шашин суртахууны хөлгөн судар. Энэ зохиол нь их хөлгөний ёсонд хамаарах ба үүнд сүсэглэх бишрэхийн тус, нүгэл хилэнцийн тухай, буян бүтээх ёс, гурван эрдэнэ хийгээд хоосон чанар, нирваан, арга билгийн талаарх шашин номын гол үндсийг багтаасан Бурхан багшийн гол сургаалын нэг болно.

ТАРИГ түр. tarīy; мо.б. tarīy; тария, тариалан; Монгол газар усны нэрийн зүйлд тааралдана. Байдраг (гол) гэдэг үгийн бүгцэд (Баян тариг) орж яваа. Мөн Баян-Адрага гэсэн нэрийн хоёрдугаар уг нь энэ тариг мөн.

ТАРЛАХ тө. thar ba; "тонилох, нярваан болох" (Ю.Р.); мо.б. tarlaqu; Хязгаарт хүрэх.

ТАРНА тө. thar pi; мо.б. tarnu; Euphorbia pallasii; Том үндэстэй, хүрэн хальстай, олон наст өвслөг ургамал буюу түүний сүүт үндэс.

ТАРНИ сам. dhāraṇi; тө. sngags; мо.б. tarni; 1. самгарди хэлээр урьж үнших их бага хэмжээний аливаа хүслийг бүтгээхэд зориулсан номын нэр. Арвис тарни, тогтоол тарни, нууц тарни гэж гурав хуваана. Тарнийн үсэг үеүд нь нигүүлсэхүй болон билэг оюуны тодорхой эрдмийг агуулсан учир утга маш гүнзгий. Тарнийн хөлгөн (Бурхны шашны Махаяна хэмээх их хөлгөний номлол дахь нэг чухал салбар болох Дандарын аймаг. Судар тарни гэвэл судар дандар болно. Тарнийн хөлгөн нь дотроо нууц тарни, үрийн тарни, аргын тарни, адис баригчийн тарни гэж хуваагдана); тарнийн ёс (эртний бурхны шашны ухааны судар тарнийн хөлгөний үндэслэл бөгөөд тэр нь сэтгэлийн мөн чанар дээр суурилна. Тарнийн увидис олж авсан дээд зиндааны мэргэдийн суралцах мөрийг хэлнэ); Тарнийн сан (аливаа хүсэл санааг дом шившилэгийн хүчээр арилган зайлзуулах цагаан домын тарнийн өв. Эдгээр нь аврах, хамгаалах, анагаах арилгах, тэтгэх хүч увидистай гэнэ); тарнийн хүрд (тарни бичиж ад зэтгэр зайлзуулах зүйл); тарнидах (тарни урьж адистидлах); *хорш*. аг тарни.

ТАРТАГ тө. m̥thar thug; мо.б. tartuγ; "эцэст хүрэх"; Эцсийн хязгаарт хүрэх; тартагтаа тулах (дорийтох, ядуурах, дампуурах); *Шашин маань тартагтаа тултал ялзраа шив* (З.Б.).

ТАСАМ уй. tasman (<перс. tasman); мо.б. tasam-a/tasman; "сур"; 1. буга, гур, зээр зэрэг гөрөөсний арьсаар хийсэн нарийн сур; тасман ганзага; *Сулхарнай тэр тасманыг ...асхаж буусу хэмээн хулж ирэв* (Зуун бил.); 2. эмжээр, хөвөөлж оёсон зүйл; дээлийн тасам; тасамдах (хөвөөлж эмжих).

ТАТИРАБА сам. titiri, дадиваа; мо.б. tatiraba; ...татирабаг доромжлох болон гардид далайг барагдуулжуухий (Суба.).

ТАХАР манж. *tahur*; мо.б. *taqar*; "зарц"; **Ван**, гүн, баяд ноёдод аар саар ажил хийж өгдөг зарлага; *Тамгын тахраас хорин мөнгөөг өгч* (Б.Р.).

ТАХИМЛИГ: аяга тэхимлиг.

ТАШ уй. *taš* (тур. *taš*); мо.б. *taš*; Чулуу.

ТАШИН хя. *ta jin*; мо.б. *tašin* (Ков.); дарга, ахлагч.

ТАЯГ тур. *tajaq*; мо.б. *tayaγ*; Тулж явах хэрэгсэл; ...*сэлмээ хувилгаж турван алд таяг болгов* (Гэс.).

ТАЯНГА манж. *tayungγa*; мо.б. *tayungγ-a*; Улгэр домогт гардаг нэг зүйлийн аварга загас.

ТИВ I сам. *dvīra*; мо.б. *dvib~tib*; "арал, хойг"; 1. бурхны шашны домогт Сүмбэр уулыг тойрсон далайн дөрвөн талд дөрвөн их тив бий гэж үздэг; 2. далай тэнгисээр хүрээлэгдсэн арал хойг бүхий асар уудам газар, хуурай эх газар.

ТИВ II: тив лам тө. *khri* па *bla ma*; мо.б. *tib* *blam-a*; Ширээт лам, тив ширээт ч гэнэ; *Сүсэгтэн олон, тив ламыг дан хун биш, давхар хун гэж бишрэх тул...* (С.Д.).

ТИЙЗ хя. *tié zi*; мо.б. *teyijē*; 1. гарын тэмдэг, тэмдэг болгон дарах хэрэгсэл ба лацтай битүүмж; *Богд...Чойрын ловон лам Агаанданзангийн нэр дээр тийзээ даржээ* (Ц.Д.); 2. орон нутгийн гүйлгэнд хэрэглэж байсан мөнгөн тэмдэгт; тийздэх (тийз дарж битүүмжлэх).

ТИЙРЭН тө. *the'u rang*; мо.б. *tireng/teyireng*; 1. үлгэр домогт гардаг найман сахиулсны нэг; *Газар лусыг номхоттон өг. ганц хөлт тийрэнг дарангуйлж өг* (МААЗДБ); 2. *шилж*. Бурхны шашны ёсоор хүнд нөхцөх нэг зүйл ад албин; тийрэн орших; Энэ гайхал тийрэн танай авдрын ард хонины тарган бөгс байна. *Авья гэж байхгүй юу* (MAY).

ТИТЭМ согд. *dydm* (<герег. *διάδυμα* ; мо.б. *titim*; 1. хүндэтгэлтэй хүний тэргүүний өмсгэл; Мөн монгол ламын өмсдөг бурхны зурагтай, таван хэсэг босоо саравчийг хооронд нь утсаар хэлхсэн, хоёр захын оосроор нь дагсан дээрээ уяж торгоох толгойн цагираг мэт малгай. Титэм малгай ч гэнэ. *Номгүй хаан титэм зүссэн илжиг* (Цэц); 2. монгол бичгийн а-ийн төрлийн үсгийн толгой ганц шүд; 3. хууч. Зэрэг тушаалын нэр; ...*их ор суусны хойно Ванчинхүүтийн титэм түшсэн* (Ц.Ц.).

ТОВРОГ тур. *topraq*; мо.бб. *tobaγ*; "шороо, тоос, тортог"; Уйрмэг хэмхдэс, талх, нунтаг; үнсэн товрог (шатсан үнс); товроглох (бүрэлгэх, товрог болгох).

ТОВУУН: товуун дүр тө. *khro bo*; мо.б. *tobun*; хилэнт, догшин дүр; товуун дүрт хүн.

ТОВЧИГ түр. *tovčiq*; мо.б. *tobčiq*; Баруун зүгээс ирсэн бүдүүн биетэй морь.

ТОВЬ: товь малгай; уй. *doppa*; хинд. *topi*; мо.б. эүмшд 1. дуулганы дотор буюу малгайн дотор давхарлан өмсөх тоорцог мэт малгай; 2. дөрвөн талдаа саравч бүхий тойруул малгай.

ТОВЬЁГ тө. *tho yig*; мо.б. *tobuoγ*; гарчиг, аливаа албан хэргийн цэс бичиг.

ТОГ тө. *thog* (оп. ток); мо.б. *toγ*; 1. гэрэл гаргах, машин хөдөлгөх зэрэгт ашиглах эрчим хүчний нэг үүсгүүр; 2. аянга, цахилгаан.

ТОГОС түр. *tuwus~tawis* (<перс. *taus*<арам. *tawus*) > мо.б. *toγus*; Том биетэй, ногоон ноолууртай, урт сүүлтэй, сүүлний үзүүрт таван зүйл солонгорсон нүдэн хээтэй, үзэсгэлэнт шувуу. Өдийг бурхан тахилын зүйлд хэрэглэнэ.

ТОД тө. *thod* па; мо.б. *tod*; 1. гавал, үхсэн хүний гавал; 2. Хүн буюу бичний гавалын ясыг хөрөөдөж алт, мөнгөөр амсарлаж, доторлож хийсэн ариун сав. Бас зандангаар ч хийнэ.

ТОДВАА тод; *Алтан сав чанартай боловч зандан тодваагийн чадалтай хаанаас адил байх вэ?* (Д.Р.).

ТОДВОН тодваа; *Тогосын өд, тодвон цөгц ...цөм бүрэн юм байна* (ЗУАЗ).

ТОЙ түр. *toi*; мо.б. *toi*; "найр, их хурим"; Найр хурим, гэрлэх хурим; *хорш* той хурим.

ТОЙВ тө. *tub*; мо.б. *toyibū*; төвөг яршиг, төвөг чирэгдэл; тойвтой ажил.

ТОЙ(ЛОХ) хя. *tuī*; мо.б. *toyilaqu*; 1. үс гэзгээ хяргах, засах; үсээ тойлох; *Түүний үс сахал тэргүүтнийг тойлж автутай* (мо.тойн); 2. үсээ хусаад тойн болох.

ТОЙН хя. *dáo ren* (*tao jen*); (дөр.бич.); мо.б. *toyin*; 1. язгуурын гаралтай лам, бомбын шашны хувраг; 2. *шилж*. ламын хүндэтгэл, тайж нарын хөвгүүн, тайжийн зэрэг хэргэм залгамжлаагүй лам болсон хүн.

ТОНХИЛ түр. *taukul*; мо.б. *tongkil*; "уулын нуур"; Говь-Алтай аймагт буй.

ТОНХУУ хя. *tóng hāo*; мо.б. *tongquu*; Иш могоцог болоод хөндий, навч хушуутай, шар цэцэгтэй ургамал. Иш навчийг идэж болно.

ТООР хя. *tao egt*; мөб. *toyor~toor*; Улаан шар өнгөтэй, үсэрхэг арьстай, сайхан амтат жимс, түүний мод; тоор мод (уянгат мод).

ТООРМОС орос. тормоз; мөб. *toγmasu*; Хөдөлгүүр бүхий аливаа өөрөө явагч машин техникийн хөдөлгөөнийг удаашруулах буюу зогсоох хэрэгсэл; тоормослох (тоормосоор зогсоох); *Базар гэнэт машинаа тоормосоллоо.* (Ц.Д.)

ТООС түр. *toz*; мөб. *toyosu*; нарийн ширхэгтэй хумхи; *хорш тоос* шороо; тоосрох (тоос дэгдэх, манан үсэх); тоослох (юмны тоос арилгах).

ТОР I түр. *tōr~tor*; мөб. *toor*; "гувчуур, өөш, урхи"; саргар нэхсэн зүйл.

ТОР II түр. *tog*; мөб. *togi*; дэгдсэн тоос.

ТОРВО тө. *gtor pud*; мөб. *torbu*; Тахил тавиглалд хэрэглэх гурил зэргээр хийсэн идээ; Бурханд торво тавих; дором (үз)-той гарал нэг.

ТОРОМ түр. *torum*; мөб. *torum*; "ботго"; Хоёр настай тэмээ; Төвдөөр хоёр настай байдсыг бас *thor* то гэнэ.

ТОРОН тө. *tho rings~tho rangs*; мөб. *torang*; Үүрийн гэгээ; үүрийн тонон; тонон жирэн.

ТОТГОД : ад тогтод, тогтор.

ТОТГОР тө. *thod dgar*; мөб. *todqar*; саад, хөнөөл, уршиг, саатуулах юм; *хорш* саад тогтор; тогтор болох (саад болох); тогтордох (тогтор хийх); тогторлох (тогтор саад болох).

ТОТЬ хинд. *tota*; мөб. *toti*; "ногоон"; Өд нь хурц өнгөтэй, хушуу монхор бөгөөд үзүүр нь доошоо махигар, ойд сүргээр амьдрах ба модны хонгилд үүрлэнэ. Аливаа юмны дуу чимээг дууриахдаа маш дадамгай, уг сурахдаа түргэн нэг зүйл шувуу.

ТОХАР тө. *tho kag*; мөб. *toqar*; Хотон улс.

ТӨВӨД тө. *m̥ho 'bod(pa)*; мөб. *töbed*; "өнлөрлөгөөс дуудах"; Төвд газар уулархаг орон учраас эрт цагт төвлчүүд бараа бараа нь харагдах уулын оройд оромж цамхаг босгон бие биеэ дуудалцсан хэл мэдээ өтдөг байснаас "өндрөөс дууддаг орон" гэсэн утгаар нэрлэх болсон гэдэг.

ТӨВХӨН: төвхөн (сүм) хийд тө. *grub khan*; мөб. *tobqan*; "бүтээлийн байшин"; Өвөрхангай аймаг, Орхоны хойт биед буй Шивээт ууланд турван талаараа өтгөн модорхог уулаар хүрээлэгдсэн хад цохиотой уулын өвөр тал буюу ёроолоосоо 20 метр өндөрт, уртаараа 40 гаруй метр, өргөнөөрөө 30 орчим метр талбайтай дэвсэг дээр байгуулсан анхдуугаар бодг Өндөр гэгээн

Занабазарын бүтээлийн сүм; Монгол бичгээр Дубхан гэж бичсэн байdag.

ТӨМПӨН хя. *tōng pén*; мөб. *töngpöng*; Юм хийх далbagар хэлбэрийн төмөрлөгөөр хийсэн сав.

ТӨНХ- хя. *tōng*; мөб. *töngki-*; 1. нүх сүв буюу ямар нэг юмны дотор талыг ухах малтах, хөндийлөх; *хорш* ухах төнхөх; 2. *шилж* өөчлөх, гоочлюх.

ТУГДАМ I тө. *thug dam*; мөб. *tugdam*; Бясалгал, сээтгэлд гүнээ бодох нь; Номын сахиулсныг шүтэн бясалгал үйлдэх нь; *хорш* тутгам үйлдэх, тутгам бясалгал.

ТУГДАМ II тө. *thugs dam*; мөб. *tuγdam*; Ордон, өргөө; төрийн тутгам (Богдын төрийн ажлаа явуулж байсан гэр өргөөний хүндэтгэл нэр); ламын тутгам, ноёны тутгам.

ТУГУЙ хя. *dūguī*; манж. *toxan*; мөб. *duγui*; Жижигхэн гүүр буюу ганц модоор тавьсан гүүр.

ТУЙПУУ хя. *tū ri*; мөб. *tuγri*; "хэвлэсэн шавар"; Тусгай модон хэвэнд шавар хийж шахан хэвнээс нь салгаж хатаасан түүхий тоосго, угтаа шатааж боловсруулсныг нь тоосго гэнэ.

ТУМБААШ тө. *m̥thun bzi*; мөб. *tunbaši*; "эвтэй дөрөв"; Монголчууд тумбаашийн зургийг ээ эвийн билэгдэл болгож иржээ. "Эвтэй дөрөв" гэсний учрыг үлгэрт ийн өгүүлдэг: Эрт цагт заан, бич, туулай, ятуу дөрөв эв найртай амьдарч байж. Нэг өдөр бидний хэн нь ах вэ гэж ярилцжээ. Тэнд нэг том мод байжээ. Заан тэр модыг зааж намайг багад энэ модны өндөр надтай адил байсан гэхэд бич, намайг багад мөн л надтай адил байсан, сүүдэр нь намайг дөнгөж халхалдаг байсан гэжээ. Тэгтэл туулай, намайг багад энэ дөнгөж үндэслэж, тэр үндсийг нь би малтан иддэг байсан гэхэд ятуу энэ модны үрийт нь би зууж ирээд энд орхисноос ургасан гэжээ. Чингэнээр ятуу ах, туулай дараагийн дүү, бич гутгаар дүү, заан отгон дүү болж дүү нар нь ахыгаа хүндэлж зааны дээр бич, бичний дээр туулай, туулайн дээр ятуу сууж аливаа зүйлд дүү нар нь ахын үтийг даган явах болсноор "зохицсон дөрвөн амьтан" гэгдэх болжээ. Бас адгуусны дүрээр амьтны тус зохиогч ч гэдэг. Ятуу нь Шигмуни, туулай нь Шаарийбуу, бич нь Монголжийбуу, заан нь Ананд хэмээн билэгдэн номлосон байdag.

ТҮН I хя. *tōng*; мөб. *tung*; 1. тон, маш, туйлын; 2. хэрхэвч, огт.

ТҮН II тө. thun; м.б. tung; "хувь, хэмжэ"; 1. нэг удаа уувал зохих эмийн хувь хэмжээ; гурван тун эм; *өвчин тусахдаа төө төөгөөр ирдэг, өвчин эдгэхдээ тун тунгаар гардаг*; 2. нунтаг эм хэмжих бяцхан халбага; тутнах (эмийг тун тунгаар болгох, тутнуураар хуваан хэмжих)

ТҮНЖААН хя. tōng jiàng; м.б. tunjiyang; Зэс гуулины дарх хийдэг хүн; Төмрийн дархан.

ТҮНРАА тө. thun gwa; м.б. tunra; Шашны зан үйл гүйцэтгэхэд гүрэмчийн хэрэглэх, үхрийн хар эврээр хийсэн, үзүүрт нь хар хадаг уясан, муу ад ээтгэрийн тарни урих зэмсэг. Үлээж муу ёрын ууль шувууны дуу, нохой хуцах чимээ гаргадаг. хамаг зэтгэрийг дарагч Очирваанийн гадас ч гэдэг. Урих тунраа, хариулах тунраа, алах тунраа гэж гурван зүйл бий; *Гүрэмч, буу тачигнах, бүрээ хаштирах дундуур тунраагаар дурвэлзэн байгаа галын зүг...гурвантаа их л сүртэй дохижээ (Б.Р.)*.

ТҮНХҮУ хя. tōnghū; м.б. tungqu; Цай зэргийг хийх данх, зэс дэвэр.

ТУРАН перс. tūrān; хинд. tūrān; Монгол-турэг овгууд суурьшиж байсан төв Азийн өмнөд хэсэг.

ТУРУУН тө. mīho ri; "өндөр уул"; Монгол газрын нэрийн бүрэлдэхүүнд ордог. Цагаан туроон, Баруун туроон гэх мэт. Гяатрууны уз.

ТУРХАГ түр. turqaq; м.б. turqay; "харуул"; tur- нь түрэг хэлнээ "зогсох" гэсэн утгатай; *Чингэс хаанд турхаг болтугай...(МНТ)*.

ТҮҮ хя. tao; м.б. tui; Анжис, тэрэг, чарга зэргийн хөллөгөөний урт дээс.

ТУУЖУУ хя. tiáo zhou; м.б. tuijii; Хог хаягдал арилган шүүрдэх жижиг шүүр; гол төлөв хялгасаар хийдэг.

ТУУЗ хя. tāo-zì; м.б. tuijia; Юм эмжих, хөвөөлөх, чимэхэд хэрэглэх тусгай нарийн зурvas эд.

ТУУЛ түр. toyla; м.б. tuyla; Бага Хэнтийн нурууны өврөөс эх авч Богд хан уулын араар урсаж Орхон голд цутгах 820 км урт гол. Зарим судлаачид энэ нэрийг гэлтэх гатлахын утгатай тулах гэсэн үгээс гаралтай гэж үздэг нь баталгаа муутай санал болно.

ТУУР хя. táo; м.б. tuij; Гөлгөр салаатай, урт зууван навчтай, ягаан цэцэгтэй, бөөрөнхий жимстэй, үзүүр хэлбэгий бага зэрэг тураг мод, түүнд ургах жимс.

ТУУЧИЙ хя. tǐ qí; Хараалын буюу доромж утгаар хэрэглэнэ, муу хар золиг; муу хар туучий!

ТУЯНЗ хя. tuò yún zi; м.б. tuyanja; Тэргэний морины хүзүүнд угладаг тоногийн зөвлөвч.

ТҮГ : түг таг тө. khrig khtag; м.б. tüg; Тиг нь монгол хэлнээ түг болон хувирчээ. Наяд буюу түг түмэн, түмэн түмэн, маш олон зэрэг утгатай.

ТҮЙ тө. khrus; м.б. tüi; "угаал"; түй өргөх (лам нар тэнгэр эзэгнэсэн бурхдад магтаал уншин, тахилч бумбатай рашаанаас толь руу дусаахад умзад өнгө өнгийн хадаг холбосон хивээр толийг арчих зан үйл).

ТҮН I түр. tun; м.б. tun; 1. балар шугуй; *Ононы тунд хуримлахуйд...(МНТ)*; 2. пад хар, хав харанхуй. Манж хэлнээ tun нь "арал, хойг" гэсэн утгаар хэрэглэгддэг бололтой.

ТҮН II тө. thun; м.б. tūng; "хувь"; Бурхны шашны зурхайн ёсоор хоногийн найманы нэг буюу гурван цагийг хэлнэ. Бас цагийн тогтсон хэмжээг ч хэлнэ; шөнийн түн.

ТҮНЖИН тө. mthun rgyen; м.б. tünjin; "зохилдох нөхцөл"; хорш. эв түнжин; түнжин хагарах (эв эвдрэх); ...та бүхний эв түнжинг эвдэгсэд гарвал ширүүн гараар хумъж өгөмз (З.Б.).

ТҮНШ хя. tōngshī; м.б. tūngshī; "хэлмэрч, орчуулагч"; 1. худалдаа арилжааны ажилд найзархаг; 2. дотно найзархаг нөхөр; түншлэх (түнш болох).

ТҮНЭР түр. tünag; м.б. tünér; "харлах, харанхуйлах, харанхуй"; Хав хар үзэгдэх байдал; хорш. хар түнэр; түнэртэх (хав харлан үзэгдэх)^

ТҮШИД дүшид; ...*Түшид тэнгэрийн газраас ...тэнгэрийн хөвгүүн...ирж...(12 зох)*.

ТЭВНЭ түр. teban; м.б. tebene; "тэмээн зүү"; Түрэг хэлнээ тэмээг teba гэх ба ап нь зүү гэсэн үг болно. Юм оёх бүдүүн зүү; хорш. зүү тэвнэ; Зэс тэвнэ авч хуга татвал намайг ална. (Гэс.).

ТЭГ тө. thig; м.б. teg; 1. тооны тэмдэг, бинт; юу ч үлдээгүйг илтгэнэ; 2. хов хоосон; 3. зураас, шугам; бурхны тэг; 4. хэмийн хэмжээ, хэлбэр; тэг хэм; *Сумийн маягийн байдал нь дөрвөлжин тэгээр байгуулмуй (МЗАО)*.

ТЭ ЖАН хя. tiē jiàng; м.б. tejiyang; төмрийн дархан; төмөрчин; төмөр зэсээ балбадаг тэж жантгийн холбоог сонсоно уу (МААЗДБ).

ТЭМБҮҮ хя. tiānpào; м.б. tembiy; Өнгөний халдварт яр өвчин, зан яр ч гэнэ; хорш. яр тэмбүү; тэмбүүрэх (тэмбүү өвчин тохиолдох).

ТЭНЗ хя. téng zi; мөб. tengse; 1. нарийхан урт ишгэй өдлөг нийлмэл навчтай, зууван урт баг цэцэгтэй, зөөлөн чанартай, бөх бат нэг зүйлийн мөнх ногоон модлог ургамал. Сагс зэргийг сүлжиж болно; 2. **шилж** тэнз modoор хийсэн бялуу шийдэм, таяг, ташуур.

ТЭНС тэнз.

ТЭНХИМ хя. tīng; мөб. tingkim; 1. хурал чуулган хийх буюу зочин гийчнийг дайлах, хичээллэх том тасалгаа; 2. хуучин цагт яамлан сууж хэрэг шийтгэх газрыг хэлж байжээ.

ТЭРБУМ тө. ther 'būt; мөб. terbūt; Арван оронтой тооны нэр, арван дүнчүүр; их тэрбум (арван нэг оронтой тоо).

ТЭРЛЭГ түр. terlik; мөб. terlig; "хөлсөвч"; Зуны дээл.

ТЭРС сам. tīrthīka; мөб. ters; 1. буруу номтон, чаалба; Бурхны шашны сургаалтан нар бурхны шашин бол дотоод ном, түүнээс бусад нь гадаад ном гэж үздэг. Гадаад номтон нь бурхны шашныг эс шүтэх тул тэrsүүд нар болно. Гадаад дотоод номтны ялгал нь юун гэвэл "турван эрдэнийг эрэн барьж итгэл явуулагчид нь дотоод номтон, Махишвари зэрэг ертөнцийн тэнгэр нарыг эрэн барьж итгэл явуулагчид нь гадаад номтон буюу" (Гүүш цорж); тэrs ном (аливаа шашинд харш ном); 2. зөрүүд, эсрэг, сөргүү; тэrs загнах (гажууд зөрүүд зан гаргах); тэrs этгээд (ёс зүйг баримтлахгүй зөрж явах этгээд); тэrsдэх (хэтэрхий тэrs болох); тэrsлүү (тэrs, эсрэг, тэrsлүү зан); тэrsлэх (зөрүү тэrs үйл ажиллагаа хийх, тэrs зан гаргах).

ТЭРСҮҮД тэrs; мөб. tersgūd; *Тэмээн сүргийн тэн хагас нь тэrsүүд хантал амьтад гэнэ.* (*ШХЗД*); тэrsүүд өдөр (зурхайн ёсоор шинэ гэр барих, бэр буулгах, сүм дуган барих, замд гарах, үр тариа тарих, мал адгуус цуглуулах, хишиг даллага авах, сүлд дуудах зэрэгт муу үйл нүүрлэх өдөр гэдэг).

ТЭРТИГЭ тэrsүүд; мөб. tertige; *тийн нөгчсөн бурхан багш бээр тэrtигэ нэрийг номхотгосон хувилгаан цагт...* (*МУЗД*).

ТЭРЭМ I түр. tārmä; мөб. temt-e; 1. чачир, орд; чачир майхан; *Ван хаан алтан тэрэм босгож хуримлан ажуутуу* (*МНТ*); 2. монгол гэрийн хана; *Найман тэрэмтэй хар цоохор барсын арьсаар бурсэн хош* (майхан) өргөөнд долоон настай хөвгүүнийг авч ирэв. (*УХТТ*).

ТЭРЭМ II тө. ther ma; мөб. tegem; Төвдийн гар үйлдвэрлэгчид хонины ноосоор нэхэж хийдэг байсан нэг зүйл бүдүүн ширхэгтэй

бөс; тэрмэн дээл; ...тэрэм жанчдаа рогдан хадаад чимэглэсэн... (*Гам.*)

ТЭТРҮҮ уй. taitur; мөб. tetürgü; Урвуу сөргүү, этгээд буруу, эсэргүү тэсэргүү; тэтрүү этгээд.

У

У-ГҮН хя. wú gong; мөб. u-güng; Чичүүр хорхой, 42 хөлтэй гэдэг. *Наян хөлтэй у-гүн чинь налж халтиргдаг...* (*Паж.*)

УВАДИНИ сам. upādhyaya; мөб. ubadini; "үйлдэгч"; 1. гэрээс гарах шагшаабад авуулагч хувраг; 2. хамба, сургаалийн багш ч гэнэ. Бас ханчин (mkhan chen) буюу их хамба ч гэдэг.

УВДИС сам. upadeśa; мөб. ubadis; upa (ойр, дөт)+desa (заан үзүүлэх)="дөтөөр зааж үзүүлэх"; 1. оньс уттыг хялбараар үзүүлэх, чухал онож үйлдэх, утга гүн бөгөөд агуу ихийг цөөн үгээр ухуулан үйлдэх ба мөрийн онол төрөхүй бэрхийг ч амар хялбараар үүсгэхийн нэр; увдисын гол (увдисын зүрхэн буюу эрхин гэсэн утга); 2. нууц эрдэм чадал, ур чадвар, илбэ ховс; *Гэсэрийг илжиг болгох увдис бүтдийг цөм би бүтээж өгсү* (*Гэс.*); 3. зөвлөгөө, сургамж, соёрхол; увдислах (увдис шингээх).

УВСАНЗ убсанз.

УВСАНЗ түр. ipasanc~ubasanč (<согд. 'wpas'nč<сам. upāsikā); мөб. ubasanča; Эмэгтэй увиши; Увшийн тайлбарт үз.

УВШИ тө. u ra si (согд. 'wp'sy); сам. upāsaka; ipra-(ойр, шадар)+saka (буян)= "буянд ойртсон"; мөб. ubasi; Буян нь амирласан нирваан гэсэн утгатай. Угтаа амь үл таслагч, эс өгснийг үл авагч, буруу тачаал үл хурьцагч, худал үл өгүүлэгч, дарс үл уугч, таван үест шагшаабадыг сахигч, гурван эрдэнийг бишрэгч, гэрээс гаралгүйгээр санваар авсан эрэгтэй гэнэн (үз) санваартан.

УГ түр. uk; мөб. ü; "төрөл, садан"; Удам гэдэг үгтэй хоршин (уг удам)төрөл садны утга илтгэнэ. Мөн угсаа, удам зэрэг утгатай; 1. ёзоор, язгуур; хэлний уг; 2. үүсгэл, эх, анх; уг нутаг, утийн бичиг (гэрийн үеийн бичиг); уг муутай (удам угсаа муутай).

УДАМБАР сам. udumbara; мөб. udumbara; Иш арваад тохой ондөр, навч зөөлөн, бас бүдүүлэг ширүүн ч бий. Цэцгийн дэлбээ нь гарын алга мэт том, олон цэцгийн дунд буюу эсвэл уулын далд газар ургадаг ургамал. Шашны домгийн ёсоор "шумнасыг дарагч" хэмээх нэртэй, түүний цэцгийн хэмжээ нь модон

тэргэний дугуйн хүрд төдий ба үнэр нэгэн бээрийн газар хуртэл түгэх машид эрхэм нэгэн мөн гэсэн байдаг. Мөн бурхныг мэндлэх цагт хамт ургаж, сүүлчийн нирваан (үз) болох үест хатаж алга болдог гэсэн домогтой.

УДАРБАДРАБААД сам. *uttarabhadrapadā*; м.б. *udarabadirabad*; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Махач заан одон ч гэдэг. Одоо Могойг хүлэгч од гэж нэрлэж буй.

УДАРБАЛГУНЬ сам. *uttaraphalgunī*; м.б. *udarabalgünī*; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монголоор Үхээр хар зардсын одон гэнэ; Одоо Харцага гэж нэрлэж байгаа. 2. Энэтхэгийн хаврын эхэн сар, цагийн хүрднээ өвлийн эцэс сар, хятад төвдийн хаврын дундад туурай сар, монголын хоёрдугаар сар.

УДАРИБАДАРБАД ударбадрабаад.

УДАРИБАЛГУНИ ударбалгунь

УДАРИСАД ударсад

УДАРСАД сам. *uttarasādhā*; м.б. *udarisad*; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монголоор Дөрвөлжин хур одон нэртэй. Одоо Элдэв тэнгэртэн гэдэг.

УДВАЛ сам. *utpalā*; м.б. *udabal*; *Nymphaea* Саегүлэа, *Mesconopsis integrifolius*; 1. Иш нь ногоон, навч нь уулзартай, цэцгийн хэлтэс ес, эрт цэцэглэж үдэш хумина. Өнгө улаан, үнэр анхилам сайхан цэцэг; 2. иш өндөр богино адилгүй, навч уулзартай, өнгө янз бүр, есдүгээр сард цэцэглэх үнэр сайхан цэцэг.

УЛУГ: улуг таг, түр. *ıluu tay*; м.б. *ıluu tay* (МНТ); "Их уул"; Одоо Булаг уул нэртэй болсон буй.

УМАА сам. *uma*; м.б. *um-a-a*; "бэрхийг няцуулагч эх"; Махашувараин хатан, охин тэнгэр. Энэ тэнгэрийг сүсэглэгчид түүнийг баястгахын тулд намрын дунд сарын шинийн еснөө нэг буюу гурван хоногт идээг тэвчиж биеэ галд тулэх ба мэсээр отглох тэргүүтнийг үйлддэг ажээ.

УМ-АА-ХҮМ тө. *om-ā-hum*; м.б. *om-a-a-hum*; Бурхны бие, хэл, сэтгэлийн бэлгэдэл болсон гурван үсэг. Бурхны оройг цагаан өнгийн ум үсгээр, хоолойг нь улаан өнгийн аа үсгээр, зүрхийг хөх өнгийн хум үсгээр тус тус томьёолно. Бас бурхны шашны номд ум аа нь төрөх, үхэхээс тонилгох, хум нь тамын халуун хүйтэн зовлонгоос гэтэлгэж чадах хүчтэй гэж тайлсан байдаг.

УМ ХУМГҮЙ тө. *om hum*; м.б. *um hum*; ум ма ни бад мэ хум гэсэн маанийн зургаан үсгийн эх төгсгөлийн хоёр үсгийг ч хэлэх завгүй, маш яаруу, ухаан зулагтүй гэсэн утгатай хэллэг; ...*lam narыг arga буюу Ombyg тавьж ум хумгүй зутгаан алга болов* (*С.Даш.*)

УМЗАД тө. *dbu mdzad*; м.б. *umžad*; "эхлэн зохиогч"; Шашны хурлын уншилага уншихад дагуулан уншигч, аргил буюу бүдүүн хоолойтой лам; Аливаа хийдийн гол дуганд их, бага хоёр умзад байна. Бага умзадыг сул умзад гэнэ. умзад хоолой; ...*guхээ сайтайгаараа умзад болжьё (MAY)*.

УПАНИШАД сам. *upaniśad*; м.б. *ubaniśad*; Олон зууны турш зохиосон вээдийн дуулалд хийсэн эртний энэтхэгийн шашин-гүн ухааны тайлбар, Вээдийн нэг хэсэг. Упанишад МЭӨ Х-ҮІ зууны үед зохиогджээ. Үүнд Вээдийн бурхад, зан үйлийг гүн ухааны агуулгатай болгож, хүмүүс ба орчлонтой зүйрээн адилтгасан дур болгон тайлбарласан. Упанишадад ертөнцийн сүнс-брахман, хувийн сүнс-аатман хоёрын нэгдэл, кармын хуулиар нэг төрлөөс нөгөөд шилжих үхэлгүй сүнсний тухай сургаалууд бий.

УРИГАСАРИ: уригасари чиндан сам. *uragasāracandana*; м.б. *urigasari*; Нэг зүйл зандан мод; ...*уригасари занданы үрэвдсэний хурыг оруулсугай хэмээн эzetэлдвэй (12 зох).*

УУЛЬ сам. *ulūka*; хинд. *ulū*; м.б. *uuli*; Махир хошуутай, том нүйтэй, шөнө дуугаран явдаг махчин шувуу.

УУШААН хя. *wuzhuāng*; м.б. *ušiyang*; Зэвсэгт цэрэг; *Уийн нөхөр Алтансүх уушаан цэрэгт явад ухсэн амьдын сурагтүй (МААЗДБ)*.

Y

ҮЙ ЗАН тө. *dbus gdzan*; м.б. *üi zang*; Төвдөд байдаг Үй мөрөн, Зан мөрөн; Зарим номд төвдийн хоёр том мужийн нэр гэдэг. Угтаа Үйзан орон гэвэл Үй нь Өмнөд төвд орон, Зан нь умарт төвд орон, нийлээд төвд орныг нэрлэх ерөнхий нэр ажээ.

ҮЙЗЭН ҮЙ ЗАН; м.б. *üijan*; Үй Зан хоёр нэрийг монголчууд хамтатган хэлж ирсэн уламжлалтай. Үйзэн мөрөн, Үйзэн далай гэхчлэн хэлэлцдэг; *Үйзэн мөрний усаар уух ундаа хийж..(ААЗ)*.

ҮЙ ТҮНİŞ хя. *wú tóng shu*; м.б. *tüngši*; "уянгат мод"; Уул довд ургадаг, өндөр, судал нарийн цул, өнгө шар нэг зүйл мод.

Домогт гардгаар бол өндөр нь гурван алд, гурван тохой, гагцхүү гарди шувуу суудаг гэнэ. Ятга хөгжим хийнэ.

ҮЙТЭНХУАР хя. wōduān huār; мө.б. ūyiteng quag; Цулгуй өнгөнд хээ товайлгож үйлдсэн нэг зүйл зузаан торго.

ҮР тө. "би"; мө.б. ūg-e; "ямар нэг юмны үр"; 1. уурагт бодисоос үүсэн гарч цаашид залгамжлах хөрөнгө болох юм; *хорш* үр хөрөнгө, үр үндэс; 2. хүүхэд; *хорш* үр ач; 3. үйл ажлын дүн; *хорш* үр ашиг; *үнэн нь өмнөө, үр нь хойноо* (*Зүйр*).

ҮРЖИН тө. u-rgyan; мө.б. ūgjīn; "толгойн чимэг" <сам. Odiyāna; Энэтхэгийн хойд хэсэгт байдаг Инд мөрний дээд урсгалын сав газар, одоогийн Пакистаны нутагт бий. Монголоор Дагшин орон ч гэдэг.

ҮРЖИНБА тө. u-rgyan ra; мө.б. ūgjīnba; "үржин хүн"; Уржингийн оронд мэндэлсэн ловон Бадамжунай төвдөд анх үндэслэсэн бурхны шашны нэг чиглэлийн нэр; Шүтгэг бурхад, өмсгөлөөр нь монголчууд улааны шашин ч гэдэг.

ҮРЖИНХАНД тө. u-rgyan mkha 'gro; "Дагшин орны отгоргуйгаар явагч дагина"; *Дунд биеийг нь Уржинханд нааар чимүүлсэн...Баян буурал Алтай дэлхий* (*ЗУАЗ*).

ҮРЭЛ рилү; мө.б. ūrel (манж: ūli); Бөөрөнхий хэлбэртэй мөхлөг, рилбү ч гэнэ; үрэл сум (жижиг мөхлөг хэлбэртэй, тусгал газартаа дэлбэрдэг сум); маанийн үрэл (ид шидгэй үрэл).

ҮС үснир; мө.б. ūsū; Хүн амьтны арьсанд ургах эвэрлэгээр бүтсэн нарийн ширхэглэг зүйл. Самгарди хэлний usnīsa гэдэг үгийн хураангуй хэлбэр.

ҮСНИР сам. usnīsa; мө.б. ūsnīr; "орой, үс"; Толгойн үс, гэзэг, орой зэргийн хүндэтгэл үг; *Нэгэн буурцаг нь оройн үснирт тогтвой* (*Үлдал*).

ҮСҮМБАД сам. upasampata; мө.б. ūsumbad; (тө. bsnyan par rdzogs); "нярваанд ойртох"; Гэлэн болохын нэр; ...*бурхан багшийн гэгээний өмнө одож инагш ир хэмээхийн үүднээс үсүмбад болвай* (*Цаг.Лян*).

ҮҮЛҮҮ хя. wū-liu; мө.б. ūlūy; "тав, зургаа"; Даалууны арван нэгэн нүхтэйгий нь хэлнэ.

X

ХААШ хя. hái shi; мө.б. qaši; Бас л, эцэстээ; хааш яапи.

ХАВ хя. hā ba; манж. kabari; мө.б. qaba; Урт сэгсгэр үстэй, богино мөчтэй, охор хоншоортой, арслантай адилдуу нэг зүйл бяцхан нохой.

ХАВАН манж. hafan; мө.б. qabān~qavan; "тушмэл"; Ноёдын хиа нарын дарга, хафан ч гэнэ; ...*тэгс өрөөлт хаван хиа нар* (*З.Б.*).

ХАВЛАН түр. qaplan; мө.б. qablan/qabalān; "МНТ"-г судалсан эрдэмтэд "барс, ирвэс, цоохор бар" гэхчлэнгээр тайлбарласан байдаг. Угтаа уул хаданд байдаггүй, тал хээрт амьдардаг, цагт 100 км хурдалдаг, биеийн урт 150 см орчим, сүүл нь 75 хүртэл см урт мийн язгуурын махчин амьтан. Энэ нь францаар guepard буюу оросоор гепард гэдэг амьтан бололтой. Монголоор өчүмбэр гэх бөгөөд сонгодог бичгийн хэлний "өчүүхэн бар" гэсэн угсийг хурааж нийлүүлсэн нэр томъёо ажээ. Нэг зүйл барын нэр болно.

ХАВСАЙ тө. kha bza'; мө.б. qabsai; "амны идээ"; Усаар зуурч, тосонд чанасан, уртхан дөрвөлжин хэлбэртэй боов, боорцог.

ХАВХАГ тө. kha 'khebs; мө.б. qabqaу; таг, халив, таглаа, нээлхий; авдрын хавхаг.

ХАВШАА тө. hab ša; мө.б. qabšiy-a; "хэрүүл, шагшаан"; Углээ яншаа; хавших (а. олноор шагшин хэлэлцэх, нийтээр хэлэлцэн муулах; б. амандаа углэж янших).

ХАД түр. qat; мө.б. qad; "жимс"; Иsgэлэн амттай, хүрэн боржимстэй, навч зулгардаг тураг мод, жимс нь.

ХАДАГ тө. kha dog; мө.б. qadaу; "өнгө"; 1. хүндэтгэлийн ёслолд барьж өгөх тorgон мяндсан нэхмэл эд; *хорш* хадаг шудаг, хадаг самбай; хадаг тавих(хүүхнийг гүйж хадаг барих); 2. арилжаа наймаанд мөнгийг орлож байсан хэрэглүүр. Хадгийн анхны нэгж нь самбай, түүнээс дээш даш, сэрш, ходоод, вандан, соном, аюуш гэхчлэнгээр ялгадаг байжээ.

ХАЙВ тө. mkhas pa; мө.б. qayibū; Эрдэм ухаан төгс хүн, таван ухаанд нэвтэрсэн эрдэмтэн; хайв хүн.

ХАЙГА манж. haiga; мө.б. qayi-y-a; Өргөн хавттай биетэй, эртгэр амттай, нарийн хайрстай нэгэн зүйл загас.

ХАЙЛАН I хя. hāi lān; мө.б. qayilang; "далай хөх"; Цэнхэр хөх өнгийн нарийн бес барааны ерөнхий нэр. Хөлөнгөр ч гэнэ.

ХАЙЛАН II : ам хайлан тө. khas len = kha len pa; мө.б. qayilan; "ам авах, үг авах"; Ам тангараг авах, жилд нэг удаа зуны адаг сар 45 хоногийн туршид бурхны шашны гэлэн, гэцэл зэрэг санваартны сахих нэг зүйл хурал; ...*хайлан хурал хурах бүх зардлыг ардаас татдаг байжээ.* (*Б.Р.*).

ХАЙМАР орос. камера; монг. qayimar; Эрзээн олгой.

ХАЙТАН хя. häi tän; монг. qayitan; Хоёр алд орчим өндөр, улаан ягаан цэцэгтэй, шар улаан жимстэй тураг мод, түүний жимс, цэцэг. Цэцэг нь хавраар цэцэглэнэ.

ХАЙЧИН манж. haičin (<хя. hai qin); монг. qayičing; Начин, шонхор шувууны өөр нэр.

ХАЛААД орос. халат; Тэрлэг, бошинз дээл; нөмрөг; эмнэлгийн халаад.

ХАЛБИНЬ манж. halifini; монг. qalbini; Шаахай ултай адил хэлбэртэй, нэг талдаа хайртай, нөгөө талдаа хайрсгүй, хоёулаа нийлсэн хойноо явж чаддаг нэгэн зүйл загас.

ХАЛИВ тө. kha leb; монг. qalib; "бүрхээс"; хавхаг, таг, таглаа; халивлах (хавхаглах); Бас тогоо бүгээх дүргэг хавтгай мод ч гэдэг.

ХАЛИМ манж. halimu; монг. qalimu; Далай тэнгист орших нэгэн зүйл сүүн тэжээлт амьтан. Дэлхий дээрх хамгийн том амьтан, биеийн хэлбэр загас мэт. Буу загас ч гэдэг.

ХАЛУУ тө. ha lo; монг. qalu; а. модлог шулуун иштэй, том навчтай, багларч ургасан одон хэлбэрт үстэй хоёр наст өвслөг ургамал, Жамба цэцгийн язгуурт багтана; б. халуу мэргэн - шаравтар өнгөтэй, бүдүүн хүзүү, урт жигүүр, охор сүүл бүхий загасчлагч шувуу.

ХАЛУУСАР тө. halo+мо. sag; монг. qalusar; Элээтэй адил агаад эрээн өрөвлөгтэй нэг зүйл шувуу. Уйгар, түрэг хэлнээ сар нь элээ гэсэн утгатай.

ХАМ ХҮМ тө. kham khum; монг. qam qum; "эндүү андуу"; Аливаа юм эндүүтэй болсон нь; хам хум хийх (ор нэр хийх, оронцоглох).

ХАМБА I тө. mkhan ro; монг. qanbo; Шашны ёсны сүм хийдийн хэргийг тэргүүлэн удирдах хүний тушаал; Хамба номун хаан (шашны хурал номын үйл, лам нарын асуудлыг хариуцсан тушаалтан)^

ХАМБА II тө. kham bu; монг. qambu; Armeniaca vulgaris L; Иш том, бат бэх, улаан шаргал түяатай цагаан цэцэгтэй, үр жимсний амт гашуун ургамал. Зэрлэг ба таримал хоёр янз бий.

ХАМБА III: нар хамба; тө. kham bu; монг. qambu; Улаан шаргал өнгөтэй, сайхан амттай нэг зүйл жимс; тоор, буйлс, бүглэс, чангаанз гэхчлэнгээр нэрлэх ч бий.

ХАМЖААР хя. kāpjān; монг. qanjiyag; Ханцуйгүй охор хувцас буюу цээжмэг, ханжаар, хантааз ч гэнэ; ...утта бүхий хятал

бичигтэй бараан хамжаар өмсчээ. (З.Б.); ханжаарлах (хамжаар өмсөх).

ХАМПААН орос. компания (<фр. compagnie); 1. компани, нэгдэл; 2. түнш, найз нөхөр, хамжаа.

ХАМПАР тө. kham phor; монг. qampor; 1. мөнгө, алт, зэс тэргүүтнийг хийж хайлуулах галууны өндөг мэт хундага; 2. шавар аяга.

ХАНАХ тур. qan- ; монг. qanaqu; "цус"; Эмчлэх зорилгоор судсыг хатгаж цус гаргах.

ХАНГАРДИ монг. qan+сам.garuda; үз. гарди; 1. гардийн нам нь буюу үлэмж сүрлэг нь; 2. Улаанбаатарын өмнө этгээдэд орших Богд хан уулын эзэн савдаг; Домгийн шувуу-гардийн хэлбэрээс баахан ялгаатай дүрсэлсэн байдаг; 3. монгол улсын нийслэл Улаанбаатар хотын судл.

ХАНД тө. khan da (<сам. khanda); монг. qanda; 1. юмыг шингэн юманд чанаж дарж идээшүүлэн шимийг шингээн авсан хорхог; цайны ханд; ханд эм; 2. өтөрүүлсэн ундаа.

ХАНДИВ тө. kha 'debs; монг. qangdib; "өргөл, нэмэр"; тусламж тус, нэмэр, нэмж өгөх юм; хорш өргөл хандив; хандивлах (хандив өгөх).

ХАНДМАА тө. mkha' 'gro ma; монг. qangdom-a; "огторгуйгаар явагч эх"; 1. тарни бүтээсний учир огторгуйд явагч тэргүүтэн ирд хувилгаан олсны нэр; 2. Бурхны шашны сахилыг төгс сахисан гэлэнэмаа нарын дээд нь; Харанхуй их модтай Хандмаа нарын орон байна (МААЗДБ).

ХАНЗ хя. kāng zi; монг. qanja; Гэр байшигийн талыг эзлүүлэн шавар тоосгоор барьсан, гал түлж халаадаг, суух хэвтэхэд зориулсан ор буюу хөмрөг; ханзан ширээ (намхан том ширээ).

ХАНИР тө. khan gnuer; монг. qanir; Гонир лугаа адил боловч сүм хийдийн гол дутаны цэвэрлэгч.

ХАНИС хя. huānzāi; монг. qanis; Доргоны зулзага, ганис ч гэнэ.

ХАНТААЗ хя. hāntāz/hāntāzi; монг. qantaayaja; Гадуур өмсөх, ханцуйгүй цээжмэг хувцас. Хамжаар ч гэнэ.

ХАНУУР түр. qanayu; монг. qanayug; "цус гаргах хоёр ирт мэс"; судас хатгаж, цоолох, ханах хэрэгсэл.

ХАНХАЙ түр. qangya; монг. qangqa; "тэрэг"; 1. шатрын тэрэг; 2. ачаагүй; ханхай эмээл (ачааны эмээл); ханхай тэрэг (ачаагүй тэрэг).

ХАНЧИН I тө. khams chen; мө.б. qančin; "Их хам (орон)"; Төвдийн нэгэн газар орны нэр. Хамын орон. Энэ газрын нэрлэсэн зүйл цөөнгүй; ханчин гутал (төвд гутал); ханчин булигаар (төвд булигаар).

ХАНЧИН II тө. mkhan po chen po = mkhan chen; мө.б. qančin; "их хамба".

ХАНШ I хя. hánsi chōu; мө.б. qansi/qangsi; Ханы тойротг хийсэн нэг зүйл маш нимгэн торгон бараа.

ХАНШ II хя. hág shí; мө.б. qangsi; Тогтоосон үнэ; **хорш** үнэ ханш; валютын ханш; ханшлах (үнэ тогтоох).

ХАНШ III хя. hán shí; мө.б. qangsi; Билгийн тооллын хорин дөрвөн улирлын хаврын дундаж үе, аргын тооллын дөрөвдүгээр сарын эхний арав хоногт тохионо. Ханш нээх буюу ханшийн улирал гэнэ. Хятад хүмүүс энэ өдөр өвгөд дээдсийнхээ булшин дээр очдог тул хаврын баяр ч гэдэг. **ханшлах** (ханшийн өдөр өнгөрүүлэх).

ХАРАНГА тө. mkhar tnga; мө.б. qarangy-a; хүрэл мэтээр хийсэн дүгрэг хэлбэртэй, голдоо хонхорхойтой, хурал ном хурах дохиог хуралдагсдад өгөх үед цохидог хөгжмийн зэмсэг; *Цогчин сүмийн үүдиээ харанга дэлдэх чимээ хэд хэдэнтээ сонсдов* (*С.Даш*).

ХАРИЙ сам. harī; мө.б. harī-qari; Хүрэн, цайвар хүрэн; *Харий зандаангийн үнэр зээ* (*Д.Р.*).

ХАРС : харс тас; тө. khara; манж. qarasu; мө.б. qarasun; Усан тасаас биеэр бага, өнгө хар нэг зүйл тас шувуу.

ХАРУУЦ тө. kha tu tshwa; мө.б. qaruča; Хар өнгийн нэгэн зүйл давс, эмнэлэгт хэрэглэнэ.

ХАРШ I түр. qarši; харьц. тө. mkhar; мө.б. qarsi; Хүндэт эрхэм хүний байрлан суух орд буюу нийтээр хуран цугларч ямар нэг арга хэмжээ явуулахад зориулсан байр; **хорш** орд харш.

ХАРШ II түр. qarši; мө.б. qarsi; Үл нийцэх, үл тохирох; эсрэг тэсрэг, эрс тэс; зохисгүй.

ХАС сам. svastika; мө.б. qas; Дөрвөн үзүүрийг нь тэгш өнцгөөр нуталсан тоонолж хэлбэртэй зураг, хас тэмдэг ч гэнэ. Хийсвэр сэтгэлгээ, зөн билгийн нууцыг агуулсан шинж чанартай. Тодруулбал эих амгалан, эрс хөдөлгөөний утгатай болно. Монгол хэлнээ хас тамга, хас төр гэхчлэнгээр хэлэлцдэг нь бат бэхийн билэгдэл болгосон хэрэг аж. Свастика-тийн тайлбарыг үз.

ХАСДАА сам. hasta; мө.б. qasda; Сарны зурхайн ёсны 28 одны нэг, Буд гаригийн харьят, өмнө зүгт орших нэг од. Түүхчин од гэж нэрлэнэ.

ХАЧИ сам. khaśa; мө.б. qaśi; кашмир; хачи гүргэм; *Хачийн дархан хадаж хийсэн, хайч түүнийг мляаая* (*Зуун бил*).

ХАЧИН гачен; *Бэйсийн хачинд өдөр турш явж очлоо* (*Ц.Д.*).

ХАШАА түр. qaś; мө.б. qasiy-a; "хил хязгаар, зааг, эрэг хөвөө"; 1. юмыг хүрээлэн хорих, халхлахаар тойруулж барьсан зүйл; 2. хот суурин газарт мод шургааг зэргээр хүрээлүүлж барьсан хороо сууц.

ХИА манж. hia; мө.б. kiy-a; Ноёд хутагт хувилгаадыг дагалдан үйлчилж явах доод тушаалтан, бараа бологч нар. Ноёд тайж нарын хия нь хар хүн, хутагт хувилгаадын хия нь доод лам нар байсан тул ноёны хия, лам хия (хия лам) гэж ялгадаг байв.

ХИАБАН хя. sià bù; мө.б. kiyaban; Монгол олсны ширхээр нэхсэн нэг зүйл зотон; хиевэн ч гэж бичдэг.

ХИВ тө. khebs; мө.б. 'kib/kib; Нимгэн тортомсог бараа; хив хадаг, өнгийн хив.

ХИЖИМ манж. kijimi; мө.б. kiójimi; Бөөрөнхий өт хэлбэртэй, өргөслөг арьстай, амны орчим тэмтрүүлтэй, далай мөрөнд төрдөг нэг зүйл хорхой, зуушинд хэрэглэнэ.

ХИЙД сам. khetā; мө.б. keyid; "тариачид, газрын эздийн орон сууц, жижиг тосгон" гэсэн утгатай. Монгол хэлнээ Юань гүрний үед лам нарын орон сууц гэсэн утгатай байв. Сүүлд нь шашны ёсны гэлэн лам нарын хуран суух сүм, орон гэсэн утгаар хэрэглэгдэх болсон. Их төлөв аглаг ууланд барьсан сондгой ганц буюу хэсэг сүм дугантай, лам нарын суух аймаг хороололтой байгууламж. Үүнээс үндэслэн энэ үтсийг хий зайд буюу аглаг хий газарт суух гэсэн утгатай гэж үзэх нь бий.

ХИЛЭН хя. qílín; мө.б. kiling; Хамар дээрээ нэг буюу хоёр эвэртэй, сүүн тэжээлт амьтан, хирс ч гэнэ. Мөн домогт гардгаар бол ганц эвэрт нэг зүйл гөрөөсийг хэлнэ. Түүнийг билэгт гөрөөс ч гэдэг.

ХИЛИНЦ уй. qilinč, (qilinč~qilinča~qilinč <сам. klesa>; мө.б. kilinče; Гэм, нүгэл, буруу муу үйл; **хорш** нүгэл хилэнц; гэм хийвээс цааз бэрх, хилэнц хийвээс там бэрх) (*Зуун бил*).

ХИЛЭНЦЭТ уй. +мо (<сам. klesita>; хилэнц бүхий; хилэнцэт хорхой (ямаан ууц буюу дигваранз).

ХИМ хя. qīnmá; мөб. kimi/kim-a; 1. дүгрэг том навчтай, ногоон иштэй, монгол амуутай төстэй нэг зүйл ургамал; 2. энэхүү ургамлын ишний хальсийг боловсруулж хийсэн нэг зүйл муухан чанарын олс; 3. жамба цэцгийн язгуурын нэг наст өвслөг ургамал, шар цэцэгтэй, хонгорцогт үртэй олсны нэгэн зүйл ургамал.

ХИМАЛАЙ сам. Himalaya (Hima-цас, ālaya-орон)=Цастин орон.

ХИНААЯНА сам. Hīmāyana (тө. theg dman); "бага хөлгөн"; Бүдийн гүн ухааны хоосон чанарын онолыг төдийлөн судалдаггүй их төлөв бурханд залбирч мөргөх хүж, зул, тахил өргөх, бэрхшээлд биеэ дасгах зэрэг зан үйлийн чанартай үйлст амьдралаа зориулах тухай гүн ухааны нэг урсгал.

ХИСМАД түр. qismat (<араб. qismat); мөб. kismad; Хувь заяа, тавилан заяа; ...хисмад салиг буу (*Turph.*).

ХОГ түр. qoq~qoq; мөб. qoq; "тоос, тортог"; 1. новш, хаягдал; юмын дахин хэрэглэгдэхгүй үлдэгдэл; 2. шилж. үлдэгдэл, эд хөрөнгө; 3. үйрмэг, нунтаг; 4. муухай юм; *хорш*. хог саг.

ХОДООГ орос. ходок (ярианы); Хойд талын хоёр дугуй нь өндер, урд хоёр дугуй нь жижгэвтэр, арал бүхий тэрэг.

ХОМ түр. qom; мөб. qom; "тэмээний тохоп"; 1. тэмээнд ачаа ачихад нуруу зоог нь хамгаалах зөвлөн эсгий бамбай; 3. хөллөгөөний малын хүзүүнд углаж, оосроор тэргэний аралд холбох зүйл; хомын ширдэг (тэмээ хомнох ширдэг); хомлох (хомнох); хомнох (тэмээнд хом нөмөргөн тогтоох).

ХОНЖОО хя. hóng jiǎng; мөб. qonjū-a; хожоо, хонжвор; хонжиж олсон ашиг; *хорш*. ашиг хонжоо; хонжооч (хонждог, хонжиж амтассан); хонжих (үнэ нэмж завшин ашиглах; тоглоомд тоглож давах; давуу байдлыг олж чадах); хонжвор (хонжиж авсан юм).

ХОНЗОН тө. khon 'dzin; мөб. qongjin; "өшөө барих"; Өвөрлөсөн занал, хадгалсан хорсол, өс; *хорш*. өшөө хонзон; хонзон өвөрлөх (өших); хонзон авах (өшилсөн санаагаа биселүүлэх); хонзогнох (өшөө хорсол хадгалах).

ХОНОГ түр. qopıç; мөб. qopıç; "зочин, зочлон хүндлэх"; 1. өдөр шөнийн хорин дөрвөн цаг; 2. шөнө, шөнө хонох нь; хоноглох (хонох); хоноц (гаднаас ирж хоносон хүн); хонох (шөнийг өнгөрөөх, нөхцөөх).

ХООВОН хя. hōréñ; мөб. qobung; 1. нүүрс хөлгөөн ноцоох сав; 2. *шилж*. шомбогор, ёмбогор; хоовон толгой.

ХОР I түр. qor; мөб. doog; 1. хордуулж гэмтээх бодис; 2. *шилж*. гэм хөнөөл, аюул; *хорш*. хор хөнөөл.

ХОР II тө. hog; мөб. qog; хор монгол (дээд монгол), Шарай голын монголчууд.

ХОРВОО тө. 'khor ba; мөб. qogu-a; орчлон (орчих гурван ертөнц), дэлхий ертөнцийн ерөнхий нэр.

ХОРГОЙ тө. hor gos; мөб. qogoy; "монгол хувцас"; 1. Монгол улсын үеийн нэхлэгт сайн торго; 2. алтан утсаар ар гарган хийсэн зузаан торго; Нолом ч гэнэ.

ХОРМУСТ түр. qormuzta (<сөгд. *χορμζτ*); мөб. qormusta; Гучин гурван тэнгэр нэрийн эрхэм нэгэн тэнгэрийн нэр, хурмаст ч гэдэг. Угтаа гэрэл хийгээд сайн эхлэлийг бүтээх зороастризмын шашны тэнгэр.

ХОРОЛ I тө. 'khor lo; мөб. qorlu; 1. төр улс, айл гэр, хүн ард нь номын гэрлээр гийгүүлэгдэн юунд ч дийлдэшгүй бат байхын билэгдэл, хаан төрийн долоон эрдэнийн нэг. Найман хэгээс бүхий хурд. Хорлын хоёр талд хөлөө бохирсон хоёр бодь гөрөөс байдаг нь Бурхны шашин дэлгэрсэн түүхтэй холбоотой; 2. амгалан тайвнаар орчин эргэлдэхийн билэгдэл болсон найман тахилын нэг; 3. хэгээс цагираг бүхий ямарваа нэг дугуй юм; хорол тамга (дундаа чагт бүхий дугуй цагираг хэлбэртэй); 4. монгол улсын төрийн сүлдний доод хэсэгт байдаг ашид дэвжихийн өлзий хутгийн билэгдэл.

ХОРОЛ II тө. 'khor lo; мөб. qorlo; Нэгэн зүйл тоглоом, хорол, чандмань, хас, гарди ба жилийн арван хоёр эрхтний дүрс бүхий зүйлээр даалуу мэт наадах тоглоом.

ХОРОМ түр. qogum; мөб. qogum-a; Хайрга чулуу, нүүдэлэл элс.

ХОТ сам. kotta; мөб. qota; 1. олон хүн нэгэн газарт хуран цугларч, орон барилга цогцлуулж суурьшсан, үйлдвэр худалдаа, засаг захирагааны байгууллага төвлөрсөн газар; 2. айл өрх, хөдөө газарт ганц нэгээр буюу хэд хэдээр хамтран буудалласны нь.

ХОТОН тө. ho thon; мөб. qotan/qotong; Хунтай адил үнсэн өнгөтэй, загас барьж илдэг сүргээр явдаг шувуу.

ХОШ түр. qos; мөб. qos/qos (МНТ); Гэр, майхан; түрэг хэлнээ бууц, тарианы газрын ойролцоо хүн суух гэр, түр зуурын бяцхан сууц, аяны гэр зэрэг утгатай.

ХОШИЛИГ түр. qosılıq; мөб. qosılıy (МНТ), хом.

ХӨЛ түр. köl~göl; мөб. köl; Нуур; Хөвсгөл гэдгийн -гөл, Байгал гэдгийн -гал, Хөлөн Буйр гэдгийн Хөл- цөм нэг гаралтай болно.

ХӨЛӨГ түр. kö/küllük; мөб. kölüg; хө- (алдар суу)+лүг (баатар; уралдааны морь); 1. өрлөг баатар; Чингисийн дөрвөн хөлөг баатар; 2. сайн морь; ажинай хөлөг.

ХӨМӨЛДРӨГ түр. kömüldürük; мөб. kömüldürge; "зүрхэвч"; Эмээлийг хойш нь явуулахгүйн тулд эмээлийн урд хавтаснаас тортон, морь малын омруунд хийх нэг зүйл хэрэглэл; хөмөлдрөглөх (морь малд хөмөлдрөг хийх).

ХӨР түр. kör~göt; мөб. kör-; "үзэх, харах"; Эртний монгол хэлэнд хэрэглэгдэж байв. Орчин цагийн монгол хэлнээ зураг, дурс, зурмал, буулгамал зэрэг утгатай хөрөг гэсэн уг болсон.

ХӨРШ уй. körši; мөб. körši; Айл, зэргэлдээ, залгаа; хорш. айл хөрш.

ХУА I түр. quva; мөб. quva; "шар улааны дундын өнгө"; 1. цайвар улаан буюу бүдэг шаравтар өнгө; 2. малын зүс, цайвар улаавтар өнгө; орчин цагийн монгол хэлнээ ухаа болж хувирсан.

ХУАЖАН хя. hùa jiāng; мөб. quva ĵang; Зураач, зурагч; зурах урлах мэргэжилтэн; тэг л зургаан зурдаг хуажангийн холбоог сонсоно уу (*МААЗДБ*).

ХУАЖУУ хя. huā jiāo; мөб. quvajuu; Халуун оронд ургадаг нэг зүйл ургамлын үр, халуун чанартай. Эмнэлэгт болон хоол хүнсэнд хэрэглэнэ. Мөн хуужуу ч гэж бичдэг. Хар чинжүү, ярам гэхчлэнгээр нэрлэнэ.

ХУАЙС хя. huái zī; мөб. quvayisa; Буурцагт ургамлын язгуурын бутлан ургадаг нэг зүйл мод, хуайз ч гэдэг, үрээр нь юм будна.

ХУА П хя. huá; мөб. quva; Архи айраг уух, зугаа цэнгээний үед арван хуруугаар тоо таалцан наадах нэг зүйл тоглоом.

ХУАЛАХ хя. huáquán; мөб. quvalaqu; Аялгуулан дуулж хуруу гарган наадах.

ХУАНГУА хя. huāng huā; мөб. quvang gua; Боловсруулахгүйгээр идэж болдог нэг зүйл ногоо, хэмх ч гэнэ.

ХУАНДИЙ хя. huāndi; мөб. quvangdi; Хуучин цагт улсын эзэн хааныг хэлж байв.

ХУАНЛИ хя. huáng li; мөб. quvangli; Цаг улирлын тооны бичиг, үгчилбээс "эзэн хааны лит" гэсэн утгатай.

ХУАНТАЙЗ хя. huáng tàizī; мөб. quvang tayı̄şı; Хуучин цагт хааны тэргүүн хүү буюу оп залгамжлах хөвгүүнийг хэлж байв.

ХУАНТАЙХУ хя. huáng tàihū; мөб. quvang tayiqu; Хааны эх.

ХУАНХҮҮ хя. huang hou; мөб. quvangkeü; Хааны эх буюу их хатан.

ХУАР хя. huār; мөб. quar; "цэцэг"; 1. цэцэг; хорш. цэцэг хуар; 2. элдэв хээ угалз; хорш. хээ хуар; орой дээр нь одон хуар (*МААЗДБ*); 3. шилж. бодоо өвчний цээр нэр.

ХУАРАН манж. huwaran; мөб. quaran; "цэргийн хүрээ"; цэргийн орших байр газар; хуарагнах (цэргийн хуарандаа байрлах).

ХУАСАН хя. huá shēng; мөб. quasang; Нэг зүйл том самар.

ХУАЦАЙ хя. huācài; мөб. quačai; цоохор ногоо, цэцэгтэй бөөрөнхий цагаан ногоо.

ХУАЮУР хя. hua ya; Хурууны хээ; хурууны хуаюур.

ХУВ хя. hǔpò; мөб. quba(n) (зөрч. hu-p'oh); 1. давирхай мэт нэг зүйл хатуу эд, гоёл чимэлд хэрэглэнэ; 2. цайвар шар.

ХУВИН хя. huibréen; мөб. qubing; "дарсны сав, домбо"; Шингэн юм агуулах нэг зүйл сав суулга.

ХУДАГ түр. quduy/qujuu; мөб. qudduy; Газрыг малтаж гаргасан устай нүх; худаглах (худаг шиг ухах).

ХУДАРГА түр. qudrug~quduriq, qudu- "сүүл"; мөб. quday-a; 1. эмээлийн хавтасны хойт этгээдэд уяж морь малын сүүл бөгсөнд тогтоох оосор бэхэлгээ; 2. шилж. эзгүй хойгуур, ар бөгсөөр; хударгаар нь.

ХУЖАА хя. hua qiao; мөб. qujū-a; Харь оронд цагаачлан суугаа хягад иргэн; Гэвч энэ үгийн талаар эрдэмтдийн санал харилцан адиulgүй байдаг. Зарим нь "найз, түнш" гэсэн утгатай hño jí гэсэн уг гэж үздэг.

ХҮЙ I хя. hui; мөб. qui; Хавтгайдуу урт биетэй нэг зүйл загас, зэвэг загасны зулзага ч гэдэг.

ХҮЙ II: хурал хуй хя. hūi; мөб. qui; хуйн хурал (өртөөний хурал, жалгын хурал мэтийн жижиг газрын цаг цагийн хурал).

ХҮЙ III хя. hūi; мөб. qui; "үнс, чандруу; шохой"; эргэлдэн мушгирч неөлгөлөх салхи; хуй салхи.

ХҮЙМАГ хя. huībīng (уй. kuimak); мөб. quyimaü; Шингэн зуурсан гурилыг халуун тосонд хайрсан нэгэн зүйл боов, хуйван ч гэнэ.

ХҮЙХ түр. quiqa; мөб. quuiq-a; "арыс"; 1. арыст юмны үсийг тулж, арилгасан хөрс; 2. үст юмны соргүй үлдэц; 3. толгойн оройн арыс.

ХҮЙХҮЙ хя. huì huí; мөб. quyiqui; 1. Хотон аймаг; *хорш* хийхүй хотон; 2. *шилж* дээрэм хийгч; тонуулчин; Өнгөрсөн зууны дунд үеэр баруун хойт хятадад гарсан түрэгчүүдийн нэг бослогод оролцогчид нь дарагдан зугтаахдаа замдаа дээрэм хийж түйвээжээ. Иймд тэднийг бас хуйхуй гэх болжээ. Төвдөөр *hus hus* гэдэг нь хятадаас орсон үг.

ХУЛ хя. hú-lu; мөб. qūshí; Хумбагар хэлбэртэй том модон тагш. Хулууны хатуу хальсаар хийж байснаар нь ийн нэрлэжээ.

ХУЛУУ хя. hú lu; мөб. qūshí; Өнгө цайвар, хэлбэр бөөрөнхий, зууван зэрэг янз бүр, зөвлөн үстэй, нялх жимсийг нь буцалгаж буюу зүрэмлэн хатааж идэж болно. Хатуу хальсаар нь шанага, сав суулга хийнэ. дий хулуу (дун хэлбэртэй, давслан идэх жижиг ногоо).

ХУМХ сам. kumbha; мөб. qumq-a; 1. алт, мөнгө, зэс гууль тэргүүтнээр хийсэн амсар цухал, ёроол уужим хэлбэртэй аршаан агуулах, цорго бүхий сав. Бумбатай ойролцоо, найман тахилын нэг; 2. хумхын орд (гэр); 3. зааны толгой.

ХҮНДАР тө. hundhara<сам. humdhara "хумыг баригч"; Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын нутагт байдаг тахилгат уул.

ХҮНЗ хя. kuāng zi; мөб. qunja; Цайны сав, нэг хунзанд 27-36 цай ордог байжээ.

ХҮНЛИН тө. hon len (<хя. huan liyan); мөб. qungling; Хурц шар цэцэгтэй, улбар шар өнгөтэй, өтгөн шүүстэй олон наст ургамал. 30-40 см өндөр ургана. Мал иддэггүй, эмд орно.

ХҮНЛУУ хя. hong la; мөб. qunglisi; "улаан лаа"; Их төлөв цагаан сарын үеэр хятад нутагт гэрийнхээ үүдэнд өлгөж асаадаг улаан хорготой лаа, угтаа хунлаа юм; *хулсан гэрийнхээ үүдэнд хунлуу лаагаар юугаа хийх вэ хо.* (МААЗДБ).

ХҮНХУУЗ хя. húnhúzí; мөб. qunghuíja; Дээрэмчин, хоёр дахь үеийн үг нь хууз (сахал) гэсэн үг болно.

ХҮНЧИР хя. huángqí; мөб. qinčíg; Буурцагт ургамлын язгуурт багтах олон наст өвслөг ургамал. Хонгорцогт жимстэй, шар цэцэгтэй, үндэс нь эмд орно.

ХУРАМ перс. qurta; мөб. qurt-a; Халуун газарт ургах нэг зүйл мод, түүний жимс. Үр жимсий нь түүхийгээр буюу хатааж иднэ. Хурма ч гэж бичдэг.

ХУРАНДАА манж. huwaran-u-da; мөб. qurangda; "хорооны дарга, хуарангийн дарга"; Хошууч генерал цолын дараах цэргийн даргын дээд цол.

ХУРМАСТ *хормуст.*

ХУС I хя. hé zi; мөб. qusa; Идээ хийх нэг зүйлийн сав, багвар ч гэдэг.

ХУС II хя. huáshi; мөб. qusa; Тэнэгэр чулуутай адил зөөлхөн нэг зүйл чулуу.

ХҮУ I хя. hù; мөб. quu; Төмөрлөгөөр хийсэн сэнж, амсар, таг бүхий данх сав, шингэн юм агуулна. dangqu, tungqu зэрэг үтийн бүтцэд байгаа *qu* гэсэн үг болно.

ХҮУ II хя. háo; мөб. quu; 1. лангийн түмэн хувийн нэг; арван хуу нэг лии болно (37,3 гр); 2. тохойн түмэн хувийн нэг.

ХУУДУУ хя. hú tu; мөб. quashuu; 1. базаахгүй муу зан байдал; 2. *шилж* хуудам; залхай, хөнгөн мечид; хуудуутай (төлөв зэхий байдалтай).

ХҮУЗ хя. hú zi; мөб. quija; Хүний эрүү шанаагаар ургасан битүү сахал, хуус ч гэнэ; хуузрах (хуузтай болох).

ХУУЛЬ хя. fáilù; мөб. qauli; 1. зүй тогтоолоор илэрч гарах үнэн байдлын аливаа үзэгдлийн хоорондын холбоо ба харьцах зүй тогтол; 2. төр засгийн дээд эрх барих газраас заавал мөрдүүлэхээр баталсан тогтоол, дүрэм.

ХУУШААН хя. hva šang/hé shang; мөб. quušang; Хятадын бурхны шашны гэлэн буюу хөхийн шашны лам.

ХУУШУУР хя. huǒ-shao; мөб. quušuur; Татсан маханд ногоо давс холин гурилд хучиж, хавтгайлан хайрч болгосон хоол.

ХУШГА сам. vasika; мөб. quší-y-a; 1. дулаан оронд ургадаг модны үр жимс, хатуу хальстай, цөмөө ихтэй, тослог, хоол хүнс, эмэнд хэрэглэнэ; хушга харвах (хуштыг нэг газарт өрж, түүнээ хушгаар буюу бөмбөгөөр шидэж наадах); 2. эрийн өндөг, бэлгийн булчирхай.

ХУЯГ түр. qujau/qujaq; мөб. quuaq; 1. төмөрлөг, шир, мод зэргээр хийсэн биеийг хамгаалахад өмсөх хувцас; 2. зарим амьтны биеийн гадуурх хайрс мэт хамгаалалт; хуяглах (хуяг өмсөх).

ХҮЖ сам. kuśa; мөб. kijí; Талхалж найруулан хийсэн нэгэн зүйл үнэртэн буюу анхилам сайхан үнэртэй эд зай. хүж өвс (харавтар ногоон навчтай, шар цэцэгтэй, үндсэнээс дээш босоо жагсан ургах нэг зүйл ургамал).

ХҮНД манж. kündü; мөб. kündü; сумын зангиин туслах буюу түүний дараах албан тушаал.

ХҮНХЭЭР түр. kunkar; мөб. küngkeger; түрэг, түргүүд; хунгар, хунгаар ч гэнэ.

ХҮҮ хя. kū; мөб. kūū; 1. эд таваар хадгалах газар; **хорш** хүүсан; 2. зээлээр авсан мөнгөн дээр өсч нэмэгдэх хувь; хүүтэй мөнгө; хүүлэгч (бусад мөнгө юмыг хүүтэй өгч ашиг ологч); хүүлэх (мөнгө, юмыг бусдад хувь хүүтэй зээлдүүлэх).

ХҮҮДИЙ хя. koïdäi; мөб. keüdei; Юм хум агуулах бэс уут.

ХҮХЭР перс. gūgarda; мөб. kükər; Химиин махбод, шар онгийн шатах бодис; хүхэрлэг (хүхэр бүхий).

ХЭБИД түр. kebit (<согд. զրբ); мөб. kibid; харьц. орос. кибитка; 1. дэлгүүр, манггуу; 2. архины муҳлаг; ...хэбидэд басарт багтан ядаад гэрийн дээрээс үзвэй (12 зох.).

ХЭВЭЙ манж. kebeī; мөб. kebeī; зөвлөх, аймгийн цэргийн хэргийг эрхлэх жанжны зөвлөгч, хувийн сайд ч гэдэг.

ХЭЖИМ түр. kedim-kejim; мөб. kejim, "kedi" "өмсгөл, хувцас"; тохом; **хээр морь нь хэжимтэй (ААЗ)**.

ХЭНТЭГ тө. khengs dregs; мөб. kenteg; Аар саар зүйлд нэн хүлцэн тэвчилгүй уурлах, цочмог түргэн зантай хүн; хэнтэглэх (хэнтэг зан гаргах).

ХЭНХИН манж. kengkin; мөб. kengkin; Салаа нь сарьсаар холбогдсон, дөрвөн мөч охор, дурс байдал баавгайтай адилдуу далай тэнгист оршдог нэг зүйл амьтан, далайн мий ч гэдэг.

ХЭРГЭМ манж. kergen; мөб. kergem; "үсгийн гар бичлэгийн тэг"; Гавьяат үйл бүтээж байсан хүмүүст олгож байсан цол зэрэг; **хорш** хэргэм зэрэг; хэргэмтэн (хэргэм бүхий этгээд).

ХЭРМЭЙН манж. kermeyen; мөб. kermiyen; Эртгэр уруултай, хэлтий биетэй, заран загасны адил болоод цэнгэг уснаа орших маш тарган нэг зүйл загас.

ХЭРМЭЭ манж. kerm-e; мөб. kerm-e; Далай тэнгист орших ногоонвтор өнгөтэй нэг зүйл загас.

ХЭРС түр. kersi; мөб. kers; Хамар дээрээ эвэртэй үхэр, хирс ч гэж бичдэг.

ХЭРТИГ сам. krittikā; мөб. kertig; 1. сарны зурхайн хорин найман одны нэг. Мичид, зургаан мичид ч гэнэ. Бас Хатгалдагч тэнгэрийн үүд одон буюу Зургаан эхтэй хүү ч гэнэ. Гирдиг, гиртиг ч гэж бичсэн нь үзэгдэнэ; 2. Энэтхэгийн намрын эцэс сар, цагийн хүрднээ намрын дунд сар, хятад төвдийн өвлийн эхэн гахай сар, монголын арван сар буюу гахай сар.

ХЭРЭМ I түр. kermen; мөб. kəgəm; 1. чулуу, тоосго буюу шавраар барьсан хүрээ хаашаа; 2. шилж. байшингийн хана туурга.

ХЭРЭМ II манж. kəgi; мөб. kiram; Халдварт өвчин, хижиг тахал.

ХЯМСАА хя. qian zi; мөб. kimsa; 1. өт, өргөс зэрэг жижигхэн юмыг хавчих, авах бяцхан хавчуур; 2. шилж хамрын говил.

ХЯСАА тө. nya phyis; мөб. kisuy-a; Далай мөрөн, гол нуурт төрөх амьтан, том жижиг олон янз. Заримынх нь ясны өнгө гилгэр гоёмсог.

Ц

ЦААЗ сам. sāsana; мөб. čaaya; Шашин гэдэг үгтэй гарал нэг боловч утга өвөрдсөн буй.

ЦАВ тө. tsha ba; мөб. čava; "халуун хоол"; Лам хуврагийн хоол; цавын будаа, махан цав, цагаан цав; **Цав манжаар дамжиж цааш бас халдвэрлэв (Д.Н.)**.

ЦАГАРИГ сам. sakraka; мөб. caṣariy; "хүрээ, тойрог"; 1. сав суулга тэргүүтний бүслүүр; 2. модны гол ишинд гарах насны тоо илтгэх дугариг хээ; 3. гархи хэлбэрийн дугариг зүйл нь; цагариглах (а. юмыг цагариг мэт болгох; б. юманд цагариг хийх; в. дугуйран хэвтэх буюу цагариг мэт болох).

ЦАГЧИГ тө. khrag khrig; мөб. čaṣciy=сам. mahāpadma; Арван тэрбум.

ЦАДИГ сам. jātaka; мөб. čadiy; "төрлийн үес"; 1. Бурхан багшийн урьд төрлийн үесийг өгүүлсэн Энэтхэгийн бурхны шашны туужилсан зохиол; Цадигт урьд төрлийн явдалтай холбогдуулж, тэнгэр, лус, арслан, гөрөөс, туурай зэрэг амьтдын тухай үлгэр, тууж, хууч үг ч ордог. Ганжурт таван зуугаад цадиг бий; 2. түүх, шастир; **хорш** түүх цадиг, цадиг намтар; 3. **шилж** хир чинээ, хэм хэмжээ; *Ус сахал нь тал тал тийшээ урган цадигаа аллаад..таван хэлний амьтдын алинтай нь ч ижилгүй болжээ. (Д.Нам.); цадиггүй (а. хирээ мэдэхгүй хэтрүү заан ааштай; б. хэт дурсгүй зан байдалтай).*

ЦАДМА тө. tshad ma; мөб. čadm-a; Тoo хэмжээ; баталгаа, гаргалга; учир шалтгааны ухаан; цадмын ухаан (учир шалтгааны ухаан); цадмын тайлбар (диалектикийн үндсэн эмхэтгэлийн тайлбар).

ЦАДЧИН тө. khyad 'byin; мөб. čadčin; Тооны нэр, арван мянжаг, арван мянган миллиард.

ЦАЙ хя. chá; мо.б. čai; 1. урт зууван навчтай, анхилмал сайхан цагаан цэцэгтэй, навчны идээг унд болгодог нэг зүйлийн бут буюу тураг мод; 2. цайны модны навчийг идээшүүлсэн унд; 3. ХҮП-ХҮШ зууны үеийн мөнгийг орлож байсан нэгж; шар цай (шахмал ногоон цайг найм хуваасны нэг буюу цаасанд боосон задгай цай. Ийм 10 шар цай нэг тэмээ, 8 шар цай нэжгээд ухэр, адуу, 2 цай нэг хоньтой тэнцэж байжээ); чулуун цай (булан цай, нэг чuluун цай 30 шар цайтай тэнцэнэ); хөл цай (ХҮП-ХХ зууны эхэн хүртэл Халхын зарим нутагт аливаа алба ногдуулахдаа хонь нэг бүрд нэг шар цай, адуу ухэр тус бүрд 4-6 шар цай, тэмээ бүрд 6-8 шар цай оноож байсныг хэлж байжээ); сэвэг цай (800 шар цайг хэлнэ); сул цай (800 хүрэхгүй шар цайг хэлнэ).

ЦАЙДАМ тө. tshad 'dam; мо.б. čayidam; 1. Цайдамын хоттор; 2. шилж хужир марз гарах газар; 3. хондий тал; цайдам хөндий.

ЦАЙЗ хя. sài zi-zhài zi; мо.б. čaujia; 1. ууланд буюу юманд хорго болгож барьсан хот хэрэм, хорго бэхлэлт; бэхлэн барьсан хэрэмт цэргийн тусгай орон барилга; 2. шилтгээн хот.

ЦАЛ I түр. čal; мо.б. čal; "хөхөмдөг цагаан, буурал"; Усний онгө маш цагаан болсны нь; **хорш**. цал буурал.

ЦАЛ II: цал бар; тө. mtshal (rag); мо.б. čal; "шунх"; шунхан бар; цал барын ганжуур.

ЦАЛ III: тө. mtshal; мо.б. čal; Төвдийн нэгэн районы нэр.

ЦАЛИН хя. qián liáng; мо.б. čaling; 1. ажил, алба гүйцэтгэсний төлөө тогтмол олгох мөнгөн хөлс; 2. хуучин цагт ноёд түшмэдэд олгож байсан амуу, зоос пүнлүү.

ЦАМ I тө. 'tshams; мо.б. čam; "завсар"; орон зайд, эзэлхүүн, зайд; Орчин цагийн монгол хэлнээ сам, сэм гэхчлэнгээр гүйвуулан буулгасан нь үзэгдэнэ; цамд суух (тогтоосон орон зайд суух).

ЦАМ II тө. 'cham(ra); мо.б. čam; "бүжиг"; Чөтөр сахиулсан, араатан гөрөөсний толгойн дүртэй баг өмсч хайллан бүжиглэх нь. Гурван зүйл цам байдаг гэдэг. а. бурхан тахихын тулд дагинас тус тусын тахилгаа барьж хөгжим үүсгэн алгуур хөдөлгөөнөөр цамнах; тахилгын цам (тө. mchod 'cham); б. Сундуй, Ямандага, Дэмчиг, Дүйнхор зэрэг тарниийн үндэсний бурхдын мандал цогцлоо, сүм хийд байгуулах үед цамнах газрын (дарлагын) цам (тө. sa 'cham); в. чөтөр, сахиулсан, араатан гөрөөсний толгойн дүртэй баг өмсч алив ад тогтоодыг дарж, хор хөнөөлийг нь тонилгох дарлагын цам (ral kar 'cham) гэж бий. Сүүлчийнх нь ар монголын хүрээ хийдэд их дэлгэрсэн жинхэнэ цам болно. Цам нь

үүргийн талаар Бурхны шалны бясалгалын номын эрх авсан хүмүүсийн бужиг, урлагийн хувьд ший жүжгийн шинжтэй бурхны шашны бужиг болно. Сахиус догшдын цамнах нь нэг талаас дээд шүгээндээ тахил өргөн бясалгаж байгааг нөгөө талаас шашинд хортой ад тогтоодыг доройтуулан дарж, шашныг бататтан, сүр хүч нэмж байгааг билэгдэнэ; цамнах (а. цам бүжих; б. амьтны хайлалах).

ЦАМБА тө. tshangs pa; мо.б. čambla; Монголчуудын дунд арван хангал гэж алдаршсан догшин сахиусны нэг. Цамбын бисийн зүс цагаан, гурван мэлмийтэй, цагаан тортон өмсгөлтэй, баруун мутартаа дайныг дарах хутга барьсан, цагаан ажинай хөлөглюсөн байдгаар дүрсэлсэн байдаг. Цамбыг шүгсэнээр үйлс бүхэн булгийн ус мэт ундрان бүтнэ гэж домогт гардаг.

ЦАМБАГАРАВ тө. tshang po dkar po; мо.б. čangbučaybu; сам. Brahma; "цагаан эсрүү"; 1. арван хангал хэмээх догшин сахиусны нэгийг Цамба гэдэг. Гурван цагийг эзэмдэгч гурван мэлмийтэй, баруун мутартаа хурц сэлэмтэй, бие хувцас нь цагаан, унасан ажинайн өнгө цагаан. Цамбын дүрийг домогт хар салхи дэгдэн, гал цахилгаан цахилсны дотор зүс царай нь хувирч хүчтэй луу мэт эргэн тойрноо тургидаг гэж дүрсэлдэг; 2. Монгол орны баруун хязгаарт байх мөнх цаст уул. Цамба сахиусыг билэгдэн өгсөн нэр; *Мөнгөн дуулгат Цамбагарав Миний өмнө хөндөлсөнө (Б.Я.)*.

ЦАМХАГ тө. 'tshams khang; мо.б. čamqaų; "завсрын гэр, цэгийн гэр", "даяан суух гэр"; 1. барилга байшигийн дээрх бөмбөгөр орой; 2. харуул, хяналтын зүйлд зориулан барьсан өндөр нарийн барилга; 3. тоононы цагиргийн дотор тэлж хийсэн мод, цамхраа ч гэнэ; 4. гудамжны амыг хааж хийсэн асар хаалга.

ЦАМЦ тө. phyam tsha; мо.б. čamča; Цээжээр өмсдөг богино хувцас; цамцлах (цамцтай болгох).

ЦАН тө. cha lang; мо.б. čang; 1. гуулиар хийдэг иргүүл бүхий дотроо хөндий, нимгэн хоёр хэлтсийг хавсран дэлдэж дуугаргах хөгжмийн зэмсэг, хумхат цан, дохио цан гэхчлэнгээр ялгана; цан нь яаж дуугарвал цан нь тэгэж харайна (Зүйр); 2. хонх цан зэргийн дуугарахад гарах дуу; цан цан.

ЦАНИД тө. mtshan nyid; мо.б. čanid; "бэлгэ чанар"; Аливаа юмсын билэг чанар, шинж төрх, дотоод шинжийг тогтоон судлах, марган шүүмжлэх буддийн гүн ухааны чиглэл. Цанидын ном нь: намдэл буюу зөв сэйтэхүйн ухаан, парчин буюу ёс суртахуун, ум буюу орчлонгийн мэдлэг, дулбаа буюу ламын суртаал, зод зэрэг

таван аймаг саваас бүрдэнэ. Цанидыг дотоод ухаан ч гэнэ; Цанид дацан (аливаа юм үзэгдлийн билэг чанарыг судлах шашин-гүн ухааны сургууль).

ЦАНХУЙ хя. *qiángwēi*; мө.б. *čangqui*; Салаандaa өргөстэй, олон янзын өнгөтэй, анхилмал үнэртэй, навч зулгарахгүй нэгэн зүйл бутлаг мод.

ЦАРВАН тө. *tshar bong*; мө.б. *čarbung*; *Artemista sieversiana*; Шарилжийн төрөл, нэг наст ургамал, 30-70 см өндөр, гол төлөв ус чийгтэй газар буюу голын хөндийд ургана. Хоолойн өвчинд хэрэглэнэ. Морин шарилж ч гэж нэрлэнэ.

ЦАХ түр. *saqa/caka*; "нярай хүүхэд"; Сая төрсөн нярай хүүхэд (МНТ).

ЦАЦ I тө. *tsha tsha* (< сам. *sāccha*); мө.б. *čača*; "дээдийн дүр хөрөг"; 1. Их төлөв улаан шар өнгийн наанги шороог зуурч суварга хэлбэртэй тусгай хэвд хэвлэн цохисон зүйл. Сайнны сайжруулан мандуулах, мууг дараах тустай ном гүрэм уншиж, талийгаачийн оршуулсан газрын эргэн тойронд газарт булдаг суварган баримал. 2. өргөн суурьтай, шовх үзүүртэй, олон цамцаалт том суварга; *Мисирийн цац суварга*.

ЦАЦ П тө. *cha cha*; мө.б. *čača*; Амт аятайхан бөгөөд эхүүндүү нэг зүйл жимс.

ЦАЦАР араб. *catir* >(түр. *čatır~čaşır~čaçır*); мө.б. *čačar/čačır*; харыц. тө. *phyā ther*; орос. шатер; Туургагүй жижиг асар; туургатай буюу дөрвөн талтай майхан хэлбэртэйг нь цацаар гэр гэнэ. Цачир, чачир гэхчлэнгээр бичсэн нь үзэгдэнэ; *Хэлтий хар цацир өгч турван голын бэлчирт цөлж илгээв* (Гэс).

ЦОВХОР цогвор.

ЦОГВОН тө. *tshogs dpon*; мө.б. *čoγbon*; Чуулган хурлын ноён.

ЦОГВОР тө. *tshogs phor*; мө.б. *čoγbor*; Хумбигар амсартай, дундуураа цүлхгэр, зузаан ёроолтой нэг зүйл модон аяга. Цовхор, цогбор, цогвор гэхчлэнгээр бичсэн байдаг; *хорш*. багвар цогвор.

ЦОГЧИД тө. *tshogs mchod*; мө.б. *čoγcid*; Чуулганы тахил.

ЦОГЧИН I тө. *tshogs chen*; мө.б. *čoγchin*; "их чуулган"; 1. залбирал, уншлага голлосон хурал; цогчин хурал; 2. цогчин хурал ном хурал гол сүм дуган; цогчин гэр (залгаа унтай, дөрвөн баганатай шашны ёсны залбирал уншлага хийх газар).

ЦОГЧИН П тө. *tshogs šing*; мө.б. *čoγsin*; "чуулганы мод"; Бүтэн модны дэвсгэр дээр зурсан бурхдын нэг зүйл хөрөг зураг. Уг модны титмийн хэсэгт нь Майдар, Манзшир зэрэг дээд буржад

хийгээд түүхэн хүн болох бурханчлагдсан Богд Зонхов, дунд хэсгийн их биед нь дээр дурдсанаас зиндаа доогуур гурван зуугаад бурхны хөрөг, үндэсний хэсгийн дэвсгэр дээр тахил өргөлийн зүйл авчирч байгаа гэлэн хуврагуудыг тус тус дүрсэлсэн байдал. Бас цогшин ч гэдэг.

ЦОМНОХ тө. *risom pa*; мө.б. *čomnaqu*; "туурвих, зохиох" (Ю.Р.); Цом болгох, бүтээн туурвих.

ЦОНДОН тө. *mishon don*; мө.б. *condong*; Утга, билэг тэмдэг, тавилан; ёр, билэгдэл; *сайны цондон*.

ЦОНЖ хя. *chuāng zi*; мө.б. *čongji*; Дохио өгөх, алсын бараа харах өндөр хад буюу өндөрлөг барилга байгууламж.

ЦОНХ хя. *chuāng-hu*; мө.б. *čongqu*; Байшин барилга, машин тэргээний гэрэл, агаар нэвтрүүлэх гэгээвч.

ЦОНХОР тө. *tshogs 'khor*; мө.б. *čongqur*; Чуулганы тахилын хурд, чуулганы хурим; тэнгэр, газар, лусын эздэд зориулсан идээ тахил.

ЦООЖ хя. *suo zi*; мө.б. *čooji*; Орон байшин, сав суулганы үүд хаалга, ам амсрыг бэхлэн торгож оньслох хэрэгсэл.

ЦООНО хя. *cháo nǎo*; мө.б. *čoopi*; 1. гавар; 2. заарт модны навчнаас боловсруулж авдаг сэнгэнэм сэргүүн үнэртэй, өнгөгүй тунгалаг хатуу зүйл. Хувцас хунарыг хүр идэхээс сэргийлэхэд хэрэглэх буюу эмд орно.

ЦОРЖ тө. *chos ḥje*; мө.б. *čogji*; "номын богд"; Хамбын орлогч бөгөөд шашны сүм, дацанд хурах хурал номын үйлийг орлон гүйцэтгэх хүний тушаал; *Цоржийн амнаас ном гоожино, цоорхой гутлаас шороо гоожино* (Зүйр).

ЦӨЛХӨӨВ орос. целковый; Оросын хуучны мөнгөний нэгж; *Сайн будуун шар 25 цөлхөөв хүрдэг байсан*. (Ц.Д.).

ЦӨН хя. *quān*; мө.б. *čōng*; Тэргээний булны нүхний ирмэгт шиггтгэн суулгасан бэхэлгээний цагариг төмөр.

ЦӨР тө. *phyur~phyur ba*; мө.б. *čögyü-a*; "ааруул"; Бог малын сүүг тусгай саванд хурааж гашилгасны нь; цөрөмний ааруулыг цөр гэнэ.

ЦУВ ар. *tsopa*; мө.б. *čuba*; "дотор хувцас"; Бороо цасанд гадуур өмсөх хувцас буюу нөмрөг.

ЦУГЛАХ тө. *btshugs ra*; мө.б. *čuγlaqu*; "хаттак, оруулах" (Ю.Р.); Боох, баглах, цомхоттон баглах; *хорш*. боох цуглах.

ЦҮЙВАН хя. *chǎo bǐng*; мө.б. *čuyibing*.

ЦҮН хя. cūn; мө. čin; Урт богинын хэмжээ, ямх; хоёр цунгийн банс; цугнах (цунгаар хэмжих).

ЦҮУ хя. cū; мө. suu~čuu; Хоолонд амт оруулах, бас идэшний зүйлийг дарж идэхэд хэрэглэх нэг зүйл исгэлэн амттай шингэн.

ЦУУВАЙ хя. xiēbái; мө. čüubaí; Цул цагаан өнгө; Цагаан өнгөтэй нэг зүйл хятад бараа; цуувай цагаан.

ЦУУХ манж. čuuqa; мө. čuuq-a; Цэрэг; *хорш*. цэрэг цуух.

ЦУУЦАЛЬ тө. chu skyag; мө. čuučali; Шар хүрэн өнгөтэй, хушуу урт, хөл өндөр, сүүл охор, хорхой шавьжаар хооллогод нүүдлийн шувуу. Үхэр цууцаль, хонин цууцаль гэхчлэн хэдэн зүйл бий.

ЦУЦАА манж. čuučaa; мө. čuučay-a; Уналга, унаа хөсөг; *хорш*. унаа цуцаа; *унаа цуцаанд сайн* (морь унахдаа чадамгай).

ЦҮГЛЭХ тө. tshugs; мө. čüglekü; "хатгах, байгуулах"; цүг + л + х; бүгээх, байгуулах, суурь тавих; тогтоох; ... (төвдийн лавран хийдийг); *1707 онд үүсгэн цүглэсэн гэнэ*. (ИТ).

ЦҮН хя. zhōng; мө. čing; Эрт цагт архи хийж байсан том сав. Мод, арьс, шаазан зэргээр хийж байжээ. (МНТ)-д "том суулга" гэсэн утгаар гардаг.

ЦЭГ тө. tshig; мө. čeg; "үг"; Өгүүлбэрийн эцэст тавих нэг зүйл тэмдэг; гурван цэг.

ЦЭДИГ = цадиг 1.

ЦЭМБЭ тө. phying ba; мө. čengme; Нягт нэхээстэй, хоёр талдаа үсэрхэг, нарийн энтэй, төвд оронд хийдэг нэг зүйлийн зузаан ноосон нэхмэл; орос цэмбэ (одончуу); тал цэмбэ (даавуу артай өнгөн тал нь үсэрхэг нэг зүйл бөс).

ЦЭН хя. qián; мө. čin; 1. лангийн аравны нэг буюу арван пун, 3,7301 граммтай тэнцэнэ; цэгнэх (цэннэх, цэгнүүр хэмжүүрээр хэмжих); 2. үнэ гэдэг үтгэй хоршин хэрэглэгдэнэ; үнэ цэнтэй зүйл.

ЦЭРЭГ сам. ksatrika trika; мө. čerig; 1. улсын зэвсэг бүхий хүчин; 2. улсын зэвсэгт хүчинд байлдагчийн албан тушаал бүхий хүн.

ЦЭС хя. kié tsu (Ков.); мө. česen/čese; харьц. тө. che'u tsi, Solanum melongene; Өнгө хар, бөөрөнхий, буцалгаад дарж идэх нэг зүйл ногоо; чэс ч гэнэ; 2. аливаа зүйлийг жагсаан бүртгэж давхарлан үдсэн дэвтэр.

ЦЭСТА жэшт.

Ч

ЧАВГАНЦ согд. šmn'nčh *šimnānča; мө. šimnanča~čibyanča; 1. сахил санваар авч гэлэнмаа болсон эмэгтэй; чавганц болох (чавганц сахил авах); 2. **шилж**. настай болсон эм хүн.

ЧАВИР тө. chab ril; мө. čabari; Тохой хирийн ам дөрвөлжин бөсөөр доторхийг нь хөндий хийсэн, дээд талд нь жижиг данх хэлбэрийн зэс савыг далд агуулсан нэг том хавтага маягийн зүйл. Лам нар үүндээ гар угаах ус буюу бага сага хэрэгцээний зүйлээ хийгээд өмнөө зүүж явдаг.

ЧАВСАН тө. chab gsang; мө. čabsang; "нууц ус", шээс.

ЧАВСИЛ тө. chab sil; мө. čabsil; Ариутгал, угаалга; ... түүнээсээ гадна өөд болж гараад гэрийн хойт зүтг чавсил хийсэн... (Паг.).

ЧАГЖАА тө. phyag cha; мө. čaγča-y-a; "гарын дохио, тамга"; 1. лам нарын ном унших үедээ гар хуруугаар дурс билэгдэл илэрхийлэх байдал буюу бурхны шашны бясалгал хийхэд тус болох арван хуруугаараа илтгэх билэгдлийн шинжтэй юм, бодисын хэлбэр дүрсийг дүрсэлснийг хэлнэ; чагжаалах (гараараа дохио билэгдэл үзүүлэх); ...гараа чагжаалж бужиглээд...хөх тэнгэрийн зүг харвабал сум, дээш их л хол явжээ (Б.Р.); 2. гар хөлөө эргүүлэн аашлах нь.

ЧАГШАБАД сам. Šiksāpada; мө. čaγšabad; шагшаабад; уйгар хэлээр дамжин орж ирсэн хэлбэр; Чигшабадыг үзмүү.

ЧАЙТАР сам. caitra; мө. čayitar; 1. Энэтхэгийн гутгаар сарын нэр, аргын 3-4-р сар; 2. хорин найман одны арван дөрөв дэх нь.

ЧАЙТИ сам. caitya; мө. čayiti (Ков); Тахилын орон (шүгээн), суварга.

ЧАЙТИР зэдэр

ЧАКРАВАРДИ сам. cakravartin; мө. čakravardi; "хүрдэн эргүүлэгч"; 1. эртний энэтхэгт нэг зүйл цэргийн зэвсгийг чакра гэж байжээ. Энэ зэвсэг тэргэний хурд мэт эргэлдэх туйлын их увидис хүчтэй. Чакраварди нь энэхүү зэвсгийг эргүүлэгч хүнийг хэлнэ. Эрдэнийн хурд эргүүлж ертөнцийг эрхшээлдээ оруулсан хааныг нэрлэдэг байв; 2. бурхны шашны ном сударт болон монголын түүхийн бичгүүдэд гардгаар энэ нь бурхан шашныг хамгаалдаг хязгаарлашгүй эрх хүчит эзэн буюу номт эзэн. Таван чакраварди хаан байсан нь: Алтан хурдэт, Мөнгөн хурдэт, Төмөр хурдэт, Зэс хурдэт, Төгс үзэсгэлэнт хаан эдгээр болно. Төвдоор

Загдхорлоо (*tsa kra 'khor lo*) гэнэ. Монгол хэлэнд тарнийн дуудлагаар загд, загар гэсэн хоёр хэлбэрээр орж иржээ.

ЧАЛ: чал чал гэх; тө. *bkyal bkyal byed* па; мө. *cal cal gekü*; чалчих, дэмий донгосох.

ЧАЛБА тө. *mchil ba*; мө. *čilba*; *Galerida*; Улаан толгойт болжмор. Дээр цагт энэтхэг төвдөд тэжээж байсан тэжээвэр болжмор. Хавар үүрээр жиргэдэг богширго, халтар амтай мөнгөн цагаан, номхон болжмор. Хавар цагт өдөр, шөнө янз бүрээр дуугардаг болжморын эрийг нь чалба гэнэ гэж эмийн сударт гардаг. Галандага шувууны тайлбарт үз.

ЧАМАР тө. *phyi mar*; мө. *čimar*; 1. тосонд багсарсан арвайн турил; 2. бурхан тахилын өргөлийн идээ. Том цөгц буюу тавганд үр тариа тэргүүтнийг хийгээд гол дунд нь хуурай замбааг турвалжлан засч орой дээр нь бяцхан шар тосоор чимдэг; чамарлах (чамар болгох, чамар хийх).

ЧАМБУ сам. *čambu*; мө. *čambu*=Замбуу мод.

ЧАМИН хя. *qiān tēn*; мө. *čamīn*; "өмнөд хаалга"; Бээжин хотын өмнөд хаалга нэртэй гудамж зээлийн бараа хээнцэр тансаг байдгаас ийн нэрлэжээ. Монгол хэлнээ хээнцэр, гоёмсогийн утгатай; чамирхах (хээнцэрлэх).

ЧАНДАА хя. *qīngdān*; мө. *činday-a*; Гааль оноох барааны тэмдэг ба цэс.

ЧАНДМАНЬ уй. *čintamani* (<согд. *čynt*"many **čindāmani*<сам. *cintāmani*; мө. *čindamani*; "зүрхэн эрдэнэ"; 1. үлгэр туульст гардаг гадаад далайгаас залж авчирсан, гайхамшигт ид шидтэй хүн бүхний хүслийг хангач норов эрдэнэ, хaan төрийн долоон эрдэнийн нэг. Энэ эрдэнэ гурван зууван дугуй дүрсээс бүтнэ. Бие, хэл, сэтгэл гурвын хүслийг хангах утгатай. Зэндмэннийг үзмүү; 2. монгол улсын төрийн сүлдний магнайн хэсэгт байдаг эрт, эдүгээ, ирээдүй гурван цагийн билэгдэл; 3. тамга, тэмдэг; 4. *шилж*. үнэт баялаг; *мал манай чандмань эрдэнэ мөн*; чандмалах (турвалжин онцөг гарган байрласан зүйл). Чандмань уул (Увс аймгийн Улаангом хотын дэргэд орших уулын нэр. Хүрэл, төмрийн үеийн булаш бүхий монголын археологийн судлалд чухал байр суурь эзлэх газар, "Чандманы соёл" гэсэн нэрээр алдаршсан).

ЧАНТУЙ тө. *chang khrus*; мө. *čangtui*; "архиар ухияахуй"; Хуучин цагт ван жинангийн авшиг хүртсэн хүн саа өвчин туссан хүнийг тарнидсан архиар нүүрийг нь угааж, тэр угаасан буртаг

архиа гурилаар хийсэн хүний сүт дээр асган уг өвчтөнийг эдгээх засал хийх шашны зан үйл гүйцэтгэхийг хэлж байжээ.

ЧАРАЛБА тө. *phyi rol pa*; мө. *tirthika* (тэрсүүд); 1. бурхны шашныг эс шүтгэгч, Махишвари тэргүүтэн ертөнцийн тэнгэрсийг барьж итгэл явуулагчид. Утгаа бурхны шашныг эсэргүүцэгчдийн сургаалийг дагагчид; 2. *шилж*. зүггүй, дүрсгүй этгээд.

ЧАС: часаа гариг, час өдөр; тө. *'chi gza'*; мө. *čisa*; "үхлийн гариг"; Хар зурхайн таван махбодын сургаалд эх хөвгүүн, эл дайсан болох харьцаагаар аливаа юмс үзэгдлийн хоорондын харьцааг тайлбарладаг. Энэ үүднээс хүнийг эхээс мэндлэх үед од, гариг, нар, сарны солбицол тодорхой үйлчилгээ үзүүлж, цаашид од гаригийн орчил, цаг хугацааны улирах давталт тухайн хүний бие махбод, оюун ухаан, сэтгэхүйд зохих нөлөө үзүүлэх тухайг зурхайчид таван махбодын сургаалаар тайлбарлаж иржээ. Хүний махбод төрсөн жилийнхээ махбодтой амин холбоотой гэдэг учир бар туулай жилтэнд сугар, мөгий морь жилтэнд буд, үхэр луу, хонь, нохой жилтэнд бархасбадь, бич, тахиа жилтэнд ангараг, гахай, хулгана жилтэнд санчир гариг дайсан гариг буюу час гариг болно. Ер нь тухайн хүний муу өдөр буюу гариг учраас энэ өдрөө элдэв муу зүйлд өртөгдөхөөс болгоомжилдог байна. Чиса ч гэж бичдэг.

ЧИВАЧИВАК сам. *jivakajivaka*; мө. *čivačivag*; Нэгэн зүйл тургуул шувуу.

ЧИГШААБУН шагшаабад; мө. *čišabun*; *nasad* чигшаабун эвдсэн нутлээ арилгаж, басхүү чигшаабун авхун болтугай (Зуун бил).

ЧИГШАБАД мө. *čišabad-čašabad-šašabad*; халх. шагшаабад, уй. *čaqsapč*, *časapt*, *caqšarat*, *čaqšarut*<согд. *čxš'r'ρ* тох.А. *šiksāpat* <<сам. *siksāpada*; Чигшабад үл алдараахун болтугай (турф); шагшаабадыг үзмүү.

ЧИДУН перс. *zeitun*; тө. *chi tun*; мө. *čidun*; Гавирын язгуурын мөнх ногоон бут мод. Цэцэг цагаан, анхилмал үнэртэй, цагтан навчтай, үрээс нь тос авна. Жимсийг бас чидун гэнэ.

ЧИЙ хя. *či*; мө. *čii*; Уртын хэмжээ, арван цун буюу 0,32 метр.

ЧИЙДҮҮ хя. *qiēdāo*; мө. *čidüü*; Max ногоо зэргийг хэрчих том хутга, боодууг үз.

ЧИЙДЭН хя. shoū dēng; мө.б. čideng; "гар дэн"; Цахилгаан гэрэл.

ЧИЙЛЭХ хя. qī; мө.б. cuilekū; Цай зэргийг бүрж идээшүүлэх; хар цай чийлэх.

ЧИЙЧААН хя. qī ché; мө.б. čičan; Хүн, ачаа тээвэрлэх машин тэрэг.

ЧИМИН хя. chīmìng; мө.б. čimíng; Хуучин цагт эзэн хаадын зарлиг тунхаг буюу сургаал бичиг.

ЧИН I хя. chéng; мө.б. čing (<уй. čing-čin); 1. үнэнч шударга; хуурмаггүй үнэн; Зүрх амгуулагсан чин сээтэлтэн хэвтүүл минь (МНТ); 2. шилж. итгэл, найдвар; хатуу, чанга; чин зориг; 3. үнэн бодтой; чин тоо; 4. өвөрдөх зан санаагүй; чин ван (урьд цагт эзэн хааны угсааны тэргүүн зэрэг хэргэм).

ЧИН II хя. qīng; мө.б. čing; Зуун мүү газрын хэмжээ.

ЧИН III: Чин улс хя. qīng; мө.б. čing; "ариун"; Өвөрモンголын 16 аймгийн ноёдын чуулган 1636 онд болж, Манжийн хаан Абахайг монголын хаанаар өргөмжилсөн үеэс Манжийн хаант улсыг Чин гэж нэрлэх болжээ. Дайчин буюу Манж чин улс ч гэнэ.

ЧИНДАН мө.б. čindan (<уй. čintan/čindan<сам. candana); ...чинданы хүрсиг оруулвай (12 зох.); занданг үзмүү.

ЧИНЖҮҮ хя. qīng jiāo; мө.б. činjüü; Хүнс хоолонд хэрэглэх гашуун бөгөөд халуун чанартай ногoo.

ЧИНСАН хя. chéng xiàng; мө.б. čingsang; Хаан эзэнд туслагч дээд сайд түшмэлийн цол; Вангийн чинсан (МНТ); ченсиян ч гэж бичдэг. Дөрвөн ойрадад тайжийн дараах сайдыг хэлж байжээ.

ЧИНЧҮҮ хя. chin chōu; мө.б. činčeü; Нэгэн зүйл торгон нэхмэл бараа.

ЧИСЧҮҮ хя. zuòsi chōu; мө.б. čisčeü; Царс модны навчаар тэжээсэн хүрийн ширхээр нэхсэн бараа.

ЧИТИРИ сам. citra; мө.б. čitiri; "элдэв"; Олон янзын, өнгө бурийн, олон өнгөт; читири эрдэнэсийн чимэгтэн хатдын чимэг нь цусан нуулимсан узэгдмүй (12 зох.).

ЧИХЭР перс. sakar; ир. sukar; араб. sukkar; мө.б. šikir-čikir; харыц.ор. сахар; англ. sugar; Тусгай манжингаас ялгаруулан боловсруулсан цагаан өнгөтэй амтлаг тэжээлийн талст бодос; элсэн чихэр (жижиг талст чихэр); чихэр амт (сайхан амт); чихэр өвс (үндэс нь чихэр амттай олон наст өвслөг ургамал); чихэрлэх (чихэртэй болгох).

ЧИЧИР сам. śāśikara; герег. statēr; согд. st'yr, *sitēr; уй. sitir; түр. šišir; мө.б. čicir; "эрдэнийн чулуу, алтан зоос"; мянган тумэн вайдури чичир... (Турф.); шижир гэдгийг үзмүү.

ЧОВОМБО чодвон; мө.б. covombu; човонбо лам (тайж тавиглах хэргийг эрхлэх лам).

ЧОГО тө. cho ga (chos gos); мө.б. čoga; "номын хувцас"; Гэлэн хүний биеэсээ салгахгүй авч явдаг зүйл, түүнд лагай, намжир зэрэг хувцасны бяцхан дүрсийг хийнэ. Сүүлдээ ламын гүйцэтгэх зан үйл ба түүний горимыг бичсэн ном авч явах болжээ. Чойго ч гэдэг.

ЧОГЖИД тө. tshogs mchod; мө.б. čočid; "чуулган тахил"; ...чогжид болгон өргөж хуримлан тутгээсэн юм бизээ (МААЗ).

ЧОДВОН тө. mchod dpon; мө.б. čodbon; "тахилын багш"; Тахилч; човомбо.

ЧОДИН тө. mchod rten; мө.б. čodin; "тахилын шүтээн"; суваргыг үз.

ЧОЁГ тө. mchod gyog; мө.б. čočou; Тахилчийн зарц, үйлчлэгч.

ЧОЙВОН тө. chos dpon; мө.б. čočibon; "номын багш"; Зарим судлаач эрдэмтэн энэ үтийг "тахил эрхлэгч" гэсэн утгатай төвд хэлний "Чомбон" гэсэн үтийн хазгай дуудлага бололтой гэсэн байдаг; Соёллог сайхан соёлтой, соёлгийн нь айлдах чойвонтой (МААЗДБ).

ЧОЙЖИЛ тө. chos rgyal; мө.б. čočijil; "номын хаан"; Тамын орны эзэн эрлэг номун хаан. Нэг гартаа толь, нөгөө гартаа жигнуур бариад тамд очсон амьтны нүгэл хилэнцийг харж, дэнсэлж халуун хүйтэн тамын аль нэг рүү шиддэг гэж домогт гардаг.

ЧОЙЖИН тө. chos skyong; мө.б. čočijong = сам. Dharmapāla; "номын сахиулсан, ном тэтгэгч"; 1. шарын шашинтнаас төвд Монголын бөө мөргөлтний ашиг сонирхолд зохицуулан зохиосон ламын шашны бөө; 2. хилэнт догшин байдлаар дүрсэлсэн шарын шашны бурхад, итгэлийг сахигч ч гэдэг. Монголоор догшид ч гэнэ; чойжин буух (шарын бөө бөөлөх); найман чойжин (Ширэндэв, Махгал, Бясман, Ям, Бэгз, Сийтаа-Бярман, Хаянхярваа, Ямандага).

ЧОЙЖИХОРОЛ тө. chos kyi 'khor lo; мө.б. čočijorlo; "номын хүрд"; Товчоор "чойжхор" гэнэ. Бурхны шашны билэг тэмдгийн нэг гол зүйл, найман цацрагт дугуй, түүний хоёр талд бодь гөрөөс

байдаг. Чойжихорлыг сүм дутаны оройд буюу эсвэл хаалганы оройд дээврийг голлуулж байрлуулдаг.

ЧОЙМЖОД тө. chos mdzad; мө.б. čoūimčad; "ном зохиогч"; Номлогч, бясалгал зохиогч; Тойн хуврагуудын нэг зүйлийн цол хэргэм; дацангийн чоймжод.

ЧОЙНЖИН тө. chos 'byung; мө.б. čoūinčin; "ном гарахий"; Гурвалжин хэлбэр; чойнжин тамга (тэнцүү өнцөгт гурвалжин хэлбэрт тамга, эзнээ торгуудад (тө. 'sog) тамга гэдэг).

ЧОЙР: чойр дацан; тө. chos grwa; мө.б. čoūigü-a; "номын дацан"; Бурхны шашны гүн ухааны онолын номыг асуулт хариултын маягаар сурч судлах сургууль. Анги дэвшин суралцахдаа 13 шатыг дамжих ба төгссөн хүнд равжамба цол олгоно. Харин ар монголд байсан чойрын сургууль төгсөгчдийг "арван бэрхийг туулсан эрдэмтэн" гэсэн утгатай гавж гэсэн нэрээр дууддаг. Төвдөд лхаарамба гэх тул уг үгийн тайлбарыг болгоноо уу. Чойрын дамжаа (Чойрын сургуульд номын зэрэг хамгаалах, үүнээ нэг лам хэдэн ламын өмнө зогсож гартаа эрих барих буюу хүзүүндээ зүүгээд хоёр алгаа хавсран алгадаж их л сүртэйгээр "хариул хариул" гэж төвдөөр чанга чанга дуугарч дагсалцдаг). Чойрын таван боть (учир шалтгааны ухаан, билэг бармидын гүн ухаан, төв үзлийн гүн ухаан, авидармын онол, винайн ухаан эдгээр болно).

ЧОЙСҮРЭН тө. chos srung; мө.б. čoūisürgüng; "номын сахиус"; Монголын эртний тоглоом. Бугын хөлөг дээр тоглогч хоёр хүн тус бүр 14 хүүг өдөөд ээлжээр нүүнэ. Хүүг чигээр эсвэл хошуулдан, хажуу тийш гэхчлэнгээр нүүнэ. Нэг нэгээр идэлцсээр хүүгүй болсон нь хожигдоно. Ерөө хавийнхан их тоглодог байсан гэнэ.

ЧОМБОН тө. mchod dpon; мө.б. čombon; чодвон; тахилгын ахлагч, тахилчийн даамал гэхчлэнгээр нэрлэх нь буй.

ЧОН тө. mchong; мө.б. čong; Улаан мана, хас, хүрэн эрдэнэ (СР); цайвар улаан буюу нал эрдэнэ мэт өнгөтэй нэг зүйл чулуу; чун эрих, чун шигтгээ (Я.Ц.); Монгол ардын түүльсад чон хүрэн зээрд морь гэж гардаг нь цусан хүрэн зээрд гэсэн утгатай.

ЧУДА сам. cūta; мө.б. čuda; зудаа; Чуда улс-тор хүрвээс эл хоёр хөлтийг хүмүнээ үл тоомуй (Соном).

ЧҮН тө. khyung; мө.б. čüng; "гарди"; Цайвар улаан буюу ногоон өнгөтэй, гэрэлд барихад тунгалаг болдог чулуу буюу эрдэс. Эрих, шигтгээ зэрэг зүйл хийнэ.

ЧУНЧИГНОРОВ тө. khyung skyug nog bu; мө.б. čüngčügnorbu; "гардийн бөөлжсөн эрдэнэ"; Сүмбэр уулнаас гарди шувуу авчирч бөөлжин гаргасан гэдэг домогтой. Тэр нь элдэв хорын өвчнийг дардаг увдистай гэнэ. Хуучин хөх оюу мэт авч их төлөв цайвар ногоон өнгөтэй, гэрэлд харахад шил шиг тунгалаг, цаанаа байгаа зүйлээ халхалдаггүй.

ЧҮНЧҮҮ хя. chun cheu; мө.б. čünčeü; Нэгэн зүйл торго.

Ш

ШАА хя. shā; мө.б. sa; 1. сиймгэр торлож нэхсэн нарийн бараа; шаа бөс, мяндсан шаа; 2. тор; шигшүүрийн шаа.

ШААЗ хя. shājīn; мө.б. šāja; чанар муу; шааз алт; газраас олборлосон жижиг элсэн алт буюу шороон алт, хумаг алт ч гэнэ.

ШААЗАН хя. shājīng; мө.б. šāyājang; 1. шороог шигшин нарийн ширхэгтэй болгон шатааж боловсруулан хийсэн ваарнаас нарийн эд, хатуу бөгөөд хэврэг; 2. шаазангаар хийсэн аяганы ерөнхий нэр.

ШААЗГАЙ түр. śayızyan; мө.б. šayaʃayai; Цагаан алаг, урт сүүлтэй шагширч дуугарах шувуу.

ШААХАЙ хя. xié; мө.б. saqai; 1. түрийгүй гутал; 2. Манжийн үеийн эрүү шүүлтийн нэг, хэрэг өдүүлсэн хүний хоёр хацрыг тус бүр 1-40 удаа занчих эрүүгийн хэрэгсэл; шаахайдах (шаахайгаар занчих).

ШАВ I тө. zhabs; мө.б. sab; Өлмий; ёроол.

ШАВ П: шав шув (хийх); тө. sab sub; мө.б. šab šub; шав шув гэсэн үргэлжлэн гарах дуу чимээний уг.

ШАВАН хя. shā wén; мө.б. šabang; Дархан хүн алт мөнгийг цувих хэв.

ШАВДАГ тө. gzhi bdag; мө.б. šibday; "оронгийн эзэн"; Тухайлсан нэгэн газар орон, уул усны эзэн, лус савдаг. *Баруун талаас нь харвал баян Лхаагийн шавдагтай... (МААЗДБ)*.

ШАВДАН тө. shabs rten; мө.б. šabdan; "өлмий батдах"; Насан хутаг, урт удаан наслахыг билэгдсэн уг; шавдан бат.

ШАВРАН тө. zhabs rten; мө.б. šabrong; Их хүнийг дотночлох шадар хувилгаан буюу хутагт хувилгаадын доторхи хамгийн доорд зэргийн хувилгаан. Бас угсаа залгаагүй бөгөөд цол ямба олгоогүй хувилгаан лам.

ШАВСАН тө. chab gsang; мө. šabsang; чавсан; ...*Бид бас шавсангаас хүртвэл ямар бол гэж аяархан асуув.* (Б.Р.).

ШАВТАЛ перс. sabtālū > уй. saptul>мө. sabdul-sabtał-a; Өвөрлөгчийн зарим аялгуунд шэптэл гэнэ; тоор жимс, бүглэс, бямба ч гэнэ. Навч зулгардаг тураг мод, зууван навчтай, шаравтар цагаан цэцэгтэй шүүслэг жимс.

ШАВЬ хя. shāmī; мө. šabi (сам. srāmanera); 1. шашны зан үйл сурхаар сүм хийдэд шавилан суугч лам нар; 2. багш болон мэргэжилтэн дагаж эрдэм ном мэргэжил сурх хүн; 3. шар феодалын харьят албат.

ШАГ перс. sāh; мө. šay; "хаан, ван, шатрын ноён"; Арабын улсуудын вангaa нэрлэдэг цол. Юань улсын үед султан, шаг, хаан, халиф гэж дөрвөн дэсээр хувааж байв.

ШАГИЙН ШАГ перс. sāhānsāh; мө. šay-in šay.

ШАГНАЛ шан- гаас үүссэн үг; мө. šangnal; Шан харамж болгож өгөх юм.

ШАГШААБАД сам. śiksapāda; мө. šayšabad; "суртлын шүгээн"; Гаж буруу үйлсийг цээрлэж, сэтгэлийг боож барих санаа, сахилга; сэтгэлийн үндсэнд сэргүүнийг олгуулагч гэсэн утгатай. Нисваанисын халуун энэлгийг амарлуулаад сэргүүн болсны нэр ч гэдэг. Тодруулбал, энэлгийг сайтар арилгах, хамаг өвчнийг амирлуулах, тэнгэр хүмүний насыг цаглангүй болгох, ямагт бусдын тусад орох тэргүүгнийг сахих сахилга; "шагшаа" нь ухаан буюу мэдлийг аваад суралцах, "бад" нь шүгээн буюу оюуны нэр.

ШАД тө. śad; мө. sad; 1. Төвд бичигт хэрэглэх нэгэн зүйл цэг тэмдэг; хэлбэртэй босоо шулуун зурлага; Эхний шад нь эх болсон амьтан, тэнгэр, хүмүний бие олох билэгдэл; хоёр дахь шад нь амьтны өндөр язгуур ба хамгийг айлдагчийн хутгийг олохыг билэгдсэн гэдэг; 2. шүлгийн нэг мөр; шад шүлэг.

ШАДВИС сам. śatabhiśaj-śatabhiśā; мө. sadabis; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монгол нэр нь Махач цөөврийн одон, Садвис ч гэж бичдэг. Одоо Чөдөр од гэж нэрлэж буй.

ШАЖИН шашин мө. šajin

ШАЛ тө. sal; мө. sala; Орон гэр, байшин барилгын мод, чулуу, тоосго зэргээр хийсэн дэвсгэр.

ШАЛБИН шарвин.

ШАЛМАЛИ тө. sal ma li (<сам. sālamali); мө. šalmali; Бурхны шашны онолоор орчин тойрны тамд байх нэг зүйл модны нэр.

Навч нь илд хутга мэт. *Шалмали модон бугд галбарварс болон төртүгэй* (Зуун бил.).

ШАЛСАЙ тө. zhāl zas; мө. šalsai; "амны идээ"; 1. амттай боорцог, боов; 2. гурилаар хийсэн балин тахил; Замбуутийн шалсай (газрын эздэд зориулан замбайн гурилаар гурвалжин босоо цац хэлбэртэй, оройд нь нар сар, чандмань эрдэнэсийг будагтай шар тосоор чимэн хийсэн балин).

ШАЛУ тө. zha lu; мө. šalu; Өрнөд Төвдийн Зан мужийн нэгэн хэсэг. Эндээс олон хэлмэрч төрж гарснаас тэднийг шалу лозваа гэдэг байв.

ШАМ тө. zha mo; мө. šama; Лам нарын өмсөх хавтгай малгай, шасэр ч гэдэг.

ШАМАН тунг. saman; мө. saman; "бүжиглэх"; Алтай язгууртны дунд үүссэн эртний шашин суртахууны нэг хэлбэр буюу бөө мөргөл, бөөгийн шашин. Үүнийг зарим эрдэмтэн төвд гаралтай цам гэсэн үтгэй холбодог нь төдийлөн үнэмшилтэй бус.

ШАМАР тө. shwa dmar; мө. šamar; "улаан малгай"; Төвдийн бурхны шашинтны Сажаба, Нинма, Гармаба чиглэлийнхний залгамжлагч нар хийгээд тэдний өмсдөг малгай.

ШАМБАЛ: шамбалын орон; сам. sambhala, мө. šambal, sambha - нь "амгалан", -la нь "баригч" (= "амгаланг баригч", төвдөөр bde ba 'dzin pa). Эртний сударт Жагар орны умар зүгийн Даваасанбо тэргүүтэн долоон номун хаан хийгээд Ригдан тэргүүтэн хорин таван хааны орон мөн гэж номложээ.

ШАМБАРАМ тө. džhang 'brum; мө. šangbürgüm, šamburam; "хошногын гөвдруү"; Хошного хавийн венийн судас бүдүүрч молцоглох өвчин, заримдаа хагарч цус гарна. Гортиг яр ч гэдэг; шамбарамтах (шамбарам яр тусах).

ШАМРИН тө. zhāmī ring ba; мө. šamring; Хөтөч, бараа бологч; зоог өргөгч; шамбрин ч гэнэ. Сойвон лугаа адил.

ШАМТАВ тө. sam thabs; мө. šamtav; 1. тэрмээр хийсэн хуниастай бансал буюу гэлэн хуврагуудын бэлхүүснээс доош өмсөх гадуур хувцас, хормогч. Шавь хувцас буюу номын хувцас болно. Бас таншин ч гэдэг. Доод биеийг хорон нүднээс халхална гэдэг; 2. хуучин цагт дайн байлдаанд өмсөж байсан хормогч; Түмэнжаргалангийн шамтавын оосроос нь уяж тавь (Гэс).

ШАН I хя. shāng; мө. sang; Тария ногооны газрын хоёр далангийн хоорондох газар.

ШАН П хя. shǎng; мө. šang; Урамшуулан олгох хувь хэсиг буюу шагнал болгож өгөх юм.

ШАНАГ тө. shwa nag; мө. šanaγ; "хар малгай"; Хүрээ хийдийн цамд наадах хар малгайтан.

ШАНАМ тө. shwa snam; мө. šanam; 1. төвд, монгол, лам нарын өмсдөг улаан буюу шар өнгийн эсгийгээр хийсэн малгай; Гомшоо малгайнаас том, үхрийн нойтон баасны хэлбэртэй адил лаглагар учир баасан малгай ч гэнэ. Цоржоос дээшихи их лам нар гэр зуураа өмсөнө. 2. *шилж*, сагсгар, салбагар; *шанам айхан сүүлийг сагсалзуулан*, *шашир сайхан дэлийг сагсалзуулан...*(АЗА).

ШАНГУУНА тө. sa ku ni; мө. šanggun-a; Тахиа шувууны өөр нэр.

ШАНДАН хя. shan dong; мө. šangdung; Цууямбуутай төстэй бөгөөд нягт нэхээстэй нэг зүйл бөс бараа.

ШАН(ДУУН) хя. shāng; мө. sang(daγun); Эртний дууны таван эгшгийн нэг.

ШАНЗ I хя. shàn zi; мө. šanzi; Салхи дэвэх хэрэгсэл, дэвүүр ч гэдэг.

ШАНЗ II хя. xián zi; мө. šanja; Гурван чавхдастай хөгжмийн зэмсэг, пийпаа, хувистай адилавтар, дөрвөлжин цартай, дөрвөн өнцөг нь мухар, хоёр талыг могоян арьсаар ширлэнэ. Нэг гараар чавхдастыг товшин, ногөө гарын хуруугаар дардаг. Шударга буюу товшуур ч гэнэ.

ШАНЗ III хя. shian za; мө. shinja; Хүнсний зүйлийн дотор найруулж амталсан идээний зүйл.

ШАНЗАВ тө. phyag mdzod ra; мө. šangjodba; "мутрын сан"; Санч, сангийн даамал; *Цэцэн сайн гээд шанзав болгож байжээ.* (МШХЗД).

ШАНЛУУ хя. xiānglu; мө. šanglu; арц хүж утиулах хэрэгсэл, хэлбэр янз олон, хулис ч гэнэ.

ШАНХ хя. shānghuan; мө. sangqu; 1. эмэгтэй хүний магнай руу унжсан үс, мөн үсийг нь хагалбарлан зассаны нь; 2. хүний хоёр шанаа руу унжсан үс; шанхавч (шанх үсийг даруулж боох түүз); шанхат малгай (үсийг хураан шууж өмсөх малгай); шанхлаг (хиймэл шанх үс); шанхлах (а. эмэгтэй хүн шанх үсийг янзлан засах; б. эмэгтэй хүний толгойн үсийг гөрж боох).

ШАНХАН (БЯЛЗУУХАЙ) хя. cānggēng; мө. šangqan biljiiqa; Бие шар, толгой хар, ой модны хорхой шавьжаар хооллогч,

уюнгалаг сайхан дутай бялзуухайн төрлийн бяцхан шувуу. Алтан гургалдай ч гэдэг. Шунхан бялзуухай ч гэж бичдэг.

ШАНЦАЙ хя. xiān cài; мө. šančai; Давсалж дарсан ногоо; шанцайтай хоол.

ШАНШАНТ тө. šang sang te'u'; мө. šangšangtu; Толгой нь нохойныхтой төстэй, мөчис нь будүүн, сүүл урт нарийн, үс үнсэн саарал нэг зүйл хөхтөн. Нохой мич, шинлиг, шанмал гэхчлэнгээр нэрлэх нь бий. Бас хүн гөрөөс гэнэ.

ШАНШИ хя. shāng shi ; мө. šangsi; "дээшилэн зоогломуу"; Тэнгэр лусаас бороо хур гүйхын тулд тахидаг ухаа тал, дов толгод хaa ч ургасан байж болох гол төлөв өнчин саглагар модыг хэлнэ. Нэг дор хосоор ургасан байвал эр, эм шанши мод гэж ялгана. Шанши модыг тахихын тулд эхлээд энэ модонд өнгө бүрийн хив хадаг уяж, хонь гаргаж болгосны хойно өндөр настай хоёр хүнийг дээши залж суулган, шаншийн өвгөн гэж нэрлээд хонины өвчүү, ууц бариулаад цугларсан олон "ус бороо оруулж, ургамал өвс хайрла" гэж тэр хоёрын дээр ус цацна. Тэгэхэд хоёр өвгөн "буяны урийг бид сацъя, бузар гарвал та нар арилга" гэхчлэн хэлнэ. Энэ заншил өверлөгчид их дэлгэрсэн байжээ.

ШАР: шар үсэг тө. gsar; мө. šar; Төвдийн таталган үсгийн нэр.

ШАРВААГ сам. śrāvaka; мө. šīravag; "сонсоод сонсгох"; Бурхны их шавь. Бурхны сургаалыг журамлан бясалгал хийж мөрийг ологчдыг хэлнэ. Бурхны шашны хоёр бага хөлгөний нэг; ...шарвагууд-бээр жаргалантан болтугай (Зуун бил.).

ШАРВИН хя. xiānróng; мө. šarbīng; Зуурсан гурилыг нимгэлэн хальс шиг болгож ногоо мах зэрэгтэй хийсэн шанз хавчуулсан хайрмал.

ШАРИГА сам. śārika~śārikā >(тө. sa ri ka); мө. šariy-a; Turdus salica; Гилгэр хөх өдтэй, цагаан бидэртэй, жижигхэн шар хушуутай, номхон дөлгөөн, сүргээр амьдардаг нэг зүйл шувуу; ...тор дахь шарига бялзуухай жиргэн донгдоход нь...чи ер санадаг уу (Кали).

ШАРИД араб. śariyat; мө. šarid; Лалын шашны жаяг дэглэмийн цогц; шударга хууль; монгол хэлнээ тушаал биелүүлэх гэсэн утгаар хэрэглэж байжээ.

ШАРИЛ сам. śārīga; мө. šarīl; 1. бурхан Шигмуний цогцсыг хайлуулсны хойно чандар дээр нь тодорсон сувд шиг гэрэлтэй толбо; 2. хутагт хувилгаадын чандраас гарах шар толбо; 3.

хүндэтгэвэл зохих хүний хүр; шарил хайлах (хүр шатаах); шарил бүтээх (шарилыг засч хэвийн болгох).

ШАРИР мө.б. šarir; *Их буянт бурхан багшийн шаририйг хурааж..их шашныг өртөнцөд маш гийгүүлвэй* (Зуун бил.).

ШАРЛАХ тө. šag ba; мө.б. šarlaqu; "ургах, санагдах"; Урьд цагт эрдэмт хүний толгойд гэнэт номын ухаан, шинэ санаа орж ирэхийг ном шарлах гэж хэлж байжээ.

ШАРМАНИ сам. śāmanera; мө.б. sarmani; "буяны ёст".

ШАСАР = шасэр (шар малгай); мө.б. šasar; *Олон лам хувраг шасар малгайгаа авцгааж..бөхөсхийн мөргөв* (Л.Т.).

ШАСТИР сам. śāstra; мө.б. šastir; 1. энэ үг угтаа самгардийн sāsanatrayati гэсэн үгийн хураагдсан хэлбэр. sāsana нь "засах", trayati нь "аврах" гэсэн утгатай. Нисваанисыг атгагаас засаад, муу заяа ба сансраас аврах гэсэн санаа; 2. үеэс үед уламжилж ирсэн түүхийн бичиг, шаандир ч гэж бичнэ. *хорштуух шастир, судар шастир.*

ШАСЭР тө. zhwa ser; мө.б. šaser; Монгол гутлын дотуур углах эсгий оймсны хэлбэртэй, дээрээ цацагтай ардаа залаатай их сүмийн хурал, их ёслолын үед өмсөх малгай. Шар малгай ч гэнэ.

ШАТ түр. satu; мө.б. šatu; 1. өгсөхөд хэрэглэх хэрэгсэл, төмөр, мод, чулуу зэргээр хийнэ; 2. *шилж* үе, зэрэг, алхам.

ШАТАН хя. shātāng; мө.б. šatang; Элсэн ширхэгт чихэр, бурам; *Шатан чихэр амттай гээд цадглаа идвэл хордоно шуу* (Паж.).

ШАТАР перс. satarang (<сам. caturamga); мө.б. šitar-a; "дөрвөн анги"; Бүгд арван зургаан дурсийн юмыг хоёр этгээд нэхжээдээр эзлэн, тусгай хөлөгт жагсаан өрж, хоёр этгээд наадах тоглоом; шатарцах (шатраар наадах); шатарчин (шатар сайн тоглодог хүн); шатарчлах (юмыг шатар маягаар үйлдэх).

ШАШИР 1. шасэр; *шашир, жанч хоёроо цааш нааш хаялж..(MAY)*; 2. *шилж* босоо нарийн гоёмсог зассан дэл (морины).

ШИВА сам. śiva; мө.б. šiva; Амьтдыг оршуулагч бурхан, хиндү шашинтны гурван гол тэнгэрийн нэг. Таван нигур, дөрвөн мутартай, зулайдаа нэг мэлмийтэй, хүзүүндээ хохимой толгойн эрхин чимэгтэйгээр эртний энэтхэгийн урлагт дурсэлсэн байдаг. Садарсан үсээ унжуулсан нь Ганга мөрний билэгдэл гэдэг. Заан, гөрөөс, ирвэсийн арьсан нөмрөгтэй, Нанди хэмээх цагаан бүх хөлөглөсөн буй.

ШИВАТИХ сам. śivatikā; мө.б. sibataki; Дулаан оронд ургадаг нийлмэл цэцгийн язгуурын улбар шар цэцэгтэй өвс. Шиваантиг ч гэнэ.

ШИВУУ хя. xibù; мө.б. šibuu; "нарийн бөс"; Нарийн ширхэгт нэг зүйл бөс; шивуу даавуу.

ШИГМУНИ шагимуни; мө.б. šigemüni.

ШИД I тө. śid; мө.б. šid; Шивэр модонд ургах жимс, самраас том бөгөөд бөөрөнхий хатуу хальстай, хальсыг хуулж цөмөөг иднэ. шид мод (царсны төрлийн жижиг мод, шивэр мод ч гэдэг), шид мөөг (шивэр модтой газарт ургадаг шар өнгийн жижиг мөөг).

ШИД II сам. siddhi; мө.б. šidi; 1. рид, оюун санааны хүч; 2. ид хав; *хорш* ид шид; шидийн барилдлагат өдөр (зурхайн ёсоор аливаа санасан үйлс сэтгэлчлэн бүтэх өдөр).

ШИДЭЛ тө. śi 'dul-'chi-'dul; мө.б. šidül; "үхлийг номхотгох"; 1. шөнө дунд унших, хүний сүнсийг дуудах шашны нууц ном; Бас буг чөтгөр дарах үед унших ном тэргүүтэн зан үйл; ...*лам ирээд..майхан бариад шидэл уншив* (Ц.Д.); 2. хараалын үг; *шинж муутай гамин чандруу шидлийн ёсоор хөөгдөв үү дээ, ай хо (МААЗДБ).*

ШИЖИДБАА тө. śi byed pa; мө.б. šijidba; "амирлуулагч"; Билэг баримицыг баримтлах нь хүний өртөнцийн аливаа зовлонг амирлуулах явдал мөн. Үнэн ном бол хамаг зовлонг амирлангий болгогч гэж үздэг шарын шашны нэг салбар.

ШИЖИР чичир; мө.б. šijir; 1. лан; зуун шижрээр үүдсэн алтан тамга (Ц.Ц); 2. хамгийн эрхэм цэвэр сайн зүйл, хольцгүй, цул; шижир алт; Уйгар хэлнээ нэг шижир нь нэг лан, хоёр цэн найман лийтэй тэнцэнэ. Шижир, шар хоёр гарал нэг.

ШИЙ I хя. xi; мө.б. ši; "баяр, цэнгэл, найр"; Нийгмийн амьдрал тэмцлийн зөрчлийг тогтолцоор тусган харуулах урлагийн нэгэн төрөл, жужиг.

ШИЙ II хя. shi; мө.б. ši; 1. эрдэмтэн, боловсорсон хүн; 2. түшмэл; ший мэргэн.

ШИЙГУА хя. xi guā; мө.б. ši gua; Хулууны язгуурын бөөрөнхий хэлбэртэй, амттайхан жимс, дотоод тал улаан шар, адил бус.

ШИЛ тө. śel; мө.б. šil; 1. Ардын эмнэлгийн судар бичигт шилийг байгалийн ба хиймэл гэж ялгадаг. Байгалийн шилийг цагаан, хөхөмдөг ногоон, улаандуу гэж гурав хуваадаг. Элсийг

хайлуулж хийсэн тунгалаг эдийг хиймэл шил гэнэ; 2. шилээр хийсэн юм; цонхны шил, нүдний шил.

ШИМНАНЦ чавганц; мөб. šimnanča (түр. šimnanč//согд. šmn'nc<сам. šamaner); Хүнтэй сууж, хүүхэд гаргахыг тэвчиж, маань уншиж, мах цээрлэдэг сахил хүртсэн эм хүн; *Marгааш нь үнэхээр нэгэн хижээл насны шимнанц ирэв* (Л.Т.).

ШИН I хя. shēng; мөб. śing; Нэг дүүгийн арваны нэгийн хэмжээний багтаамжийн нэгж, арваад атга орчим; ...*нэгэн шин буурцаг өг* (Гэс.).

ШИН П: Шин мөрөн; Угтаа Син мөрөн; Хималайн баруун нуруунаас эх аван Энэтхэгийн баруун өмнөд хил хавиар урсдаг Синхүү мөрний нэр.

ШИНБАД тө. sing + сам. pada (тө. śing 'ba' ta); мөб. śingbad; "хөлт мод"; 1. олон хөлт мод ч гэдэг. Наяагрода (үз) ч гэнэ; 2. янз хушгатай адил, өнгө хүрэн нэг зүйл жимс. Бас модорхог ишгэй, лянхуа цэцгийн адил навчтай нэг зүйл цэцэг; Ялмын язгуурын асаж ургах бут мод, өнгө хүрэн, навч том, зуувандуу зузаан, мөчир, жимс, иш үндэс нь эмд орно. Үнэрт өвс ч гэдэг.

ШИНЖ хя. xīngzhī; мөб. sinjī; Чанар байдал, овор дүр, төрх төлөв; *шинжгүй*(1. хүний ханиглаагаар муутай хүн; 2. харамч)

ШИНЦАА тө. singtsha; мөб. śingča; Мөнх ногоон тураг мод, навч урт зууван, цэцгийн өнгө цагаан, навч нь эмд орно. Дөрвөн сайхан үнэртний нэг

ШИНЭ хя. xīn; мөб. sin-e; Хуучин бус, сая гарсан, хуучраагүй.

ШИРВААН сам. sravāna; мөб. śirvan; Сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Монгол нэр нь Ялгуун дарагдагч одон. Одоо Булаагч од гэж нэрлэж буй.

ШИРВАГ сам. sravaka; мөб. śiravag; шарвааг.

ШИРВАН ширваан.

ШЛОГ сам. sloka; мөб. ślog; =шүлэг; ...*хэмээх гурван плогийг ийн ухагдахуй* (Зуун бил).

ШОЖООН хя. shí jiàng; мөб. śojiyang; Чулууг засаж дарх хийдэг хүн, чулуучин.

ШОЛОГ шлог; *Дандар аграмба нэг шолог ном нэмж зохиосон...* (Лав.эг).

ШОН хя. shuān; мөб. śong; 1. босгосон мод, суулгасан багана; 2. морь мал уях зэл, хэц татсан босгосон мод.

ШОО I хя. xiào; мөб. śoo; шоолох, элэглэх; ад шоо үзэх; шог, шоолох, шоглох, шооч, шоодох зэрэгтэй гарал нэг.

ШОО П тө. śo; мөб. śo; 1. төлөг үзэх, наадах зэрэгт орхих зургаан талтай дөрвөлжин. 1-6 хүртэлх тоог тал бүр тус тус нэгэн тооны тоогоор нүд гаргасан юм, дөрвөлж ч гэнэ; 2. **шилж**. босоо дөрвөлжин бие.

ШОО III хя. xiāo; мөб. śo; Чанар муухан, хатуу нимгэн бөгөөд бэхлэг нэг зүйлийн юнгарын ээрмэл, хадгийг шоогоор хийнэ.

ШООВИН хя. shāo bǐng; мөб. śoobing; Буудайн гурилд чихэр ус хоршиж, хүшгэны цөмийн идээ хийж тосонд хайрсан нэг зүйл идээ.

ШООЖОО хя. xiāo jiē; мөб. śoojū-a; "жижиг эгч"; Баян ноён, эрхэмсэг хүний охиныг хүндэтгэн нэрлэх үг; *Арван тавтай шоожоо нь ай хөө, аав ээждээ дэнлүү дээ ай хө* (*МААЗДБ*).

ШОР түр. śog; мөб. śog; "давслаг, давсархаг"; Зургаан амттаны доторхи гашуун амт, шорвог ч гэнэ.

ШОРЛОГ түр. śorlaq; мөб. śiruly-a, śorlay; "давсалсан юм"; Ангийн хувь, олзын хувь.

ШОХОЙ хя. shi hui; мөб. śoqoi-śoqoi; Шохойн чулууг шатааж хувилгасан цагаан нунтаг.

ШОШ тө. zho sa; мөб. śosa; Зүрхэн шоп (тө. snying zho sa); бөөрөн шош (тө. mkhal ma zho sa); лагар шош (тө. gla gor zho sa) гэсэн гурван зүйл бий.

ШОШГО тө. zhu sog; мөб. śośiy-a; 1. хаад ноёдод бараалхахдаа өмнөө барьж ордог өргөн мэдүүлэх бичгийн гарчгийг бичсэн хавтас, хас, зааны соёо, хулс тэргүүтнээр хийдэг; 2. бичиг буюу тусгай тэмдэгтэй пайз мод; 3. **шилж**. алт, мөнгө зэрэг үнэт элээр үйлдсэн гавьяя алдрын тэмдэг; 4. ямар нэг эд бараанд наасан буюу зүүсэн хадсан хаяг сэтэр; шошго тэмдэг (манжийн үед дайн байлдаанд болон аливаа алба ажилд зүтгэж гавьяя байгуулсан хунд олгож байсан үнэмлэх, жуух бичиг).

ШОШИГ сам. visākhā; мөб. śośa; 1. сарны зурхайн ёсны хорин найман одны нэг. Хүү санг баригч одон ч гэнэ; Одоо Эрхтний тэнгэрт од гэж нэрлэж буй. 2. Энэтхэгийн хаврын адаг сар, цагийн хүрднээ хаврын дунд сар. Хятад, төвдийн зуны эхэн мөгий сар. Монголын дөрвөн сар, бас сага сар ч гэдэг.

ШИРШАА сам. śirīsa; мөб. śirīsa; Acacia Sirissa ба түүний цэцэг; *Сайхан ширшаа цэцгээр чихээ чимээд...* (*Кали*).

ШУЛАМ шимну, шуламс, шумнас, ад тоттор болох зүйл.

ШУЛАМС шуламын олон тооны хэлбэр, шумнус.

ШУМНУС согд. šmnw>тур. šimnu~šamnu~šumnu>мо.б. šimnus; шумнусын үйлийг тархахун болтугай (*Турф*).

ШУНЛАЙВ тө. gzhung las pa; мо.б. šunglayiba; "голын үйлч"; Шарын шашны сүм хийдийн гүн ухааны сургуулийн дацангуудын захидал.

ШУУ хя. shú; мо.б. šuγu; Шавар, шохой зэрэг юмаар хүн амьтан болон элдэв дүрсийг барьж бүтээх; шуух, шуумал.

ШУУГИУР хя. shāo guo; мо.б. šuugiur; Архи дарсны мухлаг, архи нэрдэг газар; *Хүрээний зах шуутиур дээгүүр...モンゴл хааны эрх барих цаг боллоо гэж ярьж байх болж дээ* (*Б.Р.*).

ШУУДАЙ хя. shào dài; мо.б. šiyudai; 1. будаа тариа бусад юм агуулах бүдүүн нэхмэл сав; 2. **шилж** шуудайгаар хэмжих хэмжүүрийн нэгж.

ШУУДУУ хя. shuidào; мо.б. šuuduu; "усан зам"; Ус урсах хиймэл буюу ерийн тогтсон нарийвтар суваг; суваг шуудуу.

ШУУМААЗ хя. shāo mǎ zi; мо.б. šuumaja; Унаанд юм тэгнэх том уут сав, даврага.

ШУШМАА хя. shuà shi ma; мо.б. šusim-a; "юу хэлнэ вэ?"; 1. монгол хэл мэдэхгүй хүнийг даажигнан хэлэх уг; 2. аливаа юмны учир байдлыг мэдэхгүй байдлыг нь.

ШҮТВАА тө. śug pa; мо.б. śügħba; Juniperus sp; Төвд арц, аливаа муу юм бүхнийг арилган зайлцуулах увдистай гэдэг.

ШҮГЛЭХ тө. bzhugs pa; мо.б. śüglekū; Нөхцөх; хүслэн болох, санаашрал болох; ад шүглэх, дон шүглэх; *тийм л муухай шуламс танайд шүглэсэн байгаа юм даа* (*Мон.дом.*).

ШҮГЭЛ тө. śugs glu; мо.б. śüglü; "исгэрэх, исгэрэл"; Үлээж дуугаргах дохионы хэрэгсэл; шүгэлдэх (шүгэл дуугаргах).

ШҮДЭНЗ хя. qūdēng; мо.б. čüdenje; чүдэнз; цуулбарлан зассан нарийн модны үзүүрт фосфор хүхрийн нийлмэл бодисыг найруулж хийсэн гал гаргах юм.

ШҮЙ хя. shui; мо.б. šui; Гааль, түрээс; шүй хураах; шүйлэх (гааль хураах).

ШҮЛЭГ тө. (<сам. sloka); мо.б. silüg; Угийг айзамд тохируулж, бадаглан бичсэн уран зохиолын нэг хэлбэр.

ШҮН тө. gzhung; мо.б. šüng; гол зохиол, жинхэнэ судар; шүнгээс иш татах (жинхэнэ итгэмжтэй гол судраас эш татах); *асар их шүнгийн чинь уттыг, асгалуулан зэрэг зэргээр асуулцан...* (*Гэл*).

ШҮНШИГ тө. gzungs gžug; мо.б. süngsüg; "тогтоол тарни оршуулах"; Бурхан болгон цогцлуулан бүтээж амилуулан тэтгэх нарийн нандин зүйл, бурхны сан ч гэдэг. (*Жанрайсиг*) *Бурхны шүншигт хоёр сая илүү тарни номын зүйл орсон аж*. (*АЭ*); шүншиглэх (бурхан, суварга тэргүүтний гол хөндий зайд ариун нандин эд зайд хийж хүнчилж үзвэл дотоод мөн чанарыг бүрдүүлэхий нь).

ШҮР тө. buu gu~buı gu; мо.б. šigü; 1. далай тэнгисийн ёроолд хүйгээр амьдардаг ургамал мэт суумал амьтан. Шүрний үзүүр нь улаан, ёзоор нь цагаан буюу хар өнгөтэй, монголчуудын эрхэмлэдэг есөн эрдэнийн нэг. Шүр хорхой ч гэнэ; 2. энэ амьтны эдээр хийсэн чимэглэл; *хорш*. шүр сувд.

ШҮҮ хя. xiāo; мо.б. šeii (<манж su); Органик бус нэгдэл, азот хүчлийн давс, өнгөгүй буюу цагаан тунгалаг талст, нунтаг. Усанд уусдаг, малд идүүлэх ба арьс идээлүүлэхэд хэрэглэнэ; шүүлэх (арьс нэхий шүүдэх); шүүдэх (арьс нэхийг шүүтэй шар сүү, ус зэрэгт дүрж дарах).

ШҮҮДЭГ тө. zhūs dag/zhu gtugs; "ариутган айлдах"; Аливаа ном бичгийг тулган шүүж алдаа мадгийг засан залруулах, хянах; шүүдэглэх (тулган шүүх, засан залруулах).

ШҮҮЛЭНГЭ манж. sülenge; мо.б. śigleng; Хуучин цагт алба гувчуур татаж хүү сан эрхлэгч тушаалтан, отгийн даргын орлогч, хар хүн байдаг. śiglengge буюу śigleng ч гэж бичдэг.

ШЭХЭР перс. sahr>тур. sahar>мо.б. šeker; хот, балгас; шэхэрийн дунд, шэхэрийн балгас (*Мукад.*).

Э

ЭВАМ сам. evam; мо.б. evam; 1. Богд хаант монгол улсын төрийн далбаан дээр төвд үсгээр бичээстэй байдаг билэгдлийн уг. Үүнд: э- нь арга буюу судар, вам нь билэг буюу тарни гэсэн уттатай. Арга билэг буюу судар тарни нь төр шашны гүн билэгдэл ажээ; Өөрөөр хэлбэл "вам үсэг бөөрөнхий бүтсэн нь эгшиг хийгээд сарны номын хураангуй тул аргыг эрхэм болгосон, э үсэг гурвалжин бүтснээр гийгүүлэгч хийгээд нарны ном бүхний хураангуй тул билгийг эрхэмлэсний билэгдэл болно" гэсэн тайлбартай холбогдоно. Энэ үзэл нь шүтэн барилдахуйн ёсыг гол болгосны гэрч юм. 2. амьтан бүгд бурхны хутгийг олохыг билэгдсэн тэмдэг.

ЭВШГЭС түр. ebčikis; мө.б. ebšigis, ebci(evci) (эмэгтэй, эхнэр)+kis (булга)-= эм булга.

ЭГШИН = агшин; эгшин зуур.

ЭЛ түр. al; мө.б. el; Түрэг хэлнээ түрэгчүүд анх өөрсдийгээ нэрлэж байснаа хожуу үед хааны удмынхныг хэлэх утгад шилжсэн. Элээс элгэн гэсэн үг үссэн. Монгол хэлнээ элгэн садан, садан төрөл гэсэн утгатай. эл эстгүй (садан төрөлдөө хайртай бус); эл дайсан (янаг ба өшөөтөн); эл харш (сайн мүү).

ЭЛБЭДЭН манж. elbidün; мө.б. elbedün; Элбэнх адил, хүн шиг нүйтэй нэг зүйл гөрөөс.

ЭЛБЭНХ манж. elbihe; мө.б. elbengkü; 1. хар болоод шаравтар, үнэгтэй адилавтар, нэг зүйл үслэг амьтан, илбэнх, өлбэнх ч гэнэ; 2. энэ амьтны үсээр хийсэн үслэг эдлэл.

ЭЛЖИН манж. elje; мө.б. eljing; Халим загасны сахал.

ЭЛЧ түр. älci/elci; мө.б. elci; Томилогдон зарагдсан албан тушаалтан.

ЭЛЭЭ тө. ne le; хя. eliē (ууль); мө.б. eliy-e; Улайд дуртай, жижиг амьтас, хорхой шавж зэргийг идэж амьдардаг махчин шувуу; элээ *шуламсыг тас хялайсан минь билээ* (*Гэс.*).

ЭМА ХО тө. e ma ho; мө.б. e ma-a ho; Нууц тарнийн гүн утга бүхий хэллэг. Гүн ухааны сударт э- нь "arga" буюу "хамт төрсөн амгалант сэтгэл", ма- нь "билэг" буюу "хоосон чанар", хо- нь дээрх арга билэг хоёр хослон байхын билэгдэл мөн гэж тайлсан байдаг.

ЭНА сам. eña; мө.б. iney-a/eneuy-a; Богино хөлтэй, тас хар нүйтэй, хар өнгөтэй домогт гөрөөс, бодь гөрөөс. Бурхан багшиг номын хүрдээ эргүүлэхэд энэ гөрөөс хамгийн түрүүнд ирж эгшиг зарлигийг нь сонссон домогтой. Үүнийг бэлгэшшэн номын хүрдний хоёр талд хөлөө бохирсон байдаар дурсэлж сүм дуганы оройн хөндлөвч дээр залан байрлуулах болжээ.

ЭНГЭСЭГ сам. kimsuka; мө.б. gingsü~gengsüke~enggesge, Butea Frondosa; 1. навч хийгээд үр цэцгүүд ув улаан нэгэн зүйл мод, дулаан орноо ургана; 2. дээрх модны давирхайнаас боловсруулан гаргаж авсан эмэгтэйчүүдийн хацар уруулдаа түрхэх улаан будаг; энгэсэг хацар (гэр хацар, гэрэл хацар); энгэсэг дэлсэх (энгэсэг тавих); **хорш** oo энгэсэг; энгэсэгдэх (хацар нүүртээ энгэсэг түрхэх).

ЭНЭТХЭГ согд. 'yntk'k<үй. enatkak> мө.б. enedkeg; Самгарди хэлний Sindhu мөрний нэрээс үүсэлтэй, персчүүд Hindu гэж дуудаж согдууд энэткэк гэх болжээ.

ЭРДЭНЭ сам. ratna; мө.б. erdeni; Их үнэтэй ховор чухаг юмс; чандмань эрдэнэ (олдошгүй юм); эрдэнийн чулуу (ховор, үнэт чулуу); есөн эрдэнэ (алт, мөнгө, төмөр, зэс, оюу, номин, шур, сувд, дун).

ЭРДЭНЭЗҮҮ сам. ratna+te. jo=ratnajo; эрдэнэ, зуу зэрэг үгийн тайлбарыг үзмүү. Халхын түшээт хан Автай 1586 онд Орхон голын хөвөөн дээр монголын анхны шарын шашны сүмийг байгуулснаа ийн нэрлэжээ.

ЭРЗЭЭН орос. резина, сунадаг; эрзээн эдлэл, резин ч гэнэ.

ЭРИН манж. erin; мө.б. erin; Он тооллыг зуу буюу жараар нэгэн че болгож тоолох, эрэн ч гэнэ.

ЭРЛИЙЗ хя. er lei zi; мө.б. erleje; 1. удам угсаагаар төрөлсөхгүй хоёр өөр ястан, үндэстний дундаас гарсан хүн; 2. хоёр өөр үүлдрийн дундаас гарсан мал, ургамал; эрлийзжих (мал ургамал эрлийз байдалтай болох нь).

ЭРЛЭГ уй. erklig; мө.б. erlig; "хүчирхэг, эрх хүчтэй"; 1. нас барсан хүний урьд төрөлдөө үйлдсэн муу үйлийг шүүн шийтгэгч; Эрлэг хаанд заалдъя би (*Гэс.*); 2. **шилж**. хөнөөлтэй, дайсан; чономалын эрлэг.

ЭРЭМБЭ тө. git ra; мө.б. erimbe; зэрэг дэв, юмны дэс дараа, дэв дугаар; эрэмбэ дугаар; эрэмбэ зэрэг; **хорш**. эрэмбэ дараа; ...хүнийг эрэмбэ зэрэгээр ялгахдаа мөн ч сурамгай... (*Б.Р.*)

ЭРЭНГЭ тө. ring 'gag; мө.б. eringge~eringgi; Лам шавь хүний гадуур өмсдөг ханцуйгүй цээжмэг буюу охор хувцас. Их төлөв тэрмээр хөвөөлж, элгэн талыг нь хортойгоор хийсэн байдаг. Донгот ч гэнэ.

ЭРЭНДА сам. eranda; мө.б. erinda; Ricinus communis L; Халуун оронд ургадаг, гишүүний иштэй адил иштэй, жимсний гэр өргөстэй, зөвлөн цагаан цэцэгтэй, тослог хар үртэй ургамал.

ЭСРУА согд. 'zrw'~zargwā (сам. īsvara)>уй. ezw-a; мө.б. esru-a; харьц.зерван; Браhma, энэтхэгийн шашны турван их шүтээн сахиулсны эн тэргүүнийх нь нэр. Дэлхий өртөнцийн олон амьтныг бүтгэн турвигч. Халхад эсэр гэнэ.

ЭСЭРВАА эсэр; Яруу сайхан эгшиг нь эсэрваагийн эгшигээс илүү (*Д.Р.*).

ЭСЭРҮН эсэрваа; мө.б. *eserün*; **эсэрүн** тэнгэрээс болсон...элдэв төгс цогт галын хан (Зуун бил).

ЭФҮ манж. *efu*; мө.б. *efü*; Манжийн хааны хүргэн, тавнан ч гэнэ.

Ю

ЮГТИ сам. *yukti*; мө.б. *yügti*; ётг; *Хааны зарлигаар агам югтийн номууд-төр сайтар дадсан...*(Зуун бил.).

ЮДААГУН хя. *yuda gun*; мө.б. *yüdaγun*; Таван эгшигийн нэг, усан махбод эгшиг ч гэнэ.

ЮМБҮҮ хя. *yuánbǎo*; мө.б. *yuambuu*; ембүү.

ЮМДҮҮЖИН тө. *yu mo mde' 'byin*; мө.б. *yümdeüjin*; *Dianthus versicolor* Fisch; Caryophyllaceae-гийн намын олон наст өвслөг ургамал. Цэцгүүд ганц ганцаар, хондон ягаан тэнэгэр дэлбээтэй, дээд талдаа хурц өргөстэй. Монголоор алаг башир цэцэг ч гэдэг.

ЮНГАР тө. *yungs dkar*; мө.б. *yungyar*, *yüngger*; 1. хичийн өөр нэр. Иш өндөр, навч ногоон, цэцэг тод шар, шар будаа мэт тослог үртэй, зэрлэг таримал хоёр зүйл бий; юнгарын тос (маажингийн найрлагад ордог ургамлын үр); 2. шимэлдэг.

ЮУ хя. *uáo*; мө.б. *uusi*; бааку гэдэг үгийн нэг өнцөг бололтой. Шаазан, ваар, тоосго зэргийг шатаах зуух.

ЮУМАЙ хя. *yoútmái*; мө.б. *uuchmai*; Гурил гаргаж иддэг буюу бордоонд хэрэглэх нэг зүйл тариа.

ЮУДЭН хя. *yoúdānmáo*; мө.б. *yeüden*; 1. бороо, салхи, тоосноос хамгаалах, малгайн гадуурх бүрхүүл малгай; 2. бороо цасанд өмсөх тосон цардмал малгай.

ЮУЗ хя. *uao zi*; мө.б. *ueüj*; Өвс тариа зэргийг хэсэг хэсэг болгож багцалсан боодол; юүзлэх (юмыг юүз болгох); юуж ч гэж бичдэг.

Я

ЯАМ хя. *uámen*; мө.б. *umatun*; 1. хуучин цагийн ноёд түшмэдийн албан хэрэг шийтгэх газар; 2. зэрэг тушаал; *гүн их цол хунд яам хүртэл* (*A.to*); 3. аливаа нэг тухайлсан хэргийт хариуцсан улсын хэмжээний төвлөн захирах захиргааны том газар; яамлах (а. ардын хувьсталин өмнө албан хаагчдын ёслоч

буую хэрэг шийдэхээр албан өрөөндөө хуралдах суухыг хэлж байжээ; б. зарим нутгийн аялгуунд ямбалах гэсэн утгатай).

ЯАРМАГ ор. ярмарка; мө.б. *yaγagtaγ*; Барааг бөөнд нь зарах, худалдан авахын тулд худалдаа эрхлэх газруудаас тогтоосон цагт зохиох хурал буюу үзэсгэлэн худалдаа.

ЯАТУУ хя. *ya tou*; мө.б. *yatuu*; "салаа гээгт"; Бас заримууд "миний муу хүү" ч гэнэ. Охиныг өхөөрдсөн үг, охин.

ЯВАГЧАР тө. *ya bag šara*; мө.б. *yabaγčar*; Имрэхэд чахарсан дуу гардаг, хадны хөндий, газрын хөрсөн дор тогтсон нэг зүйл хужир. Түлсэн тарианы үнс ч гэдэг. Эмнэлэгт хэрэглэнэ.

ЯВЛАГ уй. *japilak*; мө.б. *yabalay*; Шар шувуутай адил боловч бие жижиг нэг зүйл сар шувуу; явлаг галуу (явлаг адил, нүд хөнхөр халуу мэргэний нэг зүйл).

ЯВУУ хя. *uibèi*; мө.б. *ibaū*; 1. хав загасны намын нэг зүйл нялцгай биетэн, зузаан хуягтай, мах амттай, ибагу ч гэж бичнэ; 2. **шилж**. явууны хуят, гоёл чимэглэлд хэрэглэнэ.

ЯДАМ тө. *yi dam~yid dam*; мө.б. *idam*; 1. бясалгал хийх үед гэлэн хүний өөрийнх нь сонгож авсан ивээгч (Дамдин, Замбал, Банданлхам...гэх мэт) буюу хувийг сахигч, тангараг, сахилыг хамаарагч бурхан буюу ариун сахиулсан; 2. дамжаа, тугдам (үз); 3. гарын дотгөөр хурууны нэрийдэл; ...ядам хуруут дүрээд дөрвөн зуг, *найман зовхист өргөв* (З.Б.).

ЯЖУРВЭЭД сам. *ujurveda*; мө.б. *uyaγvíd*; "тахил өргөлийн вээд"; Вээдийн эмхэтгэлийн гутгаарх нь. Тахил өргөлийн зан үйлийг бичиглэсэн байдаг.

ЯЙЧИЛ тө. *gyas 'khyil*; мө.б. *uyaičil*; "баруунаа эргэсэн"; амны эргүүлэгч нь нар зөв эргэсэн цав цагаан дун. Дунгаряйчил (тө. dung dkar gyas 'khyil баруунаа эргүүлэгтэй цагаан дун); Зааны яс цэвэрхэн боловч яйчил мэт яс бэрх (Д.Р.).

ЯМ тө. *uams*; мө.б. *umat-a*; "халдварт, хижиг", Адуу зэрэг битүү туурайтанд тусах нэгэн зүйл халдварт өвчин.

ЯМА сам. *umat*; мө.б. *umat-a*; 1. гурван ертөнцийг эзэгнэгч; 2. бусдын нөлөөгүй захирагч; 3. нас барсан хүний урьд төрөлдөө үйлдсэн сайн муу үйлийн үрийг ялган шүүн шийтгэгч, эрлэгийн эзэн.

ЯМАНДАГ сам. *umatantaka*; мө.б. *umatandaγ*; Үхэр толгойтой, хүний биетэй, нүцгэн эм тэвэрч суусан бурхан.

ЯМБИЙ хя. yángpí; мө. yambii; 1. эд юмын эвдэрч муудсаны нь; 2. хүн амьтны үзэмж жавхаагүй болсныг нь; ямбийх (ямбигар болох); ямбигар (ямбий болсон юм).

ЯМБУУ хя. yángbù; мө. yangbu; Хөвөн нэхмэл бүдүүн даавуу барааны нийтлэг нэр.

ЯМПИЙ хя. yángpí; мө. yangpii; Mash бүдүүн хийцийн ваар шаазан; ямпий аяга.

ЯН I тө. dbyangs; мө. yang; "эгшиг"; Хоолойгоор хөг оруулж уянгалуулан эгшиглэх ая; *хорш* ян дан; *Лам нарыг ян татахад бие доргимоор их дуу гарч байлаа*(Л.Т.).

ЯН II хя. yan; мө. yang; Энгийн нүдэнд үл үзэгдэх маш жижиг организм; ян судал (ян судлах ухаан).

ЯН III хя. ràng; мө. yan; Дашрам, ялдраа, найр тал; аянал, янтал хоёр гарал нэг бололтой.

ЯН IV: ян сарьдаг тунг. jang; мө. yang; "нүцгэн толгой буюу модгүй уул"; Верхоянск, Саян зэрэг нэрийн доторхи ян мөн. Саян нь "цаст уул" гэсэн үг болно. Ян хүйтэн (маш хүйтэн).

ЯН V: ян даавуу хя. yang; мө. yang; Хөвөнгөөр нэхсэн маш нимгэн зөөлөн бөс бараа.

ЯНАГ түр. inaq; мө. inay; "ina- итгэх, найдах"; 1. амраг; *хорш* янаг амраг; 2. нэн дотно.

ЯНГИР тө. gyang dkar; мө. yanggir; 1. мөнгөн цагаан өнгө; *янгир цагаан мөнгөөр цагаригласан...* (*Жан.*); 2. өвөл цагт шаргал, саарал, хацартай цагаантай нэг зүйл зэрлэг ямаа; Төвд хэлээр зэрлэг хонийг янгар гэдэг нь утга шилжсэн бололтой. Гэвч янгир гэдэг нь тунгус хэлний "ян(уул)ын амьтан" гэсэн уттатай байж магадгүй.

ЯНДАЙ хя. yang dai; мө. yangdai; амны тамхи нэрж татах нэг зүйл гаанс.

ЯНДАН хя. yán tong; мө. yandung; Утаа дамжуулан гаргах хоолой, хулан.

ЯНДАР тө. gyang dar; мө. yangdar; "хишигийн торго"; Сайн сайхан, энх эсэн, урт наслахын билэгдэл болгосон цагаан өнгийн нэг зүйл алчуур; *хорш* хадаг яндар, тут яндар.

ЯНДУАН хя. yángduàn; мө. yangduan; "тадаад торго"; Нэг зүйл торгомсог бараа, чигурай торго ч гэнэ.

ЯНЖИНЛХАМ тө. dbyangs can lha mo, =sarasvati; мө. yangjinlhamu; "эгшигт охин тэнгэр"; Дуун ухаан, яруу найргийг тэтгэн соёрхогч охин тэнгэр.

ЯНЖУУР хя. yānjuār; мө. yangjuur; Цаасанд хуйлж ороосон нэг зүйл тамхи.

ЯНЗ I хя. yàng zì; мө. yangžu; "үлгэр, төрх"; 1. хэлбэр дүрс, хэв байдал; 2. хээ, үзэмж; 3. зан чанар, шинж төлөв; 4. хэвийн байдал; 5. сонин хачин; янзын юм; янэгүй (а. үзэмж байдалгүй; б. муухай зан ааш гаргах); янзлаг (хэлбэр сайтай); янзлах (юмыг үзэмжтэй болгох); янзтай (хэв маяг сайтай).

ЯНЗ II хя. yān zì; мө. yanžu; хөвөө, ирмэг; янз мод.

ЯН-ИГ тө. dbyans yīg; мө. yang ig; "эгшигийн бичиг"; Хөгжмийн ая тэмдэглэх төвд монгол үндэсний ноот.

ЯНЛИУ I хя. yan liào; мө. yanliu; Нэгэн зүйл будаг.

ЯНЛИУ II хя. yan liào; мө. yanliu; "тамхины юм"; Тамхинд хийж үнэр оруулдаг эд зайд.

ЯНПИЙ ямбий.

ЯНТАЙ хя. yán tai; мө. yangtai; бэх будаг зуурах сав.

ЯНХАН хя. yǎng hàn; мө. yangqan; биеэ үнэлж бусадтай явалдах эмэгтэй.

ЯНЧААН хя. yang qián; мө. yangčiyan; "хятадад нэвтэрч ирсэн мексик доллар"; Мөнгөн төгрөг; луут янчаан (7 цэngийн мөнгөтэй тэнцэж байв); арван янчаан (70 цэн буюу 7 лан мөнгөтэй тэнцэнэ).

ЯНШУЙ хя. yán sui; мө. yanšui; Хүнсэнд хэрэглэх үнэрт ногоо.

ЯРАМ 1. ерма; 2. хуажуу.

ЯРГАЧИН түр. jarğan (алуурч); мө. yargacın/ırğaçın; jar- "хуваах, хэсэглэх"; 1. мал нядлах хүн; 2. *шилж* алуурч, талагч.

ЯРНАЙ төб dbyag gnas; мө. yarnai; "зун суух"; хайллан; дөчин таван хоногийн ярнай.

ЯШИЛ тө. ya sel; мө. yašil; 1. навч цуваа, жимс бөмбөлөг арьстай нэг зүйл тураг мод; 2. хангай говьд хад асганд ургах сөөг ургамал. Мод нь хатуулаг, өнгө хүрэн; 3. интоор, нохойн жимс.